

ШИХИХУТУГ ИХ СУРГУУЛИЙН 30 ЖИЛИЙН
ОЙД ЗОРИУЛСАН МАГИСТРАНТУУДЫН ЭРДЭМ
СУДЛАЛЫН ӨГҮҮЛЛЭГҮҮДИЙН ЭМХЭТГЭЛ

Редактор: С.Оюунбилэг /LLM/
Эмхэтгэн хэвлүүлсэн: Д.Оюунчимэг

ГАРЧИГ

ИЛТГЭЛ, ӨГҮҮЛЭЛ

Ж.БЯМБАА

Эрүүгийн процесс дахь нотолгоо 8

Ц.ӨНӨРЖАРГАЛ

Хүний халдашгүй эрхийн хамгаалалт 13

Б.ЖИГДЭН

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, төр, иргэдийн
хоорондын харилцан хамаарлыг тухайлан авч үзэх нь 15

Г.ДӨЛГӨӨН

Манжийн энх-амгалан хаан ба монгол орон 20

Б.ТӨРБАТ

Авлигатай тэмцэх үйл ажиллагааны эрх зүйн
зохицуулалтыг боловсронгуй болгох нь 26

А.БАЛДАНГОМБО

Иргэний нийгмийн байгууллагын эрх зүйн
зохицуулалтыг оновчтой болгох арга замууд 38

Ц.БАТТУЛГА

Монгол улсад тэтгэврийн шинэчлэл хийх нь зайлшгүй болох нь 49

Б.ТУНГАЛАГНАРАН

Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний
хэрэгжилт, түүний зарим асуудал 54

Ч.ТҮВШИНХАНГАЙ

Гэр бүл дэх хүүхдийн хуваарьт хөрөнгийн эрхийг хамгаалах
эрх зүйн хамгаалалтын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал 59

О.ЭРДЭНЭЗУЛ

Гэр бүлийн эрх зүй дэх хариуцлагын тогтолцоо 66

С.ГЭРЭЛТ-ОД

Иргэний хуулийн 282.2-т заасан эрх зүйн зохицуулалт,
түүний практик хэрэгжилт 72



Б.ОЮУН-ЭРДЭНЭ	
<i>Ипотекийн зээлийн мөн чанар</i>	84
Л.БАЯНБОЛД	
<i>Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хүний биед үйлчлэх хор хөнөөл</i>	90
Б.НОМИН-ОРГИЛ	
<i>Төрийн нууцыг задруулах гэмт хэрэгтэй тэмцэх монгол улсын эрүүгийн хуулийн хэм хэмжээнд хийсэн шинжилгээ</i>	95
Б.СОД-ЭРДЭНЭ	
<i>Захиргааны шүүн шийдвэрлэх ажиллагааны нотлох баримтын зарим онцлог</i>	102
С.НАМУУНЖИН	
<i>Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал</i>	110
Э.ЗОЛЖАРГАЛ	
<i>Иргэний процессын эрх зүй дэх хүсэлтээр шийдвэрлэгдэх хэргийн ажиллагаа, онол, арга зүйн асуудал</i>	116
Г.ТҮВШИНБААТАР	
<i>Хэрэг бүртгэлт түүнд тавих прокурорын хяналтыг шинээр авч үзэх нь</i>	125
Б.БИЛГҮҮН	
<i>Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянах нь</i>	132
Ж.БЯМБАА	
<i>Хүн танихын ухаан /Шихихутуг их сургуулийн анхны профессорын нэг Галдангийн Совдын гэгээн дурсгалд зориулав/</i>	141

ӨМНӨХ ҮГ

Судалгааны онол, арга зүй эзэмших эхний алхмуудад хийж буй. Эрх зүйн II ангийн магистрантууд энэхүү эмхэтгэлийг бие даан бэлтгэж төрөлх Шихихутуг их сургуулийнхаа 30 жилийн ойд бэлэг болгон барьж байгаа юм.

Эрх зүйн онол, Үндсэн хуулийн болон харьцуулсан эрх зүй, Монголын төрийн түүх, салбар эрх зүйн бусад чиглэлээр мэргэших зорилготой манай залуучууд дипломынхоо сэдвийн хүрээнд “баригдалгүй” эрх зүйн ухааны суурьтай судлаач болох чин эрмэлзлэлээр дүүрэн байгаагаа харуулахыг хичээж, судалгааны өгүүллийн эмхэтгэлээ бэлтгэснийг уншигч Та болгоон тунгаана уу.

Монгол Улсын гавьяат хуульч, хууль зүйн шинжлэх ухааны доктор бид бүхний гүн хүндэтгэлт багш О.Амархүү агсны суурь үндсийг нь тавилцсан 20 жилийн түүхт магистрын сургалтын үр дүнг харуулах нэгэн шинэлэг хэлбэрт хамтын бүтээл маань зүй ёсоор тооцогдох учиртай.

Хэдийгээр Төгсөлтийн дараах болон Магистр, докторын сургалтын албад хамтран магистрантуудын эрдэм судлалын өгүүллүүдийг бэлтгүүлсэн боловч уг эмхэтгэлд шүүмжлэл, дүгнэлттэй хандах асуудлууд нэлээдгүй гарах биз. Тиймээс эрхэм уншигч-оюутан, магистрант, докторант судлаач Та нөхөд уг эмхэтгэлд санал, шүүмжлэлээ харамгүй ирүүлж, дараа дараагийн ажил алхмуудад маань үнэтэй тус дэм болно гэдэгт итгэлтэй байна.

Төгсөлтийн дараах сургалтын
албаны дарга С.Оюунбилэг /LLM/

ЭРҮҮГИЙН ПРОЦЕСС ДАХЬ НОТОЛГОО

Ж.БЯМБАА

(Шихихутуг их сургуулийн магистр, докторын сургалтын албаны дарга, доктор Ph.D, профессор)

Зөвхөн нотлох баримтад тулгуурлан аливаа хэрэг маргааныг шийдвэрлэнэ. Нотолгооны материаллаг үндэслэл, процессын хэлбэрийг янз бүрээр нэрлэж ирсэн манай Эрүүгийн байцаан шийтгэх хуулиудын ерөнхий ангид бие даасан бүлэг, зүйл болгон тусгасаар ирсэн уламжлал бий.

Чингэснээрээ, тэрхүү зүйл, заалтууд тухайн хуулийн тусгай ангийн бүхий л үе шат, зохицуулалт бүрт процессын **зарчмийн** нэгэн адил удирдан чиглүүлж үйлчилдэг байсан юм. “Сайд Байбаков байгаа бол манай газрын тос байх ёстой. Газрын тосгүй бол эрхэм Байбаков ЗХУ-д хэрэггүй” гэсэн Сталины “алдарт хошигнол” оор нотлох баримт, эрүүгийн хэрэг шийдвэрлэх ажиллагаа хоёрын **амин холбоог** зүйрлэн илэрхийлж болох юм.

Нотолгоо нь эрүүгийн процессын зарчмуудтай нягт уяалдан үйлчилдэг онцлогтойг дээр өгүүлсэн. Ялангуяа **бодит үнэнийг тогтоох, хуулийг чандлан дээдлэх, шударга, энэрэнгүй ёс баримтлах** зарчмаас өчүүхэн ч холдох учиргүй. Дашрамд дурдахад эрүүгийн процессын зарчмууд эрдэмтэн судлаачдын төдийгүй эрх мэдэлтэн улс төрчдийн анхааралд “өртөж” хэлбэр агуулга нь байнга өөрчлөгдөж ирсэн нь нууц биш. Эрх зүйн салбараас тодруулсан нэгэн философич гэхэд л “... Хууль зүйн

шинжлэх ухаанд үнэний тухай асуудал яригддаггүй. Харин зөвшилцөл, ёс зүй, шударга ёс гол стандарт болдог. Тиймээс түүнийг тайлбарлан гаргасан шүүхийн шийдвэр бас харьцангуй” хэмээн онцолж Ром-Германы эрх зүйн бүлийн процесс ажиллагааны тулгуур зарчмын үйлчлэлийг эргэлзээнд оруулахад хүргэсэн. Ийм үзэл, онолыг баримтлавал тодорхой хугацаа өнгөрмөгц шүүхийн тогтоол, шийдвэр бүр хэлмэгдүүлэлтийн түүхэн баримтад зүй ёсоор тооцогдож таарна. (Энэ нь, хэрэг дээрээ, МАХН-ын Төв хорооноос хууль, хяналтын талаар гаргасан бүхий л шийдвэрийг “хар” хэмээн цоллодоогоос илүү хор уршигтай юм). Манай Эрүүгийн процессын шинэ хуулинд гэхэд л **бодит үнэнийг тогтоох зарчмыг бодит байдлыг тогтоох** болгон өөрчилж **мөн чанарыг нь өөрчлөв**. Философи утгаараа үнэний тухай сургааль **харьцангуй** шинжийг ямагт илэрхийлдэг бол эрүүгийн эрх зүйн үүднээс “бодит үнэн” гэдэг нь **тодорхой цаг, үе орон зайгаар хэмжигдэх тухайн нийгмийн харилцаагаар тодорхойлдог биет ойлголт**.

“Бодит үнэнийг тогтоох” зарчмын үйлчлэлтэй эрх зүйн салбарт Элбэгээ ерөнхийлөгчийн /байсан/ хугацаанд сүрхий **“тэмцсэн нь”** ажиглагддаг. Эрүүгийн процессын хуулийн тэр үеийн ээлжит нэгэн өөрчлөлтөөр уг

зарчмыг “мэтгэлцэх”-тэй зэрэгцүүлэн байршуулж хүчийг нь сулруулсан. Тэр тусмаа манайд уригдан ирсэн ХБНГУ-ын Мюнхений их сургуулийн эрх зүйн философич, кибернекийн онолын нэрт эрдэмтэн Б.Шюнемани гуайн “эрх зүйн аль ч бүлд **мэтгэлцэх, бодит үнэнийг тогтоох зарчмууд хамт үйлчилдэггүй юм шүү**” гэсэн зөвлөгөөнийг хүртэл хайхарч үзээгүй. Ер нь мэтгэлцэх зарчмын гол шинж, үйлчлэх хэлбэр нь яллах, өмгөөлөх талууд нотлох баримтаа тус тусдаа, бие даан цуглуулж, шийдвэрлүүлэх объектоо өөрсдөө тодорхойлж, улмаар хөндлөнгийн, хараат бус шүүх дээр “аваачиж” эн чацууран марган мэтгэлцэж **хар, цагаанаа ялгуулах** цогц ажиллагаа билээ. Манайд тэрхүү **мэтгэлцээний зүйл** нь хэрэг дээрээ яллах талын хүсэл, эрмэлзэлийн илэрхийлэл **прокурорын яллах дүгнэлтэнд тусгагдсан бүхий л материал**, тиймээс ч **шүүх хуралдааны хэмжээ хязгаар** хэрэг дээрээ прокурор, мөрдөгчийн хамтарч бэлтгэсэн **хавтаст хэргээр** тодорхойлогддог нь нууц биш. Эрүүгийн процессыг Англо-Саксоных болгож суурь үндсийг нь огцом өөрчлөөгүй юм бол эрүүгийн хэрэг мөрдөн шалгах ажиллагааг хуульчлагдсан эрх, үүрэг бүхий төрийн байгууллага, тухайлан нэрлэсэн этгээдүүд /шүүгч, прокурор, мөрдөгч/ хэрэгжүүлэхээс өөр арга зам одоохондоо алга. Ухаалаг төрөө дээдлэх онолч эндээс улбаатайг жичлэн тэмдэглэх нь зүйтэй биз. Гэтэл янз бүрийн санал, онол нэрийдлээр энэ эмзэг асуудлыг хоромын төдийд ч тайван орхидоггүй цөөн улсын нэг нь манайх.

Соросын /сангийн/ санхүүжилтээр 2010 онд “шүүх судлалын” хэсэг эрдэмтэд “Бодлогын судалгааны тойм” гэгдэх тухайн үеийн Ерөнхийлөгчид ихэд таалагдсан **бүтээл** гаргаж ээлжит компаниг ажлаа эхлүүлсэн. Анхаарал татахуйц, сонирхолтой үзэл баримтлал, практик хэрэглээний санал уг номд цөөнгүй байгааг үгүйсгэхгүй, эндээс бүгдийг биш заримыг нь дурьдвал: **Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн харилцаанд мэтгэлцэх зарчмыг заавалчгүй хэрэгжүүлэх шаардлагатай. Чингэх олон арга замын нэг нь яллагдагчийн гэрчид нотлох баримт цуглуулах эрх олгох нь зүйтэй хэмээснийг жичилж болох юм. Процесс ажиллагаанд “хөндлөнгийн шинжийг” агуулдагаараа бусад оролцогч** гэгдэх гэрчийн мэдүүлэг, хэрэгт ач холбогдолтой нь яриангүй үнэн, гэхдээ тэр нь яллах, өмгөөлөх талын үндсэн оролцогчдоос илүү үнэ цэнэтэй баталгаа, хамгаалалттай байх шаардлагатай эсэх нь ихээхэн эргэлзээтэй санагдана.

Ер нь ч нотлох баримт цуглуулна гэдэг нь байцаан шийтгэх ажиллагааг эрхэлж явуулна гэсэн үг. Өөрөөр хэлбэл, дээрх “шүүх судлаач”-дынхаар яллагдагчийн гэрч мөрдөн шалгах ажиллагаа явуулж мэдүүлэг авч, үзлэг, нэгжлэг хийж, шаардлага тулгарвал албадлага хэрэглэх эрх эдлэж таарахнээ. Элбэгдоржийн он жилүүдэд түүнд шадарласан хуульч эрхмүүд шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах нэрийдлээр энэ мэт сүр дуулиант ажил нэлээдгүй өрнүүлсэн билээ. Тухайлбал, Үндсэн

хуулиа үл тоомсорлон янз бүрийн шатны **тойргийн шүүх байгуулах, татан буулгах** зэргээр олон зуун саяын **хохирол улсад учруулсан "туршилт"** явуулсан. Шүүхийн мэргэжлийн удирдлагаар хангаж ирсэн уламжлалт хэлбэрийг хайхралгүй зарлага ихтэй, янз бүрийн "нэр цолтой" нүсэр аппаратаар сольж өөрчилсөөр байгаа нь шүүх эрх мэдлийн амин сүнс **шүүн таслах ажиллагаанд** ач тусаа өгөөгүйгээр үл барам мэргэжлийн удирдлагын үндсэн чиг үүргээс нь холдуулахад хүргэж байна.

Тэгвэл хар "ярликтай" МАХН-ын Төв хорооны 1984 оны 316 тогтоолд шил архи хувааж уусан хэргээр "зэмлэгдэж" байсан УДШ-ийхэн ардчилалын он жилүүдэд өрнөсөн шүүхийн шинэчлэлийн **"цогц арга хэмжээний"** үр дүнд авилга албан тушаалын гэмт хэрэгт холбогдож ёс суртахууны ноцтой зөрчил "үлгэрлэн" гаргах болсоныг юу гэж үзэх вэ? Ямар сайндаа хуулийн салбараас төрсөн анхны **академич маань хүртэл ийм Дээд шүүх хууль тайлбарлаж чадах уу** хэмээн эргэлзэж суухав дээ.

Гэхдээ зөвхөн ёс суртахууны шалгуураар монголын эрх зүйн амьдралыг тодорхойлоход ихээхэн учир дутагдалтай. Нэгэнт **"эерэг хромсоноор нь хуульч, шүүгчдийг шалгаруулах"** "өндөр" түвшинд хүрч амжаагүй өнөө үед **"генийн"** гэхээсээ **бие хүн болон хэрхэн төлөвшив** гэдгийг орчин нөхцөл, цаг хугацаатай нь уялдуулж нягтлах нь зүйтэй биз. /Энэ тухай Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: үзэл, баримтлал, уламжлал, сургамж, УБ

2019, 7-10 хуудаснаас дэлгэрүүлэн үзнэ үү./

Гэмт хэргийн үндсэн шинжийг тодорхойлох чадвартай **баримтат мэдээллийг** нотлох баримт гэж үзэх онол манай эрүүгийн процессын онол, практикт 2000 оны дунд үеэс давамгайлж эхэлсэн юм. Түүний эцсийн үр дүн нь өнөө үйлчилж буй **ЭХХШТ хуулийн 16.1 дүгээр зүйлийн 1 дэх заалт**. Бидний үзэж байгаагаар энэхүү томъёолол онол, арга зүйн хувьд алдаатай, практик хэрэглээнд сөрөг нөлөө үзүүлэх нигууртай болсон. Учир нь нотлох баримтаар гэмт үйл явдалтай холбоо бүхий **мэдээлэл, /онцлов/ төдийгүй материаллаг эд зүйл, аливаа мэдээ хүртэл тооцогдох үндэслэл бий**. Баримтат мэдээлэл гэдэг нь эцсийн дүндээ уг процесс ажиллагааг **эрхлэн явуулагчийн тархиндаа буулгасан тусгал-ойлголт, тиймээс ч субъектив шинжийг ямагт агуулдаг**. Тэгээд ч хавтаст хэргийг бүрдүүлэх эхлэл суурь гэгддэг мөрдөгчийн ой тоонд буусан анхны мэдээлэл ихэнх тохиолдолд нотлох баримт хэмээн үнэлэгдээд байдаг, тэр нь процессийн дараа дараачийн үе шатыг эрхлэн хэрэгжүүлэгч субъектүүдэд өөрийгөө "тулган зөвшөөрүүлэх" хүчин чадлаа хадгалсаар байдаг өнөөгийн практикийг анхаарахгүй орхиж боломгүй.

Шинэ хуулиар эрүүгийн хэргээс бусад зөрчил, маргааныг хянан шийдвэрлэхэд болон мэргэжлийн байгууллагын хяналт шалгалтын явцад хуульд заасан үндэслэл журмын дагуу цуглуулж бэхжүүлсэн мэдээлэл хүртэл нотлох баримтад тооцогдохоор болсон. Ингэсэн

тохиолдолд: **ямар хуулийн, аль заалт, хэний, хэзээ эрхлэн явуулсан ажиллагаа, эрүүгийн хэргийн нотлох баримт болох ёстой юм бэ?** гэсэн зүй ёсны асуулт тавигдаж хариулт шаардаж таарна.

Нотлох баримт мөн хэмээхэд нэн тэргүүнд байх **хамаарал, агуулгаас гадна "болохуйц"** байдлын буюу **хэлбэрийн шинжийг** тодорхойлсоор ирсэн (тухайлбал, нотлох баримтыг зөвхөн эрх бүхий этгээд л цуглуулж шалгах аас гадна процессийн шийдэл гаргах үнэлгээ өгнө. Нотлох баримт цуглуулахдаа зөвхөн Эрүүгийн процессийн хуульд заасан журмыг баримтлана г.м) **уламжлалт онол, арга зүйг** эс хайхарч үл болно. Ром-Германы эрх зүйн бүлийн процесс ажиллагааны нотлох баримт, нотолгооны тухай ойлголтыг элдэв шинэ агуулгаар ингэж "баяжуулан" сарниулаад байгаа учир нь юундаа байна?

Түүнчлэн Эрүүгийн процессын хуулийн 48 дугаар бүлэгт зааснаар ... "гадаад улсаас ирүүлсэн баримтат мэдээллийг" **нотлох баримтад тооцож** болох юм байна. Гэтэл Жастын Батхүүгийн гэгдэх эрүүгийн хэргийг саяхан шийдвэрлэхдээ олон улсын нэр хүндтэй арбитрын шүүхийн шийдвэрт тухайлан тэмдэглэж тулгуур хэмээн үзсэн нотлох баримтыг манайхан **огтхон ч хайхарсангүй**. Монголын төрийн өмчит томоохон компани, түүний удирдлага батлан даалт гарган өгч гадаадын банкнаас зээл авах боломж Батхүүд олгоод байсан нь үнэн. Гэтэл манай шүүх бүх шатандаа **"ганцаараа тоо томшгүй олон хуурамч тамга тэмдэг, гарын**

үсэг үйлдэж ноцтой гэмт өдүүлсэн" гэж хүлээн зөвшөөрсөн яллагдагчийн **"нүцгэн" мэдүүлэг**, түүнийг тойрсон **"гэнэн" баримтуудад** тулгуурлан Батхүүг **"сугалан авч" гэм буруутай** хэмээн шийтгэсэн бөгөөд чингэхдээ, дэлхийд нэр хүндтэй арбитрын шүүхийн шийдвэр, нотолгоог огт хайхарсангүй.

Ер нь баталгаатай зээл өгч, авч сурсан асар их туршлагатай банк "хүүхэд шиг гэнэн" яриат Батхүүгийн гарын үсэг, тамга тэмдгүүдэд хууртаж 100 сая давсан долларын зээл олгох уу? Тэгвэл хувь хүний /компанийн ч бай/ **зээлсэн мөнгө улсын үйлдвэрийн нэр бүхий дансаар орж, гараад байдаг** учир нь юундаа байна вэ?

Эндээс: Нотлох баримтын эх сурвалжийг илүү тодорхой болгох, тухайлбал, **мэргэжлийн** гэсэн тодотголтой авч **эрүүгийн процесс ажиллагаа эрхлэн явуулдаггүй байгууллагуудын цуглуулсан мэдээ, баримтыг нотолгоонд** шууд ашиглаж болдог, тэгсэн атлаа эрүүгийн хэрэг илрүүлэх хуульчлагдсан үүрэг бүхий **эрэн сурвалжлах албадын олж тогтоосон баримт мэдээллийг** нотолгоонд тооцох эсэх нь тодорхойгүй байгааг хууль зүйн үндэслэлтэй, үнэмшилтэй болгон зохицуулах шаардлагатай гэдгийг онцолмоор байна.

Түүнчлэн хэрэгт ач холбогдол бүхий бүхий л баримт, мэдээ, мэдээллийг шүүхийн өмнөх шатанд зөвхөн **мөрдөгч, прокурор хоёр нягтлан үзэж хэлбэршүүлдэг үүрэг хүлээх**, өөрөөр хэлбэл, нотлох баримт хэмээн тооцох **хэлбэрийн шалгуурыг**

заавалчгүй баримтлах, түүнчлэн нотлох ажиллагаанд эрүүгийн процессын зарчмуудыг хэрхэн удирдлага болгосон талаар прокурорын дүгнэлт, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгээс гарах шийдвэрт заавалчгүй, товчхон ч атугай тусгаж байх нь зүйтэй байна. /үргэлжлэл бий/

ХҮНИЙ ХАЛДАШГҮЙ ЭРХИЙН ХАМГААЛАЛТ

Ц.ӨНӨРЖАРГАЛ

(Шихихутуг их сургуулийн магистрант)

1. Хүний халдашгүй эрх гэж өөрийнх нь төрөлх жам ёсны хэрэгцээнээс үүдэлтэй, мөн чанарын хувьд төрөөс тогтоосон биш зөвшөөрсөн бөгөөд эрх зүйн хэм хэмжээгээр бэхжигдэж хамгаалагдсан ямар ч тохиолдолд хөндлөнгийн хэн ч дур мэдэн хөндөж хязгаарлаж болохгүй хэд хэдэн туйлын эрхийн тухай цогц ойлголт юм. Уг эрх нь:

- чөлөөтэй байх эрх
- бие эрхтний халдашгүй эрх
- орон байр халдашгүй эрх
- нууцын халдашгүй эрх
- нэр төрийн халдашгүй эрх
- өмчийн халдашгүй эрх гэсэн элементүүдээс бүрдэнэ.

Эдгээр эрхүүд нь ямар ч тохиолдолд нөгөөгөө зайлшгүй байдлаар нөхцөлдүүлж хүний хувийн эрхийн цөм болж байдаг юм.. Чөлөөтэй байх эрх нь бусдын эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол болон нийгмийн дэг журмыг зөрчихгүй, ямар нэг дарамт шахалт, хязгаарлалтгүйгээр өөрийн хүсэл зоригийн дагуу эрхээ эдэлж орших боломж мөн.

Иргэний халдашгүй чөлөөтэй байх эрхийн хамгийн гол баталгаа нь төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны зүгээс хуулийн үндэслэл, нотолгоогүйгээр баривчлахгүй, хорихгүй, эрх, эрх чөлөөг нь хязгаарлахгүй байх явдал юм.

Энэ талаар Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомж тухайлбал,

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Цагдаагийн байгууллагын тухай хууль, Сэжигтэн, яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль, Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хууль, Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуулиудад зааж өгсний зэрэгцээ зарим нэг төрөлжсөн хуульд тодорхой гэмт үйлдэл, захиргааны зөрчилд сэжиглэгдсэн, холбогдсон иргэнийг албадан ирүүлэх, албадан саатуулах, баривчлах, цагдан хорих, орон байр болон биед нь үзлэг, нэгжлэг хийх үндэслэл журмыг хуульчилж өгсөн байна.

2. Халдашгүй байх эрх нь жам ёсны улбаатай болохыг дээр тухайлан дурдсан. Эрдэмтэн мэргэд тэрхүү ойлголтыг онол, арга зүйн үүднээс авч үзэхдээ Үндсэн хуулийн эрх зүйн хүрээнд "туйлын" шинжийг голцуу тодорхойлдог. Туйлын гэдэг учир нь хүний байгалийн болоод нийгмийн хослол бүтээгдэхүүн болох мөн чанараас эхнийхийг илүүд үздэг үзэл онолоос үүдэлтэй.

Гэхдээ олон зууны турш шалгагдаж бодгаль хүний хамгийн нандин, хөндлөнгөөс эс хамаарах шинжийг илэрхийлж чадсанаар халдашгүй байх эрх нь аливаа улс орны тулгуур хуулинд

заавалчгүй тунхаглагдсан байхаас гадна Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Улс төр, эдийн засаг, эрхийн пакт зэрэг нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын баримт бичгүүдэд тусгалаа олсон байдаг юм.

З. Халдашгүй эрх, түүний төрлүүд манайд хэр баталгаатай байна вэ? Манайд эрх зүйн амьдралыг бохир улс төр, түүний механизм болсон эрх мэдэл хүний халдашгүй эрх чөлөөт байх эрхийг хүссэн үедээ уландаа гишгэж байна.

Тухайлбал, эрх мэдэлтнүүд өөрт ашигтай, аль эсхүл оноо очков авахын тулд хэрэг маргаан шийдвэрлэх шүүгч, прокуроруудыг элдэв хорон аргаар занганд оруулж дарамтлах явдал эрч хүчээ сүрхий авч байна. Түүний золиос өгөөш нь Монгол бүсгүйчүүд болж буйд харамсах юм.

Х.Тэмүүжинг гутаах, Хууль зүйн сайдаас нь буулгахын тулд цагдаа нар Г.Сарангэрэл гэх бүсгүйгээр тоглосон. "Энхбаярыг ялласан" гэж хамсаатан Ж гэгч тавьтаргүй этгээд "гүйцэтгэх ажил" гардан зохион байгуулж хорсолоо тайлж жирийн сайхан эмэгтэйг ахмад прокурор Сагсайтай гудамжинд гарган золиослож нэр төрийг нь гутаасан.

Тэгвэл сая Монголын цагдаа гурван шүүгчийг буруутгахын тулд Дори болон

бусад бүсгүйчүүдийг золигт гаргалаа. Тэдний ард гэр бүл, аав ээж, үр хүүхэд нь бий. Манай гүйцэтгэх албаныхны ямар ч хүнийг шившиглэх хамгийн бүдүүлэг бөгөөд хамгийн амархан арга бол гэр бүлээс нь гадуур залуу бүсгүйчүүдийг өгөөшинд хаях явдал. Өнөөдөр тэдгээр охид хүүхнүүд золиосонд явах ёстой муу муухай хүмүүс байсан гэж бүхий л байдлаараа илэрхийлж, ойлгуулах гэж цагдаагийн зарим ажилтнууд хичээж байна.

Бид ч дагаад тэднийг шившиглэж "Одооны охид ийм болчихсон юм" гэгцгээн ам уралдан муулж байна. Эрх баригчдын албан тушаалын төлөө, тэднийг цагаатган цайруулахын тулд хэн нь ч хамаагүй ингэж эмэгтэй хүн гэдэг эрхэм нандин нэрээ гутлын хатуу уланд дэвсүүлж байх ёстой гэж үү.

Энэ мэт хүний халдашгүй байх эрхийг юу ч биш болгох өнөөгийн амьдралын тохиолдол бодит жишээ бүрийг тусгайлан авч үзэн, эрх мэдэлтэй чиг үүрэг бүхий шүүх, прокурор төдийгүй Хүний эрхийн үндэсний комисс, олон нийтийн хэдэн арван байгууллагууд **уриа лозунгаасаа салж халдашгүй эрхийг бодитойгоор хамгаалан тэмцэх нь зүйтэй** хэмээн үзэж байна.

ҮЗЭЛ БОДЛОО ЧӨЛӨӨТЭЙ ИЛЭРХИЙЛЭХ, ТӨР, ИРГЭДИЙН ХООРОНДЫН ХАРИЛЦАН ХАМААРЛЫГ ТУХАЙЛАН АВЧ ҮЗЭХ НЬ

Б.ЖИГДЭН

(Шихихутуг их сургуулийн магистрант)

Хүний эрх нь төрсөн цагаас эхлэн хүн бүрт хуульчлан хамгаалагдсан эсэхээс үл хамааран жам ёсны агуулгыг илэрхийлэн тэгшээр үйлчлэх учиртай. Тиймээс ч “хувь хүнийг нэр төртэй, өөр хоорондоо харилцах ёс суртахууны эрхэм шинжтэй, оюунлаг бодьгал” болохыг бүрнээ харуулдаг. Тэрхүү нийтлэг мөн чанараас нь улбаалж хүний эрхийн тухай өнөөгийн ойлголтыг анх томьёолсон юм. Хүний эрх нь нийтлэг шинжийг ямагт илэрхийлж хэн болох, хаана амьдарч байгаагаас үл шалтгаалан хүн бүрийн заавалгүй эрхэм шинжийн илэрхийлэл. “Хүний эрх”-ийн талаар хэрхэн ойлгож буйг тухайлан асуухад ихэнх хүмүүс зөвхөн “үзэл бодолоо чөлөөтэй илэрхийлэх”, “тайван замаар жагсах цуглах” гэх мэт цөөн хэдийг нэрлэдэг. Энгийн нэгэн иргэн ч бай улс төрийн зүтгэлтэн хэн боловч ямар ч хорио саадгүйгээр өөрийн үзэл бодолтой, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх боломж нөхцөлөөр хангагдсан байх учиртай. Энэхүү эрх нь хүний бусад эрхийг хэрэгжүүлэх гол нөхцөл төдийгүй ардчилсан нийгмийн үндэс суурьд зүй ёсоор тооцогддог. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлнэ гэдэг нь хүн өөрийгөө хүндэтгэх, өөрийгөө хөгжүүлэх, нийгэмд эзлэх байр суурьтай байх чухал нөхцөл юм.

Хувь хүний тухайд үзэл бодол,

мэдээллээ бусадтай чөлөөтэй хуваалцах нь хүмүүний ертөнц, орчин тойрноо танин мэдэхэд тусалдаг төдийгүй төр засгаа, улс нийгмээ хүндэтгэж буй чухал хэлбэр юм. Хүн бүр ямар ч хорио саадгүйгээр өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх нь төрийн хувьд шударга, зөв удирдлагыг тогтоох, улмаар эдийн засгийн болон нийгмийн дэвшил хөгжилд хөтлөх боломжийг нэмэгдүүлнэ. Энэ эрх нь төрийг удирдах ажилд шударга, нэр хүндтэй хүмүүсийг татан оролцуулах, иргэдийн зүгээс тулгамдсан асуудлуудаа зоригтой гаргаж тавих, аливаа шинэ хууль бүтээхэд идэвхитэй оролцох боломж бүрдүүлэх чингэхдээ түүний хэрэгжилтэнд бодитойгоор нөлөөлж, бусад эрхүүдийг хангах үндэс суурь болж өгнө.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19-р зүйлд “Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана” гэж заасныг тухайлан авч үзвэл: Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх нь хүн бүрт хамаатай бөгөөд боловсролын түвшин, арьс өнгө, яс үндэс, хүйс, шашин шүтлэг, хэл, улс төрийн болон

бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн буюу бусад байдлаар ялгаварлахгүй байхыг илэрхийлнэ.

Хүн төрөлхтний нийтлэг ач холбогдолтой "Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх ба тэгш эрхийн Кемдений зарчим"-ыг (XIX ARTICLE 19 Global campaign for free expression) тунхаглан баталсанаар улс орнууд, байгууллага, хувь хүмүүсийг хүний эрхийг дээдэлж, энэхүү баримт бичигт тусгагдсан зарчмуудыг үйл ажиллагаандаа баримтлах учиртайг уриалж буй хэлбэр юм. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бусдад түгээх аргын нэг нь интернет орчин болоод байна. Дэлхийг хэрсэн "аалзны шүлс" буюу интернэт хэрэглээ нь хэвлэл мэдээллийн бусад хэрэгслийг бодвол компьютертэй, сүлжээнд холбогдсон хэн боловч энэ орчинд өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хүссэн мэдээллээ, аль ч газраас саадгүй хүлээн авах, ямар ч улсын иргэнтэй харилцаа холбоо тогтоох боломжийг бүрдүүлж өгсөн. Мөн интернэт нь хүн бүрт аливаа мэдээлэл, оюуны өмчийн болон урлагийн бүтээлийг бий болгох, түгээх нөхцлийг хангадаг. Өргөн тархсан, өндөр хурдтай хөгжиж буй цахим ертөнцийн хэрэглээг улс орнууд ашиглан өөрийн болгох, хянах оролдлого хийсээр байна. Цахим орчинд сайны хажуугаар саар үйлүүд олон байдагтай адил ёс суртахуунд үл нийцэх сөрөг үзэгдлүүд цөөнгүй цацагддаг. Улс орнуудад тодорхой

агуулга бүхий мэдээллийг интернетэд байршуулах, түгээхийг хориглосон хууль гаргаж зөрчиж буй түгээгч, хэрэглэгч нарт хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох гэж хичээж байна

Монгол улсын хувьд хүний эрхийг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг нь сэргээх, хохирлыг арилгах тогтолцоог бий болгох эрх зүйн бат бэх үндэс бүрэлдэхүүнийг эрмэлзсээр байна. Ер нь хүний эрхийг хангах, хүний эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн баталгааг бий болгох алхмуудыг тодорхой зорилго чиглэлтэй, нийгмийн амьдралд ахиц дэвшил гаргах үүднээс хийж байх ёстой. Ялангуяа хялбаршуулах (үйлчилгээний хүртээмжийг амар хялбар болгох), хөхүүлэн дэмжих (мэдээлэх), хэрэгжүүлэх (эмзэг бүлгийг эн тэргүүнд анхаарч, тэгш байдлыг бүрдүүлэхэд чиглэх) арга хэмжээг байнга хэрэгжүүлэх нь чухал. Жишээлбэл, төрөл бүрийн үйлчилгээг нэгтгэсэн нэг цонхны үйлчилгээ, хүүхдийн тэрэг түрсэн, тэргэнцэртэй, эсвэл ахмад настай хүн, хүүхэд хүртэл явах боломжтой налуу зам тавих, төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн үйлчилгээ үзүүлдэг дүүрэг, аймгийн төвүүд дэх "Эрх зүйн туслалцааны төв"-үүдийг энд нэрлэж болно.

Жишээлбэл, сурч боловсрох эрхийн асуудал дээр төрийн үүргийг харьцуулж харуулахад.

Хүндэтгэх	Хамгаалах	Хангах
Хангах Сургуульд сурч байгаа хүүхдүүдийг сургуулиас завсардуулахгүй, сургуулийн орчин, үзэж байгаа хичээлийг дордуулахгүй байх	Балш хүүхдийг ялгаварлан гадуурхах, зодож шийтгэх, төрөл бүрийн мөнгө, хураамж авахыг хориглож, ийм үйлдэл гаргасан бол хуулийн дагуу хариуцлага тооцдог байх	Бүх хүүхэд суурь боловсролыг үнэ төлбөргүй, заавал эзэмшихээр хуульдаа заасан байх.

Хүний эрхийг хангаж хамгаалах үүрэг хариуцлага хүлээх үүднээс төр нь иргэнийхээ эрх, эрх чөлөөний хэрэгжилтэнд байнга анхаарах ёстой. Энэ нь Монгол Улс Үндсэн хуулиараа хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулж, түүнийг хэрэгжүүлэх эдийн засаг, нийгэм, хууль зүйн баталгааг бүрдүүлэхийн хүрээнд илэрнэ. Нэмэлт өөрчлөлт орсон Үндсэн хуулийн маань "Хүний эрх, эрх чөлөө" гэсэн хоёрдугаар бүлэгт 80 орчим тусгайлан нэрлэсэн заалт бий. Үндсэн хуулийн оршил хэсгээс бусад бүлгүүдэд хүний эрхтэй холбогдолтой олон зүйл заалтуудыг тусгажээ. Хүний эрхийн олон улсын суурь баримт бичиг болох Хүний эрхийн Биллд тусгагдсан, үндсэн эрхүүдийг манай улсын Үндсэн хуульд бүрэн хэмжээгээр хамруулж чадсан гэж судлаачид үзсэн байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлд "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" хэмээсэн нь хүний эрхийг хангах гол баталгаа яах аргагүй мөн.

2003 оноос эхлэн Хүний эрхийн үндэсний хөтөлбөрийг батлаж түүнд удаа дараа нэмэлт өөрчлөлт оруулж мөрдөн хэрэгжүүлж байна.

Хүн бүрийн эдлэх ёстой эрхүүдийг баталгаажуулж, төрийн хүлээх үүргийг нарийвчлан зааж өгсөнөөрөө, эрх зүйн баталгааг өргөтгөн, зохистой механизмыг бүрдүүлэх зэрэг нэлээдгүй ажил хийгдсэн гэх үндэслэлтэй юм.

"...Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ."

Тухайлбал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 2 дугаар зүйлийн 1-т заасны дагуу "Энэхүү Пактад оролцогч улс бүр нутаг дэвсгэртээ болон харьяалалдаа байгаа бүх хүний энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг яс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн буюу бусад байдлаар ялгаварлахгүйгээр хүндэтгэн хангах үүрэгтэй." Жишээлбэл, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, шашин шүтэх, эс шүтэх зэрэг хууль тогтоомжоор баталгаажуулан шууд хэрэгжүүлдэг эрх, эрх чөлөө бий.

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 2 дугаар зүйлийн 1-д заасны дагуу "Энэхүү Пактад оролцогч улс бүр дангаараа



болон олон улсын тусламж, хамтын ажиллагаагаар, тухайлбал эдийн засаг, техникийн салбарт, энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн байдлыг бүрдүүлэхэд чиглэх) арга хэмжээг авч байх учиртай.

Харин сурч боловсрох, эрүүл мэндээ хамгаалуулах, нийгмийн хамгаалал хүртэх эрх зэрэг эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хэрэгжүүлэх нь төрийн үйл ажиллагаа, эдийн засаг, нийгмийн хөгжил, бусад нөөц бололцооноос шууд хамаардаг. Тиймээс дээрх баримт бичигт заасан үүргийг авч үзвэл:

А) “Дэвшилттэйгээр хангах” гэдэгт эдийн засаг, нийгэм, соёлын бүхий л эрхийг богино хугацаанд бүрэн хэрэгжүүлэх боломжгүй болохыг хүлээн зөвшөөрч, эрхүүдийг хүндэтгэн хангах арга хэмжээг нэн даруй авч аажим аажмаар хангахыг ойлгоно.

В) “Бүх боломжийнхоо хэрээр” гэдэгт улсуудын эдийн засаг, санхүүгийн бололцоо, бусад нөөц харилцан адилгүй тул тодорхой цаг хугацааны дараа эрхүүдийг бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай.

С) “Зохистой арга хэмжээг авах” гэдэгт оролцогч улсууд энэ Пактад нэгдэн орсны дараа богино хугацаанд авч хэрэгжүүлэх зорилгод чиглэсэн алхам хийнэ гэсэн үг. Эрх бүртэй холбоотой нөхцлийг харгалзан тэдгээрт тохирсон зохистой арга хэмжээг өөрсдөө авч хэрэгжүүлэх ёстой.

Төрийн үйлчилгээ ямар байх ёстой вэ?

Төрийн зүгээс дээрх эрхүүдийг хэрэгжүүлэхдээ нөөц, чадавх, боломж

бололцоог хангасан байхын зэрэгцээ эрхүүдийн мөн чанарыг сайтар анхаарч, үзүүлэх үйлчилгээгээ хүний эрхийн тодорхой зарчимд нийцүүлэх шаардлагатай. Энэ нь дараах зарчмуудаар илэрлээ олно:

Хүрэлцээтэй байх: Төрийн үйлчилгээг хэрхэн үзүүлэх талаар хуульчлаад зогсохгүй тухайн байгууллагын барилга байгууламж, тоног төхөөрөмж, ширээ сандал, ариун цэврийн өрөө, ундны цэвэр ус, мэргэжлийн боловсон хүчин, тэдний боломжийн цалин хөлс зэрэг асуудлыг шийдсэн байна.

Хүртээмжтэй байх: Ямар нэгэн ялгаварлан гадуурхалтгүйгээр үйлчлэх, аливаа нэгэн үйл ажиллагаанд хүн бүр оролцох тэгш боломжоор хангагдсан эсэхээр хэмжигддэг.

Хүлээн зөвшөөрөгдсөн байх: Төрийн зүгээс шаардлагатай дүрэм журмыг ойлгомжтой байдлаар тогтоох, иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн байх, төрийн үйлчилгээ авах боломжийг орчны болон мэдээллийн түвшинд бүрдүүлсэн байх зэрэг асуудлыг хамарна.

Цаг үетэйгээ зохицсон байх: Төрийн бодлого, үйлчилгээ нь нийгмийн өөрчлөлт, хөдөлгөөнд таарч зохицсон байна. Эмзэг бүлгийн хувьд тэдний хэрэгцээнд нийцсэн байхаас гадна тухайн үйлчилгээгээр дамжин бусад эрхүүдийг нь дэмжих учиртай.

Эндээс хэрэв Төр үүргээ биелүүлж чадахгүй бол яах вэ? гэсэн асуудал бидний өмнө тулгарч таарна. Иргэд төрийн холбогдох байгууллага, удирдлагатай хариуцлага тооцохыг

шаардах, зөрчигдсөн эрхээ сэргээх, учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхийг хуульчлан баталгаажуулсан. Холбогдох байгууллага гэдэгт тухайн албан хаагч, эсвэл байгууллагын дээд шатны удирдах эрх бүхий этгээд, мөн иргэний болон захиргааны хэргийн шүүх, Хүний эрхийн Үндэсний Комисс, Үндсэн хуулийн цэцэд хүртэл хүсэлт, гомдлоо гаргах шийдвэрлүүлэх зэрэг болно.

Дүгнэхэд, практик туршлага байсан ч хүний эрхийн идэвхтнүүд эрх зүйн болон улс төрийн чиглэлийн эрдэмтэн, судлаачдын дунд хүний эрхийн ойлголтоос үүсч байгаа орчин цагийн ярвигтай асуудлыг шийдвэрлэхэд байнга анхаарах шаардлага тулгардаг. Ямар ч хууль, процессын эргэлзээтэй

зохицуулалт хүртэл утга учраа заавалчгүй нээж зэрэгээр үйлчлэх ёстой. Мөн түүнчлэн хүний эрхийн үзэл санааны ойлголт нь хүний эрхийн идэвхтнүүдийг хөдөлгөж байгаа учир шалтгаан болон нийгмийн сайшаал, хяналт үнэлгээ, эсэргүүцэл, мөн хууль тогтоомж зэрэг тэдний авч хэрэгжүүлж буй практик ажиллагааны цар хүрээ, үр өгөөжийг авч үзсэнээр мэдэгдэхүйц ашиг тус авч болно. Бодит амьдралд үзэл баримтлалын тодорхой байдал чухал төдийгүй мөн арвин баялаг туршлага хүний эрхийн үзэл санаа, хүртээмжийг ойлгоход шийдвэрлэх учир холбогдолтой нь ойлгомжтой. Энэ чиглэлээр онол, практик хоёрын хоорондох тэнцвэртэй байдалд тийм ч их зөрүү байхгүй гэх үндэслэл бий.

МАНЖИЙН ЭНХ-АМГАЛАН ХААН БА МОНГОЛ ОРОН

Г.ДӨЛГӨӨН

(Шихихутуг их сургуулийн магистрант)

Монголчуудын дунд Энх-Амгалан гэж алдаршсан Манж Дайчин гүрний төрийг 61 жил (1662-1722) барьсан Канси хаан Ар монголыг эзлэн авах талаар онцгой бодлого явуулсныг "Энх-Амгалан хааны бодлогын бичиг" хэмээх 220 дэвтэрт тэмдэглэн үлдээжээ. Тэдгээрийг нягтлан үзвэл Энх-Амгалан хаанаас монголын талаар явуулсан бодлогыг 3 үе шатанд хувааж болох юм. I үе нь 1670 оноос 1691 он буюу Халх монголын эрхшээлдээ оруулах хүртэл цаг хугацааг хамаарна. II үе нь Ойрад-Монголын төрийн тэргүүн Галдан бошогтын эсрэг хийсэн тэмцэл буюу 1691-1700 оны үе юм. III үе нь 1700-1761 оныг хамарч Ойрад-Монголыг эзлэн авч Монгол улс хэмээх нэрийг бүрэн устгасан хэрэг явдалд хамаарна.

ХҮII зууны дундуур Монголын тусгаар тогтнолын төлөө тууштай тэмцэж явсан Түшээт хан Гомбодорж (1695), Сэцэн хан Шолой (1652), Зүүн гарын хаант улсын тэргүүн Баатар хунтайж (1657) нар бараг нэгэн зэрэг нас барж Монголын төрийн толгойд шинэ ноёд гарч ирснийг далимдуулан тэдний дунд яс хаяж хямралдуулах бодлогыг Манжийн эзэн хааны зарлигаар боловсруулжээ. Энх-Амгалан хааны бодлого нь дотроо хэд хэдэн үе шаттай олон салаа салбартай, маш нарийн бодож боловсруулсан, олон хувилбар бүхий аргатай байжээ. Энэ нь нэгдүгээрт 1570

оноос бий болсон Засагт ханы ширээний төлөө тэмцлийг ашиглан тэнд өөрийн талын хүнийг тавьж Түшээт ханы эсрэг хандуулан Халх-Монголыг дотор нь хямралдуулах, хоёрдугаарт, Түшээт хан Чинхундоржийг өөртөө татаж Ойрод-Монголын эсрэг хүчин болгон ашиглах, гуравдугаарт, Халх Ойрад хоёрыг хооронд нь эвдрэлцүүлж далимдуулан монгол орныг эрхшээлдээ оруулах, дөрөвдүгээрт Түвдийн далай ламыг ашиглан галданбошигтод нөлөөлж түүний тэмцлийг сааруулах, тавдугаарт монгол орныг хөрш зэргэлдээ улсуудаас хөндийрүүлж өөрийн хараа хяналтад байлгах зэрэг улс төрийн бодлогыг агуулсан байв.

Монголын ноёдын эв нэгдэлгүй, эрх мэдлийн төлөө хоорондын тэмцэл Манжийн хааны эзлэн түрэмгийлэх бодлогын бай болжээ.

Энх-амгалан хааны бодлогын 1 үе нь Халх-монголыг эрхшээлдээ оруулан авах санаагаа хэрэгжүүлэх арга нь, манжийн гүнжийг монгол ноёдод бэлэг болгон өгч худ ураг болох, тэдэнд өндөр цол хэргэм олгох, бэлэг сэлт өгөх, тагнуул туршуул хутган үймүүлэгч нарыг монгол ноёдын дэргэд сэм шургуулан суулгах, дотоод хэрэгт нь оролцож зааж зааварлах, худалдаа эдийн засгийн дарамт үзүүлэх, шарын шашныг ашиглах зэрэг олон хэлбэртэй байжээ.

I

Энх-Амгалан бодлогоо хэрэгжүүлэх анхны алхмын аян шалтаг нь 1670 оноос эхэлсэн Засаг ханы ширээний төлөө тэмцэл байв. Засаг хан Норов нас барсны дараа түүний хөвгүүд: Цуумэргэн, Ванчиг, Цэнгүүн, Шар нарын хооронд хан ширээний тэмцэл өрнөж нэг хэсэг нь албат иргэдтэй Түшээт ханы нутагт нүүн оджээ. Нөгөө тал нь Галданбошигтоос тусламж эрсэн байна. Энх-Амгалангийн зарлигаар Засагт ханы ширээнд дунд хүү Цэнгүүнийг суулгаж Халх Ойрадын дунд энэ аймгийн ноёдод манж нар элдвээр нөлөөлөх болжээ. Цэнгүүн Түшээт ханы нутагт нүүн одсон албат иргэдээ эргүүлэн авах гэсэг боловч Чихундорж өгсөнгүй. Засаг хан аймагтай нутаг залгаа бас эртний ургийн холбоотой учир галдан нь Цуу мэргэн, Шар нарыг дэмжиж байв. Засагт хан аймгийн дотоодын самуун нь Халхын баруун зүүн гарын хямрал болж 20 гаруй жил үргэлжлэн улмаар Халхын ноёдын хооронд дайн дэгдээхэд хүргэжээ. Эл байдлын улмаас Энх-Амгалангийн санаачилгаар 1686 онд Заг-Байдрагийн Хүүрэн бэлчирт Халхын ноёдын чуулган хийж түүнд манж сайд Арнай, Түвдийн далай ламын элч Галданбошогтын дүү Дорлигжав Жоно нар оролцжээ. Ингэж нэг аймгийн дотоодын асуудал олон улсын шинжтэй болж манж нар түүнд ивээн тэтгэгчээр хөндлөнгөөс оролцох шалтаг олж авчээ.

Энэ чуулган дээр Халхын нөлөө бүхий ноёдын хэргэм, өндөр цалин пүнлүү олгох Энх-Амгалан хааны зарилгийг уншин сонгосон нь тэднийг өөртөө татаж ойрадын эсрэг чиглүүлэх гэсэн

санааг агуулжээ.

Хүрэн бэлчрийн чуулган Манжийн төрийн хяналт заавраар хийгдэж үндсэндээ 1640 оны Халх-Ойрадын чуулганы шийдвэрийг сэм хүчингүй болгож халх ойрад хоёрын холбоог бүр мөсөн тасалж халхын ноёдын хямралыг манжид ашигтайгаар түр намжаах алхам хийхэд чиглэжээ. Тус чуулганаар Засагт хааны албат иргэдийг буцааж өгөхөөр тогтоосон боловч Түшээт хан Чихундорж биелүүлсэнгүй. Түүгээр ч зогсохгүй Чихундорж Галданг дэмжсэн Засагт ханы ноёдыг цохихоор түмэн цэрэг захиран 1687 онд мордож засагт хан Шар болон түүний нөлөө бүхий ноёдыг барин алж улмаар Ховд, Улаангомын газар байсан Галданбошогтын цэргийн тариалсан, хүн малыг тонон дээрэмдэв. Чихундорж өөрийн хүргэн Хөх нуурын Лувсангомборавдан тайжтай хамтран ойрадын нутгийн гунд давшин орсныг Энх-Амгалан дуулаад яаравчлан элч зарж эргүүлэн авч иржээ. Энэ нь хэвээ Чихундорж Галданг ялбал халх-монголын хүчин өсөж манжийн бодлогоор харшлах учир ийнхүү дайны ажиллагааг зогсоожээ.

1688 онд Галданбошогт 3 түмэн цэрэгтэйгээр халхад довтлоход Чихундорж манжийн хаанд илгээлт явуулж ““Одоо миний бие цэргийг тэгшлэн авч Галдан лугаа эрэгчин эмэгчнийг ялгамуй. Хэрэв дарагдахаас болзвоос болохгүйн тулд их хаан өршөөж цэрэг туслахыг түмэнтээ хүсмүй” гэсэн боловч Энх-Амгалан тусалсангүй. Чихундорж ялагдаж Өндөр гэгээний хамт Өвөрмонголын нутагт албат иргэдээ дагуулан зугатан очиход

найрсгаар угтан авч нутаг бэлчээр олгож суулгасан байна. Гэвч хэрэг дээрээ энэ газар ус нь угаасаа Монголчуудын нутаг байсан юм. 1688 оны намар Сенедийн Ар-элстэйд болсон халхын ноёдын чуулганаас Манжид дагаар орох "Бодрол бичиг" өргөсөн ажээ. Манж нар Халхын хүчин дайнд суларч нутаг бэлчээрээр гачигдахыг далимдуулан монгол ноёдод хээл хахууль цутгаж өөртөө татах бодлого явуулжээ. Халхын тайж нараас 400-аас дээш өрх дагуулан ирвээс тэргүүн зэрэг, 300 өрхөөс доош бол дэд зэрэг, 200 өрхөөс доош бол гутгаар, 100 өрхөд эс хүрвээс дөтгөөр зэрэг тайж болгомой гэж Энх-Амгалан зарлиг буулгажээ.

1691 оны Ү сарын 2-нд Долоон нуурын газар Энх-Амгалан хаан сүр бараатай хүрэлцэн ирж Халхын 550 ноёд тайж нарыг цуглуулан Халх-монголыг манжид дагаар оруулах ёслол үйлдэв. Энэ ёслол дээр уншин сонгосон түүний зарлигт халах-ойрадын дайнд "халхчууд ихэд хэлмэгдсэн тул ивээлдээ авч өөд тэнхрүүлэхээр завдан буй" гэж дурджээ. Манжид дагаар орох явдлыг тэргүүлсэн халхын 35 ноёнд нэр заан хэргэм зэрэг олгож хошууны засаг болгож мөнгө магнаг торго бүс хувцасны зүйл шагнажээ. Энх-Амгалангийн зарилгаар халхын 7 хошуу 34 болгон жижиглэн халх нутагд манжийн хууль журам үйлчилхээр тогтоосон байна. Ийнхүү Энх-Амгалан хааны бодлого ийнхүү шувтарч Халх-монгол Манж гүрний колон болов.

II

Энх-Амгалан хааны бодлогын II үе нь Галданбошогтыг халхын нутгаас хөөн гаргаж улмаар Зүүн гарын хаант улсыг эзлэн авах явдал байв. Энэ үед Галдангийн мэдэлд Ил, Тарвагатайгаас Хянганы нуруу хүртэлх нутаг байсан ажээ. Галданг цохихын тулд Нэрчү хотноо хаант Оростой хилийн гэрээ байгуулж түүний Оросоос тусламж авах замыг хаах, Хөх нуурын газарт Манжийн цэргийн бэхлэлт байгуулах, Галдангийн ач дүү Цэвээнравданг түүнээс хөндийрүүлэх, өөрийн тагнуул туршуулуудыг Ойрадад оруулах, Галданг манжид дагаар орохыг ятган, өндөр цол хэргэм амлах, айлган сүрдүүлэх, хавчин боох, хууран мэхлэх зэрэг олон арга хэрэглэж байжээ.

1690 оны Ү сард Буйр нуурын орчим Улахуй голд Арнай сайдын удирдсан манжийн цэрэг Галдантай гэнэдүүлэн байлдсан боловч ялагджээ. Энэ хэрэг явдлыг Энх-Амгалан "Арнай нар миний зарлигийг гүйхгүй даруй тантай байлдсан нь манай хааны санаа бус" гэж булзааруулж байжээ. Энэ завсар Энх-амгалан 10 түмэн цэргийг хоёр гар болгон шуурхай бэлтгэхийн хамт Галданг Хишигтний аймгийн нутагт хүрэлцэн ирж монгол ноёдын чуулганд оролцох уу? Тэнд Чихундорж, Өндөр гэгээн нарыг буцаан өгөх асуудлыг хэлэлцье гэж элч заржээ. Галданг Хишигтэн аймгийн нутаг Шар мөрний дэх Манжийн их цэрэг аль хэдийн байраа эзэлсэн тул шууд тосон байлджээ. Гурван давхар бүслэгдэж их хохирол амссан боловч Галдан арга хэрэглэн бүслэлтээс сэм гарч Ганга нуурын газар нуугдаж

амжжээ. Энэ мэдээг Энх-Амгалан сонсмогц "Галданг эртхэн сөнөөхгүй бол газар орон нэгэн өөр ч амрыг олохгүй" гэж чангалан тушаасан боловч манжийн цэрэг түүнийг гүйцэж чадалгүй алджээ.

Энэхүү хоёр дахь тулалдааны дараа Галдангийн хийх нэлээд хугацаа хүч зарж нухацтай бэлтгэсэн байна. цэрэг татлагыг нэмэгдүүлж цэргийг төрөлжүүлэн сургав. Ачиж тээвэрлэхэд төвөгтэй хүнд бууны оронд хөнгөн маягийн буу цутгуулав. Тэдгээрийг тээвэрлэх тусгай хөөг бэлтгэв. Цэргийн хоол хүнсний базаал сайжруулж Өвөрмонголын нутагт цэргийн хэд хэдэн бэхлэлт байгуулж ээ. Манж нар Галдангийн эсрэг гуравдахь удаагийн их цэргийг 1696 оны хавар энэ замаар давшуулах зарилга буулгажээ. Жинжин Фиянгугийн удирдсан Шаньси, Ганьсу мужийн цэргийг баруун гар болгож Хөх хотоос Орхон, Туулийг чиглэлд давшиж, Шабасу жанжны удирдсан Мугдээний цэрэг Мажуураас Буйр нуурыг чиглэлээр дунд замын цэргийг Энх-Амгалан биеэр захирч Бээжингээс Хэрлэнгийн чиглэлээр тус тус гарчээ. Их цэргийн явах замын дагуу олон тооны өртөө байгуулж агт морь, ачлагын хөсөг, идэшний хонь мал бэлдүүлэв. Цэргүүдийг хос морьтой 40 хоногийн хүнсстэй болгов. Түйн гол, Годил балгас, Онон голд цэргийн хүнсний бааз байгуулахаар зэхэв. Мажийн гурван замын их цэрэг 20 түм байв. Энэ үед Галдангийн мэдэлд 3 түмэн цэрэг байж ээ.

Манжийн гурван замын цэрэг Галдантай байлдахад тус бүр тодорхой үүрэг

хүлээжээ. Зүүн замын цэрэг Галданг Хянганы нуруу тийш хааж, Онон, Улз голын чиглэлээр давших, дунд замын цэрэг түүний ухрах замыг хааж бүслэн байлдах зорилготой байв.

Манжийн гурван замын их цэрэг Энх-Амгалан хаан Галданд элч зарж тулган шаардах бичиг илгээжээ "Дайчин улсын их Юванжугийн бичиг, Өөлдийн галданд гарав. Чиний муу ял дэлхий дахинд хэрхэвч багтах боломгүй тул тэнгэрийн хөвүүн би биеэр их цэргийг авч дайлаар ирэв чи түмэн буруу мянган ялыг гэмшин хүлээж гарыг хүлж үсгийг энган хөлийг нүцгэлэн "мөлхөн ирж гуйваас өчүүхэн нохойн амийг агуучлах нь тэнгэрийн хишиг болой. Хэрвээ зөрчвөөс... таван эрүүгийн цаазаар аваачиж... түмэн ялыг хүртээмүй. Далай цэрэг, жанжин дөчин түм" гэжээ. 1696 оны Ү сарын 13-нд Тэрэлжийн Зуунмодонд болсон шийдвэрлэх тулааны үер "Галданг хэн хүн олж бариваас ван хиагийн хэргэм өргөмжилж түүний нэг лан маханд "нэгэн лан мөнгө, нэг лан яасанд нэгэн лан алт шагнамуй" гэсэн зарлиг гаргажээ. Энэ боловч түүнийг устгаж монгол орныг бүрэн эзлэн авч чадсангүй.

Зуунмодны тулалдаанд Галдангийн хүч ихэд суларсан тул халх нутгийг орхиж ойрадад очоод 1697 оны эхээр таалал төгсөв. Түүний хүү Цэрэнбалжирыг баривчлан Бээжинд аваачин цовдолжээ. Үлдсэн ганц охин Зуншгайг долоон жил Цэвээнравдан ханаас нэхсээр байж дотор газар аваачжээ. Түүгээр ч зогсохгүй Галданбошогт хааны ясыг Бээжинд авчирч өгөхийг олон жил шаардсан байна. Ийнхүү монгол орны

тусгаар тогтнолын төлөө цогтой тэмцэгч үгүй болсноор Энх-амгалан хааны бодлогын II дахь үе шувтрав.

III

Энх-Амгалангийн бодлогын III үе нь ХҮIII зууны эхэн хагасыг хамарч байна. Энэ үед монгол орныг өөрийн эрхшээлд бүрэн оруулахын тулд Халхыг Ойрадын эсрэг цэрэг дайны түшэц газар болгож тэнд Манжийн цэргийн захиргааг тогтоох Оростой зах нийлсэн хил хязгаарыг сэргийлэх явдлыг чангатган Монгол орныг гадаад ертөнцөөс бүрэн тусгаарлах, Зүүнгарын Хаант улсыг эзлэн авах нарийн төлөвлөгөө боловсруулж цэрэг дайны бэлтгэлийг хангахад уг бодлого чиглэжээ. Энэхүү бодлогыг Энх-Амгалан болон түүнийг залгамжилсан Найралт Төв, Тэнгэрийн тэтгэсэн хаадууд хэрэгжүүлжээ.

Манж нар Халхын 34 хошууг 75 болгож Монгол ноёдын хуучин цол хэргэмийг халж Чин ван, Жүн ван, Бээс зэрэг цол хэргэм бий болгож цалин пүнлүүг шинэчлэн тогтоов. Түшээт ханы 19 хошууг талсан авч Сайн ноён хан аймгийг 1625 онд байгуулав. Богдын хүрээ Улиастайд манж амбаныг суулгав. Улиастайд “Хязгаар дахиныг тогтоогч Зүүн этгээдийн туслагч жанжны газрыг” шинээр байгуулж цэргийн асуудал хариуцуулав. Аймгийн чуулганы дэргэд Монгол туслагч жанжинг бий болгож цэргийн хэргийг эрхлүүлж түүнд манжийн хааны хүргэчүүдийг томилжээ.

Чуулалт ба Шүрхий хаалганаас Ховд, Улиастайн чиглэлд 70 буурь өртөөг байгуулж “Алтай замын цэргийн өртөө” гэж нэрлэв. Хошуудын хоорондын

“Суман өртөөний ” тоог олшруулав. Алтайн харуулыг цэргийн зохион байгуулалттай “Суман харуул” болгож Умард хилийн “гэрийн харуулын” тоог нэмэгдүүлжээ. Цэрэг эрс бүрт албан татвар ноогдуулав. 1715 онд хязгаар дахиныг тогтоогч жанжнаар толгойлуулсан 50 мянган цэргийг Халхад оруулан суулгав. Халхаас түмэн цэрэг дайчлан Алтай, Хангай, Завхан, Заг байдраг, Хар ус зэрэг газар суулгаж зүүн гарын эсрэг байлдахад хавсарга болгов. Түргэстан, Хами, Түрфан, Хөх нуур зэрэг Ойрад монголтой хиллэсэн газруудад өөрийн цэргийн баазыг Манж нар байгуулжээ.

1727 оны Буурийн гэрээгээр Манж дайчин гүрэн хаант Орос хоёр Монгол орныг хуваан авч Буриад монголыг Оросд өгч Өвөр ба Халх монголыг Манжийн эзэмшүүн болгож хэрэг дээрээ Монгол улсыг үгүй болгожээ.

Ийм нөхцөл байдалд Зүүн гарын төрийг барьсан Цэвээнравдан /1697-1797/, Галданцэрэн /1724-1745/ нар улс орныхоо дотоод, гадаад байдлыг засаж хүчин чадлаа бэхжүүлэх талаар ихээхэн бодлого явуулсан тул Манж нар шууд довтлож чадахгүй байв. Харин Галданцэрэнгийн дараа Зүүн гарын хаан ширээний төлөө Цэвээндорж-Намжил лам даржаа Даваач нарын хооронд болсон тэмцлийг Манж нар овжин ашигласан байна. Энэ үед Зүүнгарын ноёдын зарим нь Халхад нүүн орох нөгөө хэсэг нь Манжид дагаар орох, гурав дахь нь Хөх нуур Орос руу нүүн дүрвэх зэргээр хүч сарнисан ажээ. 1754 онд Тэнгэрийн тэтгэсэн хааны зарлигаар Халах солон, баргаа, захар, хятад

зэрэг олон аймаг хошуудаас 50 мянган цэргийг Зүүнгарын эсрэг хөдөлгөхөөр болжээ.

Манжийн энэхүү эзлэн түрэмгийлэх бодлогыг эсэргүүцэж Ойрадын бага ноён Амарсанаа, хотогойдын ван Чингүүнжав нарын удирдлагаар 1655-1658 онд бүх нийтийг хамарсан бослого гарчээ. Уг бослогыг Зүүнгар, Халхын нийт ард түмэн тэмцсэн төдийгүй богд Жавзуундамба, Ямпилдорж, Засагт хан Бальдир, Сэцэн хан Манибадар, Сайн ноён хан Дэчинжав нар талархан Амарсанаа, Чингүүнжав нартай сэм холбоо барьж янз бүрийн хэлбэрээр манжийг эсэргүүцсэн байна. Гэвч бослого гаргагчид хүчээ нэгтгэж чадаагүй, уван цуван гарсан болон Манжийн их цэргийн өмнө хүчин мөхөстсөнөөс ялагджээ. Чингүүнжавын барин авч Бээжинд аваачиж зоосны нүхээр хороов. II дугаар Богд болон, Ямпилдорж, Бальдир, Манибадар нарыг Манж нар сэм хорлон алжээ. Амарсанаа Орост зугтан гарч тэнд нас баржээ. Бослогод идвэхтэй оролцсон бусад ноёдыг барин авч цаазалсан байна.

1760 онд Ойрадын нутгийг шинэ хязгаар /Шинжан, Ховдын хязгаар/ гэж 2 хувааж 1761 онд Ховдод манж амбаныг суулгаснаар Монгол орон бүхэлдээ Манж гүрний мэдэл, дарлалд орсон байна. Ийнхүү Энх-Амгалан хааны бодлогын III үе дуусч Монгол оронд Манжийн колончлол бүрэн тогтжээ.

Эх сурвалж

1. Санждорж.М., “Монголын түүх”. УБ.,1970 он
2. “Монголын түүх ” III дугаар боть. УБ.,2014 он
3. Болдбаатар.Ж, Лүндээжанцан.Д “Монголын улсын төр эрх зүйн түүхэн уламжлал”.УБ.,2020

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ

Б.ТӨРБАТ

(Шихихутуг их сургуулийн магистрант)

Товчлол: Амьд хүний гэрч болохоор үхсэн хүний дэр бол, сүх далайтал үхэр амар, адгийн зарга 10 хоног гэх мэт эдгээр үгс нийтийн сайн сайхны төлөө, улс орны хөгжлийн төлөө нийгэмд болохгүй байгаа бусармаг зүйлсийг олон нийтэд илчлэх санаа зоригтнуудын зоригийг мохоодог гэж хэлж болохуйц юм.

Эсрэгээрээ хэрэг хуучирдаггүй, гэрчгүй гэмт хэрэг гэж хэзээ ч байдаггүйтэй адилаар улс орны маань хөгжлийн үзүүлэлтийг байнгын хойшоо татаж, нийгмийг улам бүр доройтуулж буй авлига хэмээх энэхүү эрх зүйн зөрчлийг үгүй болгох нэгэн арга ажиллагаа бол энэхүү эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх явдал билээ.

Хэрэг болсоны дараа тэмцэх нь гэмт хэрэгтэнд хариуцлага хүлээлгэх л асуудал болохоос уг хэргийн хор уршгийг нийгэмд хэзээ ч алга болгож чадахгүй тул уг эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх их үйлсийг манлайлах манлайлагч болсон шүгэл үлээгчийг хамгаалах, урамшуулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зайлшгүй хэрэгцээ шаардлага тулгараад байна.

Удирдтгал: Авлига хэмээх эл ойлголтыг Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т зааснаар "авлига" гэж энэ хуулийн

4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхгүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг¹ 4.1. Доор дурдсан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарна: төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан; төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч; төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан; улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан; Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч; бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч; эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад заасан албан тушаалтан; Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 4.1.7-д заасан Ирээдүйн өв сан корпорацийн эрх бүхий албан

¹ Авлигын эсрэг хууль, нэгдүгээр бүлэг, 3 дугаар зүйлийн 3.1.1, (2006)

тушаалтан, хяналтын зөвлөлийн гишүүн² тус тус хамаарна хэмээн заасан байна.

Авлигын эсрэг хуульд: 3.1.2.“ашиг хонжоо” гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж бусдад давуу байдал олгосны төлөө өөрт нь болон бусдад буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг;

3.1.3.“албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах” гэж албан тушаалын эрх мэдлийг албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийхийг;

3.1.4.“давуу байдал” гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласнаар хувь хүн, хуулийн этгээдэд буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг тус тус ойлгоно хэмээн тодорхойлжээ.

Эл ойлголтыг эрдэм судлаачид өөр өөрсдийн үзэл баримтлалын үүднээс мөн тодорхойлон томъёолсон байх агаад тухайлбал Монгол хэлний бичгийн их хүмүүн Я.Цэвэл: Авлига гэдэг нь ёсон бусаар шунаж авсан эд юм³ хэмээсэн аж.

Дэлхийн аливаа улс орон бүр нийгмийн гаж үзэгдэл болсон авлигатай хүч хаян тэмцдэгийн учир нь түүний хор нөлөө яг л аалзны шүлс шиг бүхэл бүтэн улс орныг хүртэл сүлжин торлож шударга бус нийгмийг бий болгож, иргэдийн төрдөө итгэх итгэлийг алдруулж улмаар

засаглал хямрах үндсэн нөхцлийг бүрдүүлдэгтэй холбоотой.

Монгол Улсын хувьд авлигатай тэмцэх хэрэгцээ шаардлага улам бүр өссөөр байна. Холбооны Бүгд найрамдах Герман улсын Берлин хотод төвтэй Транспэрэнси Интернэшнл олон улсын төрийн бус байгууллагаас жил бүр улс орнуудын төрийн албан дахь авлигын талаар шинжээч болон бизнес эрхлэгч нарын төсөөлөлд үндэслэн гаргадаг Авлигын индексийн 2020 оны дүнг 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр дэлхий нийтэд зарласан бөгөөд манай улсын хувьд уг судалгааны дүнгээр 2020 онд 35 оноо авч 180 улс орноос 111 дүгээр байранд эрэмбэлэгдсэн. Гэхдээ энэ нь урьдынхаасаа ухарсан үзүүлэлт юм.

Үнэлгээ буурсан үндсэн шалтгаан нь төрийн албан хаагчид эрх мэдэл, албан тушаалын байдлаар урвуулан ашигладаг байдал нэмэгдсэнээс хамаарсан судалгааны дүн гарсантай холбоотой болно.⁴

Тиймээс ч авлигаас урьдчилан сэргийлэх төрийн оновчтой бодлогыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ олон нийтийн оролцоо, хяналтыг эрчимжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Үндсэн хэсэг: Монгол Улсын Үндсэн хуулийн оршил хэсэгт Монголын ард түмэн бид улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс, түүх соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг

² Авлигын эсрэг хууль, нэгдүгээр бүлэг, 4 дүгээр зүйлийн 4.1 (2006)

³ <https://tsevel.toli.query.mn/>

⁴ <https://www.iaac.mn/>

хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно. Үүний учир Монгол Улсын Үндсэн хуулийг даяар олноо зарлан тунхаглаж байна хэмээн хуульчилсан билээ.

Монгол Улсын ардын багш, гавьяат хуульч Бираагийн Чимид агсан: Хуулийн үг нь байтугай таслал нь утга учиртай хэмээн нэгэнтээ онцолсон байдаг. Үнэхээр нийгмийн харилцааг зохицуулагч хуулийг амьдрал практикт бодитойгоор биелүүлэх нөхцөл бололцоог бүхий л сигментэд эс бүрдүүлбээс хууль бол ердөө цагаан цаасан дээр хараар бичигдсэн бичээс болон үлдэх биз.

Тэнгэрийн дор төрж, хуулийн дор амьдардаг нь хүмүүний амьдралын жам ёсон гэгддэг.

Эрх зүйт төрийн хорлонт дайсан болсон Авлигатай хэрхэн тэмцэх вэ, түүнд ямар ямар үйл ажиллагаа хамаарах вэ гэдгийг жичлэн авч үзэхийн тулд эдүгээ хүчин төгөлдөр үйлчилж буй Авлигын эсрэг хуульд тусгалаа олсон Авлигатай тэмцэх газрын бүрэн эрхийг товчхон авч үзье.

Авлигын эсрэг хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т Авлигатай тэмцэх газар нь *авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, энэ хуульд заасан этгээдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан, төрийн тусгай байгууллага мөн, 15.2. Энэ хуулийн 15.1-д заасан*

*газрын харьяанд авлигатай тэмцэхтэй холбогдсон судалгаа шинжилгээ хийх үүрэг бүхий бүтцийг байгуулж болно*⁵ хэмээн тус тус заасан байна.

Авлигатай тэмцэх газар нь дор дурьдсан бүтэцтэйгээр хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлж байна.

1. Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс
2. Тамгын хэлтэс /Аюулгүй байдал, хяналт шалгалт нууцын алба болон санхүү аж ахуйн алба /
3. Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс /Мэдүүлгийн бүрдүүлэлт, дүн шинжилгээний алба, хяналт шалгалтын алба/
4. Мөрдөн шалгах хэлтэс
5. Тусгай хэлтэс
6. Гүйцэтгэх ажлын хэлтэс
7. Судалгаа шинжилгээний алба⁶

Эндээс харвал авлигатай тэмцэх үйл ажиллагаа гэдэгт:

1. Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа
2. Авлигын гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, Авлигын эсрэг хуульд заасан этгээдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах үйл ажиллагаа зэрэг багтана.

⁵ Авлигын эсрэг хууль, дөрөвдүгээр бүлэг, 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 (2006)

⁶ <https://www.iaac.mn/>

Эндээс олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа тэр дундаа авлигаас урьдчилан сэргийлэхэд олон нийтийн оролцоо, хяналтыг хэрхэн сайжруулах талаар тухайлан судалж үзэхэд авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоо, хяналтыг сайжруулахад чухам ямар асуудал тулгамдаж байна вэ гэдэг асуулт зүй ёсоор тавигдаж байгаа биз. Юуны өмнө

1. Авлигаас урьдчилан сэргийлэх
2. Олон нийтийн оролцоо, хяналт гэсэн ойлголтуудыг товчхон авч үзье.

Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6. “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа” гэж авлигын шалтгаан, нөхцөлийг судлан тогтоох, тэдгээрийг арилгах, авлигыг таслан зогсооход чиглэгдсэн арга хэмжээний цогцолборыг хэлнэ гэжээ.

Олон нийт гэх ойлголт нь Монгол хэлний тайлбар тольд дурьдсанаар ард түмэн, олон нийт⁷ гэх агуулгыг хадгалдаг аж.

Оролцоо, хяналт гэдэг нь сонсогч, үзэгчийн хувиар асуудалд оролцох бус үйлдэл хийх, өөрөөр хэлбэл тус үйл ажиллагаанд оролцох эрх мэдлийг олон нийтэд бодитойгоор олгож буй хэрэг. Ингэж чадваас авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд олон нийтийн оролцоо, хяналтыг хэрэгжүүлэх боломжтой бүрдэх нь тодорхой харагдаж байна.

Учир нь эрх мэдэлгүй олон нийт авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд оролцож, хяналт тавих нь багажгүй эмч

хагалгаанд орохтой нэгэн адил.

Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоо, хяналтыг тусгасан холбогдох хууль тогтоомжуудыг авч үзвэл:

Олон нийтийн оролцоо, хяналт:

Авлигын эсрэг хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1. *Иргэн, хуулийн этгээд авлигын асуудлаар Авлигатай тэмцэх газарт өргөдөл, гомдол гаргаж, мэдээлэл өгч болно*⁸, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3. *Гэмт хэрэг, зөрчлийн талаар олж мэдсэн зүйлээ холбогдох байгууллагад мэдээлэх үүрэгтэй*⁹, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3.1. *Гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг иргэн амаар, эсхүл бичгээр гаргаж болно*¹⁰, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2. *Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх үүрэгтэй*, 8.3. *Ашиг сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдлын талаар мэдэж байгаа бусад этгээд энэ тухай холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлж*

⁸ Авлигын эсрэг хууль, хоёрдугаар бүлэг, 9 дугаар зүйлийн 9.1, (2006)

⁹ Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, дөрөвдүгээр бүлэг, 31 дүгээр зүйлийн 31.1.3, (2019)

¹⁰ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, гучдугаар бүлэг, 30 дугаар зүйлийн 30.3.1, (2017)

⁷ <https://mongoltoli.mn/>

болно¹¹, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.1. Эрх бүхий байгууллага нь хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас гаргасан зөрчлийн талаархи гомдол, мэдээллийг амаар, бичгээр болон харилцаа холбооны хэрэгслээр дамжуулан хүлээн авна¹², Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 5 дугаар зүйлийн 5.2.5. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийг шалгах, мэдээлэгчийг хамгаалахад иргэн хяналт тавих бололцоо бүрдсэн байх¹³ хэмээсэн.

Дээрх эрх зүйн зохицуулалтуудаас иргэд, олон нийтийн хувьд эдгээр хуулиудад заасан боломжийг хэрхэн ашиглаж, үүргээ хэрхэн биелүүлж байна вэ цаашлаад эдгээр субъектүүдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, аюулгүй байдлыг хэрхэн хангаж байна вэ гэх асуулт тавигдаж таарна.

Юун түрүүнд иргэн, хуулийн этгээд нийгмийн эд эс болохын хувьд нийтийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч болж чадаж байна уу, түүний эрх, хууль ёсны ашиг сонирхол хэрхэн хамгаалагдаж байна вэ гэх эл асуултад хариулах нь зүйтэй биз.

¹¹ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, хоёрдугаар бүлэг, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, (2012)

¹² Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, зургадугаар бүлэг, 6 дугаар зүйлийн 6.2.1, (2017)

¹³ Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, 5 дугаар зүйлийн 5.2.5, (2016)

1970 -аад оны эхэн үед Америкийн иргэний эрхийн төлөө тэмцэгчдийн нэг Ralf Nader энэхүү "шүгэл үлээгч" гэдэг үгийн утгыг "нууц мэдээлэгч", "матаач" гэсэн үгийн утгаас ялгаатайгаар ашигладаг гэдгийг гаргаж тавьсан. Одоо цагт "Шүгэл үлээгч" гэдэгт байгууллагын дотоодод болж байгаа үйлдлээс эхлээд гадна улс орны хэмжээнд, дэлхий нийтийн түвшинд болж байгаа зүй бус үйлдэл, тухайлбал, нийтийн эрх ашигт шууд харшилсан, хууль, дүрэм зөрчсөн, авлига, луйвар зэргийг баримт нотолгоотойгоор нийтэд дэлгэхийг ойлгодог. Авлигын асуудлын хүрээнд авлигын хэргийг илчлэгч ч гэж нэрлэх тал бий. Шүгэл үлээгч бол хохирогч биш. Нийтийн ашиг сонирхлыг хохироосон, хохироох бодит нөхцөл бүрдүүлсэн хууль бус үйлдлийг илчилж, энэ тухай өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл өгөх, тайлан гаргах, тайлбар өгөх зэрэг нийтийн ашиг сонирхлын төлөө хийх үйлдлийг шүгэл үлээх гэж үзэж болно¹⁴

Өөрөөр хэлбэл нийтийн ашиг сонирхол, аюулгүй байдлын эсрэг үйлдлийн тухай мэдээлэл тараахыг улс төрийн нэр томъёонд шүгэл үлээх гэнэ.¹⁵

Шүгэл үлээгчид нь

1. Эрх бүхий байгууллага болон олон нийтэд тухайн байгууллагад болж байгаа хууль бус үйлдлийг илчилдэг.
2. Бусдыг хохироож, хууль зөрчсөн байж болзошгүй гэж үзэж байгаа, ажлын байранд дээр гарсан хууль

¹⁴ Дуламсүрэн, Д. (2020.05.15) Шүгэл үлээгчийг хамгаалах хууль нь авлигатай тэмцэх том алхам болно, Зууны мэдээ, №96 (6321)

¹⁵ <https://jargaldefacto.com/article/shugel-uleekh-soyol>

бус үйлдлийг нийтэд ил болгодог.

сэрдэгдэх

3. Авлига болон олон нийт, байгаль орчинд аюул учруулж болзошгүй нөхцөл байдлыг илрүүлж, зарлан хэлдэг.

Манай Улсын хувьд 2021 оны 01 дүгээр сарын 25-29-ний өдрүүдэд Авлигатай тэмцэх газар авлигын гэмт хэргийн шинжтэй 18 гомдол, мэдээлэл хүлээн авч, нийт 90 гомдол, мэдээллийг шалгасан. Үүнээс 10 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлийн хэрэг нээж, 13 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн мэдээлэл нээхээс татгалзах саналтайгаар прокурорт шилжүүлж, 1 гомдол, мэдээллийг харъяаллын дагуу шилжүүлсэн ба ажиллагаанд 66 гомдол, мэдээлэл байна.¹⁶

Шүгэл үлээгчийн төрөл:

1. Дотоод мэдээлэгч /Хувь хүн өөрийн итгэл үнэмшлийг хамгаалах эсхүл байгууллагын дотор болж байгаа хууль бус гэж үзсэн зүйлсийг илчилж байгаа тохиолдолд /
2. Гадаад мэдээлэгч / Хувь хүн өөрийн итгэл үнэмшлийг хамгаалах эсхүл байгууллагын дотор болж байгаа хууль бус гэж үзсэн зүйлсийг илчилж байгаа тохиолдолд /

Авлигатай тэмцэх газрын 2020 оны тайлант мэдээнээс үзвэл 2020 оны байдлаар тус байгууллага гэмт хэргийн шинжтэй 1020 гомдол, мэдээллийг шалган шийдвэрлэсэн бөгөөд мөрдөн шалгах ажиллагаа явуулсан гомдол, мэдээллийн шийдвэрлэлт 95.7 хувьтай байна. Хянан шийдвэрлэсэн гомдол мэдээлэл өмнөх оноос 14.1 хувиар өссөн үзүүлэлттэй. Түүнчлэн хуульд заасан харьяаллын 1535 үйлдэлтэй, 696 холбогдогчтой, 1331 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, 236 хэргийг шилжүүлсэн нь өмнөх оноос өссөн үзүүлэлт юм. 2020 онд авлига, албан тушаалын 114 эрүүгийн хэрэг шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн нь өмнөх оноос 67.6 хувиар өссөн байна. Тухайлбал, Монгол Улсын Ерөнхий сайдаар ажиллаж байсан хүмүүс, мөн төрийн удирдах албан тушаалтнуудын холбогдсон эрүүгийн хэрэг шүүхээр

Шүгэл үлээгчдийн нийтлэг шинж:

1. Эрсдэлээс айдаггүй
2. Бүх нийтийн төлөө сэтгэлтэй
3. Өөрийн зан төлөвийг өөрчлөх сонирхолгүй
4. Өөрийн итгэл үнэмшилд итгэлд захирагддаг
5. Мэргэжлийн албан тушаал хашдаг, сайн боловсролтой байдаг.

Шүгэл үлээгчдэд учрах эрсдэл:

1. Ажлаас гарах, албан тушаал буурах
2. Бусдад сөргөөр үнэлэгдэх
3. Гэр бүл, эрүүл мэнд, амьдрал ахуй нь эрсдэлд орох
4. Бусдын шууд болон шууд бус дарамт хавчлагад өртөх
5. Ганцаардах, найз нөхөдгүй болох
6. Үндэслэлгүйгээр буруутгагдах,

¹⁶ <https://www.iaac.mn/news/eruugiin-523-kheregt-murdun-baitsaaltin-ajillagaa-yawuulaw?menu=147>

шийдвэрлэгдсэн байна.¹⁷

Судалгаа, тайлангаас шүгэл үлээгчдийн үйлдэл чамлагдахааргүй байгаа нь тодорхой харагдаж эхлэв.

Эдгээр субъектүүдтэй холбоотой харилцааг нийгмийн сайн сайхан, улс орныхоо хөгжлийн төлөө шүгэл үлээхийг уриалсантай холбоотой харилцааг өмнө нь дурьдсан Авлигын эсрэг хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль гэх зэрэг ердийн хуулиудын холбогдох зохицуулалтаар хуульчлан зохицуулсаны дээр суурь шинжтэй харилцааг Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16-т *Монгол Улсын иргэн итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно*¹⁸ хэмээн хуульчлан зохицуулж байна.

Нийгэмд шүгэл үлээгчид олон байх нь манай улсын хувьд Авлигын төсөөллийн индексээр гарсан үр дүн сайжрах, шударга ёс оршин тогтносон, цэвэр нийгэм бүрэлдэн тогтнох гол үндэслэл болно.

Үүний тулд шүгэл үлээгчдийг хамгаалах, тэднийг урамшуулахтай холбоотой

¹⁷ <https://www.iaac.mn/news/atg-2sh2sh-ond-yuu-khiiw>

¹⁸ Монгол Улсын Үндсэн хууль, хоёрдугаар бүлэг, 16 дугаар зүйлийн 16.16 (1992)

харилцааг зохицуулж буй эрх зүйн зохицуулалтуудыг боловсронгуй болгох зайлшгүй хэрэгцээ шаардлага бий болж байх тул холбогдох эрх зүйн зохицуулалтуудад дүн шинжилгээ хийе.

Шүгэл үлээгчийг хамгаалах нь сэдэвт хэлэлцүүлэгт ЦЕГ-ын ГХХХ-ийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад Ш.Шинэбаярын тавьсан илтгэлд: Үүнээс гадна шүгэл үлээгч, гэрчийг гэрчээр тооцохгүй байх, эсхүл хуулийн дагуу гэрчээр тооцогдох хүртэл хугацаа алдах зэрэг явдал үүсч болох юм. Улмаар авлигын талаар мэдээлсэн шүгэл үлээгчдийг Зөрчлийн тухай хуулийн дагуу “6.21. Гүтгэх” зөрчил үйлдсэнд тооцох, эсхүл Эрүүгийн хуульд зааснаар “21.2. худал мэдүүлэх”, Иргэний хуулийн 21.2-т “Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд” болж хувиргах боломжтой юм хэмээн дурьдагдсан байна.¹⁹

Авлигын эсрэг нэгдсэн үндэстний байгууллагын конвенцийн 33 дугаар зүйлд *Оролцогч улс бүр энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийн талаархи аливаа баримт нотолгоог сайн санааны үүднээс, үндэслэлтэйгээр эрх бүхий байгууллагад мэдээлж буй аливаа этгээдийг аливаа шударга бус хандлагаас хамгаалахаар заах талаархи зохих арга хэмжээг өөрийн дотоодын эрх зүйн тогтолцоонд нэвтрүүлэн оруулах асуудлыг авч үзнэ*

¹⁹ Баярсайхан, Б.(2019) Шүгэл үлээгчийг хамгаалах шаардлага, дэлгэрэнгүйг ШУДАРГА ЁС СЭТГҮҮЛ №18.pdf дам ишлэв.

хэмээн заасан.²⁰

Гэрч хохирогчийг хамгаалах тухай Монгол Улсын хуулийн 6 дугаар зүйлийн 6.1т заасанчлан гэрч хохирогчийг хамгаалах хамгаалалтын арга хэмжээ нь аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ, сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ гэсэн төрөлтэй байна.

Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ нь дараах хэлбэртэй байна. Үүнд:

1. Урьдчилан сануулах
2. Тодорхой үйлдлийг хязгаарлах
3. Биечилсэн хамгаалалт
4. Мэдээллийн нууцлалыг хангах
5. Нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах
6. Аюулгүй газарт түр байрлуулах
7. Нүүлгэн шилжүүлэх
8. Баримт бичгийг солих
9. Гадаад төрхийг өөрчлөх

Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээнд дараах арга хэмжээ хамаарна. Үүнд:

1. Гэрч хохирогчийг хамгаалалтад авсан үеэс эхлэн шаардлагатай тохиолдолд сэтгэл зүйчийг байлцуулах
2. Гэрч хохирогчийн оролцоотой явагдах мөрдөн шалгах ажиллагааны явцад үүсэх сэтгэл зүйн таагүй нөхцөл байдлын талаар урьдчилан мэдээлэх
3. Шүүх хуралдааны хугацаа, дараалал,

явц болон нөхцөл байдлын талаар урьдчилан мэдээлэх

4. Шүүх хуралдааны танхимд гэрч, хохирогчийг сэтгэл зүйчтэй хамт байлгах
5. Шаардлагатай бусад арга хэмжээ хамаарна²¹.

Эдүгээ хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт Авлигын гэмт хэргийн талаар хуульчлан тусгасан байдаг бөгөөд үүнд:

1. Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах
2. Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах
3. Хахууль авах
4. Хахууль өгөх
5. Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах
6. Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх
7. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах
8. Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах
9. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих
10. Дураараа аашлах
11. Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах зэрэг төрлийн гэмт хэрэг багтана.

Авлигын гэмт хэргийн онцлог нь нэг талд эрх бүхий албан тушаалтан байх

²⁰ Авлигын эсрэг нэгдсэн үндэстний байгууллагын конвенци, нэгдүгээр бүлэг, 33 дугаар зүйл, (2005)

²¹ Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, хоёрдугаар бүлэг, 6-17-р зүйл (2013)

бөгөөд энэ ч утгаараа ямарваа нэгэн хэлбэрээр тухайн субъектын шууд удирдлага дор эсхүл эдийн засгийн гэх мэт аливаа хэлбэрээр хамаарал бүхий байх зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан шүгэл үлээгч нар нийгэмд олноор бий болохгүй байх эрсдэлтэй байна.

Энэ ч утгаараа шүгэл үлээгчийг албан тушаал бууруулах, цалин бууруулах, аливаа нэмэгдэл хөлс олгохгүй байх, ажиллах нөхцлийг дордуулах, ажлын ачааллаар дарамтлах гэх мэт олон эрсдэл учрах бөгөөд энэ нь хэнд эрх мэдэл байна түүнд хэлэнц буй гэх үгтэй агаар нэг ойлголт болно.

Гэтэл энэ талаар дээр дурьдсан холбогдох эрх зүйн зохицуулалтад хангагдаагүй орхигджээ.

Дараагийн авч үзэх асуудал нь гэрчийг буюу авлигын гэмт хэргийн эсрэг шүгэл үлээгчийг урамшуулах асуудал болно.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэгч нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахдаа иргэдийг дараах хэлбэрээр татан оролцуулна: 33.1.1. гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон хүн, хуулийн этгээдийг урамшуулах; 33.1.2. гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээллийг иргэдээс төлбөртэй авах гэх мэт хамаарна, 34.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцон тодорхой ажил зохиож, үр дүнд хүрсэн хүн, хуулийн этгээдийг урамшуулна, 34.2. Иргэний өгсөн

мэдээллийн дагуу зөрчилд 200 хүртэл нэгжээр торгох шийтгэл оногдуулсан бол иргэнд тухайн шийтгэлийн 20 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний, 200-аас дээш нэгжээр торгох шийтгэл оногдуулсан бол 10 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгож болно, 35.1. Гэмт хэрэг, зөрчил үйлдэхээр бэлтгэж байгаа болон үйлдсэн тухай мэдээллийг гэмт хэрэг, зөрчлийг хянан шалгах эрх бүхий байгууллага иргэдээс төлбөртэй авч болно хэмээн тус тус заасан байна.

Тус эрх зүйн зохицуулалтаас үзвэл болно гэх диспозитив хэм хэмжээ үйлчилж байхаас гадна өгсөн мэдээллийн дагуу тухайн зөрчил үйлдсэн этгээдэд шийтгэл оногдуулсан бол олгох урамшууллын хэмжээ багасахаар зохицуулагдсан нь тохиромжгүй түүнчлэн иргэний өгсөн мэдээллийн дагуу гэмт хэрэг үйлдсэн этгээд хуульд заасан хариуцлага хүлээсэн бол хэдий хэмжээний урамшуулал өгөх талаар хуульчлан тусгаагүй зэрэг нь шүгэл үлээгч нар нийгэмд олноор бий болох сэдлийг нэг талаар өгөхгүй байх эрсдэлтэй байна.

Шүгэл үлээгчийг хамгаалах хийгээд урамшуулах гадаадын улс орнуудын туршлагаас авч үзвэл:

Хамгаалалт: Улс орнуудын дотоодын тусгайлсан хуулиар /АНУ, Японы шүгэл үлээгчийг хамгаалах тухай хууль, Их Британийн Нийтийн ашиг сонирхлыг илчлэх тухай хууль/ эсхүл салбарын хуулиар дамжуулан шүгэл үлээгчдийг хамгаалах, урамшуулах асуудлыг зохицуулж байна. 2018 оны байдлаар дэлхийн 27 улсад шүгэл үлээгчийг хамгаалах тусгайлсан хууль

үйлчилж байна. Шүгэл үлээгчийг хамгаалах чиглэлээр АНУ тэргүүлэх чиглэлтэй байх бөгөөд 1778 онд шүгэл үлээгчдийг хамгаалах хууль гаргаж байсан нь дэлхийн хамгийн анхны шүгэл үлээгчдийг хамгаалах хууль болно. Тус улсын үнэт цаас, арилжааны хорооноос 2018 оны төсвийн жилд 59 шүгэл үлээгчид 326 сая ам.долларын урамшуулал олгосон байна.²²

Бүгд Найрамдах Хятад Ард Улс: Хятадын Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлд зааснаар тус улс шүгэл үлээгчийг хамгаалах үйл ажиллагааг дэмждэг юм. Тус хуульд зааснаар хууль бус буюу зөвшөөрөлгүй үйл ажиллагааг иргэд мэдээлэх эрхтэй ажээ. Дэлхийн шударга ёсны тайлан /Global Integrity Report/-д дурдсанаар шүгэл үлээсэн төрийн албан хаагчийг холбогдох хууль тогтоомжоор хамгаалсан байдаг аж. Үүнээс гадна Хятадын Ардын дээд прокурорын газар авлигын гэмт хэргийн талаар мэдээлэл авах 24 цагийн утас болон вэбсайтыг ажиллуулдаг. Мөн Сахилга, хяналтын төв хороо болон Хяналт шалгалтын яам хамтран иргэдийн гомдол мэдээллийг хүлээн авах "12388.gov.cn" вэб хуудсыг нээн ажиллуулж байна. "Freedomhouse" байгууллагын үзэж байгаагаар блогчид болон сэтгүүлчдийн илчилснээр маш олон тооны доогуур болон дунд түвшний албан тушаалтнууд шийтгэгдээд байгаа аж. Гэсэн хэдий ч тус улсын засгийн газраас иргэдээ өгч байгаа мэдээллээ шууд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр илчлэхээс илүүтэйгээр засгийн газрын албан ёсны сүлжээгээр

дамжуулан илчлэхийг хүссээр байгаа юм.²³

Бүгд найрамдах Итали Улс: Авлигын эсрэг хуулийн дагуу төрийн байгууллага дахь авлигын асуудлаар мэдээлж байгаа шүгэл үлээгчийг хамгаалсан байдаг. Гэхдээ төрийн албан хаагчдын хувьд хязгаарлагдмал зохицуулалттай байдаг. Өөрөөр хэлбэл, төрийн албан хаагч шүгэл үлээхээр бол зөвхөн дээд албан тушаалтан болон Аудитын шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөлд л мэдээлэх эрхтэй байдаг ба энэ нь шүгэл үлээгчийн мэдээлэх сувгийг хязгаарлаж өгсөн, шүүмжлэлтэй байдаг байна. Харин хувийн хэвшил дэх шүгэл үлээгчийг хамгаалах талаар эрх зүйн зохицуулалтгүй.²⁴

Бүгд Найрамдах Солонгос Улс: Шударга иргэнийг бий болгох, эсхүл шударга иргэний эрхэмлэх зүйл бол авлига, хээл хахууль болон аливаа хууль бус үйлдэлтэй эвлэрэхгүй байх явдал юм. Тиймээс Солонгос Улс нь Нийтийн ашиг сонирхлыг зөрчсөн үйлдэл дэх шүгэл үлээгчийг хамгаалах хууль (Public interest whistleblower protection act)-ийг 2002 оноос мөрдөж байгаа аж. Уг хуулийн дагуу шүгэл үлээгчдийг тусгайлан хамгаалахын зэрэгцээ шүгэл үлээгчийн үлээсэн/илчилсэн асуудлынх нь хэмжээнээс буюу улсад учруулсан хохирол, төсвийн хууль бус зарцуулалтын хэмжээний 4-30 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг шүгэл үлээгчид өөрт нь олгодог байна. Үүнд шүгэл үлээгчийн илчилсэн хууль

²² Баярсайхан, Б.(2019) Шүгэл үлээгчийг хамгаалах шаардлага, дэлгэрэнгүйг ШУДАРГА ЁС СЭТГҮҮЛ №18.pdf

²³ https://www.iaac.mn/old/pdf/turshlaga/China_2015.pdf

²⁴ https://www.iaac.mn/old/pdf/turshlaga/Italy_2015.pdf

бус үйлдлийн хүрээнд хээл хахуулийн талаар илчилсэн бол 3 тэрбум хүртэл, олон нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлаар бол 4-20 хувьтай тэнцэх буюу 2 тэрбум воны шагнал олгодог байна. Ийнхүү тусгайлан дэмжиж өгснөөр шүгэл үлээгчдийг шүгэл үлээх боломжийг нь бүрэн хангасан байна.²⁵

Түүнчлэн зарим улс орнуудын хувьд тухайлбал АНУ-д шүгэл үлээгчдэд 10-30 хувь, Канад улсад 5-15 хувийн урамшуулал олгодог байна.

Дүгнэлт

Дэлхийн улс орон бүр “хөгжил” хэмээх энэхүү 6-н үсэгт үгэнд агуулагдсан үнэ цэнэ, утга учрын төлөө тэмцэж, түүний төлөө бүхий л хүч чадлаа зориулан ажиллаж байна.

Хөгжил хэмээх эл ойлголтыг заавалчгүй хэд хэдэн үзүүлэлтээр хэмжих учиртай. Үүнд: Эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд гэсэн 3-н үндсэн ухагдахууныг багтаасан хүний хөгжлийн индекс, Авлигын төсөөллийн индекс, Өрсөлдөх чадварын индекс, Аз жаргалын индексүүд юун түрүүн орно.

Манай улсын хувьд аль аль үзүүлэлтээр дундаж гэх ойлголтод багтдаг боловч энэ нь төдийлөн тайвшрах үзүүлэлт биш нь ойлгомжтой. Учир нь дундаж гэх эл үзүүлэлтээс доод үзүүлэлт рүү буух амархан ч ахиж дээшлэх нь цаг хугацаа, хичээл зүтгэл шаардах ярвигтай асуудал.

Авлига хэмээх нийгмийн хорт үзэгдэл улс оронд бүхий л салбарт тархваас тэнд

гажуудал үүсч улмаар улс орны эдийн засаг ч бүхэлдээ эрсдэлд ороход хүрнэ. Иймээс уг гаж үзэгдэлтэй тэмцэж буй дэлхий бусад улс орны сайн жишгийг өөрийн орны онцлог шинжтэй хослуулан аливаа нийгмийн харилцааг зохицуулах хууль тогтоомжид цаг алдалгүй тусгаж чадваас амжилт олох үүд нээгдэнэ.

Бусад орны хууль тогтоомжоос үзэхэд эрх мэдэлтэн, өндөр албан тушаалтан, төрийн байгууллагын зүй бус үйлдлийн эсрэг хүчтэй дуугарч асуудалд нийгмийн анхаарлыг чиглүүлж байгаа хүнийг “шүгэл үлээгч” гэх утгаар хэрэглэж байна. Шүгэл үлээхийг, ялангуяа авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх чухал бүрэлдэхүүн болохыг нь хүлээн зөвшөөрөх хандлага нэмэгдэж байгааг 1987-2018 оны хооронд нийт 27 орон шүгэл үлээгчийг хамгаалах талаар тусгайлсан хууль гаргаснаас харж болно. Иргэн хүн хувиа бодож, амиа хичээхгүй байж, хууль бус, ёс зүйгүй, зүй бус үйлдлийг илчлэх, мэдээлэхийг чухалчлах ёстой. Шударга бусын хажуугаар чимээгүй өнгөрсний хор холбогдол нь эргээд өөр дээр нь ирэхийг үгүйсгэхгүй шүү дээ. Бурууд нүд хурц байж, нэг нь нийтийн төлөө санаа тавьж байж нийгэмд шударга ёс тогтож, авлигын үндэс суурь алга болно. Шүгэл үлээх нь соёл болж тогтох ёстой.²⁶ хэмээн Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Зууны мэдээ сонинд өгсөн ярилцлагадаа дурьдсан байна.

²⁵ <https://www.iaac.mn/news/bnsu-11n-awligatai-temtsekh-irgenii-erkhiin-komissoos-zokhion-baiguulsan-surgaltaar-yarigdsan-sedwuud?menu=54>

²⁶ <https://www.iaac.mn/news/>

Өгүүлэл бичигчийн хувьд эл үзэл бодолтой санал нэг байгаа бөгөөд эрүүл мэнд эмийн санд байдаггүй гэгчээр өвдсөн хойно нь тан барихаас илүү өвдөхөөс урьдчилан сэргийлэх нь хамгийн үр дүнтэй хэмээн бодохын учир нийгэм эерэг манлайллыг үзүүлэх зорилго бүхий шүгэл үлээгч нарыг хамгаалж, урамшуулж буй холбогдох эрх зүйн зохицуулалтууд учир дутагдалтай байна гэж үзэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

Шүгэл үлээгчдэд олгох урамшууллын хэмжээг одоо байгаагаас судалгааны үндсэн дээр нэмэгдүүлэх

Шүгэл үлээгч нарыг нийгэмд олноор бий болгох үүднээс олон нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээг олноор хийх шаардлагатай.

Эцэст нь хэлэхэд манай улсын хувьд авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд томоохон дэмжлэг үзүүлэх субъект болох шүгэл үлээгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, тэднийг урамшуулах оновчтой шийдлийг холбогдох хууль тогтоомжуудад тусган хэрэгжүүлэх нэн шаардлагатай байна.

ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ ОНОВЧТОЙ БОЛГОХ АРГА ЗАМУУД

А.БАЛДАНГОМБО

(Шихихутуг их сургуулийн магистрант)

Түлхүүр үгс: Иргэний нийгэм, иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллага, ашгийн төлөө бус байгууллага, зарчим, үнэт зүйл, иргэний нийгмийн үүсэл, хөгжил, хөгжлийн чиг хандлага

Абстракт: Сэдвийн хүрээнд иргэний нийгмийн тухай ойлголт, хөгжлийн чиг хандлага, эрх зүйн зохицуулалтын асуудлуудыг тухайлан авч үзэхийг хичээв. Монгол улсад иргэний нийгмийн тухай 2010 оноос яригдаж эхэлсэн харьцангуй богино намтар түүхтэй. Энэхүү өгүүлэлдээ төрийн бус байгууллагууд, иргэний нийгмийн төлөөллүүд, иргэний нийгэм ямар үүрэг, рольтой, яагаад иргэний нийгэм хэрхэн оршин байдаг талаар хөндөхөөс гадна өнөө цагт иргэний нийгмийн байгууллагуудын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим эмзэг асуудлыг хөндөх болно.

Иргэний нийгмийн тухай ойлголт

“Иргэний нийгэм” гэх ухагдахуун эртний Грек, Ромын “Politia” ба “Societas Civilis” гэх үгнээс гаралтай аж. Анхандаа төрийн зохион байгуулалтын зэрэгцээ иргэдийн идэвхтэй амьдралын хэв маяг оршин байсныг Грек, Ромын сэтгэгчид тэмдэглэн үлдээжээ. Гэвч иргэний нийгмийн үзэл санаа нь хоёр өөр хэлбэрээр хөгжиж ирсэн байна. Эхнийх

нь иргэний нийгэм төрөөс төдийлэн ялгараагүй, улс төрөөс хамааралтай ‘улс төрийн нийгэмлэг’(societas civilis эсвэл koinonia politike)-ийн хэлбэрийг илэрхийлэл, тодруулбал, чиг үүргийн хувьд төртэй илүү нягт холбоотой байж, нийгмийн амар тайван байдлыг хангах зорилгоор хууль, институтээр дамжуулан хэрэгжүүлдэг эрх мэдлийн харилцаа юм. Хоёр дахь хэлбэр нь иргэншил, нийгмийн эв нэгдэл, ёс суртахууныг бий болгох зорилгоор өөрсдийгөө зохион байгуулж, удирдан зохицуулж, эдийн засгийн уялдаа бүхий зах зээлийн чөлөөт байдлыг эрхэмлэдэг хувь хүмүүсийн хоорондын харилцааг агуулжээ¹. Бүр 18-р зууны сүүлч, 19-р зууны эхэн үеэс “иргэний нийгэм” гэх ойлголт улс төрөөс ангид, бие даасан шинжтэй болж эхэлжээ.² Уг ойлголтыг цаашид хөгжүүлэхэд Т.Гоббс, Ж.Локк, Ш.Монтескье, Ж.Руссо, Г.Гегель, И.Кант, К.Маркс нар зүй ёсоор яригдах бөгөөд, дараа нь М.Вебер, П.Сорокин, С.Франк, Г.Алмонд, К.Поппер нарын эрдэмтэд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн байна. Тухайлбал, Ж.Локк “Иргэний нийгэм нь төрөөс анхдагч бөгөөд

¹ Civil Society, Concept and History, Islamoglu, H. 2015.

² Иргэний нийгмийн байгууллага гэдэг нэр томъёог Шотланд социологич Adam Ferguson анх “An Essay on the History of Civil Society”, Boulter Grierson, Dublin 1767 бүтээлдээ гаргаж ирсэн.

төрийг нөхцөлдүүлдэг үндэс суурь юм, харин эдийн засгийн суурь нь хувийн өмч мөн” гэжээ. Ш.Монтескью “Иргэний нийгэм бол хүн төрөлхтөний хөгжлийн үр дүн, жам ёсны төлөв байдал бөгөөд иргэдийн эсрэг бусдын дур зоргоор авирлах явдлаас хамгаалж байдаг” хэмээн тодорхойлсон байна. Их гүн ухаантан Гегель “Иргэний эрхээр харилцан үйлдлээ зохицуулдаг хувь хүн, анги, бүлэг, давхарга, институцийн нэгдэл нь үнэндээ төрөөс төдийлөн хамааралгүй байдаг, энэ нь чухамдаа иргэний нийгэм юм” гэж тодорхойлсон, тэгсэн атлаа “Эрх зүйт төр ба иргэний нийгэм бол нэг зоосны хоёр тал” гэжээ. Германы социологич Ральф Дарендорф иргэний нийгмийг “...өнөө цагт төрөөс ангид, олон тохиолдолд төрийн эсрэг хүч, эрх мэдлийн эх үүсвэрийг бий болгох боломжтой бүтэц юм. Үүнийг засаг, нам болж дүрээ хувиргасан монополь эрх мэдэлтнүүдэд устгуулах боломжгүй, олон мянган төвтэй, олон хараат бус институци, байгууллагуудын шигүү сүлжээг бий болгосоноор хэрэгжүүлнэ. Иргэний нийгэм нь нэгэн утгаараа өөрөө өөрийнхөө амьдралыг тэтгэдэг гэж хэлж болно” хэмээжээ. Эндээс иргэний нийгмийн тухай ойлголт нь хүний эрх, эрх чөлөөний үзэл санаатай салшгүй холбоотой, нийтлэг утгаараа хүмүүс төрийн шууд оролцоогүйгээр өөрсдийн өдөр тутмын амьдралын хэрэгцээ, ашиг сонирхлоо хэрэгжүүлж байгаа хэлбэр, хүрээ бөгөөд сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэх, зохион байгуулагдах, өөрсдийгөө удирдах зарчмаар үйл ажиллагаа явуулдаг орчин гэж дүгнэх үндэслэл байна. Энэ нь төр, хувийн

хэвшлийн орон зайнаас бусад нөхцөлд илэрдэг. Түүнийг эрх, ашиг сонирхлоо хамгаалах эрмэлзэлтэй хувь хүн, нөгөө талаас нийтийн ашиг сонирхлын тусын тулд шийдвэр гаргаж байдаг төр хоёрын хооронд орших тусгай ашиг сонирхол бүхий нийгмийн жижиг нэгдлүүд гэж тодорхойлох үндэслэлтэй. Эндээс: **Иргэний нийгмийн байгууллага** гэдэг нь нийгэм, эдийн засаг, улс төр, оюуны хэрэгцээний нийтлэг ашиг сонирхлоо хэрэгжүүлэн хамгаалах зорилгоор зохион байгуулагддаг хүмүүсийн сайн дурын нэгдэл юм. Тиймээс иргэд сайн дурын үндсэн дээр эвлэлдэж, эсвэл дангаараа нийтлэг эрх ашиг, зорилго, үнэт зүйлсийн төлөө гэр бүл, төр, зах зээлээс гадуур үйл ажиллагаа явуулдаг орон зай, талбарыг иргэний нийгэм гэж тодорхойлж болох юм. Иргэний нийгэм нь иргэд үзэл бодол, нийтлэг ашиг сонирхлоороо нэгдэн улс төр, эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлыг шийдвэрлэхэд орон нутаг болон үндэсний хэмжээнд оролцдог албан ба албан бус бүлэг, төрийн бус байгууллага болон хувь хүмүүсийн төрөл бүрийн нийгэмлэгийн цогц шинжийг агуулна.

Иргэний нийгмийн үндсэн шинж

Иргэний нийгмийн үндсэн шинж нь эдийн засаг, улс төр, оюун санаа гэсэн гурван гол хүрээг агуулна.

Эдийн засгийн хүрээн дэх үндсэн шинж нь хүн бүр оршин тогтнох, амьдрах үндэс болсон хувийн өмчтэй байх явдлаар илэрдэг. Өөрөөр хэлбэл, иргэний нийгэм нь хувийн өмч дээр тулгуурлан үүсч хөгждөг гэсэн үг.

Улс төрийн хүрээн дэх иргэний нийгмийн

үндсэн шинж нь эрх чөлөөт иргэн, олон ургальч үзэл, эрх зүйт төрийн үйл хэрэгт шууд болон төлөөллийн зарчмаар оролцох хэлбэрээр тодорхойлогдоно. Төрөөс хараат бус байж, төрийн засаглалыг шүүмжлэх, дэмжиж буй улс төрийн нам, эвсэл, холбоонд харьяалагдах эсэх, төрийн засаглалын болон орон нутгийн сонгуульд оролцох эсэх нь аливаа чөлөөт иргэний үндсэн эрх байдаг. Өөрөөр хэлбэл үг хэлэх, хэвлэн нийтлэх, эвлэлдэн нэгдэх зэрэг хүний жам ёсны болон олдмол эрх, эрх чөлөөг төрөөс хүлээн зөвшөөрч, хангаж, хамгаалсан байх ёстой юм.

Оюун санааны амьдралын хүрэн дэх иргэний нийгмийн үндсэн шинжийг нийт хүн төрөлхтөний үнэт зүйлсийг дээдлэх гэсэн агуулгаар илэрхийлж болно. Хүний эрх, эрх чөлөө, хуулийн өмнө эрх тэгш байх нь иргэний нийгэмд бүх хүмүүсийн "гараан дээрх" хууль зүйн эрх тэгш байдлыг хангаж, хүн бүрийн бүтээлч идэвхийг нээн харуулах нөхцлийг бүрдүүлэхэд оршино. Иргэний нийгэм хөгжих бас нэг чухал нөхцөл бол нийгэмдээ идэвхтэй үйл ажиллагаа явуулах иргэдийн идэвх, санаачлага, тиймээс иргэний үүрэг, иргэний нэр төр гэх зэрэг ёс суртахууны категориудын зохистой үйлчлэл нь иргэний нийгмийг хөгжүүлэх чухал хэрэгсэл болдог.

Иргэний нийгмийн үнэт зүйлс

Юуны урьд хүний эрх, үндсэн эрх чөлөө, ардчиллыг онцлох нь зүйн хэрэг. Эдгээр үнэт зүйлс нь хүн төрөлхтний хувьд түгээмэл ойлголт, иймээс аль ч ардчилсан улс оронд Үндсэн хууль, бусад хуулиар баталгаажсан байдаг.

Харин үйлчилж байгаа эсэх нь :

Хувийн өмчийг хүлээн зөвшөөрсөн, иргэд нь өмчтэй, тэд төрөө сонгож байгуулах, төрийн удирдлагад оролцох, нийтлэг үнэт зүйл, эрх ашгийг өмгөөлж, хамгаалах, үг хэлж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх, эвлэлдэн нэгдэх, тайван замаар жагсаал цуглаан хийх зэрэг эрх нь хуулиар баталгаажсан байх гол шалгуураар тодорхойлогдоно.

Мөн хувь хүн, бүлэг, нийгэмлэгийн сайн дурын үйл ажиллагаа, ивээлийн үйлс нь зах зээлийн нийгмийн жам ёсны үйл явцад үүссэн нийгмийн эмзэг, ядуу хэсгийн амьдралыг тэтгэх, тохиолдлын гамшиг, хүндрэлд нэрвэгдсэн хүмүүст сайн санааны туслалцаа, дэмжлэг үзүүлэх зэргээр илэрхийлэгдэх учиртай. Ийм үйл ажиллагааг голлон эрхэлдэг иргэд, хамтлагийг сайн дурынхан гэж нэрлэнэ. Сайн дурын үйл ажиллагаа гэдэг нь бусдын сайн сайхны төлөө хариу нэхэхгүй "шан, харамж"-гүйгээр, бага хөлсөөр ажиллах явдал. Сайн үйл бүтээх хүсэлтэй иргэд нэмэгдэхийн хирээр улс орны хүмүүнлэг энэрэнгүй шинж бэхжинэ. Иргэний нийгмийн байгууллагуудын хөдөлгөгч хүч бол яах аргагүй сайн дурынхан. Филантропийн бусад үйл ажиллагааг ч бас үүнд хамруулж болно.

Нийгмийн инноваци. Нийгмийн инноваци гэдэг нь нийгэм, эдийн засгийн бүхий л ажил, үйлийг илүү оновчтой, үр дүнтэй шинэлэг арга хэлбэрээр хэрэгжүүлэх явдал. Иргэний нийгмийн байгууллага нь нийгмийн шинэтгэлийг хувь хүн, бүлэг, хамт олны түвшинд түгээн дэлгэрүүлж манлайлах

үүрэгтэй. Энэ утгаараа тэд нийгмийн инновацийг гол хэрэгжүүлэгчдийн нэг. Хуримтлуулсан мэдлэг туршлага, үйл ажиллагааны уян хатан, шуурхай чанар, хөгжингүй мэдрэмж, бүтээлч хандлага зэрэг иргэний нийгмийн байгууллагын шинж чанар нь нийгмийн инновацийг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.

Нийгмийн эдийн засаг. Ашгийн төлөө бус бизнес эрхлэх үйл ажиллагаанд тулгуурлаж тойрч үүсдэг эдийн засгийн харилцаа бол энэ үнэт зүйлийн гол агуулга болдог. Нийгмийн эдийн засаг нь эмзэг бүлгийг хамгаалах, нийгэм, эдийн засаг, хүрээлэх орчноо сайжруулахад чиглэсэн ашгийн төлөө бус аж ахуйн үйл ажиллагаагаар бэхэждэг. Нийгмийн эдийн засгийн чиг баримжаатай иргэний нийгмийн байгууллага нь ажлын байр нэмэгдүүлэх, мэргэжлийн сургалт явуулах, орчноо тохижуулах, байгаль орчныг хамгаалах, эмзэг бүлгүүдийг чадавхжуулах зэрэг тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, улмаар эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чухал нөлөөтэй байдаг.

Иргэний нийгэм, түүний байгууллагуудын оршин байх үндсэн нөхцлийг тодорхой чиглэлүүд, янз бүрийн төрөл хэлбэрээр зохион байгуулагддаг тэдний үйл ажиллагаа харуулна. Тэрхүү үйл ажиллагааны чиглэл, баримтлах зарчим, зохион байгуулалтын төрөл хэлбэрийг цогцоор нь иргэний нийгмийн бүрдэл хэсгүүд хэмээдэг.

Иргэний нийгмийн үүрэг, үйл ажиллагааны онцлогийг тусгасан үнэт зүйлс нь:

- Хуулийн хүрээнд иргэний хувийн эрх чөлөөг хамгаалах,
- Нийгэмлэг, бүлэг, холбоо, хөдөлгөөн зэрэг бүрдэл хэсгүүд өөрийн удирдлага, хариуцлага тооцох механизмтай байх,
- Иргэний улс төрийн оролцоог хангах нөхцлийг бүрдүүлэх,
- Засаглалын субьектүүд нийтийн эрх ашиг, хэм хэмжээг хэрхэн сахин хамгаалж буйд хяналт тавих,
- Олон янзын ашиг сонирхлыг хооронд нь зуучлан уулзуулж, харилцан ойлголцох хамтын харилцааны үүрэг гүйцэтгэдэг,
- Нийгмийн харилцааг тогтворжуулахаар илрэнэ.

Иргэний нийгэм оршин тогтохын тулд үйл ажиллагааны чиглэл, шинж байдалтай холбоотой эдгээр үнэт зүйлсийг эрхэмлэн дээдлэх нь чухал. Тэгээд ч үйлдэл, үйл ажлаар илэрч байдаг үнэт зүйлс нь иргэний нийгмийн төлөвшлийг хэмжих шалгуур юм.

Иргэний нийгмийн олон улсын байгууллагын баримт бичиг, тунхаглалд тусгасан зарчим, үнэт зүйлс

Дэлхийн II дайны дараагаар Нэгдсэн Үндэстний байгууллага байгуулагдаж, Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсанаар иргэний нийгмийн хөгжилд хүчтэй түлхэц үзүүлсэн юм. Иргэний нийгэм, иргэний нийгмийн байгууллагууд үүсч хөгжихөд нэн шаардлагатай зарчим, үнэт зүйлсийг

Хүний эрхийн түгээмэл тунхаглал³-д тусгаж өгсөн байдаг. Гэвч дайны дараах үзэл бодлын өрсөлдөөн, Зөвлөлтийн Орос хийгээд Америкийн Нэгдсэн Улс тэргүүлсэн улс хоорондын хурцадмал байдал иргэний нийгмийн хөгжлийг орон бүрт харилцан адилгүй хөгжих үндсийг тавьж орхисон. Гэхдээ олон улсын хүний эрхийн эрхзүйн хүрээнд хоёр чухал пакт⁴ батлагдсан явдал нь иргэний нийгмийн суурь үзэл санааг хөгжүүлэхэд түлхэц үзүүлжээ⁵. Олон улсын эдгээр баримт бичигт тусгалаа олсон зарчим, үнэт зүйлсийг тоймлон дурьдвал⁶:

Олон янз байдлыг хөхиүлэн дэмжих⁷

Хүмүүсийн эрэлт хэрэгцээ нь олон янз бөгөөд, байнга хөгжин өөрчлөгдөж байдаг тул тэдний эрх ашгийг төлөөлөн илэрхийлэх, тэдэнд үйлчлэх төрийн бус байгууллагууд шинээр бий болж, төрөл хэлбэр олшрон нэмэгдэх явдлыг иргэний нийгэм дэмжиж ажиллана.

Хамтарч ажиллах

Төр, иргэний нийгэм нь улс орныхоо үйл хэрэгт өөр өөрийн ялгаатай,

³ Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 217/A/III/ тогтоолоор Парист батлагдсан.

⁴ Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200A(XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон*.

⁵ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2200A (XXI) дугаар тогтоолоор баталж, 1976 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

⁶ Хөгжлийн үр ашигтай хамтын ажиллагааны Бусаны түншлэл, 2011 он

⁷ Үр ашигтай хөгжлийн төлөө иргэний нийгмийн байгууллагуудын хөгжлийн түншлэлийн тайлан, 2018

харилцан шүтэлцээтэй үүрэг гүйцэтгэж, хариуцлага хүлээдгээ ойлгож өөр хоорондоо болон холбогдох талуудтай эрх тэгшээр хамтран ажиллана.

Иргэний нийгмийн байгууллагын бие даасан, хараат бус байдлыг эрхэмлэх

Иргэний нийгмийн байгууллага нь төрийн ямар нэгэн шахалт, нөлөөнөөс ангид байх нь нийтлэг эрх ашиг, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, төрийн үйл ажиллагаанд хяналт тавьх үндсэн чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх гол нөхцөл болдог. Иргэд, тэдгээрийн байгууллагууд нь зорилго, зорилтоо өөрсдөө тодорхойлж, үйл ажиллагаагаа үндсэн хуулийн хүрээнд явуулах эрхийг төр хүндэтгэх.

Бодлогын хэлцэл хийх

Төрийн бодлого, шийдвэр нь иргэн бүрийн аж байдал, эрх ашигт шууд хамааралтай байдаг. Бодлого, шийдвэр боловсруулах явцад иргэд өөрийн эрх, эрх ашгаа хувиараа буюу иргэний нийгмийн байгууллагаар дамжуулан илэрхийлэх нь ардчиллын хэм хэмжээ юм.

Бодитой оролцоог хангах

Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцад бодитой оролцох боломжийг бүх талуудад олгох үүргийг төр, иргэний нийгмийн байгууллага нэгэн адил хүлээнэ. Ялангуяа орлого багатай ба эмзэг бүлгүүдийг (хэл, яс үндэс, нас, хүйс, орлого, газар зүйн байршил зэрэг шинж байдлын улмаас орхигдон эрх мэдлийн хомсдолд орсон г.м) бодлого, шийдвэр, үйл ажиллагаа төлөвлөх, хэрэгжүүлэхэд

ажилд татан оролцуулахыг онцгой анхаарах нь зүйтэй.

Чанарыг хангах

Төр болон иргэний нийгмийн байгууллага нь гүйцэтгэж буй ажил, үйлчилгээнийхээ чанарын төлөө иргэдийн өмнө хариуцлага хүлээнэ. Төрийн үйл ажиллагааны чанарыг хангахад иргэний нийгмийн хяналт чухал үүрэгтэй. Иргэний нийгмийн байгууллага нь төрийн өмнөөс ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа бол холбогдох хууль журмыг мөрдөж ажиллах үүрэг хүлээдэг.

Тогтвортой хөгжлийг хангах

Иргэний нийгмийн байгууллага (ИНБ)-ын үйл ажиллагаа нь хувь хүн, хамт олныг төлөвшүүлэх, тэдгээрийн амьдрах ухааныг хөгжүүлэх, аж байдлыг нь сайжруулахад чухал үүрэгтэй. Иймээс ИНБ-ын санхүүгийн болон бусад чадавхийг нэмэгдүүлж институцийн тогтвортой хөгжлийг хангахад анхаарах.

Ил тод байх

Төр ба ИНБ хамтран ажиллах, олон нийттэй харилцах явдал нь итгэлцэлд суурилах учиртай бөгөөд энэ нь мэдээллийн нээлттэй орчныг шаардана. Ил тод байдлын зарчмыг хэрэглэх нь ИНБ-ын үйлчлүүлэгч, сайн дурын болон орон тооны ажилтан, гуравдагч тал болон байгууллагын дотоод ардчилалд аливаа хор уршиггүй байвал зохино.

Хариуцлага хүлээх

Төр, ИНБ-ын санхүүжилтийн эх үүсвэр нь татвар төлөгчдийн, эсвэл иргэдийн хөрөнгө байдаг тул үйл ажиллагааны төлөвлөлт, санхүүгийн зарцуулалт, үр дүнг дээд зэргийн нээлттэй, ил тод байлгаж, хариуцлага хүлээх учиртай. Тийм институцийн чадавхи төрд ч, ИНБ-д ч ижил байх ёстой.

Авлигаас ангид байх

Төрийн захиргааны болон нутгийн удирдлагын байгууллага нь гэрээгээр буюу төслөөр ажил, үйлчилгээ гүйцэтгэх, төрийн тэтгэлэг авах ИНБ-ыг сонгон шалгаруулахдаа гориллогч талуудтай ашиг сонирхлын зөрчил, авлига дагуулж болзошгүй аливаа харилцаанд орохоос зайлсхийнэ.

Өнөөгийн эрх зүйн зохицуулалт


Монгол Улсын Үндсэн хуульд⁸ "...эх орондоо хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм цогцлон хөгжүүлэхийг эрхэм зорилго..." болгон тунхагласан билээ.

Төр, эрх зүй нь нэг хэв маягаас нөгөөд шилжих асуудал нь орчин үеийн постсоциалист улсуудын онол, практикийн хамгийн чухал асуудлын нэг болоод байна. Энэ шилжилт нь хэд хэдэн улс орноор үл хязгаарлагдах дэлхий нийтийн шинжтэй үзэгдэл юм.

Монголын иргэний нийгмийн тойм бүүдүүвчийг дараах байдлаар харуулья⁹:

⁸ Монгол улсын Үндсэн хууль (1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан).

⁹ Г.Чулуунбаатар, Орчин үеийн иргэний нийгмийн үнэт зүйл, шалгуур үзүүлэлт, Монгол дахь иргэний нийгмийн төлөвшил, УБ., 2013



1990 оноос өмнө Монгол Улсын Засгийн газар социалист дэглэмийн хүрээнд Иргэний нийгмийн байгууллага (ИНБ)-уудыг олон нийтийн байгууллага гэж нэрлэж,

ажиллуулж байсан. Үүнд, Үйлдвэрчний эвлэл, Монголын залуучуудын холбоо, Монголын эмэгтэйчүүдийн холбоог юуны урьд нэрлэж болно.

Ардчилсан хөдөлгөөн үүсэж, 1992 онд анхны Үндсэн хуулиа батласанаар 1990 оны үүсэл бүхий ИНБ-ууд шинэчлэгдэн, үйл ажиллагаа нь бие даасан шинжтэй болов. 1992 оноос өмнө Монголын ардчилсан холбоо эвсэл, Монголын социал демократ хөдөлгөөн гэх мэт ИНБ-ууд улс төрийн зорилгоор байгуулагдаж байсан. Дараагаар нь ИНБ-ууд төрөл бүрийн бүлгүүдийн нийтлэг эрх ашгийг хамгаалахаар байгуулагдаж эхэлсэн. Тухайлан нэрлэвэл: Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан, Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн, Тогтвортой хөгжил жендэрийн төв, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв зэрэг

орно.¹⁰ Ардчилсан тогтолцоонд иргэний нийгмийн хөдөлгөөнүүд нь Монголын нийгмийн хамгийн идэвхтэй хэсгүүдийн нэг болов. Сүүлийн хорин жилд төрөл бүрийн салбар, чиглэлийн ИНБ-ууд олноор үүсч байгаа хэдий ч хууль эрх зүйн орчин ИНБ-ын хөгжлийн өнөөгийн хэрэгцээг хангахгүй байна.¹¹

Үндэсний статистикийн хорооны мэдээллээс үзвэл 2020 оны байдлаар Монгол улсын хэмжээнд 24000 гаруй төрийн бус байгууллага бүртгэлтэй байна.¹²

Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 10-т Монгол улсын иргэн нь "Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс... олон нийтийн бусад байгууллага байгуулах,

¹⁰ Д.Бямбажав. 2006. Монгол дахь ТББ: Монголын нийгэм, улс төр дэх чухал хүчин зүйл. Олон улсын харилцааны сэтгүүл. №13. Хуудас 132–146.

¹¹ 2013. ТББ-ыг хөгжүүлэх сүлжээний хандлага: Монгол дахь эмэгтэйчүүдийн ТББ-ууд. Ашгийн төлөө бус хуулийн тухай олон улсын сэтгүүл. №15(1). 3-р сар. Вашингтон, ДС: Ашгийн төлөө бус хуулийн олон улсын төв.

¹² Монгол улсын Үндэсний статистикийн хороо, 2020 он

сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй... олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн... олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно” хэмээн иргэдийн эвлэлдэн нэгдэх, зохих хэлбэр бүхий байгууллагуудыг байгуулан нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлыг илэрхийлэх, хэрэгжүүлэх хууль зүйн үндэслэлийг хуульчилсан байдаг.¹³ Мөн Монгол улсын нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын¹⁴ 22 дугаар зүйлд “Хүн бүр бусадтай эвлэлдэн нэгдэх, түүний дотор өөрийн эрх ашгийг хамгаалах үүднээс үйлдвэрчний эвлэл байгуулах буюу түүнд элсэх эрхтэй”¹⁵ гэж иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх нь улс төрийн болон нийгэм, соёлын эрхээ эдлэх, хамтдаа улс орны хөгжлийн үйл явцад оролцох боломжийг хангахад чухал нөлөөтэй болохыг тодотгон гишүүн улс орнуудын Засгийн газрыг үүрэг хүлээлгэсэн байдаг.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Төрийн бус байгууллагын тухай хууль 1997 онд батлагдсан бөгөөд тус хуульд

“төрийн бус байгууллага” гэж иргэд, төрийн байгууллага (хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллага)-аас бусад хуулийн этгээдээс нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулагдан үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус байгууллагыг хэлнэ” хэмээн заажээ.¹⁶ Тус хууль хэрэгжиж эхлэсэнээс хойш 20 жилийн хугацаанд нийгмийн өөрчлөлтийг дагаж төрийн бус байгууллагуудыг үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, зохион байгуулалтын хэлбэрт томоохон өөрчлөлтүүд гарсан байна. Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын¹⁷ 3 дугаар зүйлийн 3-т “Хүний эрх, эрх чөлөөг хангаж, Үндсэн хуульт байгууллыг бататгаж, хууль дээдлэх ёс, монгол төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг сахин дээдэлж, төрийн удирдлагыг бэхжүүлж, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, чөлөөт хэвлэл мэдээллийн төлөвшлийг дэмжиж, нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс мөн” хэмээн тодорхойлж, улмаар тус чиглэлд аюулгүй байдлыг хангахын тулд... аж ахуйн шинжтэй чиг үүргүүдийг иргэний нийгмийн байгууллагуудаар гүйцэтгүүлэх бодлого баримтална”¹⁸, “Төрийн бодлого боловсруулах, төрд хяналт тавихад төрийн бус байгууллагын

¹³ Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйл (1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан).

¹⁴ Монгол улс 1968 оны 01-р сарын 05-нд гарын үсэг зурж, 1974 оны 11-р сарын 18-нд соёрхон батласан.

¹⁵ ИУЭУОП-ын 22-р зүйлийн 9-т “шууд болон төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах эрхтэй”, 12-т “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй”, 16-д “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй”

¹⁶ Төрийн бус байгууллагын тухай хууль 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр батлагдсан.

¹⁷ Монгол улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт

¹⁸ Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3.2.5 дахь заалт

тэгш оролцоо, зөвшилцлийг хангах замаар иргэний нийгмийн төлөвшлийг дэмжинэ. Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн орчинг дэмжсэн эрх зүйн орчинг бүрдүүлж, төр-иргэний нийгмийн хамтын ажиллагааны бүтээлч арга, хэлбэрүүдийг хөгжүүлнэ”¹⁹ гэж тус тус заасан байна. Төрийн бус байгууллагын тухай хуульд 1998-2016 оны хооронд нийт 6 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан. Жишээлбэл, 1998 онд орсон Татварын ерөнхий хуулийн, 2002 оны Иргэний хуулийн, 2003, 2015 онуудад Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн, 2015 онд Эрүүгийн хуулийн шинэчлэл болон 2016 онд Төрийн болон албаны нууцын тухай хуультай уялдуулан нэмэлт, өөрчлөлтүүдийг Төрийн бус байгууллагын тухай хуульд оруулсан байдаг.²⁰ Эдгээр нэмэлт, өөрчлөлтүүд нь тухайн салбарын хуулиудын хэрэгцээнд үндэслэсэнээс бус төрийн бус байгууллагын онцлог, хэрэгцээ, шаардлагыг харгалзаагүй, харин ч эрх зүйн нөхцөл, байдлыг дордуулсан шинжтэй болсон байна. Түүнчлэн Иргэний хуультай нийцүүлэх талаар хангалттай зохицуулалт хийгээгүй, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд төрийн бус байгууллагын хэлбэр болон үйл ажиллагааны төрлийг хольж бүртгэх, ойлголт, нэр томъёоны хэрэглээний хувьд ойлгомжгүй байдал үүсэхэд хүргэжээ.²¹

ТББ түүнийг хэрхэн ойлгох талаар 1997 оны Төрийн бус байгууллагын тухай хуульд л зохицуулсан ба “холбоо” гэсэн нэр томъёо одоог хүртэл тус хуульд байхгүй харин “сан” гэх нэр томъёо 2002 онд Иргэний хууль шинэчлэгдсэнтэй холбоотойгоор орсон.

2002 онд шинэчлэн батлагдсан Иргэний хуулиар “ашгийн төлөө бус хуулийн этгээдийн хэлбэрүүдийг “холбоо, сан, хоршоо” гэж нэрлэсэн ч тус хуулийн 36.6-д “сүм хийд” нь иргэний эрх зүйн харилцаанд оролцохдоо сангийн эрх зүйн байдлын талаарх хуулийн заалтыг мөрдөнө гэж зохицуулсан. Улмаар Иргэний хуулийн 36.3 болон 36.5-д “Холбоо, сангийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно”, “хоршоотой холбоотой бусад харилцааг хуулиар зохицуулна” гэж тус тус заасан. Харин Иргэний хуулийг дагаж мөрдөхтэй холбоотойгоор Иргэний хуульд өмнө нь батлагдсан байсан “ТББ-ын тухай хууль”-ийг нийцүүлэхдээ: “Сангай холбоотой тусгай зохицуулалт” гэх 7-р бүлгийг “ТББ-ын тухай хууль”-д шинээр нэмсэнээр Иргэний хуулийн “сан” гэсэн бие даасан хэлбэр нь ТББ гэх Иргэний хуульд байхгүй хэлбэрийн дотор багтах гажуудлыг бий болгосон. Үүний үр дагаварт Хуульч эмэгтэйчүүдийн Холбоо гэж бүртгэлтэй байгууллага нь Хуульч эмэгтэйчүүдийн холбоо ТББ, Залуу удирдагч Сан байсан нь Залуу удирдагч сан ТББ гэх болсон. Ийнхүү “сан”-ийн зохицуулалтыг ТББ-ын тухай хуульд нэмсэн Иргэний хууль болон Төрийн бус байгууллагын тухай хууль зөрчилдөж байсныг засаж чадаагүй төдийгүй улам бүр зөрчилдүүлж, гажуудуулсан гэдгийг

¹⁹ Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3.4.2 дахь заалт

²⁰ Төрийн бус байгууллагын тухай хууль

²¹ Төрийн бус байгууллагын тухай хуулийг шинэчлэх хэрэгцээ, шаардлагыг тандан судласан судалгааны тайлан. 2017 он

хуулийг шинэчлэх хэрэгцээ, шаардлагыг тандан судласан судалгааны тайланд тодорхой дурьджээ.²²

Тиймээс үүссэн нөхцөл байдалд эрх зүйн орчинг цаашид олон улсын жишигт нийцүүлэх асуудал зайлшгүй тулгарч буй тул дараах шүүмжлэлт дүгнэлтийг хийж байна.

Санал, дүгнэлт

Эрх зүйн зохицуулалтын оновчтой бус байдлыг үүсгэж байгаа гол шалтгаан нь:

2002 онд Иргэний хуулийг шинээр батласаны дараа ТББ-ын тухай хуулийг Иргэний хуульд нийцүүлээгүйгээс нэр томъёоны зөрчил үүсэж Иргэний хуульд заасан "холбоо", "сан" гэх хуулийн этгээд нь ТББ гэх хуулийн этгээдийн доторх дэд хэлбэр эсхүл оноосон нэр мэтээр хэрэглэгдэх буруу жишиг тогтсон. Үүнийг 2003 оны Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн дагуу (Иргэний хуульд нийцсэн) "холбоо", "сан" гэсэн хэлбэртэйгээр бүртгэдэг байсныг 2015 оноос шинэ хууль гарч "ТББ" гэж бүртгэж байхаар өөрчилсөн.

Төрийн бус байгууллагын тухай хууль хэрэгжсэн 20 жилийн хугацаанд ТББ-ын нийгэмд гүйцэтгэх үүрэг, тэдгээрийн онцлог болон хуулийн хэрэгжилтийн сул талыг харгалзсан дорвитой өөрчлөлт хийгдээгүй байна. Зөвхөн бусад хуулийн шинэчлэлийг дагаж нэмэлт, өөрчлөлт оруулж ирсэн нь энэ төрлийн харилцааг бүхэлд нь зохицуулах боломжгүйн зэрэгцээ эрх зүйн шинэчлэлээс хоцорч, улмаар эрх зүйн зохицуулалтын хувьд

бусад хуулиудтай зөрчилдөх байдалд хүрсэн.

Төрийн бус байгууллага болон Ашгийн төлөө бус байгууллага, нийтийн эрх зүйн хуулийн этгээд (олон нийтийн байгууллага)-ийн нийтлэг байдал, тэдгээрийн онцлог ялгааг харгалзсан нэгдсэн зохицуулалтгүй байдал нь нэг талаас "ТББ"-ыг өргөн хүрээтэй ойлгож хэрэглэх, нөгөө талаас "ТББ"-ын дор сан болон сайн дурын ГҮТББ болон НҮТББ-ыг ойлгох хоёрдмол байдлыг бий болгосон. Нийгэмд үйлчилдэг болон Гишүүддээ үйлчилдэг ТББ-уудын онцлогийг үл харгалзан нийтлэг байдлаар нэгтгэн зохицуулсан нь төр болон иргэдийн үүсгэл санаачлага, ТББ-уудад аль алинд нь ачаалал үүсгэж, үр дүнгүй, хэрэгжих боломжгүй хяналтын тогтолцоог практикт бий болгосон.

Төрийн зарим чиг үүргийг ТББ-аар гүйцэтгүүлэх, төр зарим чиг үүргээ шилжүүлэхэд зарим НҮТББ гэж бүртгэгдсэн байгаа Мэргэжлийн холбоодыг иргэний эрх зүйд үндэслэсэн болон Нийтийн эрх зүйн хуулийн этгээд байх 2 өөр эрх зүйн салбарын хуулийн этгээд болохыг онцлон ялгаж иргэний эрх зүйд үндэслэсэн буюу тусгайлсан хуулийн дагуу бус мэргэжилтнүүд сайн дураар нэгдэн байгуулагдсан Мэргэжлийн холбоог ТББ-ын тухай хуулиар зохицуулах нь оновчтой. Харин МУ-ын ТББ-ын тухай хууль нь зөвхөн иргэний эрх зүйн хуулийн этгээдээр хязгаарлагдаагүй онцлог давуу талыг ашиглан Нийтийн эрх зүйн зарим хуулийн этгээдэд тавих нийтлэг шаардлага, үүрэг хариуцлагыг ТББ-ын тухай нөхөн зохицуулах боломжийг

²² Төрийн бус байгууллагын тухай хуулийг шинэчлэх хэрэгцээ, шаардлагыг тандан судласан судалгааны тайлан. 2017 он

ашиглах зүйтэй. Ийнхүү зохицуулах Иргэний хууль тогтоомж болон Захиргааны хуультай зөрчилдөхгүй байх талаас анхаарах шаардлагатай.

Төрөөс ТББ-уудад үзүүлэх дэмжлэг хязгаарлагдмал, түүний онцлогт нийцсэн татвар, хураамжийн хөнгөлөлтийн бодлого байхгүй, гэрээгээр гүйцэтгүүлэх чиг үүргийн хүрээ, шалгуур тодорхойгүйгээс ТББ-уудын хувьд төртэй хамтран ажиллахын тулд бизнесийн байгууллагын нэгэн адил шалгуураар хэмжигдэхэд хүрсэн.

ТББ-уудын хариуцлагын байдлыг зөвхөн төрийн байгууллагад тайлагнах байдлаар хязгаарласан нь олон нийтэд нээлттэй байх, нийгмийн өмнө хариуцлагатай байх зарчмыг алдагдуулж, улмаар олон нийтийн итгэл буурах, цаашлаад дэмжлэг хүлээх хүрээг хумихад хүргэсэн.

Иймд Төрийн бус байгууллагын тухай хуулиар дараах харилцааг нарийвчлан зохицуулах талаар дараах саналуудыг гаргаж байна.

Холбоо, санг ТББ-ын нэг хэлбэр гэж ТББ-ын тухай хуульд ялгаатай зохицуулсанаар Иргэний хуулийн 36.2 дахь заалтад заасан Холбоо, Сан нь тусдаа хуулиар зохицуулах асуудал шийдэгдэж, Иргэний хууль ба ТББ-ын тухай хуулийн зохицуулалт дахь зөрчлийг арилгах боломж бүрдэнэ.

Холбоо, Сан, олон нийтийн хандив, хөнгөлөлт, дэмжлэг илүүтэй хүлээдэг ТББ-уудаас үйл ажиллагааны тайланг

олон нийтэд нээлттэй байлгах, ТББ-н хяналтыг хэрэгжүүлэх төрийн эрх бүхий этгээдээс хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг нарийвчлах, ТББ-ыг албадан татан буулгахад, хөрөнгийг шилжүүлэхдээ тухайн байгууллагын үндсэн зорилгыг эрхэмлэх зэрэг онцлог зохицуулалтыг хуульчилж өгөх.

Иргэний нийгмийн байгууллага гэх ойлголтод багтах Сайн дурынханы үйл ажиллагаа, Иргэний нийгмийн төлөөх үүсгэл санаачлагыг (Buergerinitative) нийтэд тустай байх гол шинжээр нь тодорхойлох, улмаар энэ үйл ажиллагааг дэмжих зохицуулалтыг ТББ-ын тухай хуульд заавал ч үгүй тусгах.

Төрийн бус байгууллагыг төрөөс дэмжих татвар, хураамжийн бодлого болон гэрээний үндсэн дээр хамтран ажиллах харилцааг бизнесийн байгууллагаас ялгаатай байдлаар буюу нийтийн эрх зүйн хүрээнд Эрх шилжүүлэх захиргааны гэрээ зэргийг хэрэгжүүлэх боломжийг хуульчлах.

Олон нийтийн эрх ашиг сонирхлыг хамгаалах, ТББ-ын нэр хүндийг бусад ижил төстэй үйл ажиллагаанаас хамгаалах зорилгоор эдгээр төрлийн иргэдийн сайн дурын үүсгэл санаачлагыг зохион байгуулах, төлөөлөх этгээд хандивлагчиддаа санхүү, үйл ажиллагааны талаар эргэж мэдэгдэх, тайлагнах үүргийг хүлээлгэх, ТББ-ын тухай хуулинд илүү оновчтой тусгаж өгөх нь зүйтэй юм.

МОНГОЛ УЛСАД ТЭТГЭВРИЙН ШИНЭЧЛЭЛ ХИЙХ НЬ ЗАЙЛШГҮЙ БОЛОХ НЬ

Ц.БАТТУЛГА

(Шихихутуг их сургуулийн магистрант)

Эрхзүйт төрийн нэг гол чиг үүрэг нь иргэдийн зохистой амьдралын түвшнийг хангах тодорхой нөхцлийг бүрдүүлэхэд оршдог. Тиймээс нийгмийн бодлогын үндсэн асуудлын нэг бол хөдөлмөрлөх чадваргүй, тэтгэврийн насны хүн амыг мөнгөн тэтгэмжээр буюу тэтгэврээр хангах юм. Энэхүү асуудлыг шийдвэрлэхийн тулд улс орнуудын тэтгэврийн тогтолцооны үйл ажиллагаа бүрнээ чиглэдэг билээ. Ер нь хаана ч тэтгэврийн төгс тогтолцооны онолын болон практик загварыг гаргаагүй, гэхдээ тухайн орны нөхцөл болон эдийн засгийн хөгжилд хамгийн тохирохуйц тэтгэврийн тогтолцооны загвар түүний шинэчлэлийн арга замыг судлаачид санал болгосоор байна. Юуны урьд хөгжингүй улсуудийн тэтгэврийн тогтолцоо ямар байдаг талаар зайлшгүй авч үзэх ёстой. Чингэхдээ манай улсын тэтгэврийн тогтолцооны онцлог, эерэг сөрөг талуудыг харьцуулж буй улс орнуудынхтай жишиж судлах нь зүйн хэрэг.

Тэтгэврийн тогтолцоог судлаач эрдэмтэд ихэвчлэн дараах байдлаар тодорхойлсон байна.

Тодорхой нөхцөл болзол биелсний дараа иргэдэд материаллаг хангамж буюу мөнгөн тэтгэмжийг тэтгэвэр хэлбэрээр олгох зорилго бүхий байгуулагдсан төрийн болон төрийн бус институтуудын

тогтолцоог хэлнэ хэмээжээ. Өөрөөр хэлбэл үндэсний тэтгэврийн тогтолцоо гэж иргэдэд материаллаг хангамж буюу мөнгөн тэтгэмжийг тэтгэвэр хэлбэрээр олгох зорилго бүхий эрхзүй, эдийн засаг, зохион байгуулалтын институтууд, хэм хэмжээний зохицуулалт бүхий нийлбэр цогц мөн.

Баруун европын тэтгэврийн тогтолцоог судалдаг судлаач эрдэмтэд улс орнуудын тэтгэврийн тогтолцоог нийгмийн даатгал ба олон тулгуурт тогтолцоо гэж 2 ангилдаг. Эхний тулгуур нь нийтийн / төрийн/ иж бүрэн тэтгэврийн схем хоёр дахь нь ажил мэргэжилд суурилсан эсвэл хувийн, хувь хүнд тулгуурласан алтернатив схем юм.

Нийгмийн даатгалын /social insurance/ тогтолцоо Бисмаркийн тэтгэврийн схемүүд дээр суурилсан гэж үздэг. Авах үр шим нь ажиллаж байх үедээ төлсөн шимтгэлээс нь хамаардаг харин ажиллаж байх үедээ тэтгэврийн шимтгэл төлөөгүй хүмүүст ч тухайн улсад мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийг олгодог. Одоогийн ажиллаж буй ажиллах хүчний шимтгэлийг орлогоос өнгөрсөн үеийн ажиллагсдад тэтгэмж олгодог төрөөс заавал төлөх тэтгэврийн тогтолцоо юм.

Олон тулгуурт тогтолцоо нь төрийн тэтгэврийн үйлчилгээ нь зөвхөн "flat rate minimum benefits" ашигладаг орнууд байдаг. Энэхүү тэтгэврийн хангамжийн зорилго нь тодорхой тэтгэвэртэй байлгахад биш ядуурлаас урьдчилан сэргийлэх, амьдралын үндсэн хэрэгцээг хангахад чиглэдэг ба тэтгэврийн хангамж дахь төрийн хязгаарлагдмал үүрэг нь хувийн тэтгэврийн тогтолцоо хөгжих орон зайг бий болгож дотроо нэгтгэсэн онцлогтой.

Мөн тэтгэврийн тогтолцооны ангилалыг нарийсган задалж 3 тулгуурт болгон ангилж өргөн ашигладаг. Эхний тулгуур нь дээр дурдсан ангилалын нийгмийн даатгал буюу хувиарлалтын зарчим тулгуурласан суурь тэтгэврийн тогтолцоо. /"Pay as you go" гэж нэрлэгддэг./ Хоёр дахь тулгуур нь ажил мэргэжил буюу ажил эрхэлдэг салбартай нь холбоотой хуримтлалын тогтолцоо. Гуравдугаар тулгуур нь хувийн буюу сайн дурын үндсэн дээр хувь хүн өөрөө нэмэлт тэтгэвэр авах зорилгоор хэрэгжүүлдэг тогтолцоо юм.

Агуулгын хувьд хэд ангилах нь ач холбогдол багатай, гэхдээ улс орон бүрийг аль нэг рүү нь хамаатан авч үзснээр хэрэгжүүлж буй тэтгэврийн схем онцлогтой болно. Энэ нь тухайн орны насны бүлэг, ажиллах хүч тэтгэвэр авагчийн тооны харьцаа, хүн амын насжилтын хурд, ажиллах хүчний бүтэц, орлогын түвшин харилцан адилгүй байдагтай холбоотой.

Монгол улс аль ангилалын тогтолцоонд багтах вэ гэдэг асуулт зүй ёсоор тавигдана. Энэхүү асуултанд хариулах

нэг чухал үндэслэл нь Монгол улсад эрхзүйн ямар орчин байгааг товчхон авч үзэх шаардлагатай.

Манай улс 1990-ээд оноос улсын төсвөөс шууд хараат байсан тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн хамгааллын хуучин харилцааг халж нийгмийн хамгаалал, даатгалын шинэ тогтолцоог бүрдүүлэн, түүний эрх зүйн орчинг бий болгох зорилт тавин ажлыг эхлүүлсэн. 1991 онд Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай, 1993 онд Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийг тус тус батлан НД-ын биеэ даасан тогтолцоо бий болгох бодит угтвар нөхцөлийг бүрдүүлснээр 1994 онд НД-ын багц хуулиуд батлагдаж энэ чиглэлийн эрх зүйн орчин бүрджээ. Тэдгээрийг 1995 оноос мөрдөж эхэлсэн ба үүнээс хойш "Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай", "Тэтгэмжийн доод хэмжээ тогтоох тухай" зэрэг хуулиуд шинээр батлагдан нийгмийн даатгалын харилцааг зохицуулж байна. Монгол улс 1995 оноос нийгмийн даатгалын шинэ тогтолцоонд шилжихдээ эв санааны нэгдлийн буюу хуваарилалтын тогтолцоог сонгосон бөгөөд 1999 онд батлагдсан тэтгэврийн даатгалын нэрийн дансны тухай хуулиар хуваарилалт, хуримтлал хосолсон тогтолцоонд аажмаар шилжих эрх зүйн үндсийг тавьж, 1960 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш төрсөн хүмүүсийн хувьд 2000 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн нэрийн дансыг хөтөлж эхэлсэн байна. Харин даатгуулагч хэд наслахаас үл хамааран тэтгэвэр авах ёстой гэсэн зарчим хэвээр хадгалагдах учиртай. Хуваарилалт-хуримтлалын тогтолцоонд шилжсэн үед хөтөлбөрийн дагуу хуримтлагдсан

шимтгэлийн орлогын зарим хэсгийг /3%/ 2005 оноос эхлэн үнэт цаасны хөрөнгө оруулалтад зарцуулахаар зохицуулсан байна. Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2021 он хүртэл баримтлах үндсэн чиглэлд зааснаар 2005 оноос шинэ тогтолцоонд шилжиж, нэрийн данснаас тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэврийг олгохоор зохицуулсан байдаг. Мөн 2020 онд нийгмийг даатгалын багц хуулинд тодорхой өөрчлөлтүүд орсон юм.

Хууль эрхзүй хувьд “нэрийн дансны тухай хууль” хэдийгээр батлагдсан боловч хэрэгжээгүй. Энэ нь хуримтлалын тогтолцооны буюу 2 тулгуурт тогтолцоо рүү шилжих эхлэлийг тавих байсан боловч практикт амжилт олоогүй юм. Өөрөөр хэлбэл бид хөгжлийн эхний шатанд гацаж орхисон хэрэг. Хагас хуримтлалын тогтолцоотой гэгддэг боловч хэрэг дээрээ тийм биш юм.

Хаана байгаагаа мэдэж байгаа бол хаашаа явахаа тодорхойлох ёстой. Нэг тулгуурт тэтгэврийн тогтолцоотой улсуудад ямар хүндрэл тохиолдсон бэ. Улс орнуудын тэтгэврийн тогтолцоо 20-р зууны сүүлийн хагаст хөгжиж эхлээд дэлхийн 2-р дайны дараа эдийн засгийн буумын үед улс төрийн бодлогын зайлшгүй нэг хэсэг болон хувирсан. Тэтгэвэр гардаг нас 70 орчим байсан тэр үед дундаж наслалт харьцангуй бага байв. Тиймээс тэтгэвэр авах хугацаа болон зардлын дарамт бага байжээ. Дайн дараа, ялангуяа хөгжлийн хурд өндөр бсан 50-60 оны үед улс орнууд төрийн халамжийнхаа хөтөлбөрийг хэт тэлж, тэтгэврийн насыг багасгасан байдаг. Энэ нь тэтгэвэр халамжийн

харилцааг улс төрийн оноо хэрэгсэл болгож байсантай холбоотой гэж үзэх үндэслэл бий. Эндээс улбаалан тэрхүү үеийнхэн тэтгэвэрт гарах үеэс тэтгэвэртэй холбоотой элдэв бэрхшээлүүд үүсэж эхэлсэн. Энэ үед дэлхийн эдийн засгийн өсөлтийн хурд саарч эхэлсэн аж. Статистик мэдээнээс дурдвал, 1895 онд 60 дээш насныхны хөдөлмөр эрхлэлт 67.5% байсан бол 2004 он 14.4% болж эрс доошилсон. Эрэгтэйчүүдийн 60 хүртэл насалдаг хувь нийт эрэгтэйчүүдээс 33.5% байсан бол 87.8 %-р өссөн, дундаж наслалт 60 наснаас 12.1 жил байсан нь 20.1 жил болж уртассан. Үүний үрд дүнд тэтгэврийн зардлын хэмжээ ихэссэн байна. Тэтгэврийн зардал 1960 онд ДНБ -с тооцоход Швед 3.6%, Нидерланд 2.6%, Итали 3.7%, Франц 5.9%, ХБНГУ 1.2% байсан ба 80 он гэхэд Швед 6.9%, Нидерланд 7.6 %, Итали 11.4%, Франц 9.6%, ХБНГУ 5.7% бараг 2 дахин нэмэгдсэн байна¹. Хүн амын насжилт, эдийн засгийн байдал, хөдөлмөр эрхлэлтийн харьцаа, төсөвт ирэх ачаалал зэргээс шалтгаалан тэтгэврийн шинэчлэлийн асуудал гарч ирсэн. Ингээд 1986 оноос тэтгэврийн шинэчлэлүүд эхэлсэн бөгөөд өнөөг хүртэл үргэлжилсээр байна. Анх 1980-аад онд Чилид эхэлсэн энэ үйл явдал олон тулгуурт тогтолцоог сонгосон байдаг

Манай улсын хувьд тэтгэврийн тогтолцоонд зайлшгүй тохиолдох хүндрэл тодорхой байна. ҮСХ-ны хорооны 2013 онд гаргасан тооцоололоор хүн амын дундаж наслалт

¹ “Pension reform in Europe” Камила Арза, Мартин Коли 2008.

69,1, эмэгтэйчүүдийн дундаж наслалт 75, эрчүүдийн дундаж наслалт 65,4 байсан ба энэ нь 1992 оноос дундаж наслалтын түвшнөөс даруй 6.3-н жилээр өссөн байна гэжээ. Дэлхийн банкны 2018 хэвлүүлсэн "public expenditure review"-д 2050 он гэхэд манай улсын 60 түүнээс дээш насныхны хүн амд эзлэх хувь 20 хувьд хүрэх аж. Энэхүү тайланд төрөөс тэтгэврийн санд төлж буй татаас 2017 онд 2.2% байсан бол 2050 онд ДНБ-ний 11 хувьд хүрнэ гэж тусгажээ. Өөр нэг сул тал нь манайд тэтгэврийн даатгал төлөгчдийн бааз суурь муутай. Малчид, хувиаараа хөдөлмөр эрхлэгсдийн шимтгэл төлөлт аль аль нь хангалтгүй байдаг нь тэтгэвэр авагч, тэтгэврийн шимтгэл төлөгчийн харьцаанд сөргөөр нөлөөлдөг. Тухайлбал төрөөс эдгээр иргэдийн тэтгэврийн 10 хувийг төлдөг.

Олон улсын хөдөлмөрийн байгууллага /ILO/ Монгол улсын тэтгэврийн тогтолцооны тайланд манай улсад 20 жил тэтгэвэр төлсөн хүний өндөр насны тэтгэвэр 45%-р бодогдож байна хэмээжээ. АНУ-д 40 хувь байдаг². Гэхдээ АНУ олон тулгууртай тэтгэврийн тогтолцоотой улс, тиймээс төрийн тэтгэврийн буюу нэгдүгээр тулгуурт тогтолцооны эзлэх хувиаараа дэлхийд бараг хамгийн багад тооцогддог. Үлдсэн хэсгийг корпорэйт болон хувийн тэтгэврээс бүрдүүлдэг байхад манайд ганцхан тулгууртай хэвээрээ л байна.

Одоогийн байдлаар Монгол Улсад нийгмийн даатгалын тогтолцооны санхүүжилтийн талаар албан ёсоор тодорхойлсон зорилго байхгүй

байна. Гэтэл нийгмийн хамгааллын аливаа шинэчлэлийг хэрэгжүүлэхэд санхүүжилтийн бодлого шаардлагатай нь ойлгомжтой. Цаашдаа сайтар төлөвлөсөн, маш тодорхой томъёолсон санхүүжилтийн бодлого гаргаж, түүнийгээ тогтмол хугацаанд хянан үзэж шинэчилж байх нь зүйтэй хэмээн олон улсын хөдөлмөрийн байгууллагын тайланд тэмдэглэгдсэн.

Эндээс харахад дэлхийн улс орнуудын адил манайд манайд тэтгэврийн тогтолцооны шинэчлэл хийх шаардлага тулгамдсан хэвээр байна. Шинэчлэлийн чиглэл нь мэдээж, олон тулгуурт тэтгэврийн тогтолцоо руу аль болох богино хугацаанд шилжих явдал. Одоогийн байгаа тогтолцоогоор явбал ирээдүйд тэтгэвэр авагчдийн тэтгэврийг төлж чадахгүйд хүрнэ. Энэхүү ноцтой асуудлыг өнөөгийн нийгмийн даатгалын сангийн дутагдлаас харж болно. Цаашдаа төрөөс авах татаас улам нэмэгдэхнээ. Санхүүжилтийн бодлогоо зөв тодорхойлж хувь хүний оролцоог идэвхжүүлсэн тогтолцоог хөхиүлэн дэмжих хэрэгтэй байна. Тиймээс ч хувийн тэтгэврийн тогтолцоог дэмжих зорилгоор хуулийн төсөл өргөн баригдсныг энэ чиглэлээр хийгдэж буй чухал алхам гэж үзэх үндэслэлтэй. Эрхзүйн зохист тогтолцоо бүрдвэл хувийн тэтгэврийн сангууд бий болж арилжааны даатгалын энэ төрлийн бүтээгдэхүүнүүд гарах нь ойлгомжтой. Үүнийг дагаад төрийн биш тэтгэврийн сангийн тухай хууль гарах шаардлага гарцаагүй тулгарна. Мөн хяналтын тогтолцоог бий болгох, сангийн хөрөнгө оруулалтыг зохицуулах тодорхой

² "Ageing and pension reform in the world" Жулиана Боноли, Тошимицу Шинкава 2005

журмууд гарч таарна. Шилжилтийн процесс цаашдаа ч үргэлжлэх биз. Ямар үр дүнд хүрэх нь тулгамдсан асуудал хэвээр байна. Одоогийн тэтгэвэр авагчдын эрхзүйн байдлыг дордуулж болзошгүй алхмууд ч харагдаж байна. Ер нь төрийн зүгээс тэтгэвэрийн санг нэмж санхүүжүүлэх асуудлууд тасралтгүй гарч ирнэ. Энд онцлоход, түүний нэг шийдэл нь баялагийн сантай гарцаагүй холбогдож таарна.

Эх сурвалж

1. "Public expenditure review: GROWING WITHOUT UNDUE BORROWING, Enhancing efficiency of spending and revenue". Дэлхийн банк 2018
2. "Ахмад настны нийгмийн хамгаалалын тогтолцооны шинэчлэл болон малчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд зориулсан тэтгэврийн шинэ хөтөлбөрийн санхүүгийн үнэлгээ". ILO 2016
3. "Ageing and pension reform in the world" Жулиана Боноли, Тошимицу Шинкава 2005
4. "Pension reform in Europe" Камила Арза, Мартин Коли 2008 он. 2019 оны хэвлэлт.

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ТҮҮНИЙ ЗАРИМ АСУУДАЛ

Б.ТУНГАЛАГНАРАН

(Шихихуруг их сургуулийн магистрант)

Хорьдугаар зуунд улс орнууд техник технологийн хүчин зүйлийг, дараа нь эдийн засгийн хүчин зүйлийг хөгжлийн эх сурвалж гэж үзэж байсан бол өнөө үед нийгэм, эдийн засгийн бүхий л асуудлууд бие хүнтэй нарийн шүтэлцээтэй болохыг ухааран хүнээ хөгжүүлэх, түүний хүчин зүйлийг зохистой ашиглах нь хөгжлийн гол сурвалж болж байна.¹ Тиймээс ч манай улсын төрийн албан хаагчдын иргэдэд үйлчилж буй хандлага, ёс зүй, эрх зүйн орчин хөгжлийн нэг эх сурвалжууд зүй ёсоор тооцогдох учиртай.

Иргэдээс төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдыг хууль дээдэлсэн мэргэшсэн шуурхай чирэгдэлгүй, хүнд суртал, ашиг сонирхолын зөрчлөөс ангид өргөсөн тангарагтаа үнэнч, өндөр ёс зүйтэй байхыг хүсэж, шаардаж байдаг боловч зарим албан хаагчдын гаргасан эрх зүйн зөрчил нь тухайн салбарын төдийгүй өргөн утгаараа төрийн албаны нэр хүндэд сөргөөр нөлөөлж төрд итгэх итгэлийг алдагдуулахад хүргэдэг.

Төрийн албаны ёс зүйг дээшлүүлэхэд хууль эрх зүйн орчин боловсронгуй байх нь ихээхэн нөлөөтэй. Төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг хуулиар

болон дүрэм журмаар нарийвчлан тодорхойлох, хариуцлага, хяналтын тогтолцоог бий болгох, хуулиудын уялдаа холбоо болон хуулийн хэрэгжилтийг хангах шаардлагатай.

Хууль зүйн норматив хандлагын үүднээс авч үзвэл ёс зүйн нь тодорхой мэргэжил, албан тушаалын онцлогоос хамаарсан ойлголт юм². Өөрөөр хэлбэл, мэргэжил, албан тушаалын онцлогоос хамааран мэргэжлийн ёс зүйн асуудал гарцаагүй хөндөгддөг.

Мэргэжлийн ёс зүйд мэргэжил, хариуцсан ажилдаа үнэнч байх, ажил үүргээ чанартай гүйцэтгэх, нийтийн эрх ашгийг дээдлэх, мэргэжлийнхээ нэр хүндийг хамгаалах, нийгмийн хариуцлагаа ухамсарлах, үүргээ чанд биелүүлэх зэрэг шаардлага тавигддаг.

Төрийн албан хаагчийн ёс зүй гэдгийг төрийн албан хаагч албан тушаалаа эрхэлж, төрийн албаны бүрэн эрх хэрэгжүүлэхтэй холбоотой зарчим, хэм хэмжээ, шаардлага гэж тодорхойлж болно³. Эдгээр ёс суртахууны зарчимд үнэнч шударга байх, шударга байдал, хичээл зүтгэл, итгэлцэл, хүндэтгэл, зарчимч тууштай байх гэх мэтийг хамааруулж үзэх нь зүйн хэрэг.

¹ Я.Шуурав нар. Менежментийн шинэ парадигм: төлөвшил, хөгжлийн үндсэн асуудал, 2005.

² Б.Энхбаяр, "Төрийн албан хаагчийн ёс зүй" УБ, 2000 он, 16-р тал

³ Р.Вандангомбо "Төрийн албаны ёс зүй", УБ, 2007 он. 37-р тал

Ёс зүйн түгээмэл ойлголт, зарчим хэм хэмжээ нь бүх мэргэжлийн тулгуур болно. Түүнчлэн төрийн албан хаагчийн үйл ажиллагаа нь хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндийг хөнддөг тул түүний хийсэн үйлдэл бүхэн зөвхөн хуулийн хүрээнд хийгдэх шаардлага нийгмийн болон эрх зүйн зүгээс тавигддаг.

Иймээс төрийн албаны ёс зүй үүсэн бий болох хэрэгцээ шаардлага нь төрийн алба, төрийн албан хаагчийн нэр хүндийг сахин хамгаалах, төрийн албан хаагчийн ёс суртахууныг дээшлүүлэх, төрийн албаны онцлогийг тусгасан төрийн албан хаагчийн ёс суртахууны өвөрмөц хэм хэмжээг тодорхойлон боловсруулах, мөрдүүлэхэд оршдог.

Монгол Улсын хувьд Төрийн албаны тухай хуулийн 40 дүгээр зүйлд "төрийн улс төрийн болон тусгай албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг хууль тогтоомжоор, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно" гэж заасан.

Ийнхүү Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм" батлагдсанаар өнөөгийн байдлаар төрийн бусад ажил үйлчилгээ, мэргэжлийн албан хаагчдын 30 гаруй ёс зүйн дүрэм хүчин төгөлдөр үйлчилж байна.

Ёс зүйн хэм хэмжээг зөрчвөл хариуцлагын асуудал заавалчгүй хөндөгдөж таарна. Ер нь хариуцлага

нь ёс зүйн, мэргэжлийн, хуулийн, улс төрийн зэрэг олон төрөл болон ажиглагддаг.

Ёс зүйн хариуцлага гэдэг нь тодорхой хувь хүн, институт өөрийнхөө болон нийгмийн өмнө ажиллагсад, үйлчлүүлэгчид, хэрэглэгчдийн өмнө хүлээсэн үүрэг, нийтэд сайн үйл гэж үнэлэгдэх хэм хэмжээг зөрчсөнийхөө төлөө өөрөө өөртөө болон эрх бүхий субъектээс өгч буй шударга үнэлгээ, түүнийг хүлээн авч буй байдал юм⁴.

Харин төрийн албан хаагчийн ёс зүйн хариуцлага гэдэг нь төрийн албан хаагч эрх зүйн харилцаанд биеэ авч явах хуульчилсан хэм хэмжээний зарчим, дэг горим буюу төрийн албан тушаал эрхэлснийхээ төлөө сахин биелүүлбэл зохих хууль тогтоомжид заасан ёс зүйн ерөнхий зарчим, тусгай, нэмэлт шаардлагуудыг зөрчсөний улмаас хүлээж буй үр дагавар бүхий үйл ажиллагаа юм.

Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн эсэх асуудлыг Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөл шийдвэрлэх бөгөөд тус зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагааны чиглэлийг "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ээр зохицуулж байна.

Манай улсын хувьд Төрийн албаны нэг л хууль үйлчилдэг тул "state service" буюу дипломат болон цэргийн албыг тэнд хамруулан ойлгодог, ойлголтыг хэрэглэдэг болох нь харагдаж байна⁵.

⁴ Удирдлагын академи, "Төрийн захиргааны албаны ёс зүйн хариуцлагын тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлэх нь", УБ, 2019 он, 6-р тал.

⁵ Ж.Долгорсүрэн, "МУын захиргааны эрх зүй".

Гэвч олон улсын жишигт “civil service”, “public service” гэх нэршлүүд ч хэрэглэх нь харагддаг бөгөөд төрийн бус иргэнд үйлчлэх алба гэж нэрлэх нь зохистойд тооцогдож байна.

Монгол Улсын хувьд 1992 онд шинэ Үндсэн хууль баталснаар төрийн албаны тогтолцоо, зарчмын хувьд томоохон дэвшил хийгдсэн. Тодруулбал, төрийн алба нь ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх төрийн үйл ажиллагааны үндсэн зарчимуудад тулгуурлаж явагддаг, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуульчлан хангах болсон.

Эндээс улбаалан 1994 онд Төрийн албаны тухай хуулийг анх удаа баталж, 1995 онд хараат бус бие даасан төрийн албаны бие даасан тогтолцоотой болсон түүхтэй. Гэхдээ төрийн албаны талаарх ойлголт нь Монголын төрт ёс үүссэн цагаас буюу Хүннү гүрний үеэс улбаатайг заавалчгүй дурдах учиртай.

Төрийн алба нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх эрхэм зорилгын хүрээнд ажилладаг. Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Төрийн албаны тухай хуулийн 3.1.1-т “төрийн алба”-ыг төрийн зорилт, чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх, төрийн бодлого боловсруулах, төрөөс зайлшгүй үзүүлэх шаардлагатай бусад үйлчилгээг нийтэд

хүргэх үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтыг хэлнэ гэж тодорхойлсон.

Төрийн алба өнөөдрийг хүртэл үе шаттайгаар ахин дэвшиж хөгжлийн зүй тогтлоороо урагшилж байна. Судлаачдын үзэж байгаагаар орчин үеийн төрийн алба үүсэн байгуулагдсан үеэс хойш 4 үе шатыг даван туулаад байна. Үүний нэг илрэл нь 2008 онд Төрийн албаны тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр төрийн албыг бэхжүүлэхэд чиглэсэн үндсэн 3 арга юм. Энэ нь Нэгдүгээрт, төрийн албыг улс төрөөс ангид байлгахын тулд Төрийн албаны тухай хуульд намын гишүүнчлэлийг түдгэлзүүлсэн. Хоёрдугаарт, төрийн албыг мэргэшсэн, тогтвортой байлгахын тулд мерит зарчмыг тусгаж, зарим албан тушаалд тодорхойлолт өгөхийн сацуу ангиллыг нь өөрчилсөн явдал. Түүнчлэн төрийн албаны төв байгууллагын эрх хэмжээ чиг үүргийг мөн тэнд уялдаа холбоотойгоор хуульчилжээ. Гуравдугаарт, төрийн жинхэнэ алба, алба хаагчийн үйл ажиллагаа боловсронгуй болгоход чиглэсэн байна. Үүний хүрээнд төрийн албанд орох иргэнд мэргэшил, боловсрол, ур чадварын шаардлага тусгайлан тавьдаг билээ.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаас хойш 30 гаруй хууль тогтоомжийн актыг батлан гаргаж, даган мөрдүүлжээ. Үүний дараагаар 2017 оны 12 сарын 07-ны өдөр УИХ-аас Төрийн албаны тухай хуулийг шинэчлэн найруулан баталж 2019 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөөд нэг

жилийн нүүр үзэж байна.

Төрийн албаны ангилалтай уялдан төрийн албан тушаалыг улс төрийн, захиргааны, тусгай, үйлчилгээний албан тушаал гэж ангилдаг. Энэ нь дотроо удирдах, гүйцэтгэх, туслах гэсэн хэсгүүдэд хуваагддаг бөгөөд эдгээр нь иргэдэд төрийн үйлчилгээг хүргэж байгаа тул иргэд, олон нийттэй харилцахад ёс зүйн асуудал зайлшгүй хөндөгдсөөр байгаа юм.

Төрийн албаны захиалгаар 2020 онд хийгдсэн Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний судалгааны үр дүнд тулгуурлан төрийн албан хаагчийн үйлдсэн сахилгын зөрчил, ёс зүйн зөрчилд Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн хуульд заасан сахилгын хариуцлага ногдуулдаг болов.

Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтийн судалгаагаар Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүй нь эмч, эмнэлэгийн ажилтны, боловсролын байгууллага, бүх шатны багшийн, урлаг, спортын, захиргааны албан хаагчийн, мэргэжлийн, цэргийн албан хаагчийн гэх зэрэг өөр өөр онцлогтой болохыг ялган зохицуулах зайлшгүй шаардлагатай гэж дүгнэснийг зүйтэй хэмээн үзэж байна.

Төрийн алба тэр дундаа холбогдох хуулиар хүлээлгэсэн чиг үүрэгтэй холбоо бүхий ёс зүйн дүрмүүдэд онцлог байдлаар тусгасан зохицуулалтуудтай боловч хүний эрх, эрх чөлөө болон төрийн албаны нэр хүндийг дээдлэн төвийг сахих, хууль тогтоомжийг чанд биелүүлэх, улс төр, хувийн ашиг сонирхлоос ангид байх, харилцааны

ёс зүйг эрхэмлэх агуулгаар нийтлэг зохицуулалт бас байх учиртай.

Хууль тогтоох байгууллага улмаар хуулийн төсөл боловсруулагчид өнөөг болтол сахилга, ёс зүйн зөрчлийг ялгамжтайгаар хуульчлаагүйгээс төрийн байгууллага албан хаагчид тэдгээрийг нэг ойлголт мэтээр үзэж ирсэн нь хүчин төгөлдөр хууль тогтоомжийн хэрэгжилтээр илэрч байна.

Тухайлбал, Төрийн албаны тухай хуульд төрийн жинхэнэ албан хаагч буюу захиргааны албан хаагчийн нийтлэг үүрэг, хориглох зүйл болон албан тушаал бууруулах, халах, сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл журмыг хуульчилсан байна.

Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйл 48.1 дэх хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 37, 39 дүгээр зүйлд заасныг зөрчсөн, албан үүргээ биелүүлээгүй болон энэ хуульд заасан бусад тохиолдолд тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан төрийн жинхэнэ албан хаагчид дараахь сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулна:” хэмээсэн зохицуулалт бий.

Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7-д **“төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх;”** гэсэн үүргийг төрийн жинхэнэ албан хаагч хүлээсэн байдаг.

Иймд төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн зөрчилд Засгийн газрын

33 дугаар тогтоолд заасан сануулах арга хэмжээ бус Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.1 дэх заалтад зааснаар "сануулах" сахилгын шийтгэл хүлээлгэдэг юм.

Төрийн захиргааны болон үйлчилгээний алба хаагчдын дунд Засгийн газрын 33 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн дүрэм"-ийг бүрэн судлаагүй, улмаар сахилгын болон ёс зүйн зөрчлийг нэг мөр ойлгоогүй байдал судалгаанаас харагддаг. Тухайлбал, гэмт хэрэг үйлдсэн, зөрчил, сахилгын зөрчил гаргасан төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид ёс зүйн зөрчлөөр давхардуулан шийтгэл оногдуулах эсэх талаар нэгдсэн ойлголт

өнөө болтол хэлбэршээгүй байна.

Харин төрийн албаны шинэчлэлийн хүрээнд төрийн захиргааны болон үйлчилгээний алба хаагч ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд ёс зүйн хариуцлага буюу уучлал гүйлгах эсхүл сануулах хариуцлага хүлээлгэх зохицуулалт бий. Гэвч Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг, Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил, холбогдох хуульд заасан Сахилгын дүрэм зөрчсөн үйлдэл зэрэгт хариуцлага хүлээлгэсэн тохиолдолд ёс зүйн хариуцлагыг давхардуулан хэрэглэх талаар нэгдсэн ойлголт тогтоогдоогүй байдал алба хаагчдын хувьд гомдол маргаан дагуулах нэг үндэс болох бүрэн үндэслэлтэйг Төрийн албаны зөвлөл цаг алдалгүй хариуцан шийдвэрлэх шаардлагатай байна.

ГЭР БҮЛ ДЭХ ХҮҮХДИЙН ХУВААРЬТ ХӨРӨНГИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Ч.ТҮВШИНХАНГАЙ

(Шихихутуг их сургуулийн магистрант)

Товчлол: Гэр бүл дэх хүүхдийн хуваарьт хөрөнгийн эрхийг шүүхийн болон захиргааны журмаар хамгаалж буй өнөөгийн практикийг судлан эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох замаар хүүхдийн эрхийн салшгүй хэсэг болох өмчлөх эрх, хуваарьт хөрөнгийн эрхийн эрх зүйн хамгаалалтыг хангах асуудлыг хөндсөн болно.

Удиртгал: Гэр бүл дэх хүүхдийн хөрөнгийн эрх нь гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгийн эрх ба хуваарьт хөрөнгийн эрхээс бүрдэнэ. Гэр бүлийн гишүүд нь хамтран өмчлөх дундын өмчийн үл хөдлөх эд хөрөнгөө захиран зарцуулахдаа хуульд зааснаар гэр бүлийн насанд хүрсэн гишүүдийн бичгээр гаргаж, нотариатаар гэрчлүүлсэн зөвшөөрлийг авч энэхүү эрхээ хэрэгжүүлдэг бол харин насанд хүрээгүй гэр бүлийн гишүүний хөрөнгийн эрхийг түүний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч “хууль ёсны төлөөлөгч”

болохын хувьд хүүхдийн нэрийн өмнөөс ямар нэгэн итгэмжлэлгүйгээр хэрэгжүүлдэг онцлогтой. Учир нь хуулиар зөвшөөрснөөс бусад хэлцлийг хүүхдийн нэрийн өмнөөс түүний хууль ёсны төлөөлөгч /эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч/ нь хийх эрхтэй. Гэр бүлийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3-д заасан “хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах үүрэг” бүхий субъектууд юм. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн бага насны болон насанд хүрээгүй хүүхдийн эрх, ашиг сонирхлыг төлөөлөх бүрэн эрхийн хүрээнд хүүхдийн нэрийн өмнөөс тус тусдаа болон хамтарч, харин асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр томилогдсон этгээд ганцаараа хүүхдийг төлөөлөх бүрэн эрхтэй.

Гэр бүл дэх хүүхдийн хөрөнгийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалт нь гэр бүлийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгийн харилцаанд хүүхдийн хуваарьт хөрөнгийн субьектив эрхийн хэрэгжилтийг хангах хууль зүйн арга хэмжээнүүдийн нийлбэр юм. Эрх зүйн хамгаалалтын зорилго нь эрх бүхий этгээд өөрийгөө болон бусад этгээдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалахаар тодорхой үйлдэл хийх болон төрийн эрх бүхий байгууллагад хандан эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах субьектив эрх бөгөөд агуулгын хувьд

1 Иргэний хуулийн 128 дугаар зүйл. Хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах

128.1 Гэр бүлийн гишүүд нь хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах адил эрх эдэлж, харилцан тохиролцсоны үндсэн дээр эд хөрөнгөө эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулна.

128.2 Гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь хамтран өмчлөх дундын өмчийн үл хөдлөх эд хөрөнгөө захиран зарцуулахдаа гэр бүлийн насанд хүрсэн гишүүний бичгээр гаргаж, нотариатаар гэрчлүүлсэн зөвшөөрлийг авна.

материаллаг болон процессийн эрх зүйн хэм хэмжээгээр дамжин илэрнэ.

Үндсэн хэсэг: Гэр бүл дэх хүүхдийн хуваарьт хөрөнгийн эрхийг Гэр бүлийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу шүүхийн болон захиргааны журмаар хамгаална.

А. Шүүхийн журмаар хамгаалах Гэр бүл дэх хүүхдийн хуваарьт хөрөнгийн эрхийг хангаж, хамгаалахад шүүх, шүүгчийн “хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, Үндсэн хуульт байгууллыг хамгаалах, хууль дээдлэх, шударга ёс, ардчилсан ёсыг бэхжүүлэх, хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг бэхжүүлэх, иргэний эрх зүйн ухамсар, соёлыг дээшлүүлэх” зорилгын хүрээнд Үндсэн хууль, бусад хуулиар баталгаажуулан хамгаалсан хүний эрх, эрх чөлөө зөрчигдвөл, төрийн нэрийн өмнөөс хууль зүйн хувьд хамгаалах, сэргээн эдлүүлэхээр Иргэний хуулийн 9 дүгээр зүйлд заасан иргэний эрх зүйн хамгаалалтын аргуудаар хамгаална.

Шүүх, шүүгчээс эрх зүйн нийтлэг хэм хэмжээг амьдралын тодорхой тохиолдол, тодорхой хэргийг шийдвэрлэх явцдаа “due process of law” буюу хууль зүйн агуулгаараа хууль ёс, эрх зүйн зохих (дэс) журам (процедур) буюу хэргийг хянан шийдвэрлэхдээ процессын болон материаллаг эрх зүйн хэм хэмжээг

хэлбэрэлтгүй сахих зарчмын дагуу хэрэг маргааны оролцогч талуудын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг ханган хэрэгжүүлж байгаа шүүхийн хамгаалалтыг Үндсэн хууль болон процессын хуулиудаар баталгаажсан, хараат бус шүүхээр хэрэг, маргаанаа хянан шийдвэрлүүлэх журмаар хэрэгждэг иргэний эрхийн хамгаалалт⁴ юм гэжээ.

Гэр бүл дэх хүүхдийн хуваарьт хөрөнгийн эрхийг хамгаалах шүүхийн хамгаалалтад

- Гэр бүлийн эрх зүйн харилцаанаас үүссэн маргааныг шийдвэрлэх⁵
- Өв залгамжлалтай холбоотой маргааныг шийдвэрлэх
- Бэлэглэлийн гэрээтэй холбоотой маргааныг шийдвэрлэх
- Насанд хүрээгүй иргэнийг иргэний эрх зүйн бүрэн чадамжтай гэж тооцох зэрэг

хэрэг маргааныг хянан шийдвэрлэх явцад шүүх, шүүгчийн хэрэгжүүлж буй хүүхдийн хуваарьт хөрөнгийн эрхийг хамгаалсан хуульд заасан эрх зүйн арга, хэрэгсэл, үйл ажиллагаануудаас бүрдэнэ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 125 дугаар зүйлд заасан гэр бүлийн эрх зүйн харилцаанаас үүссэн эрх зүйн маргааны төрөлд хүүхдийн хуваарьт хөрөнгийн эрхтэй шууд хамааралтай маргаанууд буюу

² www.legalinfo.mn Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалт

³ Нямсүрэн Ч. Эрх зүйн ерөнхий онол. УБ. 2017 он. 295 дах тал

⁴ www.legalinfo.mn Монгол Улсын дээд шүүхийн зөвлөмж. Анхан шатны шүүхийн шийдвэрийг хянах давж заалдах шатны шүүхийн бүрэн эрх, хэмжээ, хязгаар. 2009.11.30. дугаар 05.

⁵ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 125 дугаар зүйл.

гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлах⁶, гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах⁷ харилцааны маргаан, гэр бүлийн дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөөс гишүүнд /хүүхдэд/ ногдох хэсгийг тодорхойлох⁸ хуваах⁹ хүүхдийн тэтгэлэгийн маргаан¹⁰ хамаарна.

Монгол Улсын Шүүхийн 2019 оны тайланд "Гэр бүлийн тухай хуулиар 4449 хэрэг шийдвэрлэж өмнөх оны мөн үеэс 314 буюу 6.6 хувиар буурсан, гэрлэлт цуцлах хэрэг 2736 шийдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 20 хэрэг буюу 7.9 хувиар, хүүхдийн тэтгэлэг гаргуулах хэрэг 1047 шийдвэрлэсэн нь 99 хэрэг буюу 8.6 хувиар буурсан байна", харин 2018 оны тайланд "Гэр бүлийн хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 4763 буюу 9.9 хувийг эзэлж байна. Гэрлэлт цуцлах хэрэг 2945 шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 154 хэргээр буюу 5.5 хувиар буурсан, хүүхдийн тэтгэлэг гаргуулах хэрэг 1146 шийдвэрлэсэн нь өмнөх оноос 90 хэргээр буюу 8.5 хувиар өссөн" гэжээ.

Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5-д зааснаар гэрлэлт цуцлах хэрэг маргаантай хамтатган хүүхдийн тэтгэлэг тогтоох, хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг хуваах маргааныг шийдвэрлэж байгаа бөгөөд 2018 ба 2019 оны нийт дүнгээр 9212 гэрлэлтийг шүүхээр цуцалсан нь 9212 өрхийн бага насны болон насанд хүрээгүй хүүхдийн

хөрөнгийн эрхийг иргэний хуулийн дагуу шүүхээр хамгаалсан гэж үзэж байна. Мөн 2193 хүүхдийн тэтгэлэг гаргуулах хэрэг шийдвэрлэсэн нь төдий тооны хүүхдийн хуваарьт хөрөнгийн эрхийг шүүхийн журмаар хамгаалсан байна гэсэн үг.

2018 онд эрх зүй судлаачид "гэрлэлт цуцлахтай холбоотой хэргийн хүрээнд хүүхдийн өмчлөх эрх болон бусад эрхүүдийг шүүхээс хууль зүйн үндэслэлтэй шийдвэрлэж буйг 2012-2018 онуудад шийдвэрлэсэн гэрлэлт цуцлах, хүүхдийн тэтгэлэг, асрамж тогтоолгох, гэр бүлийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг хуваах, эцэг тогтоохтой холбоотой шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ¹²хийж, хүүхдийн тэтгэлэгийг "хүүхэд тус бүрт бус, дунд нь тэтгэлэг тогтоож шийдвэртээ бичих"¹³, гэр бүлийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг хуваах үед гэр бүлийн гишүүн гэсэн хууль зүйн ойлголтыг тухайн хэрэг маргаан дээр алдаатай тогтоох, дагавар хүүхдэд тэтгэлэг олгох асуудлыг орхигдуулан шийдвэрлэсэн¹⁴ хууль хэрэглээний алдаа байгааг тогтоосон байна. Үүний зэрэгцээ хүүхдийн тэтгэлэг төлөх хугацаа хожимдуулсан тохиолдолд гэрээгээр буюу шүүхийн шийдвэрийн үндсэн дээр алданги төлүүлэх хууль зүйн боломжийг шүүхийн хамгаалалт хэлбэрээр хэрэгжүүлж байгааг хүүхдийн өмчлөх эрхийг хангаж байгаа нэг хэлбэр

⁶ Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйл

⁷ Иргэний хуулийн 128 дугаар зүйл,

⁸ Иргэний хуулийн 129 дүгээр зүйл

⁹ Иргэний хуулийн 130 дугаар зүйл

¹⁰ Гэр бүлийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дах заалт

¹¹ <http://www.judoinstitute.mn/statistic/>

¹² https://www.forum.mn/res_mat/2018/Shuukhiin_shildverin_analiz.pdf Шүүхийн шийдвэрийн эмхтгэл 1. УБ. 2018 он. Эрх зүйн хөгжлийн төлөө ТББ-ын судалгаа

¹³ www.forum.mn Шүүхийн шийдвэрийн эмхтгэл 1. УБ. 2018 он 97 дах тал

¹⁴ www.forum.mn Мөн эмхтгэлийн 98 дах тал

болж байгаа¹⁵ ...-гэжээ.

Шүүхээр тогтоосон хүүхдийн тэтгэлэгийн хэрэгжилтийн талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэл нь 2019 онд 41834 тэтгэлэгээс 15883 тэтгэлэг төлөгдөж¹⁶ байгаа нь 15883 хүүхдийн хуваарьт хөрөнгийн эрх хангагдаж байна гэсэн үг.

Шүүх өв залгамжлалтай холбоотой хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ хойт эцэг, эх, дагавар хүүхдийн харилцаа үүссэн эсэх, үүссэн бол тэдний эцэг, эх, хүүхдийн харилцаа, мөн аль аль талаасаа дагавар хүүхэдтэй байхад нэг талд нь анзаарч шийдвэрлэх, төрсөн эцэг, эхийн эд хөрөнгөгүй, өвлүүлэх чадваргүй байх зэрэг нөхцөл байдлуудыг тодруулж авч үзэлгүйгээр хатуу тогтсон байдлаар өвлөх эрхгүй гэж шийдвэрлэж¹⁷ байгаа нь дагавар хүүхдийн хуваарьт хөрөнгийн эрхийг зөрчиж байна.

2020 оны 1 сараас 2021 оны 1 сар хүртэл хугацаанд шүүхийн шийдвэрийн цахим сан¹⁸ дахь иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн бэлэглэлийн гэрээтэй холбоотой 13 хэрэг маргаанаас 1¹⁹ нь л насанд хүрээгүй хүүхдийн өв залгамжлах эрхийг зөрчсөн маргаан байна. Эдгээр 13 хэрэг маргааны нэхэмжлэл болон шүүхийн шийдвэрт маргаан зүйл болох газар, үл хөдлөх хөрөнгө нь гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгө болох тухай дурдаагүй байна.

¹⁵ www.forum.mn Мөн эмхтгэлийн 100 дах тал

¹⁶ www.1212.mn

¹⁷ https://legaldata.mn/b/675 Тайван А. Хууль ёсоор өв залгамжлах эрхийн харилцаан дахь дагавар хүүхдийн эрхийн хамгаалалт

¹⁸ https://shuukh.mn/cases/1/1

¹⁹ ХУД 18/ШШ2020/01742 шийдвэр

Манай улсын шүүхийн статистик тайлан, судалгаанд гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах харилцааны маргаан, гэр бүлийн дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөөс гишүүнд /хүүхдэд/ ногдох хэсгийг тодорхойлох, хуваах маргааныг шүүхээр шийдвэрлэсэн тухай тусгагддаггүй харин материаллаг хуулийн нэрээр “иргэний эрх зүйн маргаан²⁰” гэсэн ерөнхий байдлаар гардаг. Энэ нь шүүхээр шийдвэрлэж буй иргэний эрх зүйн маргааны төрөл тус бүрийг нарийвчлан судлахад бэрхшээл учруулахын зэрэгцээ, иргэний эрх зүйн маргаанууд эрдэм шинжилгээ, судалгааны эргэлтэд орохгүй байснаар салбар эрх зүйн хүрээнд тулгамдсан асуудлыг бүрэн, үндэслэлтэй тодорхойлох боломжгүй болгож байна. Тухайлбал, 2018 онд шүүхээр шийдвэрлэсэн иргэний эрх зүйн 21616 хэрэг маргаан, 2019 онд шийдвэрлэсэн 20624 хэрэг маргааны хэд нь гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх, дундын эд хөрөнгө, гэр бүлийн гишүүний хуваарьт хөрөнгө, өв залгамжлал, бэлэглэлийн гэрээтэй холбоотой маргаан болох нь тодорхойгүй байна.

Б. Захиргааны журмаар хамгаалах: Захиргааны журмаар хүүхдийн хуваарьт хөрөнгийн эрхийг хамгаалах үйл ажиллагаа нь төрийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий, тухайн харилцааг зохицуулж буй хуульд заасан байгууллага, албан тушаалтны хуульд заасан шийдвэр гаргах, зөвшөөрөл олгох, хяналт тавих, бүртгэл

²⁰ https://www.court.za.gov.mn/812--2019-.html Монгол Улсын шүүхийн тайлан (2019 он) 241 дэх тал

мэдээллийн сан бүрдүүлэх удирдлага-зохион байгуулалтын үйл ажиллагааны нийлбэр болно.

Захиргааны журмаар хамгаалах үйл ажиллагааг асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагаа, эд хөрөнгийн улсын бүртгэлийн үйл ажиллагаа, нотариатын үйлчилгээ, нийгмийн халамжийн байгууллагын үйл ажиллагаа, гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын үйл ажиллагаа гэсэн хүрээгээр авч үзье.

Асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагаа нь нас болон эрүүл мэнд, амьдралын нөхцөл байдлын хувьд эрхийн тусгай хамгаалалт зайлшгүй шаардлагатай байгаа иргэнд төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоож тэдний эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх, үүргийг хамгаалах зорилготой. Гэр бүлийн тухай хуулиар асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь "асрамж, дэмжлэгтэй байгаа хүнийг хоол, хүнс, орон сууцаар хангах, асран сувилах, эрх, ашиг сонирхлыг нь хамгаалах, мөнгөн хөрөнгө, үнэт зүйл, үнэт цаас, бусад баримт бичгийг банкинд хадгалуулах, үл хөдлөх эд хөрөнгө, мал, банкинд хадгалуулсан мөнгөн хадгаламж, бусад үнэт зүйлийг өөрт нь зориулан захиран зарцуулах, орон сууц хөлслөх гэрээг цуцлахдаа болон асрамж дэмжлэгтэй байгаа хүний нэрийн өмнөөс шинээр аж ахуй эрхлэх, эрхэлж байгаа аж ахуйн ажлыг зогсоохдоо тухайн сум, дүүргийн Засаг даргаас зөвшөөрөл авах, хүлээсэн үүргийнхээ талаар тухайн сум, дүүргийн Засаг даргад жил бүр тайлагнах

үүрэгтэй, энэ үүргээ биелүүлэхдээ өөрийн асрамж, дэмжлэгт байгаа бага насны болон сэтгэцийн өвчтэйгээс бусад хүний саналыг сонсох үүрэгтэй²¹. Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн ирүүлсэн тайланд дүн шинжилгээ хийх, гарсан зөрчлийг шийдвэрлэсэн тухай судалгаа, мэдээлэл нийтэд ил тод биш байна.

Эд хөрөнгийн улсын бүртгэлийн хуульд заасан төрлүүдээс гэр бүл дэх хүүхдийн хуваарьт хөрөнгийн эрхтэй хамааралтай нь эд хөрөнгийн өмчлөх эрхийн, газар эзэмших эрхийн бүртгэл юм. Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн мэдүүлгийн маягт дээр хамтран өмчлөгчийн тухай мэдээллийн хэсэгт "хүүхэд" гэж тусгайлсан мэдээлэл оруулахгүй ч регистрийн дугаараар нь тогтоож болно. Практикт гэр бүлийн гишүүд хамтран өмчлөх дундын үл хөдлөх хөрөнгийг нэг хүний дээр өмчлөх эрхийн гэрчилгээг гаргуулах сонирхол ихтэй байдаг. Учир нь бусдад худалдах, барьцаалах тохиолдолд хамтран өмчлөгч тус бүр нь ирж гарын үсэг зурах зэрэгт анхаарлаа хандуулдаг ба үүний цаана гэр бүлийн бусад гишүүдийн хөрөнгийн эрх нь хязгаарлагдах, зөрчигдөх явдал гарна гэж ирээдүйн үр дагаврыг төдийлөн ойшоохгүй байдал байсаар байна.

Нийгмийн халамжийн тухай хуулиар 16 насанд хүрсэн одой иргэн, хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн, тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдэд олгож

²¹ Гэр бүлийн тухай хуулийн 69 дүгээр зүйл.

буй нийгмийн халамжийн тэтгэвэр²², 18 хүртэлх насны хүүхдэд олгож буй сар бүр олгож буй хүүхдийн мөнгөн тэтгэмж²³ нь хүүхдийн хуваарьт хөрөнгөнд хамаарна. Гэвч дээрх халамжийн тэтгэвэр болон тэтгэмжийг эцэг, эх, харгалзан дэмжигч нарын зүгээс гэр бүлийн амьжиргаагаа залгуулах эх үүсвэр болгох²⁴ нь нийтлэг болжээ.

2012 оны 4 сарын 11-нээс өмнө төрсөн, иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдсан хүн бүр Эрдэнэс-Таван толгой ХК-ны 1072 хувьцааг эзэмшиж байгаа. Мөн Газрын тухай хуулиар хүүхдэд нэг удаа үнэгүй өмчлүүлсэн газар, 1072 ширхэг хувьцаа, хүүхдийн мөнгөний талаар маргаан одоогоор гарсан тухай албан ёсны мэдээлэл байхгүй байгаа ч хүүхдүүд насанд хүрсэн үеэс ирээдүйд эдгээртэй холбоотой хүүхдийн хуваарьт хөрөнгийн эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийн маргаан гарч ирэх магадлалтай. Иймд хүүхдийн өмчлөх эрхийг хамгаалахын тулд хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах талаар одооноос анхаарах нь зүйтэй.

Монголын нотариатчдын танхим, Улсын бүртгэлийн Ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын тайлан, мэдээлэлд хүүхдийн үл хөдлөх хөрөнгийг жилд хэдийг бусдад шилжүүлж, барьцаанд алдаж байгаа тухай албан ёсны тоон мэдээ тусгагдаагүй байна. Харин 2015 оноос Монголын нотариатчдын танхим

дэргэдээ “Өвийн мэдээллийн нэгдсэн сан” байгуулан өв залгамжлалтай холбоотой нотариатчдын үйлдлийн мэдээллийг бүртгэж байгаа ч хуульд зааснаар болон гэрээслэлээр өвлөн авсан хүүхдийн үл хөдлөх хөрөнгө, бэлэглэлийн гэрээгээр хүүхдэд зориулж шилжүүлсэн үл хөдлөх хөрөнгийг хууль ёсны төлөөлөгчид худалдаж, барьцаалж байгаад хяналт тавих боломжгүй байна.

Монгол Улсад 2017 оноос хүүхдийн эрхийн улсын байцаагчийн²⁵ эрх бүхий 38 ажилтан ажиллаж, Зөрчлийн тухай хууль²⁶д заасан хүүхдийн эрхийн зөрчлийг шалган шийдвэрлэх, хууль сурталчлах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа зохион байгуулах чиг үүрэгтэй ажиллаж, 2017 онд 26 зөрчил, 2018 онд 181 зөрчил, 2019 онд 72 зөрчил шалган шийдвэрлэжээ.

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн “14.1.6.хүүхдийн эрхийн талаар мэдээллийн сан бүрдүүлж, ашиглах;”, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2016 оны 12 сарын 26-ны өдрийн А/331 дүгээр тушаалаар баталсан “Хүүхдийн эрхийн мэдээллийн санг бүрдүүлж, ашиглах тухай журам²⁷”-ын “2.2.6. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны мэдээллийн сан” байна гэжээ. Харин энэ мэдээллийн санд хүүхдийн эрхийн талаарх ямар ямар мэдээлэл байх ёстойг тусгайлан тодорхойлоогүй байна.

²⁵ Хүүхдийн эрхийн тухай хуулийн 20 дугаар зүйл.

²⁶ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйл. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалал. 1.8 дугаар зүйлийн 6.26 дах заалт “6.26.хүүхдийн эрхийн улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйл, 10.23 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

²⁷ <https://www.mlsp.gov.mn/>

²² Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.3, 12.1.4 дэх заалтууд.

²³ Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5 дах заалт

²⁴ Нямжав Б. Хүний эрх сэтгүүл УБ.2020 он. №1. 78 дах тал.

Дүгнэлт

Гэр бүл дэх хүүхдийн хуваарьт хөрөнгийн эрхийг хэрэгжүүлэх, хамгаалах эрх зүйн боловсронгуй зохицуулалт нь нийгмийн амьдралын бүхий л салбарт хүүхдийн эрхийг нэгдмэл байдлаар хангахын нэг хэсэг болно.

Эцэг эхийн хувьд хүүхдийн төрсний гэрчилгээ, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хувьд асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосон тухай сум, дүүргийн Засаг даргын захирамж итгэмжлэл нь болно. Хэдийгээр ийм итгэмжлэлтэй ч хүүхдийн хууль ёсны төлөөлөгчийн зүгээс хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хэрэгжүүлэн явуулж байгаа үйлдэл, үйл ажиллагаандаа Хүүхдийн эрхийн тухай хууль, Иргэний хууль, Гэр бүлийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулиуд дах эрх, үүргээ хүүхдийн дээд ашиг сонирхлын хүрээнд хэрэгжүүлэхгүй байх, “хүүхэд юм чинь” гэсэн хандлагаар хуваарьт хөрөнгийн эрхийг зөрчих зөрчлүүд нэмэгдэж байна. Энэ нь нэг талаасаа манай хүн амын эрх зүйн ухамсар, соёлын түвшин, хуульд заасан эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах эрх зүйн хамгаалалтын арга, хэлбэрийн талаарх мэдлэг мэдээлэлгүй байдалтай холбоотой ч нөгөө талаас тухайн харилцааг зохицуулж байгаа хуулиудын уялдаа холбоо хангалтгүй, хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиуд “эрх зүйн хийдэлтэй, байгаа хэм хэмжээг хэрэгжүүлэх нарийвчилсан зохицуулалтгүй “хэт ерөнхийлсөн”-тэй холбоотой.

Хүүхдийн эрхийн олон улсын гэрээ конвенци²⁸-д үндэслэн хүүхдийн эрхийг

хамгаалах шүүхийн хамгаалалтын хүрээг өргөжүүлж, Гэр бүлийн тухай хуулийн хүрээнд хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хэрэгжүүлэх, хамгаалах зохицуулалтыг гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлахдаа шүүхээс гэрлэлт цуцалсны дараа хүүхдийн эрхийг хэрхэн хамгаалах талаар хүүхдийн эрхийг хангах арга хэмжээ, эцэг эхийн эрх, үүрэг, оролцоог тусгасан гэрээ байгуулах, төлөвлөгөө гаргах зэргээр урьдчилсан арга хэмжээ авсан байхыг гэрлэгчдээс шаардах, гэрлэлт цуцалсны дараа хүүхдийн эрхийг хангаж хамгаалах эцэг эхийн гэрээ, төлөвлөгөө нь хэрэгжихэд эргэлзээтэй, хүүхдийн эрхийг дордуулсан гэж шүүгч үзвэл гэрээ, төлөвлөгөөг дахин боловсруулахыг эцэг эхэд үүрэг болгож гэрлэлт цуцлах ажиллагааг түдгэлзүүлж болох зохицуулалтыг хуульчлах нь зүйтэй.

Хүүхдэд эцэг эхийн гэрлэлт цуцалсаны дараа болон өв залгамжлалаар хүлээн авсан хуваарьт хөрөнгийн эрхийг хамгаалах, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хууль бус үйлдлийг хязгаарлах зорилгоор хүүхдийн эд хөрөнгөнд узурфрукт тогтоож, хүүхдийн өмчлөлийн эд хөрөнгийг дур мэдэн түүний өмнөөс нь захиран зарцуулах үйлдлээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн хуваарьт хөрөнгийн эрхийг захиргааны журмаар хамгаалахад хүүхдийн эрхийн улсын байцаагчийн үүрэг оролцоог нэмэгдүүлсэн зэрэг эрх зүйн зохицуулалтуудыг холбогдох хууль тогтоомжид хуульчлах шаардлагатай байна.

²⁸ www.legalinfo.mn Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 19 дүгээр зүйлийн 19.2 дах заалт

ГЭР БҮЛИЙН ЭРХ ЗҮЙ ДЭХ ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦОО

О.ЭРДЭНЭЗУЛ

(Шихихутуг их сургуулийн магистрант)

Монгол улсын Үндсэн хуулийн¹ арван нэгдүгээр зүйлд "...Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална", Гэр бүлийн тухай хуулийн² 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэгт "Хүүхдийг гэр бүлийн дотор эрүүл чийрэг өсгөн хүмүүжүүлэх, хөгжүүлэх, түүний эрх, ашиг сонирхлыг нь нэн тэргүүнд хамгаалахыг эрхэмлэнэ" хэмээн тус тус заасан байдаг.

Иргэний хэргийн анхан шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн нийт хэрэгт Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 4763 буюу 9.9 хувийг эзэлжээ.³ Үүнээс Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо өмнөх оны мөн үеийнхээс 197 хэргээр буюу 4.3 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан байна.⁴

Манай улсын хувьд гэр бүлийн харилцааны суурь судалгааг 2004⁵, 2010⁶ онуудад Хүн ам, гэр бүлийн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (яам)ын захиалгаар хийж гүйцэтгэсэн. Үүнээс хойш буюу өнгөрсөн 8 жилийн хугацаанд гэр бүлийн

харилцаанд нийгмийн олон үзэгдэл, онцлог үйл явдал өрнөж, үр дагавар нь нөлөөлсөөр байгааг дараах зарим тоон мэдээллээс харж болно. Тухайлбал, 2010 онд Монгол Улсад нийт 742.2 мянган өрх байсан бол 2017 онд 885.6 болж, 19.3 хувиар нэмэгдсэн байна. Түүнчлэн өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо 76.8 мянгад хүрсэн⁷;

Архи, тамхи хэрэглэгчийн нас залуужиж, бага насны хүүхдүүдийн гэмт хэрэгт өртөх байдал ихэссэн байна. 2010 онд шүүхээс ял ноогдуулсан 7292 иргэнээс 353, 2017 онд шүүхээс ял ноогдуулсан 9019 иргэнээс 425 тохиолдол нь насанд хүрээгүй иргэд эзэлж байсан бол 2020 онд 415 буюу төдийлэн буурахгүй байна⁸;

2010 онд гэр бүл цуцлалтын тоо 3054 байсан бол 2019 оны байдлаар 4262 буюу 22.6 хувиар өссөн⁹;

2020 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын Эрүүгийн хуулийн мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах зүйл ангиар 74 хэрэгт, нийт 138 иргэн шүүхээс ял шийтгүүлсэн

¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл, №1, 1992 он

² Төрийн мэдээлэл эмхэтгэл, №30, 1990 он

³ Монгол Улсын шүүхийн 2018 оны шүүн таслах ажиллагааны тайлан, 2018 он

⁴ Монгол Улсын шүүхийн 2018 оны шүүн таслах ажиллагааны тайлан, 2018 он

⁵ Гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал. НХХЯ, Гал голомт хөдөлгөөн. УБ., 2004

⁶ Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал. НХХЯ, ФСЭХ. УБ., 2010

⁷ <https://www.1212.mn/> Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

⁸ Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн. 2010, 2017, 2020 оны Монгол улсын шүүн таслах ажиллагааны тайлан

⁹ <https://www.1212.mn/> Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

нь сүүлийн 10 жилийн тохиолдлоос 2.1 дахин их байгаа нь анхаарал татахуйц статистик юм.

Анхны гэрлэлтийн дундаж нас дээшилж, гэрлэлтээ батлуулахгүйгээр хамтран амьдрах хэв шинж хүн амын дунд нэлээд ажиглагдах болсон. Нийт хүн амын 12.8 хувийг хамтран амьдрагч буюу хууль ёсоор гэрлэлтээ батлуулаагүй иргэд эзэлж байгаа бөгөөд тэдгээрийн ихэнх нь 20-35 насныхан байна. Анхны гэрлэлтийн нас дээшилж, эрэгтэйчүүд 26, эмэгтэйчүүд 24 насандаа зонхилон гэрлэх болжээ.¹⁰ Гэрлэх насны хүн амын дунд ганц бие, гэрлээгүй иргэдийн эзлэх хувь нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. Тухайлбал, 1989 онд гэрлэх насны 4 хүн тутмын нэг, харин 2013 онд тус үзүүлэлт 3 хүн тутмын нэг нь огт гэрлээгүй байна; Өрх толгойлсон эмэгтэйчүүд 43.8 хувь, эрэгтэй тэргүүнтэй өрхийн 34.8 хувь нь ядуурлын шугамаас доогуур амьжиргаатай байна. Ядуурлын шугамаас доогуур амьжиргаатай өрхийн 12-17 насны хүүхдийн сургуульд хамрагдалтын түвшин 67.0 хувь байна; Дээд боловсролтой 35-49 насны эмэгтэйчүүдийн 25.0 орчим хувь, 20-34 насны эмэгтэйчүүдийн 46 хувь нь өөрөөсөө доогуур түвшний боловсролтой эрэгтэйтэй гэрлэжээ.¹¹

Философи, социологи, эрх зүйн хүрээлэн, Улаанбаатар Их Сургууль тус тус хийж, гүйцэтгэсэн байна. Эдгээр судалгаанд гэр бүлийн харилцааны байдал, хэв маяг, үүрэг, зөрчил, гэр бүл дэх жендерийн асуудал, гэр бүлийн харилцаанд нөлөөлж буй хүчин

зүйлсийг тодорхойлон судалсан байна. Энэ нь тус суурь судалгааг харьцуулах боломж, бүрдүүлж байгаагаар ач холбогдолтой юм. 2014 онд судлаач Б.Наранчимэгийн хийсэн Монгол дахь гэрлэгсдийн боловсролын ижил төстэй байдал судалгааг нэрлэж болно. Тус судалгаанд хүн амын гэрлэлтийг боловсролын түвшинтэй холбон үзсэн бөгөөд хосуудын нас, боловсролын түвшний ялгаа нь гэрлэлтийн төрөл, хэлбэрээс хамаарч байгааг харуулсан байдаг.

Гэр бүл судлаач Т.Намжилын Монгол гэр бүл цуврал бүтээлүүд, судлаач Б.Оюун-Эрдэнийн Гэр бүлийн боловсрол цуврал бүтээлүүд нь монгол гэр бүлийн харилцааны олон талт асуудлыг түүхэн уламжлал, зан заншил, сэтгэл зүйн хүрээнд нарийвчлан судалж, шинжилгээ хийсэн байна.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан 2010 оны Хүн ам, орон сууцны тооллогын үр дүнд үндэслэсэн Өрх, гэр бүлийн байдал сэдэвчилсэн тайланд өрхийн гишүүдийн хүн ам зүйн болон насны бүтэц, гэрлэлт, үндэстэн, ястны ялгааг тусгажээ. Гэвч Иргэний эрх зүйн харилцаан дахь гэр бүлийн хариуцлагын тогтолцоог нарийвчилсан, схемтэй байдлаар судалсан судалгааны ажил хомс байна. Дээр дурдсан баримт, мэдээлэл манай улсын хувьд гэр бүлийн бүтэц, харилцаа, боловсролын асуудалд болон гэр бүлийн эрх зүйн харилцаанд хариуцлагын тогтолцоог шинжлэх ухаанд тулгуурласан системт бодлого нэвтрүүлж, онцгойлон хандах шаардлагатай байгааг илтгэж байна.

¹⁰ МУ-ын 2010 оны хүн ам орон сууцны тооллого

¹¹ Мөн тэнд

Монгол улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 11 дэх хэсэгт "... гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална" хэмээн баталгаажуулсан байдаг. Үндсэн хуулиас бусад хууль нь түүнд захирагддаг гэдэг утгаараа Үндсэн хууль бол бүх хуулийн эх, суурь, хөрс нь юм. "Нийгмийн бүхий л төрлийн харилцаанд, тэр дундаа гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш эрхтэй байна. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн, эрэгтэй эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ" хэмээн Монгол улсын Үндсэн хуульд заасан байдаг учраас энэхүү эрхийг баталгаажуулсан хуулиуд буюу Гэр бүлийн тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай зэрэг хуулиудыг батласан байдаг. Эдгээр зохицуулах зүйлийг эрх зүйн ямар аргаар зохицуулдаг гэдэгт хариулт өгвөл

Үүнд: Императив буюу захирамжлах, диспозитив буюу зөвшилцөх гэсэн 2 аргыг нэрлэж болох юм. Жишээ авч үзье. Гэр бүлийн тухай хуулийн 6.2 заалтад "Эрэгтэй хүн нэг эхнэр, эмэгтэй хүн нэг нөхөртэй байна" гэсэн. Үүнийг зөрчих юм бол гэрлэлтийн харилцаанд харшлах буюу хоёр дахь гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцно гэсэн. Өөрөөр хэлбэл, хатуу тогтоосон, захирамжилсан хэлбэрээр зохицуулсан хуулийн заалт байгаа юм. Диспозитив буюу зөвшилцөх аргын тухайд, гэр бүлийн тухай хуулийн

14.5 заалтад "Гэрлэгчид гэрлэлтээ цуцлахдаа хүүхдээ хэний асрамжид үлдээх тухайгаа харилцан тохиролцож болно" гэсэн. Энэ нь гэр бүлийн эрх зүйн харилцаанд оролцож буй этгээдүүдэд хууль тогтоогчоос харилцан зөвшилцөх боломжийг олгох хэлбэрээр зохицуулсан хуулийн заалт байгаа юм.

Дараагийн дэд сэдэв бол эрх зүйн зарчмын асуудал юм. Эрх зүйн онолд эрх зүйн зарчим гэж эрх зүйн хэмжээг тогтоох, хэрэглэх бүрийд мөрдлөгө болговол зохих үзэл санааны нийлбэрийг ойлгоно. Гэр бүлийн харилцаанд оролцогчдын хувьд буюу та, бидний хувьд ч гэсэн доорх зарчмууд хамаатай. Үүнд:

- Гэрлэлт тэгш эрхийн, сайн дурын харилцаанд дээр үндэслэгдэх зарчим;
- Иргэний үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхахыг хориглох зарчим;
- Гэр бүл нь нийгмийн үндсэн нэгж байх зарчим;
- Гэр бүл, хүүхдийн ашиг сонирхолыг төр хамгаалах зарчим;
- Хүүхдийг гэр бүл дотор эрүүл чийрэг өсгөн хүмүүжүүлэх, хөгжүүлэх, түүний эрх ашиг сонирхолыг нь нэн тэргүүнд хамгаалах зарчим;
- Гэр бүлийн гишүүд нэг нөхөр, нэг эхнэртэй байх зарчим;
- Гэр бүлийн дотоод асуудлыг зөвхөн гэр бүлийн гишүүд харилцан тохиролцож, шийдвэрлэх зарчим;

Дээр дурьдсан агуулгаас гадна хариуцлагын тогтолцоонд оролцох

субъект, объектийг тодорхойлох шаардлагатай.

Иргэний эрх зүй дэх Гэр бүлийн харилцаан дах субъект нь тухайн харилцаанд эрх эдэлж, үүрэг хүлээн оролцож байгаа этгээд буюу эхнэр, нөхөр, салсан эхнэр, нөхөр, эцэг, эх, үрчлэгч, үрчлүүлэгч, төрсөн, үрчилж авсан, дагавар хүүхэд, төрсөн ах, эгч, дүү эмээ, өвөө, ач, зээ, хойд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, асран хамгаалах, харгалзан дэмжих байгууллага байдаг.

Гэр бүлийн эрх зүйн харилцааны объект гэдэг нь тухайн харилцаанд өртөгдөж буй бүхий л зүйлийг илэрхийлсэн ойлголт. Объектэд гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгө, хүүхдийн тэтгэлэг болон эрх, үйлдэл хамаарна. Харин гэр бүлийн эрх зүйн харилцааны агуулга гэдэг нь тухайн харилцаанд оролцогчдын субъектив эрх, хууль зүйн үүргийн нийлбэрийг илэрхийлсэн ойлголт юм.

Гэр бүлийн харилцаан дахь хариуцлагын тогтолцоо нь Иргэний хууль, Гэр бүлийн тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хуулиар тодорхойлсон үүрэг, хариуцлагын нэгдмэл хэлбэрийг илэрхийлж байдаг аж.

Тулгамдсан асуудлуудыг тодорхойлох нь

Гэр бүлийнхээ өмнө хүлээсэн үүргээ хариуцлагаа ухамсарлах нь тухайн хувь хүнээс шалтгаалах нь ойлгомжтой. Мөн гэрлэлтээ цуцлуулах, гэрлэлтээ цуцлуулсанаас үүсэх үр дагаврыг хариуцах нь ч гэрлэгсдийн хүлээх ёстой үүрэг мөн. Эрүүгийн тоо бүртгэлээс

харахад улсын хэмжээнд 2020 оны эхний 3 сард 8003 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1902(19.2%)-оор, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 279 гэмт үйлдэл бүртгэгдсэн бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 104 (27.2%)-өөр тус тус буурчээ. Тус гэмт хэргийн нийт дүнд эзлэх хувь 3.5 байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.4 пунктээр буурсан байна.¹²

Гэр бүл цуцлалтыг гэр бүл болон хамтран амьдарч байсан хугацаагаар нь авч үзэхэд 4-6 жил амьдарч байгаад гэр бүл цуцалсан хосуудын эзлэх хувь сүүлийн жилүүдэд нэмэгдэж байснаа 2013 оноос буурсан байна. Харин 10, түүнээс дээш жилийн хугацаанд гэр бүл болон амьдарч байсан хүмүүсийн эзлэх хувь 2008 оноос хойш буурах хандлагатай байсан боловч 2015 оноос өсч 2018 онд 62.1 хувь болж өмнөх оноос 3.5 пунктээр өсжээ. Гэр бүл цуцлалтыг сүүлийн 10 жилийн байдлаар авч үзэхэд 2008 онд хамгийн бага буюу 1901 байсан бол 2018 онд гэхэд хамгийн их буюу 4201-д хүрсэн бол цаашид өсөх хандлагатай байгааг 2019 оны байдлаар 4,262¹³ гэсэн тооноос харж болно. Үүнээс улбаалан хүүхдийн эрхийн зөрчил өссөн дүнтэй гарсан байна. Тодруулбал, Нэг цэгийн үйлчилгээний төвд 2020 оны эхний 3 сарын байдлаар, нийт 920 хүн үйлчлүүлсэн (618 нь эмэгтэй, 114 эрэгтэй, 274 хүүхэд) нь өмнөх оны мөн үеэс 76.6 хувиар нэмэгдсэн байна.¹⁴

¹² Статистикийн тойм: "Гэр бүлийн хүчирхийлэл", Монгол улсын Үндэсний статистикийн хороо, 2020 он

¹³ Монгол улсын статистикийн Үндэсний хороо, 2020 он

¹⁴ Статистикийн тойм: "Гэр бүлийн хүчирхийлэл", Монгол улсын Үндэсний статистикийн хороо, 2020 он

Санал, дүгнэлт

Гэр бүл бол хүүхэд амьдрах, хөгжих, төлөвших анхдагч орчин юм. Тиймээс хүүхэд хамгааллын асуудлыг гэр бүлийн орчин, эцэг эхийн үүрэг, хариуцлага, гэр бүлийн бусад гишүүдийн оролцооноос салган үзэх боломжгүй. Гэрлэгчид гэрлэлтээ цуцлуулах үед хүүхдийг хэн өөртөө авч асрамжлах талаар тохиролцож чадаагүй бол шүүх Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6, 14.7-д зааснаар хүүхдийн нас, эцэг эхийн халамж, ахуйн нөхцөл, бололцоо, ёс суртахууны байдал, хүчирхийлэл үйлдсэн эсэхийг харгалзан асрамжлагчийг тогтоодог. Зорилго талаас авч үзвэл ямар нэг харилцааг зохицуулж буй хууль нь хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, харилцаанд оролцогчдын эрх зүйн ухамсар дээшилж буй хэдий ч эрх зүйн зохицуулалтанд гэрлэгчдийн хүлээх хариуцлагыг нэлээд тодорхой хуульчилж өгөх шаардлагатай байна. Үүнд:

Хүүхэд аюулгүй орчинд эрүүл саруул, сурч хүмүүжих эрхээ эдлэн, инээж хөөрөн, айх айдасгүй сэргэлэн цовоо өсөх боломжийг нэн тэргүүнд анхааран үзэх шаардлагын үүднээс гэр бүлээ цуцласан тохиолдолд бага насны хүүхдэд эцэг, эхийнхээ хэнд илүү ээнэгшин дассаныг нэн тэргүүнд анхаарах;

Хойд эцгээр овоглосон насанд хүрээгүй дагавар хүүхдэд тэтгэлэг нэхэмжлээгүй үндэслэлээр хүүхдийн тэтгэлэг тогтоолгүй орхигдуулж байгааг эрх бүхий байгууллагууд заавал ч үгүй шийдвэрлэж байх;

Хамтран өмчлөх дундын эд хөрөнгөөс гэр бүлийн гишүүдэд ногдох хэсгийг тодорхойлохдоо дагавар хүүхдийг гэр бүлийн гишүүнээс хасах, гэр бүлийн хамтран өмчлөх дундын хөрөнгөөс түүнд хуваарилахгүй орших тохиолдол цөөнгүй гарч байна. Шүүх энэ асуудлыг шийдвэрлэхдээ Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д "гэр бүлийн гишүүн" гэж гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл, садангийн хүнийг" хамруулахаар заасны зэрэгцээ мөн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3-д "Дагавар хүүхэд хойд эцэг, хойд эхийн хооронд эцэг, эх, хүүхдийн эрх, үүрэг үүснэ", мөн хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-д "Гэрлэлтээ бүртгүүлээгүй эцэг, эхээс төрсөн болон гэрлэгчдийн хэн нэгний нь дагавар хүүхдийг ялгаварлан гадуурхаж, эрх, ашиг сонирхлыг нь хохироохыг хориглоно" гэсэн зохицуулалтуудыг заавал ч үгүй эргэж харах;

Хүүхдийн асрамжийг хариуцаж буй тал нь нөгөө талд хүүхэдтэй уулзах, хүмүүжил, өсөн бойжиход хувь нэмэр оруулах боломж олгох ёстой. Хэрэв хоорондоо харилцан тохиролцож чадахгүй бол шүүх талуудын хүсэлтээр тухайн асуудлыг зохицуулах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, эцэг, эх нь гэрлэлтээ цуцлуулсан ч хүүхдийн хувьд эцэг, эх байх хариуцлага хэвээр үлдэх тул хүүхдийн эрхийг зөрчих нөхцлийг үүсгэх ёсгүй.

Эх сурвалж

1. Төрийн мэдээлэл эмхэтгэл, №1, 1992 он
2. Төрийн мэдээлэл эмхэтгэл, №30, 1990 он
3. Монгол Улсын шүүхийн 2018 оны шүүн таслах ажиллагааны тайлан, 2018 он
4. Монгол Улсын шүүхийн 2018 оны шүүн таслах ажиллагааны тайлан, 2018 он
5. Гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал. НХХЯ, Гал голомт хөдөлгөөн. УБ., 2004
6. Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал. НХХЯ, ФСЭЗХ. УБ., 2010 <https://www.1212.mn/> Статистикийн мэдээллийн нэгдсэн сан
7. Монгол Улсын шүүн таслах ажиллагааны тайлан. Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн
8. <https://www.1212.mn/> Статистикийн мэдээллийн нэгдсэн сан
9. МУ-ын 2010 оны хүн ам орон сууцны тооллого
10. Мөн тэнд
11. Статистикийн тойм: "Гэр бүлийн хүчирхийлэл", Монгол улсын Үндэсний статистикийн хороо, 2020 он
12. Монгол улсын статистикийн Үндэсний хороо, 2020 он
13. Статистикийн тойм: "Гэр бүлийн хүчирхийлэл", Монгол улсын Үндэсний статистикийн хороо, 2020 он

ИРГЭНИЙ ХУУЛИЙН 282.2-Т ЗААСАН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТҮҮНИЙ ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

С.ГЭРЭЛТ-ОД

(Шихихутуг их сургуулийн магистрант)

Түлхүүр үг: Хүүгийн хэмжээ, илт хохирол, зээлдэгчийн хүсэлт, зээлийн хүү багасгалт, мөнгө угаалт, бизнес эрхлэгчийн бүртгэл, зээлдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, маргааныг хянан шийдвэрлэж буй шүүхэд олгогдсон эрх хэмжээ

Удиртгал: Эрх зүйн этгээдүүдийн хооронд үүссэн зээлийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг Монгол Улсын Иргэний хуулийн 281-286 болон 451-453 дугаар зүйлүүдэд заасны дагуу зохицуулж байна.

Энэ нь тухайн зээлийн гэрээний талууд хэн болох, гэрээний зүйл нь юу болох, тус гэрээ нь онцлог шинж аль төрөлд багтаж байгаа зэрэгтэй холбоотой ойлголт бөгөөд мөн хуулийн 281-286-р зүйлд заасан зээлийн гэрээ нь хувь этгээдүүдийн зээлийн гэрээний харилцаа, бусдын өмчлөлд хөрөнгө шилжүүлэхтэй холбогдсон гэрээний үүрэгт хамаардаг бол 451-453-р зүйлд заасан зээлийн гэрээний нэг талд банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдүүд болох банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо зэрэг байх ба энэ гэрээ нь төрлийн хувьд зээл, төлбөр тооцооны гэрээний төрөлд хамаарна.

Юуны урьд Иргэний хуулийн 281-р зүйлд тусгалаа олсон иргэд хоорондын

зээлийн гэрээний хүүгийн хэмжээ, түүнтэй холбоо бүхий харилцааг зохицуулж буй эрх зүйн зохицуулалт, тулгамдаж асуудал, шийдвэрлэх арга замын талаар тухайлан авч үзье.

Учир нь өдгөө хүчин төгөлдөр үйлчилж буй Иргэний хуулийн холбогдох эрх зүйн зохицуулалт хэт ерөнхий, маргааныг хянан шийдвэрлэж буй шүүхэд олгогдсон эрх хэмжээ диспозитив, гэрээний талуудын эрх зүйн мэдлэггүй байдлаас улбаалан тус зохицуулалтын практик хэрэгжилт муу байгаа зэрэгтэй холбоотойгоор алтаар бороо орсон ч хүний шунал ханадаггүй гэгчээр аливаа этгээдийн эдийн засгийн хүнд байдлыг далимдуулан ашиг хонжоо олох улмаар хүүгээр дарамтлан эдийн засгийн хүнд байдалд оруулах замаар их хэмжээний мөнгө олох зорилго бүхий тухайн үйл ажиллагааг өөрийн амьдралын эх үүсвэрийн нэг хэсэг болгож буй этгээдүүд нийгэмд олноор бий болж улс оронд далд эдийн засаг бий болгох, иргэдийн амьдралыг улам бүр доройтуулах гэх зэрэг нийгмийн олон сөрөг үзэгдлүүд бий болох эрсдлийг бий болгосоор байна.

Үндсэн хэсэг: Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн захиргаа, удирдлагын газрын Мэдээллийн технологи, хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтсээс 2021 оны 01 дүгээр

сарын 06-ны өдөр гаргасан "Анхан шатны шүүхийн 2020 оны 12 дугаар сарын хэргийн хөдөлгөөний нэгдсэн мэдээлэл № 12"-с үзвэл 2020.12.01-2020.12.31-ний өдрийн байдлаар Улсын хэмжээнд нийт 5470 хэрэг, нэхэмжлэл хүлээн авснаас эрүүгийн 1329 хэрэг, иргэний 3902 нэхэмжлэл, захиргааны 239 нэхэмжлэл байх ба дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхүүдийн хувьд нийт 4984 хэргийг хянан шийдвэрлэсэн байна.¹

Түүнчлэн хамгийн сүүлийн үеийн байдлаар гарсан Монгол Улсын Шүүхийн 2019 оны 3 дугаар улирлын тайлан мэдээнээс үзвэл Дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх шийдвэрлэвэл зохих 45977 нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авснаас 8517 нэхэмжлэлийг хуульд заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзаж, буцаах, харъяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлэх, татан авах, нэгтгэх зэрэг ажиллагааг хийж, 30501 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, 6959 хэргийн үлдэгдэлтэй байсан байна. Иргэний хэргийн анхан шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн нийт хэрэгт Иргэний хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 12999 буюу 42.6 хувь байх ба энэхүү маргааны төрлийг 100 хувь хэмээн авч үзвэл нийт хэргийн 52.1 хувийг зээл, худалдах, худалдан авах гэрээтэй холбоотой маргаанууд эзэлж байгаагаас Иргэний хуулийн 281-286-р зүйлд заасан хувь этгээдүүдийн хоорондох зээлийн гэрээний маргаан шийдвэрлэгдсэн нийт маргааны 25 хувийг дангаар эзэлж байгаа нь энэ төрлийн маргаан иргэний

эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд ихээхэн үүсч байгааг харуулж байна.²

Иргэний хуулийн 281 дүгээр зүйлийн 281.1-т *Зээлийн гэрээгээр зээлдүүлэгч нь зээлдэгчийн өмчлөлд мөнгө буюу төрлийн шинжээр тодорхойлогдох бусад эд хөрөнгө шилжүүлэх, зээлдэгч нь шилжүүлэн авсан эд хөрөнгөтэй ижил төрөл, тоо, чанар хэмжээний эд хөрөнгө буюу мөнгийг тохирсон хугацаанд буцаан өгөх үүргийг тус тус хүлээнэ, 282.1. Зээлийн гэрээгээр талууд хэлэлцэн тохиролцож хүү тогтоож болно, 282.2. Хүүгийн хэмжээ нь зээлдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд илт хохиролтойгоор тогтоогдсон бол түүний хүсэлтээр шүүх зээлийн хүүг багасгаж болно*³ хэмээн тус тус заасан.

Иргэний хуулийн 282.2-т заасан эрх зүйн зохицуулалтад тусгалаа олсон заалтуудыг авч үзвэл:

1. Хүүгийн хэмжээ нь зээлдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд илт хохиролтойгоор тогтоогдсон байх;
2. Зээлдэгч нь зээлдүүлэгчтэй байгуулсан хүү тогтоосон зээлийн гэрээнийхээ хүүгийн хэмжээг багасгахаар харьяалах шүүхэд хүсэлтээ өгсөн байх
3. Шүүх зээлдэгчийн хүсэлтийг үндэслэж зээлийн хүүг багасгаж болно зэрэг багтана.

² <http://www.judinstitute.mn/main/244--2019-3-.html>

³ Монгол Улсын Иргэний хууль, Хорин дөрөвдүгээр бүлэг, 281-282 дугаар зүйл, (2002).

¹ <https://www.judcouncil.mn/site/news/statistik>

Асуудлыг тухайлан авч үзэх үүднээс дээрх зүйл заалтуудад тусгалаа олсон асуудлуудад анхаарлаа хандуулбал:

Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар тольд дурьдсанаар дор дурьдсан нөхцөл бий болсон тохиолдолд хүүгийн хэмжээ зээлдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд илт хохиролтой тогтоогдсон гэж ойлгогдохоор байна.

1. Энэ тохиолдолд гэрээний нөхцөл нь хэн ч харсан шударга бус байна гэж шууд хэлэхээр тухайн салбарт тогтсон жишгээс хазайсан байх ёстой.
2. Гэрээний нэг тал нь нөгөө талаас өөрийн гүйцэтгэх үүрэгтэй нь яагаад ч харьцуулж үл болох хамаагүй их хариу үүргийг шаардах тохиолдол яригдах ёстой. Өөрөөр хэлбэл энэ төрлийн харьцуулж үл болох үүрэг болон хариу үүрэг бүхий гэрээг нэг тал нь мэдлэг дутуугаас, эсхүл эдийн засгийн хувьд хүнд байдалд орсоноос болж байгуулах нь цөөнгүй тохиолддог.⁴

Харин зээлийн хүү гэх эл ойлголтыг академич С.Нарангэрэл өөрийн туурвисан “Эрх зүйн эх толь бичиг” бүтээлдээ: Зээлийн хүү бол зээлийг ашигласан хугацаанд гэрээнд заасан хэмжээгээр тооцсон зээлдэгчийн хариу төлбөр буюу зээлийн үнэ юм⁵ хэмээн тодорхойлсон байна.

Угтаа иргэд хоорондын зээлийн гэрээний хариу төлбөр болох хүүгийн

⁴ Наранчимэг, Д. Баярмаа Н нар (2010) Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар, Улаанбаатар хот, х.564

⁵ Нарангэрэл, С. (2007) Эрх зүйн эх толь бичиг, Улаанбаатар хот, х. 226

хэмжээ зээлдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд илт хохиролтойгоор тогтоогдсон бол түүний хүсэлтээр шүүх зээлийн хүүг багасгаж болно гэх эл эрх зүйн зохицуулалт нь гэрээний чөлөөт байдлын зарчмыг нийгмийн тэнцвэрт байдлыг хангах зарчим⁶, шударга ёсны зарчим⁷, болон нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд нийцүүлэн хязгаарлаж байгаа хэлбэр болно⁸.

Гэвч бодит амьдрал дээр иргэд хоорондын зээлийн гэрээний хүүгийн хэмжээ зээлдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд илт хохиролтойгоор тогтоогдсоны улмаас холбогдох эрх зүйн харилцааг маргаан болгон шүүхэд нэхэмжлэл гаргах нь төдийлөн их байхгүй байх ба энэ нь иргэдийн хувьд өөрт болсон эрх зүйн асуудлыг шүүхэд хандан шийдвэрлүүлэх хууль эрх зүйн мэдлэг хомс байгаатай холбоотой ойлголт болно.

Хэд хэдэн шүүхийн шийдвэрт анализ хийвэл:

Шүүхийн шийдвэр 1⁹.

Үйл явдал:

Нэхэмжлэгч Т.Б шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ: Хариуцагч П.Э нь 27.000.000 төгрөгийн зээлийн гэрээг 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдөр

⁶ Тэмүүлэн, Б. Энхзул, Д. Буянхишиг, Б (2010) Иргэний эрх зүйн ерөнхий анги, Улаанбаатар хот, х.17

⁷ Амарсайхан, Ц. Бямбаа, Л. Доржготов, А (2007) Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Гэрээний эрх зүй-1) Улаанбаатар хот, х.99

⁸ Наранчимэг, Д. Баярмаа Н нар (2010) Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар, Улаанбаатар хот, х.564

⁹ https://shuukh.mn/single_case/100074

байгуулж **7 хоногийн хугацаатай, 20 хувийн хүүтэй зээлдсэн.** Зээлээ төлөхгүй элдэв шалтаг хэлж, биднээс зугтан утсаа авахгүй байсаар өнөөдрийг хүрсэн. П.Э нь ганцхан надаас мөнгө зээлээд зогсоогүй өөр олон хүнээс мөнгө авсан, бусдын автомашиныг ломбардад тавиулж мөнгийг нь авч хүмүүсээс зугтаж алга болсон. П.Э нь зээлсэн мөнгөө өгнө, алданги нэмж төлнө гэж бичгээр хүсэлт бичиж өгсөн. Иймд хариуцагч П.Э-с үндсэн зээл 27.000.000 төгрөг, сарын хүү 5.400.000 төгрөг, алданги 13.500.000 төгрөг нийт 45.900.000 төгрөг гаргуулж өгнө үү гэв.

Хариуцагч П.Э шүүхэд ирүүлсэн хариу тайлбартаа: Иргэн Т.Б надаас нэхэмжилсэн үнийн дүн нь хуулийн дагуу зөв бурууг тогтоож өгнө үү. Би шүүхийн шийдвэрийн дагуу төлбөрийг төлнө. Нэхэмжлэлийн үнийн дүн бодит эсэхийг тогтоож өгнө үү гэв.

Шүүхээс хэрэг маргааныг хянан шийдвэрлэсэн байдал:

Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх: 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн дугаар 102/ШШ2020/03208 тоот шийдвэрээр Иргэний хуулийн 281 дүгээр зүйлийн 281.1, 282 дугаар зүйлийн 282.4-т тус тус зааснаар хариуцагч П.Э-с үндсэн зээл 27.000.000 төгрөг, 7 хоногийн хүү 1.260.000 төгрөг, алданги 13.500.000 төгрөг нийт 41.760.000 төгрөг гаргуулж нэхэмжлэгч Т.Б-д олгож, үлдэх 4.140.000 төгрөгийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэв.

Тус шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж үзвэл: Иргэд

хоорондын зээлийн гэрээний хүүгийн хэмжээ зээлдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд илт хохиролтойгоор тогтоогдсон байх ба хэдий тийм ч зээлдэгчийн хувьд шүүх хуралдаанд хүрэлцэн ирээгүйн дээр өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж 7 хоногийн 20 хувийн хүүгийн хэмжээг багасгахаар шүүхэд холбогдох хүсэлтийг гаргаагүй болохыг харуулж байна. Энэ нь хариуцагчийн энэ талаарх хууль эрх зүйн мэдлэг дутмаг байгааг илтгэж байна хэмээн нэг талаар үзэж болох ба нөгөө талаар шүүхийн хувьд 7 хоногийн хүүгийн хэмжээг сарын хүүгийн хэмжээ хэмээн эндүүрсэн тохиолдол гарсан болох нь харагдаж байгаан дээр эл нөхцөл байдлаас улбаалан магадгүй зээлдүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна. Учир нь өгүүллийн сэдэв болгон авч үзэн буй хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн уг хэм хэмжээг авч үзвэл хэдийгээр зээлийн гэрээний талуудын харилцан тохиролцсон хүүгийн хэмжээ зээлдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд илт хохиролтой болох нь тогтоогдсон ч зээлдэгч хүсэлт гаргаагүй тохиолдолд уг зээлийн хүүгийн хэмжээг багасгах эрх хэмжээ шүүхэд олгогдоогүй болохыг илтгэсэн эрх зүйн зохицуулалт болно.

Шүүхийн шийдвэр 2.¹⁰

Үйл явдал:

Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ: 2016 оны 09 дүгээр 27-ны өдөр Х.Б, О.О нар мөнгө зээлэх

¹⁰ <http://new.shuukh.mn/irgenhyanalt/5180/view>

талаар надтай уулзахдаа "Мөнгөний хэрэг гараад байна. Өөр газар руу яваад мөнгө олдохгүй байна. Танай дүү нар чинь гадаад, дотоодод байдаг биздээ. Мөнгө зээлээч гээд манай дүү Ж.Б-ийн утасны дугаарыг аваад Эрдэнэт хот руу явсан. Үдээс хойш нь 15, 16 цагийн үед манай дүүтэй очиж уулзсан байсан. Х.Б нь 2017 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр миний дүү Ж.Б-ээс 1 сарын хугацаатайгаар 6.500.000 төгрөгийг 25 хувийн хүүтэйгээр зээлэн зээлийн гэрээ байгуулсан. Зээлийг авахдаа гэрээг бичгээр байгуулж, нотариатчийн хажууд хүлээн авсан. Мөн зээлийн барьцаанд өөрийн эзэмшлийн приус маркийн 7102 БУЛ улсын дугаартай тээврийн хэрэгслийг барьцаалж барьцааны гэрээ байгуулсан. Зээлийн гэрээнд заасан хугацаанд хариуцагч нь үүргийг гүйцэтгээгүй. Иймд хариуцагч нараас үндсэн зээл 6.500.000, хүү 1.625.000, алданги 3.900.000 төгрөгийг тус тус нэхэмжилж байна гэжээ.

Хариуцагч шүүхэд гаргасан тайлбартаа: 2018 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр О.О эгч намайг Эрдэнэт яваад өгөөч гэж гуйхад нь би жолоочийн үүрэг гүйцэтгэж явсан. Эрдэнэтэд очоод Ж.Б-тэй уулзаж мөнгө төгрөгний асуудал ярьсан. Тэгэхэд Ж.Б барьцаа өг гэж хэлсэн. О.О эгч намайг машинаа барьцаалаад өгөөч дараа нь чамд туслана ш дээ гээд гуйгаад байхаар нь би зөвшөөрч зээлийн гэрээ байгуулахаар болсон. Ж.Б О.Отгонсүрэнд 6 500 000 төгрөг банкнаас авч өгсөн. Мөнгийг би аваагүй О.Отгонсүрэн эгч тоолж аваад гадаад руу шилжүүлэхээр банк руу явсан. Ж.Б бид хоёр гэрээ байгуулахаар

нотариат явсан, нотариатч мөнгө хаана байна гэж асуугаад байхаар нь О.Отгонсүрэн эгчийг дуудаж мөнгийг нь харуулсан. Би тэр мөнгөнд гар хүрээгүй. Ж.Бямбасүрэн эгчээс мөнгө гуйж байгаагүй. 2017 оны 04 дүгээр сарын 12-ны орой Ж.Бямбасүрэн эгч нөхөртэйгөө гэрт ирж дарамталсан. Ж.Б-ыг утсаар ярихад нь О.Отгонсүрэн мөнгө авсан гэдгийг хэлсэн. Тэгээд би О.Отгонсүрэн рүү залгаж Ж.Б мөнгөө нэхээд байна гэж хэлэхэд удахгүй мөнгө олж өгнө гэж хэлсэн. Тиймээс нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй гэжээ.

Шүүхээс хэрэг маргааныг хянан шийдвэрлэсэн байдал: Булган аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх: 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 81 дүгээр шийдвэрээр Иргэний хуулийн 281 дүгээр зүйлийн 281.1, 282 дугаар зүйлийн 282.2, 232 дугаар зүйлийн 232.6, 232.8-д зааснаар хариуцагч Х.Б-гаас 10 400 000 /арван сая дөрвөн зуун мянга/ төгрөг гаргуулж Ж.Б-д олгож, үлдэх 1 625 000 /нэг сая зургаан зуун хорин таван мянга/ төгрөгийг хэрэгсэхгүй болгож, хариуцагч Х.Б-гийн сөрөг нэхэмжлэлээс Ж.Бямбасүрэнгийн хууль бус эзэмшлээс Приус маркийн 71-02 БУЛ улсын дугаартай тээврийн хэрэгслийг чөлөөлүүлэх шаардлагыг хангаж, зээлийн болон барьцааны гэрээг хүчин төгөлдөр бусад тооцуулах шаардлагыг хэрэгсэхгүй болгож, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д зааснаар төлөөлөн нэхэмжлэгчийн

улсын тэмдэгийн хураамжинд төлсөн 207 350 /хоёр зуун долоон мянга гурван зуун тавь/ төгрөгийг, хариуцагч Х.Б-гийн төлсөн 259 350 /хоёр зуун тавин есөн мянга гурван зуун тавь/ төгрөгийг тус тус Төрийн санд хэвээр үлдээж, хариуцагч Х.Б-гаас 181 350 /нэг зуун наян нэгэн мянга гурван зуун тавь/ төгрөгийг гаргуулж төлөөлөн нэхэмжлэгч Ж.Бямбасүрэнд, төлөөлөн нэхэмжлэгч Ж.Бямбасүрэнгээс 70 200 /далан мянга хоёр зуу/ төгрөгийг гаргуулж хариуцагч Х.Б-д тус тус олгож шийдвэрлэжээ.

Булган аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх:

2018 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 08 дугаар магадлалаар хариуцагчийн өмгөөлөгч Д.Оюунчимэгийн давж заалдсан гомдлыг хангахгүй орхиж Булган аймаг дах сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 81 дүгээр шийдвэрийг хэвээр үлдээж, хариуцагч Ж.Б-гийн давж заалдах журмаар гомдол гаргахдаа улсын тэмдэгийн хураамжинд төлсөн 181 350 000 төгрөгийг төрийн санд хэвээр үлдээжээ.

Хяналтын шатны шүүх: Анхан болон давж заалдах шатны шүүх хэрэгт авагдсан нотлох баримтад тулгуурлан зохигчийн хооронд зээлийн гэрээний харилцаанаас үүссэн эрх зүйн маргааныг Иргэний хуулийн холбогдох зохицуулалтын дагуу үндэслэл бүхий хянан шийдвэрлэжээ. Нэхэмжлэгч Ж.Б-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч Ж.Бямбасүрэн шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ хариуцагч Х.Б-гаас зээлийн гэрээний үүргийн биелэлтэд 6 500 000 төгрөг, хүүд 1 625

000 төгрөг, алдангид 3 900 000 төгрөг нийт 12 025 000 төгрөг гаргуулахаар шаарджээ. Хариуцагч Х.Б шаардлагыг эс зөвшөөрч, Ж.Б-оос мөнгөө зээлж аваагүй, О.Отгонсүрэнгийн зээлийн үүрэгт өөрийн автомашиныг барьцаалсан гэж нэхэмжлэлийг татгалзжээ. Хоёр шатны шүүх хэргийн оролцогчийн гаргасан нотлох баримтыг тал бүрээс нь бодитойгоор харьцуулан үзсэний үндсэн дээр, тухайн хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв, эргэлзээгүй талаас нь үнэлж, маргааны үйл баримтын талаар эрх зүйн хувьд үндэслэлтэй дүгнэлт хийжээ. Хэрэгт авагдсан баримтаас үзвэл нэхэмжлэгч Ж.Б, хариуцагч Х.Б нар нь 2016 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр зээлийн гэрээ байгуулж, Х.Б 6 500 000 төгрөгийг 2016 оны 09 дүгээр сарын 27-ны өдрөөс 2016 оны 10 дугаар сарын 27-ны өдрийг хүртэл 25%-ийн хүүтэй зээлж, Тоёота Приус маркийн автомашиныг үүргийн гүйцэтгэлд барьцаалжээ. Хариуцагч Х.Б зээлийн гэрээнд зээлдэгчээр, барьцааны гэрээнд барьцаалуулагчаар оролцсоноос гадна мөнгийг бэлнээр хүлээн авсан гэж гарын үсгээ зурсан байна. Тухайн зээлийг О.Отгонсүрэн хэрэглэсэн, мөнгийг бэлнээр авсан, захиран зарцуулсан гэх хариуцагчийн тайлбар түүнийг зээлийн гэрээний үүргээс чөлөөлөх, зээлийн болон барьцааны гэрээг хүчин төгөлдөр бусад тооцох үндэслэл болохгүй байна. Анхан болон давж заалдах шатны шүүх энэ талаар хууль зүйн үндэслэлтэй дүгнэлт хийжээ. О.Отгонсүрэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрчийн мэдүүлэг өгсөн ба шүүх гэрчийн мэдүүлгийг зохих журмын

дагуу үнэлсэн байна. Нэхэмжлэгч Ж.Б гэрээнд зээлдэгчээр оролцсон Х.Б-г хариуцагчаар татан, түүнээс зээлийн гэрээний үүргийн биелэлтийг шаардсан нь Иргэний хуулийн 281 дүгээр зүйлийн 281.1.-д заасан шаардлагад нийцсэн байх ба Х.Б нь өөрт учирсан хохирлыг гэм буруутай этгээдээс шаардахад энэ хэргийн шийдвэрлэлт саад болохгүй юм. Түүнчлэн, Нийслэлийн Цагдаагийн газраас өгсөн тодорхойлолтод О.Отгонсүрэнд холбогдуулан үүсгэсэн хэрэг бүртгэлтийн хэрэгт Х.Б хохирогчоор тогтоогдсон болохыг заажээ. хуулбар хувь 2020-10-13 -нд www.shuukh.mn сайтаас татаж авав. Хуудас: 5/5 Анхан болон давж заалдах шатны шүүх Иргэний хуулийн хэрэглэвэл зохих зохицуулалтыг тухайн маргаанд зөв тайлбарлан хэрэглэсэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд заасан журмын дагуу явуулсан байх тул хариуцагчийн хяналтын журмаар гаргасан гомдлын агуулгаар шийдвэр, магадлалыг өөрчлөх, хүчингүй болгох боломжгүй байна. Давж заалдах шатны шүүх магадлалын тогтоох хэсэгт хариуцагчийн давж заалдах гомдол гаргахдаа төлсөн 181 350 төгрөгийн улсын тэмдэгтийн хураамжийг улсын орлогод үлдээхээр заахдаа үнийн дүнг "181 350 000" гэж ташаа бичсэнийг анхааруулан тэмдэглэх нь зүйтэй гэж үзлээ. Техникийн шинжтэй уг алдаа магадлалыг өөрчлөх, хүчингүй болгох үндэслэл болохгүй юм. Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 176 дугаар зүйлийн 176.2.1.-д заасныг удирдлага болгон ТОГТООХ НЬ: 1.Булган аймаг дахь Сум

дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 81 дүгээр шийдвэр, Булган аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 08 дугаар магадлалыг тус тус хэвээр үлдээж, хариуцагчийн гомдлыг хангахгүй орхисугай. 2.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.4.-т зааснаар хариуцагчаас хяналтын журмаар гомдол гаргахдаа улсын тэмдэгтийн хураамжид урьдчилан төлсөн 181 350 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

Тус шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж үзвэл: Эл шүүхийн шийдвэрээс үзвэл иргэд хооронд байгуулагдсан зээлийн гэрээнд буюу өдрийн зээлээс бусдад ч гэсэн өндөр хүү тогтоогдох явдал ажиглагдаж байхаас гадна шүүх хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ хэрэглэх ёсгүй хуулийн заалтыг хэрэглэсэн болох нь харагдаж байна. Учир нь Монгол Улсын Иргэний хуулийн 282.2-т Хүүгийн хэмжээ нь зээлдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд илт хохиролтойгоор тогтоогдсон бол түүний хүсэлтээр шүүх зээлийн хүүг багасгаж болно хэмээн заасан байх бөгөөд хуульд тусгагдсан гипотез буюу нөхцлөөс үзвэл зээлдэгч хүүгийн хэмжээг өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд илт хохиролтой гэж үзсэн тохиолдолд өөрийн хүсэлтийг үндсэн эсхүл сөрөг нэхэмжлэлийн хэлбэрээр шүүхэд гаргасны үндсэн дээр шүүх зээлийн хүүг багасгах эсэхээ Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40

дүгээр зүйлийн 40.1.Шүүх хэргийн оролцогчийн гаргасан нотлох баримтыг тал бүрээс нь бодитойгоор харьцуулан үзсэний үндсэн дээр нотлох баримтыг өөрийн дотоод итгэлээр үнэлнэ.

Шүүхийн шийдвэр 3.¹¹

Үйл явдал:

Нэхэмжлэгч Н.Т- шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ: Би 2016 оны 03 дугаар сарын 24-ний өдөр Э.Э-тай зээлийн гэрээ байгуулж, 15.000.000 төгрөгийг түр хугацаанд 5 хувийн хүүтэй зээлэхээр тохиролцож, уг мөнгийг хүлээлгэж өгсөн ба зээлийн болон барьцааны гэрээ байгуулж, нотариатаар гэрчлүүлсэн. Барьцаа хөрөнгөнд түүний өмчлөлийн орон сууцыг барьцаалж зээл олгосон. Э.Э- гэрээний үүргээ биелүүлэхгүй 2 жилийн хугацаа өнгөрсөн. Иймд хариуцагчаас үндсэн зээл 15.000.000 төгрөг, хүү 750.000 төгрөг, алданги 7.875.000 төгрөг, нийт 23.625.000 төгрөгийг гаргуулж, үүргийн гүйцэтгэлийг барьцаа хөрөнгөөр хангуулж өгнө үү гэжээ.

Хариуцагч Э.Э-шүүхэд гаргасан тайлбартаа: Би 2016 оны 3 сард зээл чөлөөлөх зарын дагуу н.Мөнхжаргалтай холбогдож, уулзахад Н.Т-тай хамт ирсэн. Миний банк бус санхүүгийн байгууллагад төлөх 15.000.000 төгрөгийг тэд төлсөн өгсөн бөгөөд надад бэлнээр 15.000.000 төгрөгийг хүлээлгэж өгөөгүй. Дараа нь нотариат орж зээлийн болон барьцааны гэрээг Н.Т-тай байгуулсан. Би Н.Т-д 15.000.000 төгрөг төлөхийг зөвшөөрч байна. Харин бидний хооронд хийгдсэн зээлийн

гэрээ хүчин төгөлдөр бус байсан. Би мөнгийг бага багаар төлөх сонирхолтой байсан боловч Н.Т- надаас хүү, алданги их хэмжээгээр нэхдэг байсан. Бидний хооронд байгуулагдсан зээлийн гэрээ болон барьцааны гэрээ бүгд худал тул хүчин төгөлдөр бус юм. Иймээс нэхэмжлэлийг бүхэлд хэрэгсэхгүй болгож өгнө үү гэжээ.

Шүүхээс хэргийг шийдвэрлэсэн байдал: Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн 181/ШШ2018/00743 дугаар шийдвэрээр: Иргэний хуулийн 281 дүгээр зүйлийн 281.1, 282 дугаар зүйлийн 282.2, 232 дугаар зүйлийн 232.4 дэх хэсэгт заасныг тус тус баримтлан хариуцагч Э.Э-гаас 23.250.000 төгрөг гаргуулан нэхэмжлэгч Н.Т-д олгуулж, нэхэмжлэлийн шаардлагын үлдэх хэсэг 375.000 төгрөгт холбогдох хэсгийг хэрэгсэхгүй болгож, Иргэний хуулийн 175 дугаар зүйлийн 175.1 дэх хэсэгт зааснаар үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд Сүхбаатар дүүргийн 3 дугаар хороо, 5 дугаар хороолол, 10-79 тоот хаягт байршилтай ГД-0045563, Ү-2203003484 улсын бүртгэлийн дугаартай 27 м.кв талбайтай 2 өрөө орон сууцны үл хөдлөх хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хангуулахыг Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газарт даалгаж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2, 60 дугаар зүйлийн 60.1, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д заасныг баримтлан нэхэмжлэгчийн улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 276.100

¹¹ <http://new.shuukh.mn/irgenhyanal/5168/view>

төгрөгийн 276.075 төгрөгийг төсвийн орлогод хэвээр үлдээж, илүү төлсөн 25 төгрөгийг төсвийн орлогоос, хариуцагч Э.Э-гаас улсын тэмдэгтийн хураамж 274.200 төгрөгийг тус тус гаргуулан нэхэмжлэгч Н.Т-д олгож шийдвэрлэжээ.

Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн 1288 дугаар магадлалаар: Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 181/ШШ2018/00743 дугаар шийдвэрийн 2 дахь заалтыг “Иргэний хуулийн 175 дугаар зүйлийн 175.1 дэх хэсэгт заасан үндэслэлгүй тул Сүхбаатар дүүргийн 3 дугаар хороо, 5 дугаар хороолол, 10-79 тоот хаягт байршилтай, ГД-0045563, Ү-2203003484 улсын бүртгэлийн дугаартай 27 м.кв талбайтай 2 өрөө орон сууцыг худалдан борлуулж үүргийн гүйцэтгэлийг хангуулах тухай нэхэмжлэгч Н.Т-ын нэхэмжлэлийн хэрэгсэхгүй болгосугай” гэж өөрчилж, шийдвэрийн бусад заалтыг хэвээр үлдээж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 162 дугаар зүйлийн 162.4 дэх хэсэгт зааснаар хариуцагчаас давж заалдах журмаар гомдол гаргахдаа улсын тэмдэгтийн хураамжид 146.950 төгрөг төлснийг улсын орлогод хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

Хяналтын шатны шүүхийн тогтоолоор: Зээл чөлөөлөх үйл ажиллагаа явуулдаг этгээдүүдээс мөнгө зээлсэн тухай хариуцагчийн тайлбарыг нэхэмжлэгч үгүйсгээгүй тул түүнийг зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг болохоо хүлээн зөвшөөрсөн гэж үзэх нь

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.4-т нийцнэ. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 3.1.1., 3.1.2.-т тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагааг тогтоосон хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу эрхлэн явуулах эрхийг иргэн, ашгийн ба ашгийн бус хуулийн этгээдэд эрх бүхий байгууллагаас олгосон албан ёсны баримт бичгийг аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл гэж, тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэхээр эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан этгээдийг тусгай зөвшөөрөл эзэмшигч гэж тус тус тодорхойлсон ба банкнаас бусад этгээд хадгаламж, зээлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэхээр мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.3.4.-т заасан. Нэхэмжлэгч зээлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй эрхэлдэг болох нь хэргийн баримтаар тогтоогдоогүй байна. Энэ тохиолдолд зохигчийн хооронд байгуулсан зээлийн гэрээ Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.8.-т зааснаар хүчин төгөлдөр бус тул хүү, алданги гаргуулах хууль зүйн үндэслэлгүй. Иргэний хуулийн 87 дугаар зүйлийн 87.1.-т зааснаар өөр эрхтэй салшгүй холбоотой, түүнгүйгээр бие даан хэрэгжиж үл чадах эрхийг салгаж үл болох эрх гэнэ. Өөрөөр хэлбэл, зээлийн гэрээ хүчин төгөлдөр бус нөхцөлд барьцааны гэрээ хуулийн 56 дугаар зүйлийн хуулбар хувь 56.1.10.-т зааснаар мөн адил хүчин төгөлдөр бус байна. Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.5.-т “энэ хуулийн 56.1-д заасан хэлцэл хийсэн талууд нь

уг хэлцлээр шилжүүлсэн бүх зүйлээ харилцан буцааж өгөх, боломжгүй бол үнийг төлөх үүрэгтэй” гэж заасан тул хариуцагчаас 15.000.000 төгрөгийг буцаан гаргуулж, нэхэмжлэлийн бусад шаардлагыг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй. Дээрх үндэслэлээр шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж, хариуцагчийн гомдлыг хангах боломжтой гэж шүүх бүрэлдэхүүн үзэв. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 176 дугаар зүйлийн 176.2.2.-д заасныг удирдлага болгон ТОГТООХ НЬ: Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн 1288 дугаар магадлалын тогтоох хэсгийн 1, Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн 181/ШШ2018/00743 дугаар шийдвэрийн тогтоох хэсгийн 1, 2 дах заалтыг нэгтгэн 1 гэж дугаарлан “Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.8., 56.1.10., 56 дугаар зүйлийн 56.5.-т заасныг баримтлан хариуцагч Э.Э-гаас 15.000.000 төгрөг гаргуулж, нэхэмжлэгч Н.Т-д олгож, нэхэмжлэлээс 8.625.000 төгрөг гаргуулах болон Сүхбаатар дүүргийн 3 дугаар хороо, 5 дугаар хороолол, 10-79 тоот хаягт байрлах 2 өрөө орон сууцнаас үүргийн гүйцэтгэлийг хангуулах тухай шаардлагыг тус тус хэрэгсэхгүй болгосугай” гэж, 3 дах заалтын “...274200...” гэснийг “...232.950...” гэж тус тус өөрчлөн, 3, 4, 5, 6 дах заалтыг 2, 3, 4, 5 гэж дугаарлан, шийдвэр, магадлалын бусад хэсгийг хэвээр үлдээсүгэй. 2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3.-т зааснаар

хариуцагч хяналтын журмаар гомдол гаргахдаа улсын тэмдэгтийн хураамжид 2018 оны 7 дугаар сарын 04-ний өдөр төлсөн 142.950 төгрөгийг шүүгчийн захирамжаар буцаан олгосугай.

Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ хийж үзвэл: Хяналтын шатны шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж үзвэл энэ төрлийн зээлийн гэрээнд мөн л хүүгийн хэмжээ илт их байх бөгөөд шүүх хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ удирдлага болгон баримталсан Ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар иргэн зээлийн үйл ажиллагаа эрхлэхдээ тусгай зөвшөөрөл авах ёстой хэдий ч энэ үйл ажиллагаа манай улсад хэрэгждэггүй болох нотлогдсон болно.¹²

Дээрх 3 төрлийн шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийж үзвэл иргэд хооронд байгуулагдсан зээлийн гэрээний хүүгийн хэмжээ зээлдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд илт хохиролтой тогтоогддог болох нь тодорхой байх авч зээлдэгч нарын хэн аль нь хүүгийн хэмжээг багасгуулахаар шүүхэд хүсэлт гаргаагүй байгаа нь иргэдийн энэ чиглэлийн эрх зүйн мэдлэг дутмаг, түүнчлэн шүүх хүсэлт гаргаагүй байхад асуудлыг шийдвэрлэдэг, хэрэглэх ёсгүй хуулийн зүйл заалтыг хэрэглэдэг мөн зарим иргэдийн хувьд энэ төрлийн үйл ажиллагаагаар бизнес эрхэлдэг болох нь тодорхой харагдаж байгаа болно.

Өөрөөр хэлбэл энэ бүхнээс дүгнэн үзвэл тогтоогдсон бол гэх эл ойлголт нь зээлдэгчийн хувьд зээлдүүлэгчтэй байгуулсан зээлийн гэрээнийхээ хүүгийн

¹² <http://new.shuukh.mn/irgenhyanal/5168/view>

хэмжээг өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд илт хохиролтойгоор тогтоогдсон хэмээн үзэж холбогдох нотлох баримтыг бүрдүүлсэний үндсэн дээр тус хүүгийн хэмжээг багасгуулахаар шүүхэд хүсэлтээ илэрхийлж шүүх нотлох баримтад тулгуурласан өөрийн дотоод итгэл үнэмшлийн үндсэн дээр хуульд захирагдан нөхцөл байдлыг бодитой үнэлэх тухай ойлголт болно.

Гэвч уг эрх зүйн хэм хэмжээнээс үзвэл нэг талд зээлдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хүүгийн хэмжээнээс шалтгаалан хохирсон нь тодорхой болсон байхад шүүхэд зээлийн хүүг багасгаж болно гэх диспозитив эрхийг олгосон байгаа нь учир дутагдалтай зохицуулалт болно.

Учир нь үйл баримт нэгэнт тогтоогдсон байхад багасгана гэх императив хэм хэмжээг тусгаагүй байгаа нь хатуугаар хэлэхэд хүний амь насыг хохироосон нь тодорхой байхад тохирох ял шийтгэлийг оногдуулах эсэх нь шүүхийн эрх хэмжээний асуудал болгосонтой ижил ойлголт болно.

Мөн нэгэнт иргэдийн хувьд энэ чиглэлээр эрх зүйн мэдлэг хомс байгаа нь ажиглагдаж байх тул бусдын хүнд хэцүү байдлыг далимдуулан ашиг хонжоо олох нөхцөл байдлыг хязгаарлах үүднээс зээлдэгчийн хүсэлтээр гэх эл ойлголтыг уг эрх зүйн зохицуулалтаас хасч харин эл асуудлыг шүүхийн эрх хэмжээ болгон хуульчлах нь зүйтэй санагдана.

Зарим орны эрх зүйн зохицуулалтаас:

Иргэд хоорондын зээлийн гэрээний зээлдүүлэгч субъект нь мөнгөн зээлийн үйл ажиллагаа тогтмол эрхэлдэг бизнес эрхлэгч, эсхүл нэг удаагийн шинжтэй зээл өгөгчийн аль нь болохыг зааглаж өгсөн. Харин манай улсын хувьд эл ялгаа заагийг гаргаагүйн улмаас далд эдийн засгийг хөхүүлэн дэмжих, улс оронд татвар төлдөггүй бизнес эрхлэгчийн эгнээ өргөжих эрсдэл байна.

Дэвшилтэт жишээг авч үзвэл:

Япон улсад гэхэд л 1954 онд баталж мөрдүүлсэн "Зээлийн хүүг хязгаарлах тухай", 1983 онд баталсан "Зээлийн үйл ажиллагааны тухай" хуулиудаар зээлийн үйл ажиллагааг зохицуулдаг байна. "Зээлийн хүүг хязгаарлах тухай хууль"-д зааснаар 100.000 еэнээс бага үнийн дүнтэй зээлийн гэрээний хүүгийн дээд хэмжээ нь жилийн 20 хувь, 100,000 еэнээс 1,000,000 хүртэлх үнийн дүнтэй зээлийн гэрээнд 18 хувь, 1,000,000 еэнээс дээш үнийн дүнтэй бол жилийн 15 хувь байхаар тус тус заажээ.

Малайзын холбооны улсад зээлийн үйл ажиллагаа болон зээлийн хүүгийн дээд хэмжээг нэг хуулиар зохицуулсан. Тус хууль нь 1951 онд баталсан Moneylenders Act буюу Мөнгө зээлдүүлэгчийн тухай хууль юм. Хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Энэ хуулийн дагуу тусгай зөвшөөрөл аваагүй этгээд өөрийгөө бусдад мөнгө зээлдэгч хэмээн танилцуулах, сурталчлахыг хориглоно" гэж заасан. Ингэсэн тохиолдолд 5 жил хүртэл хорих ял шийтгэхээр зохицуулжээ.

Дүгнэлт

Аливаа эрх зүйн зохицуулалтаар нарийвчлах шаардлагатай асуудал бүрийг тусгаж чадваас тэнд эрх зүйн хийдэл үүсэхгүй. Энэ нь хүний эрх, хууль ёсны ашиг сонирхол хамгаалагдах нөхцөл бүрдүүлэх үндэслэл болно. Эдийн засгийн хүчин зүйл, тэр дундаа мөнгөн харилцааг тооцоолохгүй орхивол сэтгэл зүйн дарамтыг бий болгох сөрөг үр дагаварыг бий болгодог. Хүн төрөлхтөний дунд **баялгийн тэгш хуваарилалт** гэх эл ойлголт бүрэн дүүрэн хэрэгжих боломжгүйтэй нэгэн адил зээлийн гэрээний харилцаан дахь гажуудал амь бөхтэй үзэгдэл мөн. Зээл нь өрийн дарамт, аль эсхүл эдийн засгийн хөшүүрэг болох уу гэдэг

нь хэдийгээр хувь хүний асуудал мэт боловч нарийвчилсан зохицуулалтгүй эрх зүйн хэм хэмжээнээс үүдэлтэйгээр үлдээвэл иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд харш нөлөө тогтмол үзүүлэх болно.

Иргэд хоорондын хүүгийн хэмжээнд хязгаарлалт тогтоох, энэ төрлийн үйл ажиллагааг өөрийн амьдралын эх үүсвэрээ болгож буй этгээдүүдийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэлжүүлэх, улмаар Иргэний хуулийн 282.2 дахь хэсэгт **хүүгийн хэмжээ нь зээлдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд илт хохиролтойгоор тогтоогдсон бол шүүх зээлийн хүүг багасгах эрхтэй** байх нь зүйтэй юм.

ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН МӨН ЧАНАР

Б.ОЮУН-ЭРДЭНЭ

(Шихихутуг их сургуулийн магистрант)

“Ипотек” гэдэг нэр томъёо анх МЭӨ 6-р зуунд Афинд үүсчээ. Зээл авсан газрын эзний эзэмшил нутгийн зааг дээр энэхүү өмч нь зээлийн барьцаанд байгаа, эзэн нь хэдий хэмжээний өртэй болох, хэзээ барагдуулах тухай бичсэн “ипотека” хэмээн нэрлэгдэх баганат самбарыг байрлуулдаг байжээ. Хэрэв зээлээ төлөөгүй тохиолдолд газрын эзэн өмчилж байгаа газраа алдах төдийгүй боол болох аюул тулгарч байсан. Биеэрээ төлдөг байсныг эд хөрөнгөөрөө төлдөг болгох зорилгоор барьцааны шинэ хувилбарыг бий болгосон нь орчин үеийн ипотекийн эхлэл болжээ¹. Яваандаа багана босгохоо больж ипотекийн дэвтэр хөтөлдөг болов.

Ипотекийн зээл гэдэг нь үл хөдлөх хөрөнгөөр баталгаажсан урт хугацаатай зээлдэгч нь тодорхой хэмжээний төлбөрийг урьдчилан төлөх үүрэг хүлээсэн зээлийг хэлнэ. Төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд барьцааны үл хөдлөх хөрөнгөөр төлбөрийг барагдуулах эрхийг ипотекийн зээл нь зээлдүүлэгчид олгодог. Ипотекийн² зээл болон Моргейжийн³ зээл нь хоёулаа орон сууцны зээл гэсэн утгатай. Ипотекийн зээл нь Ром Германы эрх зүйн бүлтэй,

Моргейжхан нь Англо-Саксоны гэгдэх улс орнуудад тус тус хэрэглэгддэг.

Үгийн гарал үүсэл, түүний эрх зүйн ойлголт, зарчим, эдийн засгийн агуулгад мөн үндэслэн ипотекийн “Үнэ цэнээ хадгалах орон сууцны барьцаагаар баталгаажин урт хугацааны мөнгөн хөрөнгийн урсгалыг бий болгох харилцаа юм” гэж тодорхойлж болох юм.

Үл хөдлөх эд хөрөнгийн эрх зүйн зохицуулалт

Монгол Улсад үл хөдлөх хөрөнгийн ойлголт онолын болоод практик утгаараа 1990-ээд оноос өмнө ихээхэн бүрхэг байв.⁴ Энэ нь нэг талаас нүүдлийн соёл иргэншлээр явж ирсэн монголчуудын түүхэн нөхцөл, нөгөө талаас манай оронд зах зээлийн эдийн засгийн харилцаа бүрэлдэн тогтоогүй байсантай холбоотой.

Үл хөдлөх хөрөнгийн харилцааг сонгодог утгаар нь хөгжүүлэх боломж манайд хаалттай байсан гэж хэлж болно. Учир нь тухайн үеийн нийгэм зах зээлийн эдийн засгийг үгүйсгэдэг байсан юм. Харин Монгол Улс ардчилсан замыг сонгож авсан тэр цаг үеэс, онцолбол 1992 оны Үндсэн хууль батлагдаж, өмчийн төрөл, хэлбэрийг чөлөөтэй тэгш хөгжүүлэх үүд

¹ Норовдондог Ц. “Ипотекийн үнэт цаасны зах зээлийн хөгжлийн асуудал” 2011. 5 дахь тал

² Европ нэршил.

³ Америк нэршил

⁴ Монгол Улсын үл хөдлөх эд хөрөнгийн эрх зүйн зохицуулалт, А.Батсайхан, УБ хот, 2000он, т16

хаалгыг нээж өгсөн нь Монгол Улсад үл хөдлөх хөрөнгийн харилцаа олон улсын нийтлэг чиг хандлагын дагуу хөгжих эрх зүйн үндэс бүрдсэн юм.

Манай улсад үл хөдлөх хөрөнгийн тухай ойлголт ямар байсан түүхэн уламжлалыг товчхон авч үзвэл. Монголын эртний хууль цаазын дурсгалуудад үл хөдлөх хөрөнгийг эзэмших болон ашиглах эрхийг 1640 оны "Их цааз", "Халх журам" зэрэг хууль цаазын дурсгалд хуульчилж, түүнийг хуваарилах, өвлүүлэх харилцааг зохицуулж байсан нь үл хөдлөх хөрөнгийг хувь хүн өмчлөх ёсгүй гэсэн монголчуудын уламжит үзэл сэтгэлгээтэй холбоотой хэмээн судлаачид тэмдэглэсэн байдаг.⁵ Үл хөдлөх хөрөнгийг өмчлөхийн төлөө төдийлөн чармайдаггүй байсан нь нүүдлийн соёл иргэншилээс улбаатай гэх үндэслэл бий.

Харин 1924 оны Үндсэн хуульд хувийн өмчийн хэлбэрийг хуульчлан хамгаалаагүй орхисон үл хөдлөх хөрөнгийг хувийн өмчид шилжүүлэхийг хориглосон, түүнчлэн энэ хуулийн 13 дугаар зүйлд "Ван, гүн, тайж нарын хэргэм зэрэг, аливаа хутагт хувилгаадын захиран тушаах ба ардын хөрөнгөд холбогдох эрхийг устгавал зохино" гэж тус тус зааснаас болоод өмчлөх эрхийг үндсийг нь гажуудуулах эхлэл суурь тавигдсан.

1940 оны Үндсэн хуулийн 6 дугаар зүйлд: "Ард иргэдээс мал ба хөдөө аж ахуйн багаж зэвсэг хийгээд үйлдвэрлэлийн бусад багаж зэвсэг,

түүхий эд мөн боловсруулсан үйлдэхүүн, орон сууц, хашаа, барилга, гэр хогшил, орлого зэргийг өмчлөх эрх ба түүнчлэн хувийн өмчийн өвлөх эрхийг хуулиар хамгаална", 1960 оны Үндсэн хуулийн 13 дугаар зүйлд: "Иргэний хөдөлмөрлөж олсон орлого, хадгаламж, орон сууц, амины туслах аж ахуй, амины хэрэгцээт зүйлс, гэрийн эд хогшлыг, түүнчлэн амины өмчийг өвлөх эрхийг хуулиар хамгаална. Амины өмчийн эрхийг улс нийгмийн эрх ашигт харш ашиглаж үл болно" гэж заасан байна. Гэхдээ хувийн өмчийг өмчийн бие даасан хэлбэр гэдгийг эдгээр хуулиудын алинд нь ч заагаагүй, тухайлбал, 1940 оны Үндсэн хуулинд улсын өмч, хөдөө аж ахуйн нэгдлийн нийтийн өмч, 1960 оны Үндсэн хуулинд социалист өмч нь улсын, хоршооллын гэсэн хоёр хэлбэртэй гэж тусгасан байна.

Монгол Улс 1990-ээд оноос төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэнээр өмчийн олон хэлбэрт тулгуурласан эдийн засаг бүхий орон болсон билээ.

Улмаар 1990 онд шинэчлэн найруулсан БНМАУ-ын Иргэний хуулийн 59 дүгээр зүйлд "БНМАУ-д хувийн болон нийтийн өмч байна" гэж зааснаар социалист өмчийн талаархи уламжлалт сэтгэлгээ өөрчлөгдөж эхэлсэн юм. Улсын Бага хурал 1991 онд Өмч хувьчлах тухай хууль гаргаж, нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг зөвшөөрч, зах зээлийн эдийн засагт шилжихтэй холбогдсон бусад суурь хуулиудыг гаргаж мөрдүүлсэн нь иргэний эдийн засгийн эрхийг тал бүрээр хангах анхны

⁵ Монгол Улсын үл хөдлөх эд хөрөнгийн эрх зүйн зохицуулалт, А.Батсайхан, УБ хот, 2000он, т18

алхам болсон юм.⁶

Монгол Улсын шинэ Үндсэн хуулиар /1992 он/ “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна. Тер нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална” гэж заасан.

Мөн түүнчлэн Үндсэн хуулийн 6 дугаар зүйлд “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн, Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно. Энэ нь газрын хэвлийг өмчлөхөд хамаарахгүй. Иргэд хувийн өмчийнхөө газрыг худалдах, арилжих, бэлэглэх, барьцаалах зэргээр гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлөлд шилжүүлэх, түүнчлэн төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр бусдад эзэмшүүлэх, ашиглуулахыг хориглоно” хэмээн заасан нь Монгол Улсын иргэнд өмчлүүлсэн газрын өмчлөх эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэх эрх зүйн үндэс суурийг тавьж өгсөн юм.

Монгол Улсын Иргэний хуулийн 84.3-т “Газар, түүнээс салгамагц зориулалтын дагуу ашиглаж үл болох эд юмс үл хөдлөх хөрөнгөд хамаарна” гэж заасан бөгөөд харин үүнээс бусад эд хөрөнгө нь хөдлөх хөрөнгө байхаар хуульчилсан байна.

Монгол Улсын эдийн засгийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд эд хөрөнгө барьцаалан зээл олгох асуудлыг нарийвчлан зохицуулах, зах зээл өндөр хөгжсөн орнуудын жишгээр эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийг улсын бүртгэлд бүртгэн баталгаажуулах шаардлага зүй ёсоор тавигдсан юм.

Түүнчлэн 2009 онд Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль батлагдсан нь эрхийн улсын бүртгэлд бүртгэж баталгаажсан иргэдийн эд хөрөнгийн өмчлөх эрхийг эдийн засгийн эргэлтэд оруулах үйл явцыг боловсронгуй болгох, барьцаалагч, барьцаалуулагчийн эрх, үүргийг нарийвчлан зааж өгөв. Үүнд:

Орон сууцны зээлийн тогтолцоо

Иргэдээ орон сууцжуулах нь олон улс орнуудын хувьд тулгамдаж буй нийгмийн голлох асуудлуудын нэг тул орон сууцны зээлийн зохистой тогтолцоог үүсгэж, хөгжүүлэх нь улс орнуудын эрх баригчдын анхаарлын төвд байсаар ирсэн.

Санхүүгийн салбарын хөгжилтэй уялдан орон сууцны санхүүжилтийг албан бус зээлдүүлэгчээс институцианал хөрөнгө оруулагч гүйцэтгэх хүртэл өргөжин хөгжсөн бөгөөд түүхэн хугацаанд дараах хэд хэдэн төрлийн тогтолцоот замыг туулжээ. Олон улсын жишгээс үзвэл орон сууцны зээлийн санхүүжилтийн тогтолцоо нь:

1. Хадгаламжид суурилсан тогтолцоо
2. Гэрээт хадгаламжийн тогтолцоо
3. Орон сууцны банкны тогтолцоо

⁶ Үл хөдлөх эд хөрөнгийн харилцаа, Гантулга.Г., УБ хот, 2006 он, т18

4. Хуримтлалын сан

1. Хадгаламжид суурилсан тогтолцоо

Орон сууцны зээлийн хамгийн анхны санхүүжилтийн хэлбэр нь хадгаламжид суурилсан тогтолцоо бөгөөд уг тогтолцоонд тусгай сан болон арилжааны банкууд иргэдээс хадгаламж татах замаар зээл олгодог. Тус тогтолцоо нь Англи улсад анх үүсэж, бусад англи хэлтэй улсуудад дамжин хэрэгжсэн.

2. Гэрээт хадгаламжийн тогтолцоо

Хадгаламжид суурилсан тогтолцооны нэг дэвшилтэт хэлбэр бол гэрээт хадгаламжийн тогтолцоо юм. Уг тогтолцоонд зээлдэгч банкинд тодорхой хугацаанд хадгаламж байршуулснаар тухайн банкнаасаа зээл авах боломжоор хангагддаг. Нээлтэй ба хаалттай гэсэн хоёр төрөлтэй бөгөөд нээлтэй системд зээлдүүлэгч ирээдүйн хадгаламжийн эх үүсвэрээс зээл олгох, харин хаалттай системд одоо байгаа хадгаламжид тохируулан зээл олгодог.

3. Орон сууцны банкны тогтолцоо

Банк нь өөрийн эх үүсвэр дээр үндэслэн зээл олгож, зээлээ барьцаалан үнэт цаас гаргах замаар нэмэлт эх үүсвэр татдаг. Анх 1700-аад онд Герман болон Скандинавын орнуудад үүссэн бөгөөд дийлэнхдээ үнэт цаасанд урт хугацааны тэтгэврийн сан, даатгалын байгууллагууд хөрөнгө оруулдаг. Хөгжиж буй орнуудад орон сууцны зээлийн банк нь илүү нээлтэй болсон давуу талтай боловч эх үүсвэр, үйлчилгээний төрөл хязгаарлагдмал зэргээс шалтгаалан дампуурах хандлагатай байдаг байна.

4. Хуримтлалын сан

Орон сууцны зээлийн тогтвортой тогтолцооны нэг хэлбэр бол орон сууцны зээлийн хуримтлалын сан юм. Хуримтлалын санг хөдөлмөр эрхлэгчдийн цалин, тэтгэврээс орон сууцны хэрэгцээг хангах зорилгоор дийлэнхдээ төрөөс албадан зохион байгуулдаг. Хуримтлалын сан нь ажилчдын хуулиар тогтоосон цалингийн тодорхой хувийг тусгай санд байршуулж, сангийн хөрөнгийг бүрдүүлэх; тухайн хуримтлалыг удирдах үүрэг гүйцэтгэдэг. Хөрөнгийн санг дийлэнхдээ тухайн орны Засгийн газар, Төв банк, ипотекийн корпораци зэрэг субъектууд байгуулдаг туршлагатай байна.

Ипотекийн зээлээр иргэдээ орон сууцжуулсан улс орнууд

Ипотекийн зээлээр иргэдээ орон сууцжуулсан улс орнууд маш их байдаг. Зээлийн эргэн төлөгдөх хугацааны хувьд ихэвчлэн 20-40 жил байдаг бөгөөд Европын төв банкны 2020 оны мэдээллээр Европ тивд 20 болон 30 жилийн хугацаатай ипотекийн зээл зонхилж байна гэсэн тоо баримт гаргасан байна. Гэхдээ хэд хэдэн улсад 50 жил хүртэлх хугацаатай ипотека байдаг бөгөөд үүнд Испани, Франц улсуудыг нэрлэж болно. Харин Финлянд улсын ипотекийн зээлийн хугацаа 60 жил хүртэл байдаг бол Япон, Швейцарь улсуудад 100 жилийн хугацаатай ипотекийн зээл байдаг.⁷

⁷ International Comparison of Mortgage Product offerings, Dr Michael Lee, pg25

Америкийн нэгдсэн улс

АНУ-ын ипотекийн салбар нь эдийн засгийн томоохон салбарын нэг юм. Холбооны засгийн газар нь хэд хэдэн хөтөлбөр хэрэгжүүлж моргейжийн зээл, барилга байгууламжийг дэмжих, үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөхийг хөхиүлэн дэмжихэд чиглэсэн. Эдгээр хөтөлбөрүүдийн үндсэн дээр Засгийн газрын үндэсний ипотекийн холбоо, Холбооны үндэсний ипотекийн холбоо, ипотекийн корпорациуд бий болсон.

АНУ-ын ипотекийн салбар өнгөрсөн зууны туршид эдийн засгийн томоохон хямралын төв болсон. Үл хөдлөх хөрөнгийн зээлийн практикууд нь 1930-аад оны Үндэсний ипотекийн хямрал, 1980-аад оны 1990-ээд оны хадгаламж, зээлийн хямрал, 2007 оны дэд бүтцийн үл хөдлөх хөрөнгийн хямралаас үүдэн 2010 оны хямралыг үүсгэсэн.

Ипотекийн салбарын үйл ажиллагаа АНУ-д бусад орнуудыг бодвол арай өөрөөр ажилладаг. Ипотекийн зээл нь үнэт цаас гэж тооцогддог бөгөөд зээлдүүлэгчид чөлөөтэй шилжүүлж болно гэсэн үг юм. Энэ нь санхүүгийн байгууллагууд ипотекийн зээлийг иргэдэд хөрөнгө оруулалт маягаар өгдөг. АНУ-д энэ системийг хөнгөвчлөхийн тулд Засгийн газрын үндэсний ипотекийн холбоо, Холбооны үндэсний ипотекийн холбоо зэрэг засгийн газрын дэмжлэгтэй компаниуд байдаг. Ихэнх ипотек нь тогтмол хүүтэй байлгах үндсэн чиг үүрэгтэйгээр ажилладаг.

Япон

Японд 1950 онд орон сууцны чанарыг сайжруулах, иргэдийг орон сууцжуулах зорилгоор тогтмол хүүтэй ипотекийг японы засгийн газар зах зээлд анх нэвтрүүлсэн. 1950-2017 он хүртэл 19,4 сая орон сууцыг санхүүжүүлсэн байна.

2011 онд болсон газар хөдлөлтийн улмаас Япон үндэстэнд маш том гарз тохиосны нэг нь орон сууцны зах зээл дэх алдагдал юм. Нийт ипотекийн зээлд хамрагдсан орон сууцнаас 129,520 орон сууц засах боломжтойгоор эвдэрсэн бол 256,420 тооны орон сууцыг дахин барих шаардлагатай болсон. Энэхүү гамшигийн улмаас 2 төрлийн ипотекийг Япон улсын засгийн газар бий болгосон. Эхнийх нь, анхлан ипотекийн зээл авч буй иргэдэд зориулсан, харин хоёр дах нь өмнө нь ипотекийн зээл авч байсан бөгөөд орон сууц нь байгалийн гамшигаас болж сүйрсэн иргэдэд зориулсан ипотекийн зээл юм

Солонгос

Тус улсын нийслэл болох Сөүлд 10 сая хүн амтай, Сөүлийн ойрын хотууд 15 сая хүн амтай бөгөөд орон сууцны асуудал мөн л засгийн газрын анхаарал тавьдаг асуудлуудын нэг юм.

Солонгосын засгийн газар Солонгосын Орон Сууцны Корпорацийг байгуулж байсан бөгөөд ипотекийн зах зээлийг энэхүү корпораци зохицуулдаг байсан бол 2004 онд Солонгосын Ипотекийн Корпораци болгон өөрчилсөн.

Солонгосын ипотекийн зах зээл тохируулагч хүүтэй байх нь элбэг бөгөөд

жилийн хүү нь 3,1 хувь байдаг.⁸

Монгол улс

Манай улсын хувьд хүн амын дийлэнх нь улсын нийслэл буюу Улаанбаатар хотод төвлөрсөн. Дэд бүтэц муутай бөгөөд гол асуудлын нэг бол орон сууц гэж зүй ёсоор тооцогддог.

2006 оны 10 дугаар сард Монгол банк болон арилжааны 10 банк хамтран Монголын Ипотекийн Корпорацийг байгуулсан аж.

Дэлхий нийтэд тархсан цар тахлын үед улсын эдийн засаг маш хүнд байдалд орсон. Олон удаагийн, урт хугацааны хорио цээрийн дэглэм нь эдийн засгийн эргэлтийг удаашруулж, нийгмийн хэвийн амьдралын балансийг алдагдуулж байна. Урт хугацааны хорио цээрийн дэглэм нь бизнесийн байгууллага, банк санхүү, жижиг дунд үйлдвэр эрхлэгч, хувиараа бизнес эрхлэгч гээд бүхий л салбарт сөрөг нөлөө үзүүлсэн бөгөөд үүнээс гадна банкны зээлдэгч нарт хүнд асуудал тулгарч байна. Юуны өмнө зээлдэгчдийн хувьд зээлийн эргэн төлөлтийн асуудал эмзэг хэвээр байна. Манай улсын нийт 63.553 өрх нь зээлэнд хамрагдсан байдаг бөгөөд үүнээс Улаанбаатар хотод 48.659, орон нутагт 14.894 өрх байдаг юм. Үүнээс, орон сууцны буюу ипотекийн шинээр олгогдсон зээлтэй иргэд нь 88.3%, дахин санхүүжигдсэн орон сууцны зээл нь 11.7%-тай байдаг байна. Энэхүү эдийн засгийн ноцтой асуудлыг Засгийн газар, Монгол банкнаас оновчтой ухаалгаар шийдвэрлэх ёстой. 2020 оны 04 дүгээр

сарын 03-ны өдөр Монгол банкнаас ипотекийн 5% болон 8%-ийн зээлтэй иргэдийн зээлийн эргэн төлөлтийг 3 сараар хойшлуулсан, уг хугацааг дахин 3 сараар хойшлуулан 6 сар болгохоос өөр аргагүйд хүрсэн. Удалгүй энэхүү зээлийн хугацааг 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хойшлуулах шийдвэр гаргасан юм.

Арилжааны банкнуудын ипотекийн зээлийг Монголбанкнаас санхүүжүүлдэг учир ипотекийн зээлийн талаар авч буй Засгийн газар болон Монголбанкны бодлого, шийдвэр нь алдагдал аль болох бага, Монголын эдийн засгийн нөхцөл байдалд тохирсон, иргэдэд хүндрэл бага учруулах оновчтой ухаалаг, зүй ёсны шийдвэр байх ёстой юм.

⁸ Aisan mortgage markets working paper, 2017, Masahiro Kobayashi, pg 26

МАНСУУРУУЛАХ БОЛОН СЭТГЭЦЭД НӨЛӨӨЛӨХ БОДИСЫН ХҮНИЙ БИЕД ҮЙЛЧЛЭХ ХОР ХӨНӨӨЛ

Л.БАЯНБОЛД

(Шихихутуг их сургуулийн магистрант)

Бодгаль хүн эхээс мэндлэхдээ өөрт шаардлагатай бүхий л бодисуудаар бүрэн хангагдах хувь тавилантай төржээ. Байгалиас заяасан түүн дээр өөр ямар нэгэн бодисыг нэмэх, хэт их тунгаар хэрэглэх нь бие организмийн тэнцвэрийг алдагдуулж ноцтой гэмтэлд хүргэх нигууртай. Байгалийн нэгэн адилаар хүний бие тодорхой нэгэн тэнцвэр дээр суурилан тогтнодог тэрхүү тэнцвэрийг зориуд алдагдуулах, түүгээр наргиан хийвэл хожим нөхөж баршгүй том гарз хохирлын уутыг нээнэ гэсэн үг. Тухайлбал мансууруулах бодисыг хэтрүүлэн хэрэглэвэл хэн боловч догшин араатан болон хувирах нь энүүхэнд. Хүн амьдралдаа ямар нэг таашаал авахын тулд тодорхой нэг зүйлийг зорин бүтээж, түүний төлөө хичээл зүтгэл гаргаж амжилтанд хүрдэг бол мансууруулах бодис нь энэ үйл явцыг гажуудуулж, ямар ч зүйл хийлгүйгээр таашаалын дээдийг авч буй мэт төөрөгдөлд оруулдаг. Мансууруулах бодис гэдгийг монгол хэл зүйн толь бичигт Намуу цэцгийн төрөл зүйлд багтах урт, том навчтай, шар буюу улаан өнгийн цэцэгтэй ургамал түүний бүрэн гүйцэт боловсроогүй байхад үйлчилж болохуйцаар огтолж, сүү мэт шүүсийг нь авч хатаасныг ойлгоно гэж тэмдэглэжээ¹.

Дэлхий дээр мансууруулах бодисыг “Наркотик” гэж нэрлэх бөгөөд хөшөөх, мэдээ алдуулах, нойрсуулах, мэгдэх гэсэн Грек үгнээс гаралтай мансуурахад хүргэдэг ургамлын болон синтетик эх үүсвэр бүхий төрөл бүрийн бодисын бүлэг агууламжтай. Тухайн бодис нь хэрэглэсэн хүний уураг тархинд давамгайл нөлөө үзүүлж төв мэдрэлийн системийн үйл ажиллагааг цочроож сэтгэцийг дарамтлан өвчтэй болгодог, булчин сулруулах гэх мэт гаж үйлчлэл үзүүлэх агууламжийг өөртөө шингээсэн эмчийн хяналтгүйгээр хэрэглээд байвал эмгэг хэрэгцээг бүрдүүлж хүний бие сэтгэцийг эрхшээлдээ оруулах чөтгөрийн увидасыг өөртөө агуулдаг. Шинжлэх ухаан, технологийн эрэн зуунд тухайн ургамлаас нь боловсруулж химийн аргаар бүрэн нийлэгжүүлж, урьд өмнө нь огт мэдэгдээгүй, хүчтэй мансууруулах үйлчилгээтэй бодисуудыг цоо шинээр гарган авах гаж үйлдэл ихсэв. Хэрэглээд байвал дасал үүсгэдэг энэ мэт бодисуудыг гарал үүсэл, хүний биед үзүүлэх нөлөөллөөр нь хор аюулыг нь тогтоон үнэлж НҮБ-ын Мансууруулах эмийн тухай 1961 оны нэгдсэн конвенци, Сэтгэцэд нөлөөт бодисын тухай 1971 оны конвенциудад тодорхой тусгажээ.

Харамсалтай нь: Сүүлийн жилүүдэд нутаг нэгтний өдүүлж буй мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль

¹ Я.Цэвэл “Монгол хэл зүйн тайлбар толь” УБ., 52-р хуудас

бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг нь ашиг олох зорилготой үндэстэн дамнасан, зохион байгуулалтын шинжтэй болон хувирсаар тухайн гэмт үйлдлийн эрүүгийн нөхцөл байдал хүндэрч байгаа төдийгүй гэмт хэргийн гаралт, түүнд холбогдон шалгагдах хүмүүсийн тоо нэмэгдэж байна. БНХАУ-аас боловсруулсан гашишыг Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн гэмт хэрэг нэлээдгүй бүртгэгдэж байсан бол сүүлийн жилүүдэд Метафетамин буюу мөс гэх нэршилтэй бодис, хүчтэй үйлчилгээтэй героин, кокайн, экстаси зэрэг лабораторын аргаар боловсруулсан мансууруулах бодисыг хил давуулан оруулж ирэх тохиолдол ч нэмэгдэв.

Залуучуудад зориулан мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэдэг, бэлтгэдэг, борлуулдаг, тээвэрлэдэг этгээдүүд тэдний дунд цөөнгүй байгаа нь тодорхой болсон. Манай улсад мансууруулах төрлийн ургамал нэлээд тархацтай ургадаг аймаг орон нутгууд бий. Энэхүү нөхцөл байдал нь хүүхэд залуучуудыг мансууруулах бодисын төрлийн ургамлыг хууль бусаар түүж бэлтгэн хэрэглэх боломжийг бүрдүүлж идэвхтэй хэрэглэгчидийн эгнээ өргөжих хандлагатай байна. Монгол Улсад түр болон удаан хугацаагаар оршин сууж байгаа гадаадын зарим иргэд мансууруулах бодисыг хэрэглэх, түүнийг худалдаж авах борлуулах ажилд идэвхийлдэг, түүгээр ч үл барам манай иргэдийг элдэв хэлбэрээр татан оролцуулах хандлага ажиглагдаж байна.

Мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдож байгаа хүмүүсийг дараах гурван төрөлд хуваан авч үзэж болох юм:

Тус улсад ургаж байгаа каннабисын төрлийн ургамлыг түүж хэрэглэх хандлага ихээр ажиглагдаж байгаа бөгөөд ийм бүлэг хүмүүсийн эгнээнд өсвөр насныхан, амьд хөгжим тоглодог, сонирхдог залуучууд хамаарна.

Хөрш зэргэлдээ орших Хятад, ОХУ улсаас манай улсын иргэд каннабис, метафетамин зэрэг мансууруулах бодис авчирч хэрэглэх явдал гарч байна. Тухайн гэмт хэрэгт холбогдогч этгээдийн ихэнх нь боломжийн амьдралтай, хөрөнгө чинээтэй айлын хүүхдүүд мөн гадаадад сурч ажиллаж байгаа хүмүүс байна.

Амьдралын орлого багатай өрх толгойлсон эмэгтэйчүүд болон амар хялбар аргаар мөнгө олох гэсэн залуучууд бусдын санал болгосноор Зүүн Өмнөд Азийн орнуудад мансууруулах бодисыг биедээ залгиж тээвэрлэх үүрэг гүйцэтгэх болов.

Мансууруулах бодисыг нийгмийн шинжлэх ухааны үүднээс эм, бэлдмэл, бодисыг хэрэглэсэн этгээд зан үйлийн болон ёс суртахууны зөрчил рүү түлхэн гэмт хэрэг үйлдэх нөхцөл бололцоог бий болгож улмаар нийгэмд хор хохирлыг учруулах чадвар бүхий бодис түүнийг агуулсан эм бэлдмэлийг хэлнэ гэж үздэг.

Мансууруулах бодисыг химийн аргаар үйлдвэрлэн гаргасан, байгальд бэлнээр оршдог хэмээн ангилж болох бөгөөд байгалийн гэдэгт анх түүж авсан

ургамалыг, нийлэг гэж хожим химийн аргаар гаргаж авсан бодисыг нэрлэдэг ажээ.

Мансууруулах бодис олон төрөлтэй, хэрэглэх арга ч олон янз байдаг. Мансууруулах бодисыг хууль бусаар хэрэглэх үндсэн хэлбэрүүдийг авч үзвээс:

Олон зуун жилийн өмнөөс опиумыг гаансанд хийж шатааж амаараа утааг нь сордог байсан. Татаж хэрэглэх үед мансууруулах бодис биед орж үйлчлэх хугацаа 7-10 секунд. Мансууруулах бодисыг цаас, хутган дээр тавьж хамрын нэг нүхээ тагалж, нөгөөгөөр нь татаж хэрэглэдэг. Зарим төрлийн мансууруулах бодисыг цаасан мөнгөн дэвсгэрт дотор ороодог, энэ нь авч явахад хялбар, мөн нуун далдлах боломжтой бөгөөд хэрэв татахыг хүссэн үедээ ороосон мансууруулах бодисоо гаргаж ирээд нэг хамраараа сорно. Каннабисийг голдуу гаансанд хийж татаж хэрэглэдэг бол экстасийг зальгиж, кокаинийг уушгилахын зэрэгцээ шатааж утааг нь сорж, героиныг дүнсэн тамхитай хольж хэрэглэж байна. Түүнчлэн арьсан доор, булчинд, судсаар тарих аргуудыг ашигладаг байна. Энэ аргуудаас судсаар тарих нь илүү түгээмэл тооцогддог. Мансууруулах бодисыг судсанд тарьсанаар тархинд 15-30 секундэд үйлчлэл үзүүлнэ. Героин, кокаин, мөс зэргийг судсаар тарьдаг. Чингэхдээ бугалганы дотор талын судсаар ихэвчлэн тарьдаг аж. Мэдрэгдэхгүйн тулд гүрээ, хөл, гуяаны судсаар тарих нь олонтой. Мөн эмэгтэйчүүд хөхны доохон хэсэгт болон хэлний дор, эрэгтэйчүүд шодойн арын судсанд тарьж хэрэглэдэг. Судсаар тарих нь цусанд шууд орж

хамгийн хурдан үйлчлэл үзүүлдэг байна. Мансууруулах бодис хэрэглэх арга нь тухайн газар нутгийн мансууруулах бодисын хэрэглээний нөхцөл, гаж нөлөөллийн чиг хандлагыг илэрхийлж байдаг гол үзүүлэлт юм. Мансууруулах бодисын хэрэглээ ноцтой болсон нутагт, ялангуяа героин дэлгэрсэн газар тарих аргыг ихэнхдээ хэрэглэдэг, харин үүсч хөгжиж, тархаж байгаа газар утааг татаж хэрэглэх нь түгээмэл байдаг. Донтогчид илүү хурдан, хүчтэй үйлчилгээ хүсэх бүр эдийн засгийн байдал ч хүндэрч хэрэглэх арга тарилга хийх рүү шилждэг байна.

Мансууруулах бодисыг хэрэглэсэн хүнд илрэх шинж тэмдэг, хор уршиг нь дэлхий даяар хэдэн зуун жилийн туршид мансууруулах бодисын хор хөнөөлийн эсрэг тэмцсээр ирсэн боловч төдийлөн амжилтанд хүрэхгүй байгаа нь хүн төрөлхтөн өдий хүртэл үүний гарцыг нь олохгүй байна гэсэн үг. Мансууруулах бодис нь бие эрүүл мэнд болон нийгэм эдийн засгийн асар их хор хохирол учруулдаг бөгөөд хэрэглэсэн этгээд нь зөвхөн өөрөө төдийгүй ар гэр, ард нийтэд айдас түгшүүр төрүүлж, амь насандаа халтай эрсдэлийн дунд амьдардаг гол утга учир нь оршино.

Мансууруулах бодисыг хэрэглэснээр бие эрүүл мэндэд учрах хор хохирол:

- Уураг тархинд нөлөөлж, тархины хэвийн үйл ажиллагаа алдагдагдуулж эрүүл биш болно.
- Хүнд хордлогод орж, дотор муухайрах бөөлжих нь хэвийн үзэгдэл болно.

- Хамрын салст үрэвсэх, хоолой ам хатах, байнгын эрүү зуурсан байдалтай явах нь эргээд төв мэдрэлийн системийг гэмтээнэ.
- Сэтгэцэд нөлөөлөн зан үйл өөрчлөгдөж, оюуны доройтолд орж байнгын айдас түгшүүрийн байдалд автана.
- Арьс хөхөрч хумс унана, Шүргүүлсэн газар өвчилж цус хөхөрнө.
- Үргүйдэл үүсч үр удмаа үлдээх боломж алдагдана. Жирэмсэн болсон ч бие эрхтний согогтой гаж хүүхэд төрөх магадлал эрс нэмэгдэнэ.
- Нүдний болор цайж хараа муудахаас гадна хөгшрөлт эрт явагдаж гоо сайхнаа алдана.
- Дархлаа суларч биеийн эсэргүүцэл муудсанаар амьсгалын замын өвчин, хорт хавдарт илүү хурдан нэрвэгдэнэ.
- Тунг хэтрүүлбэл жам ёсны бус зуурдын үхэлд ч шууд хүргэнэ

Мансууруулах зүйл хэрэглэснээр үүсэх ерөнхий шинжүүд:

- Оюун ухаанд гарах өөрчлөлтийг хөнгөн ба гүн илрэх гэж хоёр ангилж болно. Оюун ухаанд хөнгөн өөрчлөлт гарах тохиолдолд мансуурагч нь дуугаа хураах, шалтгаангүй инээх, ганцаараа ярих, эргэн тойрны хүмүүст анхаарлаа хандуулахгүй байх зэрэг зантай болно.
- Оюун ухаанд гүнзгий өөрчлөлт гарсан тохиолдолд мансуурагч нь хөдөлгөөн багатай хөл гар хөшүүн

болно. Мансуурмагц хөгжилтэй цовоо, хэл ам, хөдөлгөөн хурц болж сэтгэл санааны хөөрөлд автана.

- Бие махбодод гарах өөрчлөлт гарах тохиолдолд мансуурагчид нүдний гал унтарч гөлгөр болох, хүүхэн хараа нарийсах эсхүл өргөсөх, арьс хуурайших, шүлс ихээр ялгарч, хүзүү толгой усан хулгана болтлоо хөлрөнө.

Мансууруулах бодист гүнзгий хордох шинж нь:

- Хордолтын эхэнд сэтгэл хөдлөлгүй байсанаа түргэн хугацаанд зовиуртай болж 15-20 минутын дараа зогсох, бөөлжих шинж тэмдгүүд илэрнэ.
- Дараагийн 10-20 минутад хэрэглэгч алхаж явах чадвараа хадгалсан мэт авч ухаан санаагаа алдах, хөдөлгөөн болон сэтгэл санааны сааталд орох, бие сулрах, нойрмоглох эцэст нь алхах, гишгэх чадвараа алдаж комд орох нь энүүхэнд.
- Мансууруулах бодис хэрэглэж гүнзгий хордох үйл явц нь харилцан адилгүй хугацаанд явагдана. Комын өмнөх үе шат нь 1-18 цаг хүртэл хугацаанд үргэлжилнэ. Ком нь 1-5 хоног хүртэл хугацаагаар, комын дараах үе шат нь 12 цагаас 3 хоног хүртэл үргэлжилнэ.
- Байнгын хэрэглэгчид: Дээр дурдсан гурван бүлгийн хүмүүсээс бүрдэнэ. Сэтгэхүйн хувьд мансууруулах бодисоос хамааралтай агаад зуршил тогтсон учир байнгын хэрэглэгч болдог

Мансууруулах бодист донтогчид: Энэ бүлгийн хүмүүс нь бие болоод сэтгэцийн хувьд мансуурлаас хамааралтай болсон байдаг. Тийм этгээдүүд мансууруулах бодис хэрэглэхээс нааш бие махбод, сэтгэл санааны хувьд тайвширдаггүй хүмүүс орно.

Мансууруулах бодис хэрэглэгчийн бие махбодод илрэх ерөнхий шинж:

- Наснаасаа илүү хөгшин харагдах, эрт бууралтаж сул дорой, царай зүс нь цонхийж, арьс нь хуурайшиж үрчлээтэй болно.
- Удаан хугацааны хэрэглээнээс амархан ядарч арьс шаргалтаж эцэж турна.
- Хэл ягаарч, цагаан өнгөр тогтож, биеийн жингээ огцом алдаж түрж эцнэ.
- Нүүрний арьсан дээр идээт бижрүүнүүд гарах, дуу хоолой сөөнгө болно.
- Каннабис хэрэглэгчдийн сэтгэхүйн чадвар нь ердийн хүмүүсээс байнга доогуур үнэлгээтэй гардаг.
- Шарх сорвины эдгэрэлт удаашрана.
- Судасны хана хатуурч, цусны бөөмд бижрүү үүсч, унтах шаардлагагүй болно.

- Мансууруулах бодисыг их хэмжээгээр хэтрүүлэн хэрэглэсэн тохиолдолд дотор муухайрах, толгой эргэх, ухаан санаа самуурах, ухаан санаагаа бүрэн алдах, чичрэх, амьсгаадах, амьсгал тасалдсаны улмаас үхэлд хүрэх аюултай.

Мансууруулах бодисын хор хөнөөл нь архины шарталтаас 60 дахин илүү хараат байдал үүсгэж хүний биеийн эрхтнийг гэмтээдэг бөгөөд энэ төрлийн эмчилгээ авахаар эмнэлэгт хандаж байгаа хүмүүсийн тоо сүүлийн хоёр жилийн дотор 30-40 хувиар өссөн дүн мэдээ бий. Мансууруулах бодис бүх эрхтэнд үхжил үүсгэж, оюун чадамжийг алдагдуулснаар ёс суртахуунтай байх, нийгмийн дэг журам, зөв хүн болж төлөвших, зөв хандлагатай болох чадвар алдагдахаас гадна ялангуяа дотор эрхтэнд үхжлүүд үүсгэдэг учраас эмчилгээ авахдаа тун муу атлаа мансууруулах бодис хэдхэн хоромд нөлөөлнө. Харин мансууруулах бодисын нөлөөлөл зогсоход хэрэглэгч бөөлжих, татах, чичрэх шинж илэрдэг. Энэ нь уг хүн мансууруулах бодисын хараанд орсон гэж үздэг.

Мансууруулах бодис нь тайвшруулах, сэргээх, солиоруулах гэсэн нөлөө үзүүлдэг ч ямагт хортой үр дагавар дагуулна.

ТӨРИЙН НУУЦЫГ ЗАДРУУЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ХЭМ ХЭМЖЭЭНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Б.НОМИН-ОРГИЛ

(Шихихутуг их сургуулийн магистрант)

Монгол Улсын төрийн нууцтай холбоотой харилцааг Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, хууль болон хууль тогтоомжийн бусад актаар зохицуулдаг. Сүүлийн жилүүдэд төрийн болон албаны нууцыг хамгаалах эрх зүйн орчинг илүү боловсронгуй болгох зорилгоор Монгол Улсын Их Хурлын 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар Төрийн болон албаны нууцын тухай хуулийг шинэчлэн баталж, хийдэл бүхий нийгмийн харилцааг эрх зүйн зохицуулалтанд хамруулав. Түүнчлэн тус хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газар “Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам” зэрэг холбогдох 5 журмыг шинээр баталсан. Үүнээс гадна төрийн нууцыг хамгаалахад чухал үүрэгтэй Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга)¹-ийг Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр баталснаас хойш багагүй хугацаанд үйлчилж байна.

Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн шинжтэй бол гэм буруутай этгээд Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээх ёстой. Ингэснээр төрийн нууц илүү баталгаатай хамгаалагдах нөхцөл,

боломж бүрдэж байгаа юм.

Шинэчлэн найруулсан Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн “Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг” хэмээх 19 дүгээр бүлэгт төрийн нууцтай холбоотой 4 төрлийн гэмт хэргийн бүрэлдэхүүн, хүлээлгэх хариуцлагыг заасан. Үүнд:

- Эх орноосоо урвах /19.1/
- Гадаадын тагнуулын алба, байгууллага, иргэнтэй хууль бусаар хамтран ажиллах /19.4/
- Тагнуул хийх /19.10/
- Төрийн нууцыг хууль бусаар олж авах /19.11/²
- Төрийн нууцыг задруулах /19.12/
- Төрийн нууцыг үрэгдүүлэх /19.13/ зэрэг болно.

Манай улсын эрүүгийн хууль тогтоомжийн хөгжлийн түүхэнд 1933 оны Шүүх цаазын бичигт “Улсын нууц болох мэдээ, баримтыг гадаад улс ба хувьсгалын эсрэг байгууллагад шилжүүлэх, тагнуул хийх” хэмээн анх тусгалаа олсноор төрийн нууцыг задруулах үйлдэл нь ихэвчлэн эх орноосоо урвах, тагнуул хийх гэмт хэргийн объектив талын шинжид хамаарч ирсэн бөгөөд эдгээр гэмт

¹ Монгол Улсын Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга). 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр. <http://legalinfo.mn>

² Шинээр бие даасан гэмт хэрэг болгон тусгасан.

хэргийн шинжгүйгээр төрийн нууцыг задруулсан, үрэгдүүлсэн үйлдлийг гэмт хэрэгт тооцдоггүй байв.

Харин 1961 оны БНМАУ-ын Эрүүгийн хуульд “Эх орноосоо урвах” гэмт хэргээс тусад нь “Улсын нууц задруулах” гэмт хэргийн бүрэлдэхүүнийг анх удаа тусгаж өгсөн. Тус хуулийн “Төрийн эсрэг бусад гэмт хэрэг” гэсэн бүлгийн 54 дүгээр зүйлд “Улсын нууц мэдээ, материалыг итгэмжлэгдэн хариуцаж байгаа хүмүүс буюу албан тушаал, ажил төрлийн хувиар мэдэж байгаа хүмүүсээс задруулсан явдал нь эх орноосоо урвасан буюу тагнуулын шинж байдалгүй бол дөрвөн жил хүртэлх хугацаагаар хорих, ноцтой хор хохирол учруулсан бол гурваас найман жил хүртэлх хугацаагаар хорьж шийтгэнэ” гэж заасан нь одоогийн Эрүүгийн хуульд тусгагдсан төрийн нууцыг задруулах гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив, субъектив шинжтэй төсөөтэй байгааг харуулж байна. Ийнхүү эх орноосоо урвах, тагнуул хийх гэмт хэргийн шинжгүй төрийн нууцыг задруулах үйлдлийг салгаж тусгай зүйл, заалт болгон хуульчилсан нь манай эрүүгийн эрх зүйн хөгжилд шинэлэг зүйл болсон гэх бүрэн үндэслэлтэй.

2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 19.12 дугаар зүйлд “төрийн маш нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйлийг итгэмжлэгдэн хариуцсан, албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд задруулсан нь эх орноосоо урвах, гадаадын тагнуулын алба, байгууллага, иргэнтэй хууль бусаар хамтран ажиллах гэмт хэргийн шинжгүй бол...” **төрийн нууцыг задруулах** гэмт

хэрэгт тооцохоор заажээ.

Эндээс “төрийн маш нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйл” гэдэгт юуг авч үзэх, “итгэмжлэгдэн хариуцсан, албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд” гэдэгт хэнийг хамааруулах, “задруулсан” гэдгийг хэрхэн ойлгох вэ гэдэг асуудал үүсдэг бөгөөд эдгээр нь Эрүүгийн хуульд заасан бусад ижил төсөөтэй гэмт хэргийн шинжээс тухайн гэмт хэргээс хэрхэн ялгах вэ гэдэг зүй ёсны хариулт шаардсан асуулт тавигдаж таарна.

Юуны урьд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 19.12 дугаар зүйлд заасан гэмт хэргийн объект нь төрийн нууцыг хамгаалахтай холбоо бүхий харилцаа учраас тухайн зүйл заалтыг төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан тулгуур ойлголтуудтай хэрхэн уялдуулах вэ гэдгийг тухайлан авч үзэх шаардлага тулгарч байна.

Төрийн болон албаны нууцын тухай Монгол Улсын хуулийн 5.1.1 дүгээр зүйлд “Төрийн нууц гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан, задруулах үрэгдүүлэх тохиолдолд үндэсний аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхолд аюул, занал, хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг хэлнэ”³ гэж тодорхойлж, түүнд Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13.1-д заасан төрийн нууцад хамааруулсан мэдээлэл хамаарахаар заасан билээ. Үүнээс гадна Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн баталсан 247

³ Монгол Улсын Дээд шүүх. “Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар” УБ., 2010 он, 243 дахь тал.

дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-ыг тухайн зүйлийн ишлэлт диспозицид хамаарагдах учиртай. Гэхдээ эдгээр хууль тогтоомжид төрийн нууцад хамаарах “мэдээ”, “баримт бичиг”, “эд зүйл” гэдэгт юуг ойлгох, хоорондоо хэрхэн ялгагдах талаар тодорхой тусгагдаагүй байна. Мөн бусад холбогдох хууль тогтоомжид эдгээр ойлголтыг нэг мөр болгож чадаагүй, Улсын дээд шүүхийн тухайлсан тайлбарч байхгүй байна.

Нэрлэсэн шинэ хууль эрх зүйн холбогдох баримт бичгүүд үйлчилж эхлэхээс өмнө Улсын Дээд шүүхээс гаргасан “Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар”-г:

“Мэдээ—бичгийн хэлбэр бүхий төрийн нууцыг агуулсан мэдээлэл.

Баримт бичиг—хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээлэл бүхий баримт сэлтийг хамааруулан ойлгоно. Жишээ нь, албан ёсны тамга тэмдэг бүхий баримт бичиг, гэрээ, төсөл, төлөвлөгөө, фото зураг гэх мэт.

Эд зүйл—хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээлэл агуулсан зэвсэг, техник, биет зүйл юм.”⁴ гэж тайлбарласан байна.

Эндээс мэдээ, баримт бичгийн аль аль нь бичгийн хэлбэртэй хэмээсэн бөгөөд баримт бичиг, эд зүйл хоёрын ялгаа ч төдийлөн харагдахгүй байна.

Монгол хэлний тайлбар тольд “мэдээ — сонсгон мэдэгдэх үг сураг” гэж тайлбарласан байгаа нь бичгийн

⁴ Монгол Улсын Дээд шүүх. “Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар”. УБ., 2010 он, 245 дахь тал.

хэлбэртэй бус, аман хэлбэрийн мэдээлэл болж байна.⁵ Мөн орчин үед цахим баримт бичиг гэсэн баримт бичгийн шинэ төрөл бий болсон бөгөөд эдгээрийг агуулж хадгалж байгаа техник, биет зүйл нь түүний бүрдэл хэсэгт тооцогддог.

Үүнээс харахад “мэдээ, баримт бичиг, эд зүйл” гэдгийг үндэслэлтэй зөв тодорхойлохгүй бол Эрүүгийн хуулийн холбогдох хэм хэмжээг хэрэглэхэд ихээхэн төвөг учрана.

Зарим орны эрүүгийн хууль тогтоомжоос үзэхэд “төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйл” гэж нэг бүрчлэн тоочоогүй, “төрийн нууцад хамаарах мэдээлэл” гэсэн агуулгад багтаасан байна. Тухайлбал, ОХУ, ТУХН-ийн орнууд, Латви, Литва, Турк, Өмнөд Солонгос улсын Эрүүгийн хуульд “төрийн нууцад хамаарах мэдээлэл”, “нууц байх мэдээлэл” гэжээ. Манайд “улсын нууц мэдээ, материал”, “улсын нууцад хамаарах мэдээ, баримт” гэж Эрүүгийн хуульдаа томъёолж байж.

Эрүүгийн хуулийн 19.12 дугаар зүйлд төрийн нууц задруулах гэмт хэргийн субъект нь “Итгэмжлэгдэн хариуцсан, албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд” байхаар заасан. Албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээдэд ихэнх судлаачид зөвхөн албан тушаалтныг хамааруулан авч үздэг. Харин сүүлийн үед зарим судлаач хууль, гэрээгээр хүлээсэн ажил, үүргээ хэрэгжүүлэхдээ төрийн нууцтай танилцсан албан тушаалтан, иргэн

⁵ Б.Баярсайхан, А.Янжиндолгор “Монгол хэлний хураангуй тайлбар толь бичиг” УБ., 2009 он, 74, 1023 дахь тал

хамаарна⁶ хэмээн үзэх болсон байна.

Практикт сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зорилгоор иргэн төрийн нууцтай танилцах тохиолдол гардаг бөгөөд ингэж төрөлжүүлэх шаардлагатай эсэх нь эргэлзээ төрүүлэх билээ.

Тухайн гэмт хэргийн субъектыг өргөн хүрээтэй авч үздэг улс орон нилээдгүй бий. Тухайлбал, ОХУ-ын Эрүүгийн хуулийн 283 дугаар зүйлд "хариуцсан ажилтан болон ажил албаны шугамаар мэдсэн этгээд", Өмнөд Солонгос, БНХАУ, Турк улсын Эрүүгийн хуульд субъектыг "задруулсан этгээд" гэж ерөнхий хүрээнд заажээ.

Монгол Улсын Эрүүгийн хуульд "төрийн нууц задруулсан" гэж тухайн гэмт хэргийн объектив шинжийг заасан ч үйлчлэлийн хэлбэрийг тодорхойлоогүй байна. Харин Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 5.1.11 дүгээр зүйлд "төрийн болон албаны нууц задруулах гэж мэдээлэх, дамжуулах, үзүүлэх, хэвлэн нийтлэх болон бусад арга замаар мэдэх эрхгүй этгээдэд тодорхой болсон..." гэж нэлээд дэлгэрэнгүй тайлбарлажээ.

Зарим судлаачид "төрийн нууц задруулах" гэдгийг "Төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг итгэмжлэгдэн хариуцсан буюу албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд задруулж байгаа идэвхитэй үйлдлээр илрэн гарна. Ийм үйлдэлд төрийн нууц мэдээ, баримт бичиг, эд зүйлийг бусдад биет эх буюу

хуулбарласан байдлаар шилжүүлэн өгөх, нууцтай холбоотой асуудлаар захидал бичих, лекц яриа хийх, сурвалжлага өгөх, сонин сэтгүүлд мэдээ тайлбар бичих, радио телевиз зэрэг мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэг дамжуулах зэрэг багтана", "Төрийн нууцыг задруулах нь төрийн нууцыг хадгалах, хамгаалах журмыг зөрчсөний улмаас төрийн нууц түүнийг мэдэх эрхгүй этгээдэд тодорхой болсон байх явдал юм. Задруулах нь амаар (мэдээллийн хэрэгслээр олон нийтэд дамжуулсан, бусдад ярьсан), бичгээр (ном, хэвлэлд нийтэлсэн) болон үйлдэл, эс үйлдэхүйн бусад хэлбэрээр (төрийн нууцад хамаарах баримт бичгийг орхиж явсан) илэрч болно.⁷ гэж тайлбарласнаас үзэхэд "төрийн нууц задруулах" гэх ойлголтыг нэлээд ул суурьтай өргөн утгаар нь авч үзэх шаардлагатайг харуулж байна.

Туулсан түүхэн замнал нь манайхтай төсөөтэй Казахстан Улсын Төрийн нууцын тухай хуульд "Төрийн нууцыг задруулах гэж төрийн нууцыг мэдээлэх, дамжуулах, танилцуулах, илгээх, хэвлэн нийтлэх болон бусад аргаар түүнтэй танилцах эрхгүй хувь хүн, хуулийн этгээдэд хүргэсэн байхыг" ойлгохоор заажээ⁸.

ОХУ-ын Эрүүгийн хуульд төрийн нууцыг задруулахад "төрийн нууцыг задруулсан, эдгээр мэдээлэл нь бусдын хүртээл болсон" байхыг шинжийг илүү

⁷ Монгол Улсын Дээд шүүх "Монгол Улсын эрүүгийн хуулийн тайлбар" УБ., 2010 он. 243 дэх тал

⁸ Б.Батхишиг. Монгол Улсын төрийн нууцыг хамгаалах үндэс. УБ., 2014 42 дахь тал.

⁹ Закон Республики Казакстан "О государственных секретех" 15 марта 1999.

⁶ Б.Батхишиг. Монгол Улсын төрийн нууцыг хамгаалах үндэс. УБ хот., 2014 он 42 дахь тал

анхаарсан байдаг. Мөн Испанийн Эрүүгийн хуульд “Эрх бүхий албан тушаалтан буюу төрийн албан хаагч өөрт нь итгэл хүлээлгэн хадгалуулсан төрийн нууц баримт бичгийг санаатайгаар өөр этгээдэд мэдэх боломж олгосон байхыг онцолжээ.”¹⁰

Эдгээрээс үзвэл, төрийн нууцыг задруулсан гэдгийг ямар арга замаар гэдэг талаас нь бус, харин “бусад этгээдэд мэдэх боломж олгосон байх” гэдэгт ихээхэн анхаарах нь зүйтэй санагдана.

Төрийн нууц задруулах гэмт хэргийн онцлог нь эх орноосоо урвах, тагнуул хийх гэмт хэргийн шинжгүй байдаг оршино.

Эх орноосоо урвах гэдэг нь Монгол Улсын иргэнээс гадаад улс болон тэдгээрийн тагнуул, төлөөлөгчидтэй буюу гадаадын байгууллагатай хамтран өөрийн улсын үндэсний аюулгүй байдлын эсрэг дайсагнасан үйл ажиллагаа явуулахыг хэлнэ.¹¹

Эх орноосоо урвах гэмт хэргийн объектив талын нэг хэлбэр нь Монгол Улсын иргэн төрийн нууцыг гадаад улс, тэдгээрийн тагнуулын алба, түүний төлөөлөгч, эсхүл гадаадын байгууллагад шилжүүлэн өгөх хэлбэрээр эх орноосоо урвах нь өөрийн улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, нутаг дэвсгэрийн халдашгүй дархан байдал, батлан хамгаалах хүчин чадалд хохирол учруулах зорилготой байдаг тул төрийн

нууцыг гадаад улс, тэдгээрийн тагнуул, төлөөлөгч, эсхүл гадаадын байгууллагад шилжүүлэн өгөх нь шууд санаатай үйлдэл юм.

Үүнээс үзвэл, төрийн нууц задруулах санаатай үйлдэл нь өөрөө эх орноосоо урвах гэмт хэрэг болж, давхар зүйлчлэгдэж болзошгүй. Гэхдээ тухайн хэргийн субъектив тал (сэдэлт, зорилгыг) нарийн тогтоосноос уг хэргийг ялган зүйлчилж болно.

Судалж буй сэдэвтэй уялдуулан тухайлан харьцуулах шаардлага бүхий зарим хэргүүд бий. Тухайлбал, тагнуул хийх гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 19.10 дугаар зүйл) уг үйлдэл нь “гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэрт тагнуул хийсэн бол, мөн гадаад улсын тагнуулын байгууллагын үүрэг даалгавар гүйцэтгэсэн, Монгол Улсын иргэнийг гадаадын тагнуулын албатай нууцаар хамтран ажиллахыг ятгасан, ажиллуулсан, төрийн нууцад хамаарах мэдээ, баримт, эд зүйлийг хулгайлсан, цуглуулсан, хадгалсан, дамжуулсан үйлдлийг хэлнэ”¹². Энэхүү гэмт хэргийн халдлагын зүйл нь Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйл байдаг боловч субъект нь зөвхөн гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн байх ёстой. Гадаад улсын иргэн харьяалалгүй хүний тагнуулын үйл ажиллагаа нь Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах хүчин чадалд хохирол учруулах зорилго бүхий төрийн нууцыг олж авах (хулгайлах,

¹⁰ ТЕГ “Гадаад орнуудын төрийн нууцыг хамгаалахтай холбогдсон эрх зүйн зохицуулалт” УБ., 2011 он 111 дэх тал

¹¹ Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2013 228 дахь тал.

¹² ХЗДХЯ. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын гарын авлага. УБ., 2017 195 дахь тал

олзлох), шилжүүлэх идэвхитэй үйлдлээр төгсөнө. Харин Монгол Улсын иргэн энэ үйлдлийг хийсэн бол эх орноосоо урвах гэмт хэрэг гэж үздэг.

Эрүүгийн хуулийн 19.12 дугаар зүйлийн 2 дах хэсэгт "Энэ гэмт хэргийг үйлдэж төрийн маш нууц, онц чухал-маш нууцыг задруулсан бол таван жил хүртэл хугацаагаар эрх хасаж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ" гэсэн нь нууцын зэрэглэлээр ялгаж хариуцлагыг хүндрүүлснээрээ илүү оновчтой болсон гэх үндэслэлтэй байна. Учир нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 16.1-д учирч болох хор уршгийн хэмжээнээс хамаарч нууцын зэрэглэлийг тогтоосон байдаг тул хамгийн дээд зэрэглэлийн нууцыг задруулах нь учруулах хор уршиг их, ноцтой гэсэн үг юм.

2002 оны Эрүүгийн хуульд төрийн нууц задруулах хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол ялыг хүндрүүлж оногдуулахаар заасан бөгөөд хүнд хор уршиг гэдэгт юуг ойлгох нь тодорхойгүй байсан судлаачид "Хүнд хор уршиг учирсан" гэдэгт төрийн нууцад хамаарах мэдээ баримт бичиг, эд зүйл, объект үйл ажиллагааг итгэмжлэгдэн хариуцсан буюу албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд задруулсныг тагнуулын зорилгоор гадаад улсын иргэн буюу харьяалалгүй хүн олж авсан, түүнчлэн Монгол Улсын иргэн эх орноосоо урваж дээр дурьдсан төрийн нууцыг гадаад улс түүний тагнуулын алба, гадаадын байгууллагад шилжүүлэн өгсөн, үүнтэй холбоотойгоор хүнсний болон эрүүл ахуй, байгаль, экологи, эдийн засгийн аюулгүй байдалд их буюу онц их

хэмжээний хохирол учирсан, төр засгийн байгууллын хэвийн үйл ажиллагаа тасалдсан зэргийг ойлгож болно"¹³, "Хүнд хор уршиг" гэдэгт улс орны гадаад аюулгүй байдалд онц аюултай хохирол учруулсан, энэ хохирлыг арилгахад их хэмжээний зардал, чирэгдэл гарсан байхыг ойлгоно."¹⁴, "Хүнд хор уршиг" нь хүний амь нас хохирохоос бусад тухай бүрдээ үнэлэмж шаарддаг гэмт хэргийн үр дагавар¹⁵ зэргээр олон янзаар тайлбарлаж байв.

Харин шинэчилсэн Эрүүгийн хуулиар тухайн гэмт хэрэгт оногдуулах ялыг хорих ялаас гадна эрх хасах, зорчих эрхийг хязгаарлах зэрэг сонгох боломжтой байхаар заасан нь ололгтой болсон юм. Төрийн нууцыг санаатай задруулах, болгоомжгүйгээр задруулах сэтгэл зүйн хувьд ялгаатай байдаг, уг хэргийг гол төлөв албан тушаалтан үйлддэг зэрэг онцлогийг харгалзан ялгаатай ял оногдуулах боломж бүрдсэн. Гэхдээ нэг дутагдалтай тал нь Эрүүгийн хуулийн 19.12 дугаар зүйлийн 2 дах хэсэгт төрийн нууцын хоёр зэрэглэл / маш нууц, онц чухал-маш нууц/-ыг заачихсан учир 1 дэх хэсэг бараг хэрэглэх боломжгүй болсон. Ийм учраас төрийн нууцыг задруулах гэмт хэрэгт зөвхөн хүнд ялыг нь оногдуулахаар болсон анхаарал татаж байна.

Эндээс дүгнэхэд Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 19.12 дугаар

¹³ Монгол Улсын Дээд Шүүх. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар толь. УБ., 244 дэх тал

¹⁴ С.Жанцан. Монгол Улсын эрүүгийн эрх зүй. УБ., 2012 он 220 дахь тал

¹⁵ С.Жанцан "Монгол Улсын эрүүгийн эрх зүй" Тусгай анги. УБ., 2012 31 дэхь тал

зүйлд заасан “Төрийн нууц задруулах” гэсэн ойлголт тухайн гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг бүрэн тодорхой гаргаж чадаагүй учраас (бланкетный) ишлэл авсан тайлбар шаардлагатй байгааг анхаарах, чингэсэн нөхцөлд Эрүүгийн хуулийн “хууль ёсны байх” зарчим алдагдахад хүрч болзошгүй юм. Тэгээд ч Төрийн болон албаны нууцын тухай хуультай уялдаагүй, гадаад орны нийтлэг жишигт төдийлөн анхаараагүй зэрэг нь практикт уг зүйлийг хэрэглэхэд хүндрэл учруулахаар байна гэх үндэслэл байна.

Иймээс Монгол Улсын Эрүүгийн хуулийн төрийн нууц задруулах гэмт хэрэгтэй тэмцэх хэм хэмжээг боловсронгуй болгох дараах саналыг дэвшүүлж байна:

1. Эрүүгийн хуулийн 19.12 дугаар зүйлд заасан “Төрийн нууцад

хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйл” гэснийг бусад орны нийтлэг жишиг, Төрийн нууцын тухай хуульд нийцүүлэн “төрийн нууцад хамаарах мэдээлэл” гэж өөрчлөх;

2. Төрийн нууцыг “итгэмжлэгдэн хариуцсан, албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд” гэсэн нь явцуу хүрээтэй болсон тул хуульд заасны дагуу танилцсан, мэдсэн иргэн бүр задруулах субъект байхаар “итгэмжлэгдэн хариуцсан болон хууль тогтоомжид заасны дагуу танилцсан бусад этгээд” гэж өөрчлөх
3. Эрүүгийн хуулийн 19.12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг шинэчлэн найруулах, мөн зүйлийн 2 дахь хэсгээс “маш нууц” гэснийг хасах нь зүйтэй юм.

ЗАХИРГААНЫ ШҮҮН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ НОТЛОХ БАРИМТЫН ЗАРИМ ОНЦЛОГ

Б.СОД-ЭРДЭНЭ

(Шихихутуг их сургуулийн магистрант)

1. Захиргааны хэргийн шүүхийн нотлох баримтын ойлголт, тавигдах шаардлага

Эрх зүйн олон салбар нь ямагт хувирч өөрчлөгдөн, шинэчлэгдэж байдаг учраас “нотлох баримт” хэмээх ойлголтод нэгдсэн нэг тодорхойлолт өгөхөд хүндрэл учирдаг. Гэвч эрдэмтэн, судлаачид онол арга зүйн үндсийг нь гаргаж тавихыг чармайсаар байна. Тухайлбал, академич С. Нарангэрэл “Эрүүгийн, иргэний, үндсэн хуулийн, арбитрын, түүнчлэн захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хэргийг зөв шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлын тухай аливаа бодит мэдээ, сэлт юм”¹ хэмээн ерөнхий утгаар нь тодорхойлсон байдаг.

Захиргааны процессын анхны гэгддэг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай 2004 оны хуулийн 30 дугаар зүйлд нотлох баримттай холбоотой асуудлыг шийдвэрлэхдээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмыг дагаж мөрдөхөөр “ишлэл” оруулан зохицуулжээ. 2016 онд шинээр батлагдаж, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”-нд захиргааны хэргийн нотлох баримтын тухай асуудлыг нарийвчлан холбогдох зүйл

заалтыг нэлээд тодорхой болгожээ.

Манай улс нь Ром-Германы эрх зүйн бүлийн улсад хамаардаг, тиймээс ч захиргааны хэрэг шийдвэрлэхдээ “Мөрдөн шүүх загвар”-ын зарчмыг баримтлах учиртай гэтэл Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай шинэ хуулийн 6 дугаар зүйлд зааснаас үзэхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь “Мэтгэлцэх зарчим”-ын дагуу явагдах зохицуулалттай байна.

Өөрөөр хэлбэл, захиргааны шүүх нь гэм бурууг тогтоож, гэмтнийг гэсгээн цээрлүүлж, ял эдлүүлэх, нийгэм иргэдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалдаг эрүүгийн хэргийн болон эрх тэгш хоёр хүн, хуулийн этгээдийн өөр хоорондын өр зээл зэрэг эд хөрөнгийн гол шинж бүхий маргааныг шийдвэрлэх замаар мөн хамгаалдаг иргэний хэргийн шүүхээс зарчим, чиглэлийн ялгаа бүхий нийгэм-эрх зүйн өвөрмөц онцлогтой аж.² “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”-д заасанчлан захиргааны хэргийн нотлох баримт нь дараахь онцлог шинжийг агуулана. Үүнд:

- Шүүх хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий байх
- Хуульд заасан журмын дагуу олж

¹ Нарангэрэл С. Эрх зүйн эх толь бичиг. УБ хот. 2013 он.

² Чимид Б. Захиргааны хэргийн шүүхийн тухай мэдэгдэхүүн УБ хот. 2004 он. 35 дугаар тал.

авсан байх

- Хэргийн бодит нөхцөл байдлыг тогтооход шаардлагатай байх
- Тухайн хэрэгт хамааралтай байх. Эдгээр шинжийг товчхон авч үзье:

Шүүх хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий байх шинж:

Тухайн нотлох баримт нь хэрэг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай, уг хэрэгт хамааралтай байна. Хэрэгт хамааралгүй, нотолгооны ач холбогдолгүй, хуулиар зөвшөөрөгдөөгүй баримтыг шүүх хэргийн нотлох баримтаас хасч, уг баримтыг шаардан гаргуулах хүсэлтийг хүлээн авахаас татгалзан захирамж, тогтоол гаргадаг. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогоос үүдэн хэргийн оролцогчдоос гаргаж өгсөн нотлох баримтуудад шүүгч үнэлгээ өгөөд хангалтгүй гэж үзвэл тухайн хэрэгт зайлшгүй ач холбогдолтой шаардлагатай нотлох баримтыг цуглуулах шаардлагатай болно.

Хуульд заасан журмын дагуу олж авсан байх шинж: Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдын шүүхэд гаргасан нотлох баримтаас гадна шүүхийн цуглуулсан нотлох баримт нь хуульд заасан арга хэрэгслээр олж авагдсан байх ёстой. Арга хэрэгслээр гэдэгт захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед хийгдэх мөрдөн шалгах ажиллагаа, түүнээс бусад үйл ажиллагаа нь хууль, түүнд нийцүүлэн гаргасан журамд заасан дараалал, хэлбэр, шаардлагад нийцүүлсэн үйлдэл, үйл ажиллагааг ойлгоно. Ийнхүү хууль, түүнд заасан

журмын дагуу олж аваагүй нотлох баримт нь нотолгооны шинжээ алдаж, ач холбогдолгүй болдог.

Техник, технологи өндөр түвшинд хүрсэн орчин үед хэргийн оролцогчид нь нотлох баримтыг хуурамчаар үйлдэх, өөрчлөх, засварлах тохиолдол нэлээдгүй гарч буй тул шүүгч нь нотлох баримт бүрийг нарийвчлан авч үзэх, шаардлагатай тохиолдолд нарийн мэргэжлийн шинжээч заавалчгүй томилно.

Хэргийн бодит нөхцөл байдлыг тогтооход шаардлагатай байх шинж:

Хэрэгт ач холбогдолтой, хуульд заасан журмын дагуу олж авсан нотлох баримт нь янз бүрийн ч зарим тохиолдолд зөвхөн нэг нөхцөл байдлыг тогтоох ч бий. Аль ч тохиолдол тэр нь бодитой бөгөөд үнэнийг тогтоох шалгууртай байх учиртай.

Шүүх нь бодит үнэнийг тогтоож, хэрэг маргааныг хянан шийдвэрлэх үүргийнхээ хүрээнд ийнхүү хүрэлцэхүйц нотлох баримтыг цуглуулж авсан байх шаардлагатай юм. Иймээс захиргааны хэргийн шүүх нь мөрдөн шалгах чиг үүргийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ хэргийн оролцогчид ч энэ ажилд хуульчлагдсан эрх үүргээ эдэлж идэвхи санаачлага гаргах ёстой.

Тухайн хэрэгт хамааралтай байх:

Нотолгооны зүйл нь нэхэмжлэлийн зүйл, харуицагчийн тайлбар, гуравдагч этгээдийн гомдол, шаардлагын аль нэгийг нотолсон эсхүл үгүйсгэсэн шинжтэй байх ёстой. Тэгэхээр нэг хэргийг шийдвэрлэхийн тулд шүүгч хэргийн нөхцөл байдлыг тогтоож чадах

маш олон үйл баримтыг цуглуулна. Тэр цуглуулсан баримтууд нь бүгд тухайн хэрэгтэйгээ шууд ба шууд бусаар хамааралтай ач холбогдолтой байх ёстой.³

Захиргааны хэргийн шүүх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахдаа төрийн албадлага хэрэглэн холбогдох этгээдээс нотлох баримтыг шаардан гаргуулж авдаг. Иймээс тус шинжийг агуулаагүй тохиолдолд хэрэгт хамааралгүй гэж үзэн хэргийн нотлох баримтаас хасч, оролцогчийн хүсэлтийг хүлээн авахаас татгалзна.

2. Захиргааны шүүхийн нотлох баримтын онцлогууд

Нотлох баримтыг ангилах нь эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг боловсронгуй болгож, эмх цэгцтэй, бүрэн дүүрэн, бүх талаас нь бодитойгоор судлахад чухал ач холбогдолтой төдийгүй нотлох үйл ажиллагааг түргэн шуурхай бодитой явуулахад тус дөхөмтэй байдаг.⁴

- **Нотолгооны шинжээр нь:** Шууд нотлох баримт, шууд бус нотлох баримт гэж ангилдаг. Шууд бус нотлох баримт нь хэрэгт ач холбогдол бүхий бусад байдлыг тогтоох буюу хэргийн нөхцөл байдлыг шууд бусаар нотолдог. Харин шууд гэдэг нь нотлох үйл явдалд шат дамжлагагүй хамаарагдана.

³ Чимид Б. Захиргааны хэргийн шүүхийн тухай мэдэгдэхүүн. УБ хот. 2004 он 105 дугаар тал

⁴ Батзориг Б. Эрүүгийн хэргийг нотлох ажиллагаан дахь нотлох практикийн асуудал. УБ хот. 1999 он, 36 дугаар тал, А.А.Хмыров "Основы теории доказывания" Краснадар 1981, 39 дүгээр тал

- **Эх үүсвэрт бэхэжсэн шинжээр нь:** Бичмэл ба эд мөрийн баримт гэж 2 ангилдаг. Бичмэл болон эд мөрийн баримтын талаар "Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль"-ийн 38, 39 дүгээр зүйлүүдэд тодорхой тайлбарласан байдаг.

- **Эх сурвалжийн чадвараар нь:** Анхдагч ба дамжмал нотлох баримт гэж ангилна. Анхдагч нотлох баримт нь шууд, эх байдлаараа олж авагдсан баримтат мэдээлэл юм. Харин дамжмал нотлох баримт нь үндсэн эхээрээ бус өөр эх үүсвэрээр дамжиж авагдсан байна.

Нотлох баримтын төрөл. Тодорхой хэргийг болон тэдгээртэй холбоотой бусад нөхцөл байдлыг тогтооход чиглэгдсэн аргуудыг тусгай арга хэмээх бөгөөд уламжлалт арга болон уламжлалт бус арга гэж 2 ангилдаг. Олон жилийн хугацаанд уламжлагдсан хэрэглэсэн аргыг уламжлалт арга хэмээдэг бол шинжлэх ухаан, техник технологийн ололт амжилтанд тулгуурласан шинэ, шинэлэг аргуудыг уламжлалт бус аргууд гэнэ.⁵

3. Эрүүгийн шүүхийн нотлох баримтаас ялгагдах шинж:

"Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль"-ийн 16 дугаар бүлэгт "Нотлох баримт"-ын талаар тухайлан дэлгэрэнгүй байдлаар хуульчилсан байх бөгөөд уг хуулийн 16.1 дүгээр зүйлийн 16.1.1 дэх хэсэгт нотлох баримтыг "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, энэ хуульд заасан

⁵ Нотолгооны онол /Гарын авлага/. УБ хот. 2013 он. 26 дугаар тал

үндэслэл, журмын дагуу олж авсан аливаа баримтат мэдээлэл юм” гэж тодорхойлжээ. Эрүүгийн шүүх болон Захиргааны шүүх нь шаардлагатай тохиолдолд үзлэг, туршилт, таньж олуулах зэрэг мөрдөн шалгах үйл ажиллагааг явуулж нотлох баримтыг өөрсдөө цуглуулдагаараа төсөөтэй хэдий ч захиргааны хэргийн нотлох баримт нь эрүүгийн хэргийн нотлох баримтаас дор дурьдсан шинжээрээ ялгаатай байна. Үүнд:

Хэдийгээр өөр хоорондоо төсөөтэй боловч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мөрдөгчийн магадлагаа, хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас ирүүлсэн гэмт хэргийн талаархи гомдол, мэдээлэл зэрэг нь эрүүгийн хэргийн нотлох баримт болдгоороо онцлог юм. Мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэгжлэг хийх, хураан авах зэрэг захиргааны хэргийн шүүхийн хийж гүйцэтгэдэггүй мөрдөн шалгах ажиллагаа явуулж, тэмдэглэл үйлддэг ба тухайн тэмдэглэл нь нотлох баримтын нэгэн төрөл болдгоороо ялгаатай юм.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд нотлох баримт цуглуулах ажиллагааг мөрдөгч, прокурор хийж гүйцэтгэдэг. Иймээс тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нь мөрдөн шалгах ажиллагааг хийж гүйцэтгэн, нотлох баримт цуглуулсан мөрдөгч, прокуророос цэвэр шалтгаалах нь олонтой. Харин захиргааны хэргийн шүүхийн хувьд шүүгч, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нар нь мөрдөн шалгах ажиллагааны болон шүүх хуралдаан, урьдчилсан

хэлэлцүүлгийн тэмдэглэл бичиж, гүйцэтгэсний үндсэнд эдгээр бичиг баримт нь нотлох баримтын нэгэн төрөл болдог. Ихэнх тохиолдолд захиргааны хэргийн шүүх нь хэргийн оролцогч талууд болон холбогдох захиргааны байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн нотлох баримтын хүрээнд шийдвэр гаргаж, хариуцагчийн шийдвэр, үйл ажиллагаа нь хууль ёсны эсэхэд үнэлгээ өгч ажилладаг.

Гэмт хэргийн нотолгооны зүйлийг нотлох баримтаар тогтоох явц нь болж өнгөрсөн үйлдэл, эс үйлдэхүй, үйл явдлыг сэргээн нотолж байгаа танин мэдэхүйн ажиллагаа бөгөөд гэмт хэрэг ихэвчлэн нууц аргаар үйлдэгддэг учир сэргээж тогтооход маш хүндрэлтэй байдгаараа онцлог юм.⁶ Иймээс шаардлагатай бүхий л арга хэмжээг хэрэглээд ч хэргийг хянан шийдвэрлэхэд хүрэлцэхүйц нотлох баримтыг цуглуулж, тухайн этгээд нь гэмт хэрэг үйлдсэн эсэхийг тодорхойлж чадахгүй байсаар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дуусч, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох тохиолдол практикт ихээхэн гарч байна. Харин захиргааны хэргийн хувьд ийнхүү нотлох баримт олдохгүй, хэргийн нөхцөл байдлыг тодорхойлох боломжгүй гэх үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх тохиолдол байхгүй. Эсэргээрээ, нотлох баримт цуглуулах буюу шинжээчийн дүгнэлт гаргуулах, хилийн чанадад нотлох баримт бүрдүүлэх шаардлагатай тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг тодорхой хугацаанд

⁶ Батзориг Г.Б. Гэмт хэргийн нотолгооны ерөнхий онол. УБ хот. 2002 он. 108 дугаар тал.

түдгэлзүүлэх тохиолдол бий.

Гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй этгээдийг олж тогтоон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлсэн хэдий ч тухайн этгээд нь гэм буруугүй гэдгээ нотлох үүрэг хүлээдэггүйгээрээ онцлогтой. Харин захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд хариуцагч тал хэзээд ойлгомжтой, тодорхой байх бөгөөд хариуцагч нь өөрийн гаргасан шийдвэр, үйл ажиллагаагаа хууль эрх зүйн үндэслэлтэй байсан хэмээн хариу тайлбар гаргаж, үүнийхээ хүрээнд холбогдох нотлох баримтыг шүүхэд гаргаж өгөх үүрэгтэйгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдоггоороо ялгаатай.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтыг ил болон далд аргаар цуглуулж болдог. Ийнхүү далд аргаар нотлох баримт цуглуулах буюу мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулсан тохиолдолд шүүгч буюу шүүх бүрэлдэхүүн, прокурор, мөрдөгч зэрэг эрх бүхий албан тушаалтнаас бусад этгээдүүд энэ талаар мэдэхгүй тэр үед олж авсан нотлох баримттай зөвхөн дээрх эрх бүхий албан тушаалтан танилцах эрхтэй байдаг. Харин захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд нотлох баримтыг зөвхөн ил аргаар цуглуулах ба хэргийн оролцогчид нь хэргийн бүхий л нотлох баримттай танилцан, шаардлагатай тохиолдолд хуулбарлаж авах эрхтэй байдаг.

Эрүүгийн процессын хувьд нотолгооны процесс нь нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх, нотлох баримтыг шалгах,

үнэлэх зэрэг үе шатуудыг дамжин явагддаг. Нотлох баримтыг цуглуулах ажиллагаа нь гол төлөв хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хэрэгжүүлдэг⁷ гэдгээрээ захиргааны хэргийн шүүхээс ихээхэн ялгаатай юм. Уг ажиллагаатай салшгүй холбогдох нотлох баримт бэхжүүлэх ажиллагааг мөрдөгч, прокурор, цөөн тохиолдолд шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нар хийж гүйцэтгэдэг хуулийн зохицуулалттай.

Мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед “нотлох баримтыг шалгах” үе шат ихээхэн чухал нөлөөтэй байх бөгөөд уг үе шатанд мөрдөгч, прокурор, шүүгч, шүүх бүрэлдэхүүн нь шаардлага хангасан хэмээн авагдсан баримт мэдээлэл бүрийг бүх талаас нь бүрэн гүйцэд шалгаж ажилладаг.⁸

4. Иргэний шүүхийн нотлох баримтаас ялгагдах шинж

“Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”-ийн 37 дугаар зүйлийн 37.1-д “Хэргийн оролцогчоос өөрийн шаардлага ба татгалзлаа үндэслэж байгаа, шүүх хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, хуульд заасан арга хэрэгслээр олж авсан бодит нөхцөл байдлыг тогтооход шаардлагатай аливаа шаардлагатай аливаа баримтат мэдээллийг нотлох баримт гэнэ” хэмээн тодорхойлжээ. Энэхүү тодорхойлолт нь “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай

⁷ Бямбаа Ж, Эрхэсхулан Ж. Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал. УБ хот. 2018 он. 152-153 дугаар тал.

⁸ Бямбаа Ж, Эрхэсхулан Ж. Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал. УБ хот. 2018 он. 154 дахь тал

хууль"-д заасан нотлох баримтын тухай тодорхойлолттой утга агуулгын хувьд адилхан байх бөгөөд нотлох баримтын төрлийн хувьд ч нэгэн адил байдаг. Гэсэн хэдий ч тус хоёр шүүхийн чиг үүрэг, хянан шийдвэрлэх маргаан, түүний агуулга нь тэс өөр байх учир дараахь шинжээрээ ялгагдахаар байна.

Иргэний хэргийн шүүх нь эрх тэгш этгээдүүд буюу иргэн, хуулийн этгээд хооронд үүссэн маргааныг хянан шийдвэрлэдэг тул зохигчид болон гуравдагч этгээд нь өөрсдийн нэхэмжлэл, хариу тайлбараа баталж нотлохын тулд холбогдох нотлох баримтыг өөрсдөө гарган, цуглуулж иргэний хэргийн шүүхд өгдөг. Иймээс иргэний хэргийн шүүхийн нотлох баримт нь тухайн хэргийн зохигчдын эрх зүйн чадамж, эрх зүйн мэдлэг, боловсролтой шууд холбоотой байдаг тул нотлох баримт болох гэрээ, бичиг баримт зэрэг нь илт хууль зөрчсөн, хэлбэр, агуулгын хувьд ойлгомжгүй байх тохиолдол ихээхэн бий. Харин захиргааны хэргийн шүүх нь өмнө дурьдсанчлан эрх тэгш бус этгээдүүдийн хооронд үүссэн маргааныг хянан шийдвэрлэх бөгөөд хэргийн нэг талд захиргааны байгууллага, албан тушаалтан байдаг. Уг этгээд нь хууль, эрх зүйн тодорхой хэмжээний мэдлэгтэй, өөрийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах явцдаа хууль тогтоомжтой, түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг зөрчсөн эсэхтэй холбоотойгоор "Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль" батлагдан мөрдөгдөж эхэлсэн 2004 оноос хойш, "Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль"-д

заасны дагуу хариуцагчаар татагдаж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсоор ирсэн. Иймээс "Захиргааны ерөнхий хууль"-ийн 5.1 дүгээр зүйлийн 5.1.1-д заасан байгууллага, албан тушаалтнууд нь өнгөрсөн 15 жилийн туршид захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хариуцагч болж, хууль, эрх зүйн үндэслэлгүйгээр иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдваас гаргасан шийдвэр нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэрээр хүчингүй болдог талаар ойлголттой болсон нь захиргааны хэргийн шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн хэргийн тоо жил ирэх тусам өсөлттэй байгаагаас харагдаж байгаа юм.⁹

Үүнээс үзвэл хариуцагч болох этгээдүүд нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг ойлгож мэдсэний үндсэнд шийдвэр гаргаж, үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдын тайлбар нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зохигч, гуравдагч этгээдийн тайлбараас ялгагдах онцлог нь захиргааны хэргийг бүх талаас нь бүрэн дүүрэн нотлохыг нэхэмжлэгчээс шаарддаггүйд оршино. Харин хариуцагчийн тухайд нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрөх эсэх тухайгаа шүүхэд бичгээр мэдэгдэх үүрэгтэй.¹⁰ Уг тохиолдолд хариуцагч этгээд нь нэхэмжлэгчийн хууль ёсны

⁹ admincourt.gov.mn/ 2015-2018 оны шүүн таслах ажиллагааны тайлан

¹⁰ Захиргааны хэргийн шүүхийн тухай мэдэгдэхүүн 117 дугаар тал

эрх, ашиг сонирхлыг зөрчсөн, зөрчиж болзошгүй нөхцөл байдал үүссэн байдаг тул дараахь үүргийг хүлээдэг байна.

Иргэний хэрэг шүүрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зохигчдын тайлбар нь зөвхөн бодит үнэнд нийцсэн шинжтэй байх шаардлагатай байдаг бол захиргааны хэрэг шүүрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд хэргийн оролцогчдын тайлбар нь хуулинд заасны дагуу бодит үнэнд нийцсэн, хэрэгт авагдсан нотлох баримтад үндэслэгдсэн байх шаардлагатай болно.

Иргэний хэрэг шүүрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зохигчид нь нотлох баримтыг өөрсдөө гаргуулан авах боломжгүй тохиолдолд иргэний хэргийн шүүхэд нотлох баримт гаргуулах тухай хүсэлт гаргах ба шүүхээс уг хүсэлтийг хянан шалгаж, үндэслэлтэй хэмээн үзвээс холбогдох этгээдээс нотлох баримт гаргуулахаар захирамж гаргадаг. Үүнээс үзвэл, иргэний хэргийн шүүх нь зөвхөн зохигчийн хүсэлтийн үндсэнд бусад этгээдээс нотлох баримт гаргуулахаар шийдвэр гаргадаг байна. Харин захиргааны хэргийн шүүхийн хувьд хэргийн оролцогчдын хүсэлтийн дагуу нотлох баримт гаргуулан авдаг хэдий ч оролцогчид ийнхүү хүсэлт гаргаагүй тохиолдолд ч өөрийн санаачилгаар нотлох баримт гаргуулахаар холбогдох захиргааны байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд зэргээс шаардаж болно.

Эцэст нь, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримт сайтар цуглуулж, өөрийн нэхэмжлэл, хариу тайлбараа

үндэслэлтэйгээр нотолж чадсан талд ашигтай шийдвэр гардаг. Иймд эрх зүйн мэдлэг, боловсрол багатай иргэн нь өмгөөлөгч, төлөөлөгчгүй оролцсон тохиолдолд өөрийн хүссэн үр дүнд тэр бүр хүрдэггүй. Гэтэл захиргааны хэргийн шүүх нь хэргийг хянан шийдвэрлэхэд шаардлагатай нотлох баримтыг өөрөө болон оролцогчдын хүсэлтээр цуглуулж, иргэн, хуулийн этгээдийн эрх, ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд эрхийг сэргээн, эрх зүйн хамгаалалт тогтоож, учирсан хохирлыг барагдуулан бүхий л үйл ажиллагааг өөрөө хийж гүйцэтгэдэг онцлогтой.

Дүгнэлт

Захиргааны процесс ажиллагаан дахь нотлох баримт, нотолгоотой холбоотой зохицуулалт нь зарим талаараа боловсронгуй биш. Иймд илүү нарийвчилсан зохицуулалт, зүйл заалтууд шаардлагатай байна. Ялангуяа, үзлэг, туршилт, таньж олуулах зэрэг мөрдөн шалгах ажиллагааг хэрхэн хийж гүйцэтгэх заалтуудыг илүү тодорхой болгох шаардлагатай.

Захиргааны хэргийн шүүх нь хэрэгт хамааралгүй, нотолгооны ач холбогдолгүй, хуулиар зөвшөөрөгдөөгүй баримтыг шаардан гаргуулж болохгүй.¹¹ Гэтэл шүүхээс тус үүргээ зөрчин хэргийг хянан шийдвэрлэхэд төдийлөн шаардлагагүй, ач холбогдолгүй нотлох баримтыг холбогдох этгээдээс шаардаж буй тэр тохиолдолд давж заалдах гомдол гаргах боломж байхгүй, тэгээд ч хуулинд заасан хэрэг хянан шийдвэрлэх

¹¹ Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.6

ажиллагааны хугацаа хэтрэх тохиолдол нэлээдгүй гардаг.

Түүнчлэн “Архивын тухай”, “Зөрчлийн тухай” салбар хуулийн холбогдох зүйл заалт гэхэд л захиргааны шүүхээс нотлох баримт гаргуулан авахад бэрхшээл учруулах нөхцөл байдлыг үүсгэж байгаа нь нууц биш. Өөрөөр хэлбэл, “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”-аас гадна бусад салбар эрх зүй, төрийн байгууллагын үйл ажиллагааны зохицуулалт бүрт захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд шууд, шууд бус хэлбэрээр төвөг саад учруулах зүйл заалтууд байх учиргүй.

НЭХЭМЖЛЭЛИЙГ ХҮЛЭЭН АВАХААС ТАТГАЛЗАХ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

С.НАМУУНЖИН

(Шихихутуг их сургуулийн магистрант)

Зөрчигдсөн эрхээ шүүхийн журмаар нөхөн сэргээлгэх иргэдийн эрхийг баталгаатай эдлүүлэх зорилгоор Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах,... нотлох баримтыг шалгуулах,... шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох,... шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхтэй. ¹ гэж Үндсэн хуульд тодорхой зааж өгсөн байдаг.

Иргэн, хуулийн этгээд зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62 дугаар зүйлд заасан бүрдүүлбэрийн үндэслэлүүдийг хангаж, нэхэмжлэл гаргана. Харин 65 дугаар зүйлийн 65.1-д заасан үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж болно.

Шүүхээс нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж иргэн, хуулийн этгээдийн хариуцлагыг өндөрдүүлж, хуульд заасан шаардлагыг биелүүлэхийг үүрэг болгож буй хэдий ч нэхэмжлэлийн 19.1 хувийг ² татгалзаж байгаа нь иргэдэд хүндрэл чирэгдэл үүсгэж, Үндсэн хуульд заасан иргэний үндсэн эрх, Монгол улс нэгдэн орсон олон улсын хүний эрхийн

конвенцийн заалтыг зөрчиж байгаа нэг хэлбэр мөн.

Хүний эрхийн тухай ойлголт, Шударга шүүхээр шүүлгэх эрх

Хүн бүр тулсан аливаа эрүүгийн ял болон эрх үүргээ тодорхойлуулахдаа хараат бус, тал хардаггүй шүүхээр шударгаар шүүлгэх эрхтэй³. "...Хүн бүр өөрт тулгасан эрүүгийн хэргийг хянан хэлэлцүүлэх буюу иргэний нэхэмжлэлийн хүрээнд эрх, үүргээ тодорхойлуулахдаа хуулийн дагуу байгуулагдсан эрх бүхий, хараат бус, тал үл харах шүүхээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй⁴.

Шударга шүүхээр шүүлгэх эрх нь шүүн таслах ажиллагаа шударга байх, хэлбэрээр хангагдах хуулийн дагуу байгуулагдсан, бүрэн эрх бүхий шүүхээр, хэрэг маргаанаа шийдвэрлүүлэх учиртай. Энэ нь хувь хүнийг шударга бусаар яллах, шийтгэхээс хамгаалах урьдач нөхцөл болдог аливаа хэрэг маргааныг шийдвэрлэх шүүх нь юун түрүүнд, эрх мэдэл бүхий, бие даасан, хараат бус, хамгийн гол нь хуулийн дагуу байгуулагдсан байхын илрэл юм.

Шударга шүүхээр шүүлгэх нь хуралдааны өмнө болон хуралдааны үед, хуралдааны дараа эдлэх эрхүүдийг

¹ Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэхь хэсэг

² 2020 оны Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн хүлээн авсан нэхэмжлэл

³ Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 10 дугаар зүйлийн 1 дэх заалт

⁴ Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 дүгээр зүйлийн 1 дэх заалт

багтаасан өргөн хүрээтэй ойлголт бөгөөд үүнд, шүүх хуралдаанаас өмнө эрх зүйн зөвлөгөө авах, өмгөөлөгч сонгох, эрүү шүүлтэд өртөхгүй байх, хуралдааныг шударгаар явуулах (*талууд адил тэгш мэтгэлцэх*, *шүүх хуралдаан нээлттэй байх*), гэм буруутай нь нотлогдоогүй тохиолдолд гэм буруугүйд тооцогдох, хэргийг цаг алдалгүй шийдвэрлүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг мэдэх зэрэг олон эрхүүд багтаж ордог.

Шүүх нь төрийн үйл ажиллагааны механизм болохын хувьд хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзэж шүүхэд мэдүүлж байгаа этгээдийн эрхийг сэргээх, зохих хариуцлагыг хүлээлгэх үүрэгтэй. Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна ⁵.

Хуулийн өмнө эрх тэгш байна гэдэг нь хэн боловч Монгол Улсын хуулиар хүлээсэн үүргээ адилхан биелүүж, эрх, эрх чөлөөгөө ялгаваргүй эдэлнэ гэсэн үг юм. Гэхдээ гадаадын иргэн, харьяалалгүй хүний хувьд хүний салшгүй эрхээс бусад зарим эрх, эрх чөлөөг (*тухайлбал сонгох, сонгогдох эрх гэх мэт*) хуулиар хязгаарлаж болдог. Гэхдээ тэд шударга шүүхээр хэрэг маргаанаа эрх тэгш шийдвэрлүүлэх эрхийг заавал ч үгүй эдэлнэ.

Орчин үеийн утгаар хүний эрх хэмээх ойлголт нь дундад зууны турш ноёрхож ирсэн феодалын дарангуйлал болон шашны консерватизм аажмаар үгүй болон арилж "Сэргэн мандалт", "Европын шинэчлэл"-ийн үеэс эхлэлтэй гэж үздэг. Энэ үед Европын тэргүүлэгч

эрдэмтэд шашны ёс зүйг иргэний хувилбарт оруулах оролдлого хийж байжээ.

Хувь хүний эрх, өөр нэг хэлбэрээр буюу эрх чөлөөний санаа нь хүн төрөлхтөний түүхийн нэгэн чухал хэсэг болон оршиж байсан хэдий ч, тэдгээр нь орчин үеийн хүний эрхийн үзэл баримтлалтай ялгаатай тодорхойлогддог байсан нь ойлгомжтой. Европын анхны хүний эрхийн тухай баримт бичиг бол "Арванхоёр зүйл" хэмээх 1525 оны Германд болсон тариачдын дайны Тунхаг юм ⁶. Энэ нь тухайн тариачдын өөрийн эрхийн төлөө тэмцлийн шаардлагын нэг хэсэг байсан юм. Зарим судлаачид 1265 оны "Калишийн статуст" зарим холбогдох эрхийг заасан байдаг гэж үздэг. XVII зууны үед Жорж Смит, Т.Хэлвис болон Р.Вилльямс, түүний дотор баптизм хүртээгч теологичид, сэтгэл санааны эрх чөлөөний талаар судартаа бичиж байсан⁷.

Тусгаар тогтнолын тунхаглал, АНУ-ын Үндсэн хууль, Америкийн эрхийн тухай Билл зэрэг нь дээрх эрх зүйн уламжлалуудыг хуульчлан баталгаажуулсан. Эдгээр баримт бичгүүд нь Америкийн хувьсгалыг өдөөсөн бөгөөд улмаар дараа нь НҮБ-ын "Хүний эрхийн түгээмэл Тунхаглал" бий болоход нөлөөлсөн байдаг.

Хүний эрхийн талаархи энэхүү санаа нь Английн Эрх чөлөөний Их харти (1215), Английн эрхийн тухай бичиг (1689), Америкийн эрхийн тухай бичиг (1791)

⁶ Эрх зүйн зарим тунхаг эрдэм шинжилгээний илтгэл Б.Золбоо 2018 он

⁷ Эрх зүйн зарим тунхаг сэдэв эрдэм шинжилгээний илтгэл Б.Золбоо 2018 он

⁵ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалт

болон 1789 онд батлагдсан Францын "Хүний ба иргэний эрхийн тухай Тунхаглал" зэргээр их урт зам туулсан байдаг⁸.

1922 онд Герман, Францын лигийн санаачилгаар, 20-иод оронд Хүний эрхийн олон улсын холбоод байгуулагдаж (FIDH), хүний эрхийг хамгаалах, дэлхийн хамгийн анхны олон улсын байгууллага бий болгосон байна. Дэлхийн II-р дайн болон тоталитар дэглэмүүдээс олж авсан эмгэнэлт туршлагаас улбаалж хүний ба иргэний эрх зүй олон улсын эрх зүйн хөгжилд чанарын шинэ алхам авчирсан. 1946 оны 12 дугаар сарын 10-нд Ерөнхий Ассамблейн 217 А (III) дугаар тогтоолоор "Хүний эрхийн түгээмэл тунхаглал"⁹-ыг НҮБ-ын Ерөнхий Ассамблей батлан зарласан.

Хүний эрх бол хувь хүний эрх зүйн байдлын үндсэн суурь эрх, тиймээс

Хүснэгт 1

№	Тайлангийн эхний үлдэгдэл	хүлээн авсан нэхэмжлэл	Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан тоо	Шийдвэрлэсэн хэрэг	Иргэний хэрэг үүсгэсэн тоо
1	412	4803	902	2940	3901

Хүснэгт 2

№	Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан тоо 65.1	Үүнээс									
		65.1.1	65.1.2	65.1.3	65.1.4	65.1.5	65.1.6	65.1.7	65.1.8	65.1.9	65.1.11
1	902	16	11	12	3	25	12	4	0	184	635

Ч эрх зүйт орнуудын Үндсэн хуулийн цөм үндэс юм.

Манай Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж байгаа үндэслэл нь шударга шүүхээр шүүлгэх хүний эрхийг хөндөж байгаа нэгэн хэлбэр.

Нэхэмжлэл гаргах гэдэг нь иргэн, хуулийн этгээд өөрийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзэж байгаа аливаа этгээд уг эрхээ хамгаалуулахаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу шүүхэд нэхэмжлэл, хүсэлт, гомдол гаргаж буй ажиллагаа.

Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны хүлээн авсан нэхэмжлэлээс харвал,¹⁰

Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх /2020 оны бүтэн жилийн байдлаар/

⁸ Эрх зүйн зарим тунхаг сэдэв эрдэм шинжилгээний илтгэл Б.Золбоо 2018 он

⁹ 1946 оны 12 дугаар сарын 10-нд Ерөнхий Ассамблейн 217 А (III) дугаар тогтоол

¹⁰ Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх

Хүснэгт 3

№	Шүүхийн нэр	/65.1.11/	Үүнээс: Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62 дугаар зүйлийн							
			62.1.1	62.1.2	62.1.3	62.1.4	62.1.5	62.1.6	62.2	62.3
1	ЧДИХАШШ	635	12	9	232	339	14	7	22	0

Эндээс үзэхэд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.4-т "нэхэмжлэлийн үндэслэл, шаардлага, түүнийг нотлох баримт" заасан үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж байна. Нөгөө талаар шүүхэд нэхэмжлэл гаргаж байгаа этгээд өөрийн эрх ашиг сонирхол нь хэрхэн зөрчигдсөн эрхийнхээ үндэслэл шаардлагыг тодорхойлдоггүй, хэнээс юу шаардаад байгаа нь ойлгомжгүй, ямар эрх ашиг нь хэрхэн зөрчигдсөн, түүнийгээ яаж сэргээлгэх, хэнээс юу шаардаж байгаа нь ойлгомжгүй зэрэг нь шүүхэд гаргаж байгаа нэхэмжлэл, холбогдох хууль тогтоомж харагдаж байна.

Нэхэмжлэлийн үндэслэл гэдэг нь нэхэмжлэгчийн шүүхэд хандах болсон бодит нөхцөл ба түүний шаардлага ямар учир шалтгаантай болохыг нэхэмжлэгчийн зүгээс тодорхойлсон байдал нэхэмжлэлийн шаардлага нь тэрхүү үндэслэлд тулгуурлан нэхэмжлэгч шүүхээс юу хүсэж байгааг харуулна.

Нэхэмжлэлийн үндэслэл болон шаардлагаас шүүх шийдвэрлэх гэж буй хэргийн төрлийг тодорхойлох тул үндэслэл нь тодорхой бус эсхүл шаардлага нь ойлгомжгүй нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалздаг.

Ер нь нэхэмжлэлийн үндэслэл болон шаардлага нь тодорхой биш бол иргэний хэрэг үүсгэхгүй. Учир нь иргэний хэрэг үүсгэхэд хэнээс хэн, юун тухай, ямар шаардлага гаргасан болох нь тодорхой байх учиртай юм. Үндэслэл болон шаардлагыг тодруулах боломжгүй байгаа тохиолдолд нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах ёстой.

Нөгөөтэйгүүр нэхэмжлэгч нотлох баримтыг нэхэмжлэлд тусгана гэсэн хуулийн шаардлагыг шүүх буруу тайлбарлан хэрэглэх нь нэлээдгүй байна. Нэхэмжлэлийн үндэслэл болон шаардлагыг нотлох ямар баримт байгааг нэхэмжлэлд тусгах эсэхийг нэхэмжлэлд хавсаргах ёстой гэж шүүх тайлбарлан нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалздаг явдал цөөнгүй. " Гэтэл нотлох баримтыг цуглуулах, бүрдүүлэх хоёр сарын хугацаа олгогдсон байхад нэхэмжлэлд хавсаргаж ирүүлээгүй гэж үзэх үндэслэлгүй юм. Зарим нотлох баримтыг нэхэмжлэлийн хамт шүүхэд ирүүлсэн байж болно. Гэхдээ шаардлагатай бүх баримтыг нэхэмжлэлд хавсаргах боломжгүй юм. Тухайлбал, гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт зэргийг нэхэмжлэгч гаргаж өгөх боломжгүй. Нөгөө талаар нэхэмжлэгч нь хариуцагчийн хариу тайлбарын дараа нотлох баримтыг

" Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар Улаанбаатар хот 2014 он 179 дэх тал

гаргаж өгөх хүсэлтэй ч байж болно.

Нөгөө талаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн шүүгчийн захирамжид улсын тэмдэгтийн хураамжийг буцаан гаргуулах ёстой. Нэхэмжлэлийн бүрдүүлбэрээ хангасны дараа шүүхэд нэхэмжлэлээ гаргахад улсын тэмдэгтийн хураамж дахин төлөх учиргүй.

Нэхэмжлэл гаргаж буй хугацаа, төлбөр төлсөн хугацаа зөрөх, хураамжийн талаар гарсан хүчин төгөлдөр эрхийн актын заалт биелэгдэхгүй зэрэг сөрөг үр дагавар гарах магадлалтай тул зүй нь нэхэмжлэгч хураамжийн төлбөрийг шинээр төлөх ёстой ба түүрүүчийн хураамжийг буцаан авах эсэх нь түүний эрхийн асуудал юм.

Хууль зүйн талаасаа: Монгол Улсын Олон Улсын гэрээ

Хүний эрхийн түгээмэл тунхаглалд тусгагдсан байдал буюу Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 217/A/III/ тогтоолоор 1946 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсуудад уриалжээ. Үүнд Хүний эрхийн түгээмэл тунхаглал тусгасан байдлыг зохицуулалтыг дурьдвал

*Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчилалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй. Хүн бүр энэхүү Тунхаглалд харшлах аливаа алагчилалаас болон тийнхүү алагчилахыг өдөөсөн турхиралтаас адилхан хамгаалуулах эрхтэй*¹².

¹² Хүний эрхийн түгээмэл тунхаглалийн 7 дугаар зүйл

*Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон үндсэн эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй*¹³.

*Хүн бүр тулгасан аливаа эрүүгийн ял болон эрх үүргээ тодорхойлуулахдаа хараат бус, тал хардаггүй шүүхээр бүрэн адил тэгш үндсэн дээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй*¹⁴. Эдгээр эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхдээ Нэгдсэн Үндэстний Байгууллагын зорилго, зарчимтай хэрхэвч зөрчилдүүлж болохгүй¹⁵.

Дүгнэлт, санал

Монгол Улсын хууль, Олон Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзэж байгаа аливаа этгээд уг эрхээ хамгаалуулахаар энэ хуульд заасан журмын дагуу шүүхэд нэхэмжлэл, хүсэлт, гомдол гаргах хэлбэрээр мэдүүлэх эрхийг хэрэгжүүлэх хүрээнд

1. Шүүхээс нэхэмжлэлийг хүлээн авахад саад болж байгаа зөрчлийг хэрхэн засахыг зааж өгөх,
2. Монгол Улсын бүх шатны шүүх болон Татварын албаны хоорондын харилцан хамаарлын уялдаа холбоог сайжруулах,
3. 16 наснаас дээш Монгол Улсын иргэн бүрийг албан ёсны цахим хаягтай болгох

¹³ Хүний эрхийн түгээмэл тунхаглалийн 8 дугаар зүйл

¹⁴ Хүний эрхийн түгээмэл тунхаглалийн 10 дугаар зүйл

¹⁵ Хүний эрхийн түгээмэл тунхаглалийн 29 дугаар зүйлийн 3 дэхь хэсэг

4. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1-д заасан үндэслэлд тодорхой заалтуудад гомдол гаргахад мөн хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.9, 65.1.11-д дэх заалтад тухайн шатны шүүхэд гомдол гаргах
5. Хэргийн оролцогч нарыг шүүхээс албан ёсны утас, факс, олон нийтийн сүлжээ, цахим хаягаар шүүхэд дуудан ирүүлэх тухай мэдэгдсэнийг шүүхээс зарлан дуудах хуудас мэдэгдсэн, мэдсэн гэж үзэх
6. Улсын тэмдэгтийн хураамжийг нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн тохиолдолд дахин нэхэмжлэл гаргахад заавал улсын тэмдэгтийн хураамж шинээр төлсөн байхыг шаардахгүй байх зэрэг асуудлуудаар хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Ашигласан материал

- Монгол Улсын Үндсэн хууль
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
- Хүний эрхийн түгээмэл тунхаглал
- Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль
- 1946 оны 12 дугаар сарын 10-нд Ерөнхий Ассамблейн 217 А (III) дугаар тогтоол
- Эрх зүйн зарим тунхаг эрдэм шинжилгээний илтгэл
- Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар /нэмэлт, өөрчлөлтийн 3 дахь хэвлэл/

ИРГЭНИЙ ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙ ДЭХ ХҮСЭЛТЭЭР ШИЙДВЭРЛЭГДЭХ ХЭРГИЙН АЖИЛЛАГАА, ОНОЛ, АРГА ЗҮЙН АСУУДАЛ

Э.ЗОЛЖАРГАЛ

(Шихихутуг их сургуулийн магистрант)

Түлхүүр үг: Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа, нэхэмжлэл, гомдол, хүсэлт, онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

Онол болон түүнд суурилсан практик хосолж байж тэнд жинхэнэ утгаар эрх зүйт төр оршин тогтнох боломж бүрдэх жамтай. Суурьгүй байшин баригддаггүйтэй адил онолын үндэслэл муутай хууль эрх зүйн аливаа зохицуулалт аливаа асуудлыг бодитойгоор шийдэх боломжоо алдана.

Энэхүү бяцхан оршилд тулгуурлан шүүхээс иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн хэм хэмжээний нийлбэр цогц болох иргэний процессын эрх зүй дахь хүсэлтээр шийдвэрлэгдэх хэргийн ажиллагаа болох онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог, онол болон практикийн зөрүүтэй ойлголт, түүнийг хэрхэн өөрчлөх талаар товчхон өгүүлье.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т *Шүүх дараах үндэслэлээр иргэний хэрэг /цаашид “хэрэг” гэх/ үүсгэж болно* хэмээн заасан. Үүнд:

1. Эдийн ба эдийн бус баялагтай холбоотой эрх нь зөрчигдсөн тухай

эрх зүйн харилцаанд оролцогч этгээдээс гаргасан нэхэмжлэл;

2. Бусдын эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалж шүүхэд мэдүүлэх эрх нь хуулиар олгогдсон этгээдээс гаргасан нэхэмжлэл;
3. Онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлүүлэхээр хуульд заасан асуудлаар сонирхогч этгээдээс гаргасан хүсэлт;
4. Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд зааснаас бусад байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа болон тэдгээрийн гаргасан захиргааны актын талаар гаргасан гомдол;
5. Хуульд заасан бусад үндэслэл¹ зэрэг багтана.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа гэж иргэн, хуулийн этгээдээс зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар шүүхэд нэхэмжлэл, гомдол, хүсэлт гаргах, шүүх түүнийг хүлээн авч хянан шийдвэрлэх цаг хугацаа, үйл явцыг хамарсан ойлголт.

Нэхэмжлэл-Энэ нь хууль болон гэрээний үүргийг биелүүлээгүйгээс өөрт учирсан эдийн ба эдийн бус хохирлоо гэм

¹ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, хоёрдугаар бүлэг, 12 дугаар зүйл, (2002)

буруутай этгээдээс гаргуулахаар шүүхэд хандаж гаргасан эрх зүйн баримт бичиг юм. Нэхэмжлэл нь иргэний хэрэг үүсгэх үндэслэл мөн ба түүнийг нэхэмжлэлээр үүсэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гэнэ.

Гомдол-Захиргааны байгууллага, шүүх, прокурор, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон бусад аж ахуйн нэгж байгууллага тэдгээрийн албан тушаалтны үйл ажиллагаа болон шийдвэр нь бусдын хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзэж, уул эрх ашгаа сэргээлгэхээр шүүхэд хандаж гаргасан баримт бичиг. Гомдлоор авч хэлэлцэх хэргийн субъект нь нэг талд буруу шийдвэр гаргасан төрийн захиргаа, шүүх, прокурор, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон бусад аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн албан тушаалтан, нөгөө талд тэдгээрийн үйл ажиллагаа, буруу шийдвэрийн улмаас хохирсон иргэн, хуулийн этгээд байна.

Хүсэлт-Энэ нь ямар нэгэн эд хөрөнгө нэхэмжлээгүй, иргэн, хуулийн этгээдийн эрх, эрх чөлөө зөрчигдөөгүй, харин эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоолгохоор шүүхэд гаргасан баримт бичиг юм. Хүсэлтээр үүсэх хэргийг онцгой ажиллагааны улмаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гэнэ.²

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны нэг төрөл бол хүсэлтээр үүсэх ажиллагаа буюу онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх хэргүүд юм. Хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагаа гэдэг нь эрх зүйн үйл

явдал болон үйлдлийг шүүхээс тогтоох үйл ажиллагаа юм.

Онцлог нь:

1. Иргэн, хуулийн этгээдээс гаргасан хүсэлтэд үүснэ. Энэхүү хүсэлт нь ямар нэгэн этгээдэд хандаж гаргасан шаардлага биш байдаг. Бас зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох, маргаантай эрхийг хамгаалахыг шаарддаггүй.
2. Хариуцагч байхгүй. Өөрөөр хэлбэл хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагаанд материаллаг эрх зүйн маргаан байдаггүйгээс улбаалан хэрэгт эсрэг сонирхолтой этгээд байхгүй. Гэхдээ хоорондоо зөрүүтэй ашиг сонирхол байхыг үгүйсгэж болохгүй. Хэргийг онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх тухай хүсэлтийг аль нэг иргэн, хуулийн этгээд эсэргүүцэх, тэдгээр нь ашиг сонирхлоо хөндөгдөнө гэж үзэж болох юм. Ийм тохиолдолд эсэргүүцэж, ашиг сонирхлоо хөндөгдөнө гэж үзэж байгаа этгээдийг хуулийн 29 дүгээр зүйлд зааснаар гуравдагч этгээдийн нэгэн адил хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулна. Гуравдагч этгээдээр оролцуулж байгаа этгээдэд шүүхэд мэдүүлэх эрхээ бүрэн эдлэх боломжийг шүүх олгох ёстой.
3. Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдал болон иргэний эрх зүйн байдлыг тогтооно. Энэ нь иргэний эрх зүйн хамгаалалтыг хэрэгжүүлэх нөхцөл бололцоог бий болгодог түүний ач холбогдол оршино³.

² Хууль зүй, дотоод хэргийн яам. (2007), Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, УБ, ВСТ принт, х.31

³ Монгол Улсын Дээд Шүүх. (2007), Иргэний

Онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх хэргүүд:

1. Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоох
2. Хүнийг сураггүй алга болсон тооцох буюу нас барсан гэж зарлах
3. Сэтгэцийн өвчний улмаас хүнийг эрх зүйн чадамжгүй болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэдгийн улмаас хязгаарлагдмал чадамжтай гэж тооцох
4. Хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох
5. Асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцох
6. Эрх олгосон бичиг баримтыг үрэгдүүлснээс алдагдсан эрхийг сэргээх
7. Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд буруу бичигдсэнийг тогтоох
8. Иргэний хэргийн буюу шийдвэр гүйцэтгэлийн үрэгдсэн материалыг сэргээх
9. Нэхэмжлэгчээс гаргасан хүсэлтийн дагуу хариуцагчийг эрэн сурвалжлах
10. Хуулийн этгээдийг дампуурсан⁴ зэрэг болно.

Монгол Улсын шүүхийн 2019 оны 3 дугаар улирлын шүүн таслах ажиллагааны тайлангаас үзвэл анхан шатны шүүх 2019 оны 3 дугаар улиралд

хэрэг шүүхэд хянан тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар, УБ, Интерпресс, х.325

⁴ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, арван гуравдугаар бүлэг, 133 дугаар зүйл, (2002)

нийт 45977 нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авснаас 8517 нэхэмжлэлийг хуульд заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзаж, буцаах, харьяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлэх, татан авах, нэгтгэх зэрэг ажиллагааг хийж, 30501 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, 6959 хэргийн үлдэгдэлтэй байна.

Анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 4756 хэрэг буюу 13.5 хувиар буурсан байна.

Шүүхээр хянан шийдвэрлэсэн нийт 30501 хэргийн 18065 буюу 59.2 хувийг нь ИХШХШТХ-ийн 115 дугаар зүйлээр шийдвэрлэсэн бол 8353 хэрэг буюу 27.4 хувийг ИХШХШТХ-ийн 74 дүгээр зүйлд заасан хялбаршуулсан журмаар, 4083 хэрэг буюу 13.4 хувийг ИХШХШТХ-ийн 117 дугаар зүйлд зааснаар хэрэгсэхгүй болгожээ.

Иргэний хэргийн анхан шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн нийт хэрэгт Иргэний хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 12999 буюу 42.6 хувь, ИХШХШТХ-иар 10721 буюу 35.1 хувь, Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 3178 буюу 10.4 хувь, Хөдөлмөрийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 855 буюу 2.8 хувь, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 301 буюу 1 хувь, Нийгмийн даатгалын багц хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 217 буюу 0.7 хувь, бусад хуулиар шийдвэрлэсэн маргаан 2230 буюу 7.3 хувийг тус тус эзэлжээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар шийдвэрлэсэн хэрэг

өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2925 хэрэг буюу 21.4 хувиар буурсан бөгөөд нийт шийдвэрлэсэн иргэний хэргийн 35.1 хувьтай тэнцэж байна. Задалж үзвэл онцгой ажиллагааны журмаар 8289 хэрэг шийдвэрлэсэн нь ИХШХШТХ-иар шийдвэрлэсэн хэргийн 77.3 хувьтай тэнцэж байна.

Үүнийг нарийвчлан авч үзвэл ажилласан жил тогтоосон 5512 хэрэг, нэхэмжлэгчийн гаргасан хүсэлтийн дагуу хариуцагчийг эрэн сурвалжлах 2777 хэрэг, бусад 2432 хэрэг тус тус эзэлсэн.⁵

Тус үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж үзэх ахул хуулийн 133.1.1, 133.1.9-т тусгалаа олсон эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоох тэр дундаа хүний ажиллаж байсан байдлыг тогтоох түүнчлэн нэхэмжлэгчээс гаргасан хүсэлтийн дагуу хариуцагчийг эрэн сурвалжлах хэрэг дийлэнх хувийг эзэлж байгаа болох нь тодорхой харагдаж байх тул эдгээр заалтуудаас нэхэмжлэгчээс гаргасан хүсэлтийн дагуу хариуцагчийг эрэн сурвалжлах хэмээн эрх зүйн зохицуулалтад сэдвийн хүрээнд жишээ болгон гол анхаарлаа хандуулан авч үзсэн болно.

Нэхэмжлэгчээс гаргасан хүсэлтийн дагуу хариуцагчийг эрэн сурвалжлах:

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 155 дугаар зүйл. *Иргэний эрх зүйн маргаанд хариуцагчаар оролцвол зохих этгээд оршин суугаа газар нь мэдэгдэхгүй бол түүнийг эрэн сурвалжлуулах тухай хүсэлтийг шүүхэд гаргаж болно, энэ хуулийн 155.1-д заасан хүсэлт гаргагч өөрийн оршин*

суугаа газрын шүүхэд гаргана, хүсэлтэд хариуцагчаар оролцвол зохих этгээдийг эрэн сурвалжлуулах үндэслэлийг тодорхойлж, түүний оршин байгаа газрыг олж тогтооход ач холбогдол бүхий бичиг баримтыг боломжтой бол хавсаргана. Шүүх хүсэлтийг хүлээн авч эрэн сурвалжлах тухай шийдвэр гаргана, хариуцагчаар оролцвол зохих этгээдийг эрэн сурвалжлах, түүний оршин суугаа газрыг тогтоох ажиллагааг шүүхийн шийдвэрийн дагуу цагдаагийн байгууллага гүйцэтгэнэ⁶ хэмээн тус тус заасан.

Тус эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийж үзье.

1. Иргэний эрх зүйн маргаанд хариуцагчаар оролцвол зохих этгээд оршин суугаа газар нь мэдэгдэхгүй бол түүнийг эрэн сурвалжлуулах тухай хүсэлтийг шүүхэд гаргаж болно.

Мөн хуулийн 26 дугаар зүйлийн 26.3. *Хариуцагч гэж нэхэмжлэгчийн эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд хохирол учруулсан буюу үүргээ биелүүлээгүй, эсхүл зохих ёсоор биелүүлээгүй гэж нэхэмжлэлд дурдсан этгээдийг хэлнэ. Хариуцагч нь нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх буюу хүлээн зөвшөөрөхөөс татгалзах, сөрөг нэхэмжлэл гаргах, эвлэрэх эрхтэй, 62 дугаар зүйлийн 62.1.2. Нэхэмжлэгчийн овог, эцгийн нэр, нэр, хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, оршин байгаа газрыг нэхэмжлэлд тусгасан байна, 62.3.*

⁶ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, хоёрдугаар бүлэг, 155 дугаар зүйл, (2002)

⁵ judinstitute.mn

Нэхэмжлэлийн хариуцагчийн тоогоор хувилж өгнө, 65.1.9. Хариуцагчийн хаяг тодорхойгүй бол шүүгч захирамж гарган нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана хэмээн тус тус заасан.

Хэд хэдэн шүүхийн шийдвэрийг авч үзвэл:

Шүүхийн шийдвэр 1.⁷

Хүсэлт гаргагч: Баянгол дүүргийн 20 дугаар хороо, үйлдвэрийн бүс А2 үйлдвэрийн байранд байрлах хуулийн этгээд 5.....9 тоот регистрийн дугаартай А2 бетон зуурмаг ХХК

Хүсэлтийн агуулга: Манай компани А ХХК-д холбогдуулан бэлтгэн нийлүүлсэн зуурмагийн үлдэгдэл төлбөр болох 103.920.475 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлийг Сүхбаатар дүүргийн шүүхэд гаргасан боловч тус компани Сүхбаатар дүүрэгт байрладаггүй, хаяг тодорхойгүй гэсэн үндэслэлээр 2016 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн дугаар 181/ШШ2016/05177 шүүгчийн захирамжаар хэрэгсэхгүй болгосон.

Гэтэл тус компанийн захирал Ё.П нь А ХХК-г өөрийн төрсөн дүү Ё.О-т шилжүүлсэн байх бөгөөд Ё.О нь Хан-Уул дүүргийнхороо, гудамжнытоотод оршин суудаг боловч манай компани энд байдаггүй гэсэн шалтгаанаар шүүхийн мэдэгдэх хуудсыг хүлээн авахаас татгалзсан. Үүнээс шалтгаалан манай компани 103 сая төгрөгөө нэхэмжлэх боломжгүй байгаа тул А ХХК-ийн хаягийг тодруулах шаардлагатай болсон.

Ё.О-н утас бөгөөд Ё.П нь шүүх

⁷ new.shuukh.mn

цагдаагийн асуудлаас шалтгаалан түр хугацаагаар компаниа шилжүүлсэн бөгөөд Ё.П-ийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны Баянзүрх дүүргийн шийдвэр гүйцэтгэгч А.С дээр явагдаж байгаа болно.

Иймд тус компанийн хаягийг тогтоолгох тухай хүсэлтийг хүлээн авч өгнө үү.

Шүүхээс гарсан шийдвэр: А ХХК болон тус компанийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг эрэн сурвалжилж, оршин суугаа болон үйл ажиллагаа явуулж буй газрыг тогтоох ажиллагааг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай 155 дугаар зүйлийн 155.4 дэх хэсэгт зааснаар Цагдаагийн ерөнхий газар, Мөрдөн байцаах газрын эрэн сурвалжлах хэлтэс гүйцэтгэнэ. А ХХК-н захирал гэх Ё.О-н РД:, мөн тэрээрдугаар эзэмшдэг болохыг дурдсугай.

Шүүхийн шийдвэр 2⁸.

Хүсэлт гаргагч: Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороо, Энх тайвны өргөн чөлөө 19 хаягт байрлах, "Худалдаа хөгжлийн банк" ХХК

Хүсэлтийн агуулга: Иргэн Д.Х нь тус банктай 2014 оны 05 дугаар сарын 16-ны өдөр № 2014/000375/0254-н тоот "Цалингийн зээлийн гэрээ" ба "Цалингийн зээлийн барьцааны гэрээ"-г байгуулан 3.000.000 төгрөгийг сарын 1.5 хувийн хүүтэй, 24 сарын хугацаатай зээлж авсан билээ. Зээлдэгч Д.Х нь зээл авснаас хойш оршин суугаа хаягаа өөрчилж, хаана байгаа нь тодорхойгүй болсон бөгөөд зээлийн гэрээгээр

⁸ shuukh.mn

хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс зээл, зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүүгийн төлбөрт өнөөдрийн байдлаар 1.025.966.01 төгрөгийн үлдэгдэлтэй байна. Зээлдэгчийн бүртгэлтэй хаяг болох Сонгино хайрхан дүүрэг, 6 дугаар хороо, Тоосгоны 34 дүгээр гудамж, 05а тоот хаягаар шүүхэд нэхэмжлэл гаргасан боловч Сонгино хайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 05987 дугаар захирамжаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан. Иймд зээлдэгч Д.Х-н оршин суугаа хаяг, холбоо барих утас тодорхойгүй байх тул Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5, 155 дугаар зүйлд заасны дагуу эрэн сурвалжилж, оршин суугаа хаягийг нь тогтоож өгнө үү гэжээ.

Шүүхээс гарсан шийдвэр: Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 155.1, 155.4-т иргэний эрх зүйн маргаанд хариуцагчаар оролцвол зохих этгээд оршин суугаа газар нь мэдэгдэхгүй бол түүнийг эрэн сурвалжлуулах тухай хүсэлтийг гаргаж болно, хариуцагчаар оролцвол зохих этгээдийг эрэн сурвалжлах, түүний оршин суугаа газрыг тогтоох ажиллагааг шүүхийн шийдвэрийн дагуу цагдаагийн байгууллага гүйцэтгэнэ гэж заасан байна. Иймд Д.Х-г эрэн сурвалжилж, оршин суугаа хаягийг нь тогтоох ажиллагааг Цагдаагийн байгууллагаар гүйцэтгүүлэх нь зүйтэй гэж үзэв.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай 133 дугаар зүйлийн 133.1.9 дэх хэсэгт зааснаар хариуцагчаар оролцвол зохих этгээд болох Д.Х-г

эрэн сурвалжилсугай. Хариуцагч болох Боржигон овогт Д.Х-ийн оршин суугаа газрын хаягийг тогтоох ажиллагааг хийж гүйцэтгэхийг Сонгино хайрхан дүүргийн Цагдаагийн 2-р хэлтэст даалгасугай.

Эндээс: Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн харилцаанд оролцогч гэдэгт тухайн эрх зүйн харилцаанд оролцож эрх эдэлж, үүрэг хүлээж буй аливаа этгээдийг ойлгох бөгөөд үүнд иргэн, хуулийн этгээд, төр хамаарна.

Дээр дурдсан эрх зүйн зохицуулалтаас үзвэл иргэний эрх зүйн маргаанд хариуцагчаар оролцвол зохих этгээд оршин суугаа газар нь мэдэгдэхгүй бол түүнийг эрэн сурвалжлуулах тухай хүсэлтийг шүүхэд гаргаж болно хэмээн хуульчлагдсан байх бөгөөд эрх зүйн зохицуулалтад агуулагдсан гол гипотез нь эрх зүйн маргаанд хариуцагчаар оролцвол зохих этгээд оршин суугаа газар нь мэдэгдэхгүй бол хэмээх нөхцөл юм.

Оршин суугаа газар гэх эл ойлголт нь Иргэний хуулийн 22 дугаар зүйлд тусгалаа олсноор иргэнтэй холбоотой ойлголт бөгөөд мөн зүйлд зааснаар Иргэний оршин суугаа газрыг хуулийн дагуу түүний харьяалагдан бүртгүүлсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр тодорхойлно, Иргэн бүртгүүлсэн газраа байнга оршин суудаггүй бол гол төлөв амьдран суудаг, эсхүл тухайн этгээдийн эд хөрөнгийн дийлэнх хэсэг байгаа газрыг түүний оршин суугаа газар гэж тодорхойлж болно, Бусдын асран хамгаалалтад байгаа этгээдийн оршин суугаа газрыг тэдгээрийн эцэг, эх, асран

хамгаалагчийн оршин суугаа газраар тодорхойлно хэмээн заасан.

Иргэний оршин суугаа газар гэдэг нь эрх зүйн ач холбогдлын хувьд иргэний эрх зүйн харилцааны тогтвортой байдлыг хангах, төрийн ашиг сонирхол болон иргэний эрх, ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн ба зориулагдсан нэг чухал ойлголт юм. Энэ байдал нь эрх зүйн шинж чанартай янз бүрийн асуудлыг шийдэхэд практик ач холбогдолтой. Үүнд: үүргийн харилцаанд үүрэг гүйцэтгэх газрыг тодорхойлох, өв нээгдэх газар, нэхэмжлэл гаргах, шүүхийн шийдвэр биелүүлэх газар, иргэнийг сураггүй алга болсонд тооцох, иргэнийг нас барснаар зарлахад шаардагдах хууль зүйн фактыг тогтоох зэрэг.

Иргэний оршин суух газрыг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүртгэлээр тодорхойлох нь ерөнхий журам бөгөөд энэ нийтлэг болон ерөнхий журмаас гадуур иргэний оршин суугаа газрыг тодорхойлох боломжийг энэ хуулиар зохицуулсан байна. Ерөнхий журмын дагуу иргэн нэг л оршин суух газартай байна. Иргэн оршин суугаа газраа байнга амьдардаггүй, өөр газар амьдран суудаг тохиолдолд түүний амьдран суух газрыг тодорхойлох бөгөөд энэ нь хууль зүйн ач холбогдолтой.⁹

Харин хуулийн этгээдийн хувьд оршин байгаа газар гэх ойлголт байх бөгөөд мөн хуулийн 28.1.Хуулийн этгээдийн ерөнхий захиргаа байршин байгаа газрыг түүний оршин байгаа газар гэнэ,

⁹ Наранчимэг,Д. Баярмаа Н нар (2010) Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар, Улаанбаатар хот, х.39

28.2.Хуулийн этгээд нь оршин байх нэг газар буюу хууль ёсны хаягтай байна хэмээн заасан байна.

Монгол Улсын Ардын багш, эрдэмтэн Бираагийн Чимэд агсан Үндэсний шуудан сонинд 2013 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр өгсөн ярилцлагадаа: Хуульд үг нь байтугай, таслал нь утгатай байдаг юм хэмээн нэгэнтээ хэлсэн байдаг бөгөөд энэхүү үгнээс иш үндэс аван дүгнэн үзэх ахул Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 155.1.Иргэний эрх зүйн маргаанд хариуцагчаар оролцвол зохих этгээд **оршин суугаа газар нь мэдэгдэхгүй бол** түүнийг эрэн сурвалжлуулах тухай хүсэлтийг шүүхэд гаргаж болно хэмээх эрх зүйн зохицуулалтад эсхүл оршин байгаа газар мэдэгдэхгүй бол гэх үг өгүүлбэр байхгүй байснаараа хүсэлт гаргагчийн хувьд хуулийн этгээдийн оршин байгаа газар нь мэдэгдэхгүй байх тохиолдолд хүсэлтээ шүүхэд гаргах хууль зүйн боломжгүй байдлыг үүсгэж байна.

Өөрөөр хэлбэл, тус эрх зүйн зохицуулалтад Иргэний эрх зүйн маргаанд хариуцагчаар оролцвол зохих этгээдийн оршин суугаа газар, байгаа газар нь мэдэгдэхгүй бол түүнийг эрэн сурвалжлуулах тухай хүсэлтийг шүүхэд гаргаж болно хэмээх нь зүйтэй юм.

Хүсэлтэд хариуцагчаар оролцвол зохих этгээдийг эрэн сурвалжлуулах үндэслэлийг тодорхойлж, түүний оршин байгаа газрыг олж тогтооход ач холбогдол бүхий бичиг баримтыг боломжтой бол хавсаргана. Шүүх хүсэлтийг хүлээн авч эрэн сурвалжлах

тухай шийдвэр гаргана.

Түүнчлэн уг эрх зүйн зохицуулалтад:

Эрэн сурвалжлуулах үндэслэлийг тодорхойлох: Үндэслэл гэдэг нь Монгол хэлний тайлбар тольд дурдсанаар уламжлал, иш, батлах нотлох зүйл¹⁰ гэх ойлголт. Эндээс үзвэл хүсэлт гаргагчийн хувьд хэрэгт хариуцагчаар оролцвол зохих этгээдийг эрэн сурвалжлуулах үндэслэлийг тодорхойлно гэдэг нь нэг талаар өмнө нь энэ талаар шүүхийн байгууллагад хандаж асуудал шийдэгдээгүй байх, түүнчлэн шүүхэд хандаагүй ч боломжит бүх арга хэлбэрээр хариуцагчийн оршин суугаа эсхүл оршин байгаа газрыг олж тогтоох бүхий л идэвхтэй үйлдэл хэрэгжүүлсэн байх явдал юм.

Хариуцагчийн оршин суугаа эсхүл оршин байгаа газрыг олж тогтооход ач холбогдол бүхий бичиг баримтыг боломжтой бол хавсаргана. Тус эрх зүйн зохицуулалтаас үзвэл боломжгүй бол хариуцагчийг эрэн сурвалжлах хүсэлтэд мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-т тусгалаа олсон хэргийн оролцогчоос өөрийн шаардлага ба татгалзлаа үндэслэж байгаа, шүүх хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, хуульд заасан арга хэрэгслээр олж авсан бодит нөхцөл байдлыг тогтооход шаардлагатай аливаа баримтат мэдээлэл болох нотлох баримтыг заавал хавсаргах шаардлагагүй болох нь тодорхой харагдаж байна. Өөрөөр хэлбэл хүсэлт гаргагч холбогдох нотлох баримтыг цуглуулж өгөөгүй тохиолдолд шүүх хүсэлтийг шийдвэрлэхэд шаардлагатай нотлох баримтыг өөрийн санаачлагаар

¹⁰ <https://mongoltoli.mn/dictionary/detail/100521>

бүрдүүлэх ёстой болно. Энэ талаар Монгол Улсын Дээд Шүүхийн 2016 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн дугаар 4 зөвлөмж “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан зарим ажиллагааны талаар” -ийн 2.4-т *Хариуцагчаар оролцвол зохих этгээдийг эрэн сурвалжлуулах үндэслэлийг тодорхойлж, түүний оршин байгаа газрыг олж тогтооход ач холбогдол бүхий бичиг баримтыг хүсэлт гаргагч шүүхэд ирүүлж болох талаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 155 дугаар зүйлд заасан хэдий ч нотлох баримтыг шүүх өөрийн санаачлагаар бүрдүүлж шийдвэр гаргах нь мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-т нийцнэ. Шүүх хүсэлтийн дагуу ажиллагаа явуулж “хариуцагчийг эрэн сурвалжлах” эсхүл “хүсэлтийг хэрэгсэхгүй болгох” тухай шийдвэрийн аль нэгийг гаргана. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 18 дахь хэсэгт зааснаар Монгол Улсын иргэн нь улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй тул “...хариуцагчаар оролцвол зохих этгээдийн оршин суугаа газар нь мэдэгдэхгүй...” байгаа нь баримтаар тогтоогдсон байхыг шаардана.* ¹¹

Шүүх хүсэлтийг хүлээн авч хариуцагчийг эрэн сурвалжлах тухай хүсэлт гаргана.

Өмнөх шүүхийн шийдвэрүүдээс авч үзвэл хүсэлт гаргагчид нь хариуцагчийг эрэн сурвалжлуулах талаар хүсэлтээ гаргахаас урьд өөрийн мэдэж байсан хариуцагчийн хаягаар холбогдох

¹¹ <http://www.supremecourt.mn/act/view/235>

шүүхэд нэхэмжлэлээ гаргаж улмаар хариуцагчийн хаяг тодорхойгүй гэсэн үндэслэлээр шүүхээс нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан байна.

Энэ тохиолдлоос үзвэл нэг асуулт урган гарч байна. Хүсэлт гаргагч хүсэлтээ гаргахын урьд заавал мэдэх хаягаараа дамжуулан шүүхэд нэхэмжлэл гаргах ёстой гэх асуулт болно.

Шүүхийн шийдвэрийн цахим санд авагдсан онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэгдсэн хэд хэдэн шүүхийн шийдвэрийг түүврийн аргаар авч үзвэл хүсэлт гаргагчдын хувьд хариуцагчийг эрэн сурвалжлуулах талаар хүсэлтээ гаргахаас урьд өөрийн мэдэж байсан хариуцагчийн хаягаар холбогдох шүүхэд нэхэмжлэлээ гаргаж улмаар хариуцагчийн хаяг тодорхойгүй гэсэн үндэслэлээр шүүхээс нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шийдвэр гарсны дараа өөрийн оршин суугаа газрын шүүхэд хандан хариуцагчийг эрэн сурвалжлуулах хүсэлтээ өгсөн нь харагдаж байна.

Мөн хуулийн 155.1. Иргэний эрх зүйн маргаанд хариуцагчаар оролцвол зохих этгээд оршин суугаа газар нь мэдэгдэхгүй бол түүнийг эрэн сурвалжлуулах тухай хүсэлтийг шүүхэд гаргаж болно, 155.3-т Хүсэлтэд хариуцагчаар оролцвол зохих этгээдийг эрэн сурвалжлуулах үндэслэлийг тодорхойлж, түүний оршин байгаа газрыг олж тогтооход ач холбогдол бүхий бичиг баримтыг боломжтой бол хавсаргана. Шүүх хүсэлтийг хүлээн авч эрэн сурвалжлах тухай шийдвэр гаргана хэмээн тус тус заасан.

Иргэний эрх зүйн маргаанд хариуцагчаар оролцвол зохих этгээд оршин суугаа газар нь мэдэгдэхгүй бол гэх эл гипотезээс авч үзвэл мөн асуудлаар урьд заавал нэхэмжлэл гаргахыг шаардахгүй байна.

Гэвч практикт уг хүсэлтийг гаргахад шүүхийн хувьд заавал тухайн асуудлаар шийдвэр гарсан байхыг шаарддаг бөгөөд үүнийг хариуцагчаар оролцвол зохих этгээд эрэн сурвалжлах үндэслэл байгааг тогтоохын тулд гэсэн агуулгаар илэрхийлэгдэнэ.

Энэ нь онол болон практикийн зарчмын зөрүү үүссэн болохыг харуулж байна.

Эндээс: Онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэгдэх хэргүүдийн нэг төрөл болох практикт хамгийн ихээр үүсч буй нэхэмжлэгчийн хүсэлтээр гэдэг эл ойлголт байгаа шалтгаан нь манай улсын хувьд иргэн, хуулийн этгээдүүд хаягтаа байхгүй эсхүл үйл ажиллагаа явуулдаггүйтэй бахтай холбоотой.

Монгол Улсын иргэн хэн боловч Үндсэн хуульд заасны дагуу оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй тиймээс эрх зүйн харилцаанд орсон тохиолдолд иргэний хаяг адресс нь тодорхой байх бүртгэлийн системийг орчин үеийн дэвшилтэт технологийг ашиглан бүрэн бүрдүүлэх шаардлагатай байна.

ХЭРЭГ БҮРТГЭЛТ ТҮҮНД ТАВИХ ПРОКУРОРЫН ХЯНАЛТЫГ ШИНЭЭР АВЧ ҮЗЭХ НЬ

Г.ТҮВШИНБААТАР

(Шихихутуг их сургуулийн магистрант)

2002 оны ЭБШ хуульд хөнгөн, зарим хүндэвтэр гэмт хэргийн тухай гомдол, мэдээллийг хүлээн авч, шалгах улмаар эрүүгийн хэрэг үүсгэн нотлогдвол зохих байдлуудыг тогтоон прокурорт яллагдагчаар татсан тогтоолыг батлуулах хүртэлх бие даасан процессын үе шатыг хэрэг бүртгэлт гэж нэрлэж байв.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн зорилго, чиглэл нь:

- Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх явдлаас урьдчилан сэргийлэх
- Гэмт хэргийн тухай гомдол, мэдээллийг хүлээн авч бүртгэх шуурхай шалгах ингэснээр гэмт хэргийн илрүүлэлтийг ахиулж, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хангах
- Гэмт хэргийн тухай гомдол мэдээллийг шалгах явцад цуглуулсан баримт сэлт, мэдээлэл нь ЭХХШ ажиллагааны явцад нотлох баримт болгон бэхжүүлэх
- Шүүхийн өмнөх шатны бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг шалгах хугацаанд хохирогчийн хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалах
- Гүйцэтгэх ажлын шугамаар явуулсан тодорхой ажиллагааны журмыг

чанд баримтлах, эрүүгийн эрэн сурвалжлах явцад цугларсан баримт сэлт, мэдээлэл нотлох баримтын хэмжээнд үнэлэх

Хэдийгээр ЭБШ хуулийн зорилтод заан тодорхойлсны дагуу мөрдөн байцаалтын үе шаттай нягт холбоотой үйл ажиллагаа явуулахыг эрхэмлэж байсан боловч бүтэц, зохион байгуулалт, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд нэлээдгүй бэрхшээл хэрэг бүртгэлтэнд тулгарч байсан юм.

Иймээс бие даасан ажиллагаанд зарим өөрчлөлт оруулах шаардлага үүссэн билээ.

ЭХХШ тухай шинэ хуулиар мөрдөгч гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох зорилгоор гэмт хэргийн талаархи гомдол, мэдээлэл хүлээн авснаас эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах хүртэл явуулж байгаа энэ хуульд заасан ажиллагааг хэрэг бүртгэлт гэнэ.

Иймээс “мөрдөгч” гэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хуульд заасан эрх, үүргийн дагуу, эсхүл прокурорын даалгавраар энэ хуулиар харьяалуулсан эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулна уг хуульд тодорхойлжээ.

Хэрэг бүртгэлт нь тухайн гэмт хэргийн тухай гомдол мэдээлэл мөн эсэх, түүнийг

хэн үйлдсэн талаар мөрдөгч эрх зүйн зохицуулалтын хүрээнд мөрдөн шалгах ажиллагаа явуулна. Үүнд:

- Мөрдөгч бие даан явуулах
- Прокурорын зөвшөөрөлтэй явуулах мөрдөн шалгах ажиллагаа
- Түүнчлэн шүүхийн зөвшөөрөл авах мөрдөн шалгах ажиллагааг тусгайлан авч үзэх нь зүйтэй.

Учир нь дээрх 2 ажиллагааны аль алинд нь үндсэн хуулийн баталгаат халдашгүй эрхийг хязгаарлах нөхцөл, шаардлага тулгарч болно.

Хэрэг бүртгэлтийн явцад “сэжигтэн” эрх зүйн харилцааны гол объект байх төдийгүй мөрдөгч аливаа гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг шууд сэжигтнээр тооцохгүйгээс гадна, албадлагын шинжтэй таслан сэргийлэх арга хэмжээ авах эрх зүйн зохицуулалтгүй.

2002 оны ЭБШ хуульд заасан гэмт хэргийн талаар гүйцэтгэх ажлын шугамаар авагдаж, баримтжуулагдсан баримт байгаа тохиолдлыг ЭХХШТ хуульд гэмт хэргийн шинжийг мөрдөгч шууд илрүүлсэн агуулгад багтааж нэгтгэн томъёолжээ.

Харин ЭХХШ тухай хуулиар дараах тохиолдолд гэмт хэргийн талаархи мэдээллийг төлбөртэй авах эсэхийг мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагын дарга шийдвэрлэхээр тусгасан. Үүнд:

- Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгаа, завдсан, эсхүл үйлдсэн тухай болон эрэн сурвалжлагдаж байгаа хүн,

эд зүйл, тээврийн хэрэгсэл, баримт бичгийн тухай мэдээллийг төлбөртэй авахаар нийтэд зарласан

- Хувь хүн, хуулийн этгээдээс хүсэлт тавьсан

Мөрдөгч, прокурор гэмт хэрэг үйлдсэн, үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай гомдол, мэдээллийг хүлээн авах үүрэгтэй.

Мэдээллийг хүлээн авахдаа санаатайгаар худал мэдээлбэл хуульд заасан хариуцлага хүлээлгэхийг мэдээлэл өгөгчид сануулна.

Гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзсан тохиолдолд тухайн гомдол гаргасан, мэдээлэл өгсөн хүн ЭХХШТ хуулийн Арван тавдугаар бүлэгт заасан журмын дагуу гомдол гаргаж болно.

ЭХХШТ хуульд **“мөрдөн шалгах ажиллагаа”** гэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад прокурорын зөвшөөрлөөр, эсхүл мөрдөгч бие даан явуулах энэ хуульд заасан ажиллагааг ойлгоно гэснийг дээр дурдсан билээ.

Мөрдөгч гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг хүлээн авснаас хойш тав хоногийн дотор прокурор, шүүхийн зөвшөөрөлгүй бие даан явуулах мөрдөн шалгах ажиллагаанаас гадна дараах **хойшлуулшгүй мөрдөн шалгах ажиллагааг** ЭХХШТ хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулна. Үүнд:

- үзлэг хийх;
- шинжилгээнд зориулж дээж, хурууны хээ, ул мөрний хэв авах;
- мэдүүлэг авах;

- хэрэгт ач холбогдол бүхий тээврийн хэрэгсэл, мөнгө, эд зүйлийг хурааж авах;
- эд хөрөнгийг битүүмжлэх.

Гэмт хэргийн тухай гомдол, мэдээллийг шалгах ажиллагааны талаар 2002 ЭБШ хуультай харьцуулахад дараах онцлогтой байна. Үүнд:

- Гэмт хэргийн тухай өргөдөл, гомдол мэдээллийг шалгаж эрүүгийн хэрэг үүсгэх эсэхийг 5, нийт 19 хоногийн дотор шийдвэрлэдэг байсан бол ЭХХШТ хуулиар гагцхүү гэмт хэргийн шинж байгаа эсэхийг тогтооход 5 хоногийн хугацаа олгогдсон нь гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэл нэг бүрийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээн шалгах боломжийг олгосон байна.
- Иргэдээс тайлбар авах, гаргуулах зэрэг хойшлуулшгүй ажиллагаа явуулсны дараахь эрүүгийн хэрэг үүсгэж дахин хэргийн оролцогчоор тогтоон, мэдүүлэг авах нь чирэгдэл үүсгэдэг байсныг халж анхнаас хууль сануулан мэдүүлэг авснаар шүүхийн шатанд нотлох баримтаар үнэлэгдэх боломжийг бүрдүүлжээ.

Аливаа газар нутаг, үйл ажиллагааны онцлогоор гэмт хэргийн үл мөр, эд мөрийн баримтыг хамгаалах, гэмт хэрэг үйлдсэн хүн хуулийн этгээдийг олж тогтоох зорилгоор мөрдөгчөөс гадна ЭХХШ тухай хуульд заасан эрх бүхий албан тушаалтанд хойшлуулшгүй хойшлуулшгүй мөрдөн шалгах ажиллагаа явуулах үүрэг олгогдсон.

Энэ хүрээнд гагцхүү хуульд

зөвшөөрөгдсөн мөрдөн шалгах ажиллагааг дараах эрх бүхий албан тушаалтан хойшлуулшгүй тохиолдолд явуулж, прокурорт даруй шилжүүлэх үүрэг хүлээсэн байна. Үүнд:

- гомдол, мэдээллийг шалгах явцад гэмт хэрэг үйлдэж байгаа болон үйлдсэн тухай үндэслэлтэй сэжиг байгаа тохиолдолд мөрдөгч, тагнуул, авилгатай тэмцэх, цагдаагийн байгууллагын алба хаагч;
- Монгол Улсын хилийн гадна байгаа тус улсын усан онгоц, агаарын хөлөг аялж яваа үед гарсан гэмт хэрэгт усан онгоцны ахмад, агаарын хөлгийн багийн дарга;
- Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын эзэмшил нутагт гарсан гэмт хэрэгт тухайн Дипломат төлөөлөгчийн газрын консулын асуудал эрхэлсэн ажилтан;
- хорих ангийн харьяа нутаг дэвсгэрт хоригдлын үйлдсэн гэмт хэрэгт хорих ангийн дарга, дэд дарга;
- зэвсэгт хүчний анги, байгууллагын нутаг дэвсгэрт цэргийн албан хаагчийн үйлдсэн гэмт хэрэгт тухайн зэвсэгт хүчний анги, байгууллагын захирагч;
- хилийн бүсэд гарсан гэмт хэрэгт хил хамгаалах байгууллагын эрх бүхий албан тушаалтан;
- цэргийн албан хаагч энхийг дэмжих, олон улсын бусад ажиллагаанд оролцох явцад тэдний хооронд үйлдсэн гэмт хэрэгт тухайн цэргийн багийн эрх бүхий албан тушаалтан;

- гаалийн хяналт, шалгалтын явцад илэрсэн гэмт хэрэгт гаалийн улсын байцаагч.

ЭХХШТ хуульд “хойшлуулшгүй тохиолдол” гэж хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах, сэжигтэн, яллагдагч оргон зайлах, хэргийн ул мөр, эд мөрийн баримт устах, зөөвөрлөх, нуун далдлах, үрэгдэх бодит аюул байгааг ойлгоно гэж заажээ.

ЭХХШТ хуулиар мөрдөгч хуулиар харьяаллуулсан гэмт хэргийн тухай гомдол, мэдээллийг хүлээн авангуут нэн даруй, эсхүл хуульд заасан мөрдөн шалгах ажиллагаа явуулсны эцэст дараах шийдвэрүүдийн аль нэгийг гаргана. Үүнд:

- Хэрэг бүртгэлтийн хэрэг нээх
- Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах санал гаргах
- Гэмт хэргийн тухай гомдол мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэх санал гаргах

Энэ ч утгаар мөрдөгч хуулиар харьяаллуулсан гэмт хэргийн тухай гомдол, мэдээллийг хүлээн авч хянаж даруй, гэмт хэргийн шинжтэй бол хэрэг бүртгэлтийн хэрэг нээх тогтоолыг бие даан гаргана.

Харин хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах эсхүл харьяаллын дагуу шилжүүлэх саналтай прокуророор шийдвэрлүүлнэ.

Харин эрх бүхий бусад албан тушаалтнууд хойшлуулшгүй тохиолдолд мөрдөн шалгах тодорхой ажиллагаа

явуулж, шийдвэр гаргуулахаар харьяаллын дагуу прокурорт саналаа нэн даруй хүргүүлнэ.

Хэрэг бүртгэлтийн явцад хийгдэх мөрдөн шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналт нь тодорхой чиглэл, хэлбэрүүдтэй. Тухайбал:

Хэрэг бүртгэлтийн үе шатан дахь мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа байгууллагын эрх бүхий албан тушаалтнуудаас хуулийг хэрхэн биелүүлж байгаад чиглэдэг.

Хэрэг бүртгэх үе шатан дахь мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа байгууллага албан тушаалтнуудаас хүний эрх, эрх чөлөөг хөндсөн үйлдлийг гаргуулахгүйн тулд прокурор юуны өмнө уг ажиллагаанд хяналт тавих бөгөөд хууль ёсыг сахин биелүүлэхэд анхаарлаа чиглүүлдэг.

Ингэхдээ прокурорын эсэргүүцэл, мэдэгдэл, зарим тохиолдолд тогтоол гаргах замаар эрүүгийн хэрэг бүртгэлтэнд мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа албан тушаалтны хууль зөрчиж олж авсан нотлох баримтыг хүчингүй болгуулах, зөвтгөх, тэдгээрийн үйл ажиллагаанд оршиж буй хууль бус явдал, түүнд нөлөөлсөн шалтгаан, нөхцлийг арилгуулах¹, хууль бус үйлдлийг зогсоох, залруулах, албан тушаалтны хууль бус үйлдэлд нь сахилгын болон захиргааны арга хэмжээ тооцуулахаар цаашдын үйл ажиллагаанд санамж болох эрх зүйн хэрэгслүүдийг ашигладаг юм.

¹ Прокурорын хяналт /эмхтгэл/ УБ, 1974 он, 98-р тал

Прокурор нь иргэд, байгууллагаас ирүүлсэн гэмт хэргийн гомдол, мэдээлэл, хяналтын явцад илэрсэн зөрчил, дээд шатны байгууллагын даалгавраар хийсэн шалгалт, мөн тухайн байгууллагаас өөрөө санаачлан явуулж буй шалгалтын үр дүнд хяналтын хэрэгсэл болсон эрх зүйн актыг үйлдэнэ.

Прокурор хэрэг бүртгэлтийн үе шатанд дахь мөрдөн шалгах ажиллагаанд тавих хяналтын үндсэн хэлбэр нь мөрдөгч хүний эрх, эрх чөлөөг хязгаарлаж зөрчиж байгаа эсэх мөн хууль тогтоомжийн дагуу явагдаж буй эсэхийг хянах шалгалт билээ.

Зөрчлийн хэрэг бүртгэлтийн шатанд мөрдөн шалгах ажиллагаанууд хууль тогтоомжийн дагуу явагдаж буй эсэхийг хянаж мөрдөн шалгах ажиллагааны явцад шүүхийн зөвшөөрөлгүй хууль бусаар саатуулагдсан этгээдийг нэн даруй суллах, хууль зөрчиж мөрдөн шалгах ажиллагаа явуулж олж авсан нотлох баримтыг хүчингүй болгуулах буюу зөвтгүүлэхээр эсэргүүцэл бичих, хууль бус явдал, түүнд нөлөөлсөн шалтгаан нөхцлийг арилгуулахын тулд мэдэгдэл бичих зэрэг прокурорын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг юм.

Хяналтын чиг үүргээ амжилттай биелүүлэх боломжийг прокурорт олгохын тулд аль ч нийгмийн үед үйл ажиллагаагаа хэвийн явуулах зайлшгүй шаардлагатай бүрэн эрхийг төрөөс олгодог ч оршино². Гэхдээ прокурорт хууль бус юмуу үндэслэлгүй гэж үзэж буй бусад мөрдөн шалгах ажиллагаа буюу гүйцэтгэх ажлаар олж авсан мэдээ

баримтыг нотлох баримтаар тооцохгүй байх, нотлох баримтаас хасуулах хүртэл эрхийг хуулиар олгожээ.

Эрүүгийн хэрэг дээр гарсан прокурорын тогтоолыг эрүүгийн мөрдөн шалгах байгууллага заавал биелүүлнэ. Тиймээс олон улсын жишгээр прокурорын туслах хэмээн нэрлэдэг³.

Хэрэг бүртгэлтийн үе шатанд хийгдэж буй мөрдөн шалгах ажиллагаанууд нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн заалт, шаардлагыг ягштал биелүүлж байгаа эсэхээс хамаарч хүний эрх, эрх чөлөө хэрхэн хангагдаж байгаа нь шалтгаалдаг тул прокурор уг ажиллагаанд хяналт тавьж байгаа нь хүний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөхөөс урьдчилан хамгаалж байгаа баталгаа болж байгаа юм. Иймд прокурорын байгууллага нэг талаараа хүний эрх, эрх чөлөөг хангагч субъект бөгөөд нөгөө утгаараа төрийн хуулийг чандлан сахиулагч мөн.

Хэрэг бүртгэлтийн үе шатанд мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй байгууллагын гол зорилго бол гэмт хэргийг таслан зогсоож, урьдчилан сэргийлэх, хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох, гэмт хэргийг илрүүлэх арга хэмжээ авахад оршино.

Иймд прокурорын байгууллага нь хэрэг бүртгэлтийн шатанд явагдаж байгаа мөрдөн шалгах ажиллагаа хуулийн дагуу явагдаж буй эсэх хяналт тавьж, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоохын тулд шаардлагатай ЭХХШ

³ Б.Шюнеманн "Цагдаа ба прокурорын байгууллага" Төр эрх зүйн хуудас-эсэргүүцэл сэтгүүл, УБ, 2001 он, 187-р тал

² В.И.Басков "Прокурорский надзор" Москва, 1996 он, 141-р тал

тухай хуульд заасан мөрдөн шалгах ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгор, мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд цуглуулсан нотлох баримтыг шалгах, үнэлэх, нотлох баримтаас хасах зэрэг бүхий л ажиллагааг удирдан чиглүүлэх чиг үүрэгтэй.

Мөн мөрдөгчөөс шалгаж буй эрүүгийн хэргийг хэрхэн шийдвэрлэх талаар саналыг прокурор хянаж хууль бус, эсхүл үндэслэлгүй шийдвэр гаргасан бол уг шийдвэрийг хүчингүй болгуулахаар тогтоол гаргадаг. ЭХХШ тухай хуулиар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг тусад нь салгаж хэрэг бүртгэлтийг гэмт хэргийг илрүүлэх үе шат болгож мөрдөн байцаалтаас ялгаж эрүүгийн хэрэг үүсгэх, яллагдагчаар татах шийдвэр гаргах эрхийг прокурорт олгосон нь зүйтэй алхам.

Эрүүгийн хэрэг бүртгэлт нь Монгол улсад одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуульд зааснаар гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг 19 хоногийн хугацаанд цагдаагийн байгууллага, авлигатай тэмцэх байгууллага, тагнуулын байгууллага, хорих анги байгууллага зэрэг нийт 8 субъект гүйцэтгэх ба эдгээр байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнууд шалгах ба тухайн гомдол, мэдээлэл нь гэмт хэргийн шинжийг агуулсан болох нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар тогтоогдсон бол хэрэг бүртгэлтийн хэрэг нээгдсэнээс хойш мөрдөгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг биечлэн явуулахаар заасан байна. Иймээс прокурорын хяналт нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шаардлага тухайлбал,

хэрэг бүртгэх байгууллагаас хэрэг бүртгэлтийн хэрэг нээх, шийдвэрлэх хугацаа, гэмт хэргийг цаг тухайд нь бүрэн илрүүлэх, түүнд бололцоо олгох нөлөөлсөн шалтгаан нөхцлүүдийг илрүүлэн арилгах талаар тогтоосон журмуудыг хэр зэрэг биелүүлж байгааг хянах, мөрдөн шалгах ажиллагаа явуулахад байнгын хяналт тавьдаг.

Энэхүү үе шатанд тавих прокурорын хяналтын бас нэг үндсэн чиг үүрэг нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг заавалчгүй илрүүлэхийн зэрэгцээ гэм буруугүй нэг ч хүн, түүнчлэн нийгмийн хор аюулаар ялимгүй, хэлбэрийн төдий агуулсан хэргийг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татуулахгүй байхад оршино.

Ер нь Эрүүгийн хэрэг бүртгэлтийн шат нь эрүүгийн процесс ажиллагааны цаашдын хувь заяаг шийддэг ихээхэн чухал үүрэгтэй.

Тийм учраас энэхүү үе шатанд мөрдөн шалгах ажиллагаа эрхлэн хэрэгжүүлэгч субъект ихээхэн санаачлагатай, шуурхай, овсгоо самбаатай ажиллах ёстой юм.

Эрдэмтэн судлаачид, практик ажилтны санал, урьдын уламжлалыг эс тоомсорлосон 2002 оны ЭБШ хуулийн зохицуулалтаас үүдэлтэй мөрдөн байцаалттай өрсөлдсөн хэрэг бүртгэх бие даасан механизм бүрдэж гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн зорилгоос хазайж эхэлсэн нь нууц биш. Харин 2017 оны шинэ хуулиар хэрэг бүртгэлтийг мөрдөн байцаалтын амин холбоот үе шат болохыг заан зохицуулж өгсөн боловч үндсэн чиг үүргийг нь

эрүүгийн бусад албадтай уялдуулах талаар анхаараагүйгээс үүдэлтэй зарим асуудал, тухайлбал:

Гүйцэтгэх ажилтай хэрхэн уялдах "эзэнгүй" хэргүүд ихэсч ачааллыг

хүндрүүлэх үед хэрэг бүртгэлтийн ажиллагааг жигд хэрэгжүүлэх боломж, нөхцөл ямар болохыг тооцож үзээгүй санагдана.

ШИНЭЭР ИЛЭРСЭН НӨХЦӨЛ БАЙДЛЫН УЛМААС ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ХЯНАХ НЬ

Б.БИЛГҮҮН

(Шихихутуг их сургуулийн магистрант)

Аливаа хэрэг, маргааныг хянан шийдвэрлэж буй шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий баймааж шүүх эрх мэдлийг жинхэнэ утгаар хэрэгжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг баттайаа хамгаалах үндсэн нөхцөл бүрдэх учиртай.

Эрх зүйн аль ч тогтолцоот улс оронд Үндсэн хууль, бусад хуулиудын нийтлэг хэм хэмжээний зохицуулах нөлөөлөл, эрх зүй хэрэглэх шүүхийн үйл ажиллагаа улам бүр эрч хүчээ авч, даяарших хандлага илт ажиглагдах болов.

Тиймээс ч шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянах ажиллагаа нь шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх эрх зүйн нийтлэг зарчмыг хэрэгжүүлэхэд ихээхэн чухал болж байна. Уг ажиллагаа нь өөрийн агуулга зорилгоороо шийтгэх ба цагаатгах тогтоолын хуулийн үндэслэлтэй байхад нэмэлт хүчин зүйлд тулгуурлан үйлчилдэг, шүүхийн хяналтын нэг чухал хэлбэрт тооцогддог¹.

Эдүгээ дэлхийн улс орнуудын эрүүгийн процессын эрх зүйн харилцаанд жишиг, зарчим, хандлагыг нэвтрүүлж буй гэрээ, конвенцуудын нэг болох “Олон Улсын Эрүүгийн шүүх /ОУЭШ/-ийн Ромын дүрэм”-ийн 84 дүгээр зүйл /

Шийтгэсэн буюу ял ногдуулсан шийтгэх тогтоолыг хянаж үзэх/-ийн 1 дэх хэсэгт “Гэм буруутай гэж тооцогдсон буюу түүнийг нас барсны дараа эхнэр болон нөхөр, хүүхэд нь буюу эцэг эх, эсхүл яллагдагч нас барах үед хамт амьдарч байсан бөгөөд түүнд тийм нэхэмжлэл гаргах талаар бичгээр тодорхой чиглэл өгсөн этгээд буюу гэм буруутай хэмээн тооцогдсон этгээдийн нэрийн өмнөөс прокурор дараах үндэслэлээр шийтгэсэн буюу ял ногдуулсан тогтоолыг буюу эцсийн шийдвэрийг хянан үзэх тухай хүсэлтийг Давж заалдах шатны танхим гаргаж болно”;

а) дор дурдсан нөхцөл, байдал шинээр илэрсэн бол:

- i) шүүх хуралдааны үед байгаагүй бөгөөд тийнхүү байгаагүйн хариуцлагыг хүсэлт гаргасан тал бүрэн буюу хэсэгчлэн хариуцах ёсгүй асуудал;
- ii) хэрэв тэдгээрийг шүүх хуралдааны явцад гаргасан бол өөр шийдвэр гаргахад илт нөлөөлөх баримт;

б) шүүх хуралдааны явцад анхаарлын төвд байсан, тэр нь шийтгэх тогтоол гарахад нөлөө үзүүлсэн нөхцөл байдлын нотлох баримт нь худал буюу зохиомол болохыг илчилсэн шинэ баримтууд тус тус байгаа бол,

¹ Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тайлбар, УБ., 2003 он, 503 дахь тал

² <https://www.legalinfo.mn/law/details/1217>

с) шийтгэх тогтоол гаргах үед яллах үндэслэлийг зөвшөөрсөн нэг буюу хэд хэдэн шүүгч (46 дугаар зүйлийн дагуу) тухайн хэргийг хянан хэлэлцэхэд албан тушаалаас нь огцруулах хангалттай үндэслэлээр өөрийн үүргээ зөрчсөн бол;

2 дахь хэсэгт “Давж заалдах шатны танхим хүсэлтийг үндэслэлгүй гэж үзвэл буцаана. Хэрэв тэрээр хүсэлт нь мөн чанартай үндэслэлтэй гэж үзвэл шаардлагатай тохиолдолд дараах зүйлийг хийж болно”;

а) анхны шүүхийн танхимыг дахин хуралдуулах;

б) шүүхийн танхим шинээр байгуулах;

с) тухайн асуудалтай холбоотой хэргийг шүүн шийдвэрлэх эрхийг өөртөө үлдээх, ингэхдээ Дэгийн болон нотолгооны журамд заасны дагуу тийнхүү талуудыг сонсох замаар шийдвэрийг эргэн хянан үзэх эсэхийг шийдвэрлэнэ гэж заасан байдаг.

Уг дүрэм нь Олон улсын байнгын ажиллагаатай эрүүгийн шүүхийг байгуулах тухай олон улсын гэрээ бөгөөд анх 1998 оны 7 дугаар сарын 18-ны өдөр Ром хотод батлагдаж, 2002 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн.

Монгол Улс ОУЭШ-ийн дүрэмд 2000 оны 12 дугаар сарын 29-ний өдөр гарын үсэг зурж, 2002 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр соёрхон баталсан ба ОУЭШ-ийг үүсгэн байгуулагч 60 улсын тоонд багтдаг.

Манай орны эрдэмтэн судлаачид шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг сэргээх тухай асуудлыг шүүхийн

гарч болзошгүй алдааг засаж залруулах, хүний эрх, эрх чөлөөг хангах нэг арга хэрэгсэл хэмээн үзэж, судалгааны объектоо болгож ирсэн.

Монгол хэлний Их тайлбар толь бичигт “нөхцөл байдал” хэмээх хоршоо үгийн утгыг “тухайн юм, үйлийн үүсэх, хөгжих, оршин байх үеийн төлөв” гэсэн байдаг.

Харин “шинээр илэрсэн нөхцөл байдал”-ыг логик буюу учир зүйн ухааны үүднээс авч үзвэл урьд өмнө мэдэгдээгүй байсан боловч тухайн үзэгдэл үүсч, хөгжихөд нөлөөлөн гарч ирж байгаа хүчин зүйл хэмээн үзэж болно.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг сэргээх ажиллагааны талаарх зохицуулалт 1963 оны Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд анх тусгалаа олсон юм.

Дээд шүүхийн бүгд хурлын 1991 оны 33 дугаар тогтоолоор анх шинээр илэрсэн нөхцөл байдлыг тайлбарласан аж. Ингэхдээ, “Хэргийн үндсэн нотлох баримт болсон гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, түүнчлэн орчуулагчийн орчуулга санаатай худал байсан, эд мөрийн баримт болон мөрдөн байцаалт, шүүхийн ажиллагааны протоколыг зориуд хуурамч үйлдсэн, уг хэргийг мөрдөн байцаасан болон шийдвэрлэсэн албан тушаалтан эрх хэмжээгээ хортойгоор урвуулан ашиглаж, хууль бус үндэслэлгүй таслан шийдвэрлэх тогтоол, магадлал гаргасан болох нь хуулийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоолоор тогтоогдсон, түүнчлэн шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол, магадлал гарах үед мэдэгдээгүй байсан бөгөөд шийтгүүлсэн этгээдийн

гэм буруугүйг, эсхүл үйлдсэн хэрэг нь түүний шийтгүүлсэн хэргээс хүнд буюу хөнгөн болох /эсхүл цагаатгагдсан буюу хэрэг нь хэрэгсэхгүй болсон этгээд гэм буруутайг нь нотолсон/-ыг шинээр илэрсэн нөхцөл байдал гэж ойлговол зохино³ гэжээ.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянах нь эрүүгийн процесс ажиллагааны онцгой үе шатанд зүй ёсоор тооцогддог бөгөөд өөрийн мөн чанараар хяналтын шатны ажиллагаатай төсөөтэй, аль аль нь шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх явцад гарсан алдаа, хууль зөрчсөн байдлыг засах зорилго агуулдаг, онцлог нь хуулийн хүчин төгөлдөр болсон шийдвэрийн дараа явагдана.

Гэхдээ хяналтын шатны ажиллагаа нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх, түүний дотроос анхан болон давж заалдах шатны шүүхэд бодит үндэслэл / нотлох баримт, нотолгоотой холбоотой/ болон хуулийн үндэслэл /Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн/-ийг нягтлан үзэхэд чиглэгдсэн байдаг бол шинэ нөхцөл байдал үүсэх нь эрүүгийн хэргийг эрхлэн явуулагчид /мөрдөгч, прокурор, шүүгч/ болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын аль нэг нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг өдүүлж, тэр нь процессын бүхий л үе шатанд мэдэгдэлгүй өнгөрч шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсны дараа

илрэх тохиолдолд үүссэн гэдгээрээ илүү ноцтойд тооцогддог. Иймээс энэхүү ажиллагааны зайлшгүй агаад ярвигтай шинж чанараас улбаалж эрүүгийн процессын хуульд тусгай бие даасан бүлэг болж оруулсан юм.

2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хууль⁴ нь 15 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилсэн бөгөөд энэ хуулийн 41 дүгээр бүлэг буюу 357-363 дугаар зүйлүүдэд “Шинэ нөхцөл байдлын улмаас хэргийг сэргээх” ажиллагааны үндэслэл, журмыг заан тодорхойлжээ.

Өдгөө Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр баталж, мөн оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль⁵-ийн мөн Дечин нэгдүгээр бүлэг буюу 41.1-41.5 дугаар зүйлүүдэд “Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянах ажиллагаа”-ны үндэслэл, журмыг шинэчлэн тусгажээ.

³ БНМАУ-ын Дээд шүүхийн бүгд хурлын тогтоолын эмхтгэл. УБ., 2001 он 105-106 дах тал

⁴ <https://www.legalinfo.mn/law/details/59>

⁵ <https://www.legalinfo.mn/law/details/12694>

Дээрх 2 хуулийг харьцуулбал дараах өөрчлөлт ажиглагдана. Үүнд:

№	Өөрчлөлт	2002 оны ЭБШТХ	2015 оны ЭХХШТХ
1.	Нэршил	Шинэ нөхцөл байдлын улмаас хэргийг сэргээх	Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянах
2.	Хэргийг сэргээн шалгах үндэслэл		Хуулийг илт буруу хэрэглэсэн шүүхийн шийдвэрийн улмаас хүний эрх ноцтой зөрчигдсөн бол.
3.	Прокурорын дүгнэлт хүлээн авч шийдвэрлэх шүүхийн харьяалал	... прокурор уг хэргийг мөрдсөн материал ба өөрийн дүгнэлтийн хамтаар ... Улсын Дээд Шүүхэд хүргүүлнэ.	Прокурор ... дүгнэлтээ гаргахдаа анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах шатны шүүхэд; давж заалдах, хяналтын шатны шүүхийн шийдвэрийг хяналтын шатны шүүхэд гаргана.
4.	Шүүхээс шийдвэрлэх үйл явц,	... прокуророос шилжүүлсэн хэрэг, материалыг Улсын дээд шүүх хяналтын шатны шүүх бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлэнэ.	... дүгнэлтийг хүлээн авсан шүүх хянан хэлэлцэж, олонхийн саналаар шийдвэр гаргана.
5.	Шүүхээс гарах шийдвэрийн төрөл	<ul style="list-style-type: none"> - тогтоол, магадлалыг хүчингүй болгож, хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буюу шүүхийн шинэчилсэн хэлэлцүүлэгт буцаах; - тогтоол, магадлалыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгох; - прокурорын дүгнэлтийг хэрэгсэхгүй болгох. 	<p>Шүүх дүгнэлтийг хүлээн авахаас татгалзах шийдвэр гаргасан бол энэ талаар хүсэлт гаргалчид мэдэгдэнэ.</p> <p>Шүүх дүгнэлтийг хүлээн авах үндэслэлтэй гэж үзвэл:</p> <ul style="list-style-type: none"> - тухайн хэргийг хянан шийдвэрлэх шүүхийн харьяаллыг тогтоож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаах; - хэргийг прокурорт буцаах.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай шинэ хуулийн 41.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянах үндэслэлүүдийг шалтгаан нөхцөлөөр нь ангилж үзвэл дараах онцлогууд ялгарч байна. Үүнд:

1.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эрхлэн явуулагчдаас шалтгаалсан нөхцөл байдлууд	<ul style="list-style-type: none"> - эрх бүхий албан тушаалтан, - мөрдөгч, - прокурор, - шүүгч нар эрх хэмжээгээ урвуулан ашигласан; 	Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрээр тогтоогдсон
----	--	--	--

2.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогчдоос шалтгаалсан нөхцөл байдал	<ul style="list-style-type: none"> - гэрчийн санаатай худал мэдүүлэг, - шинжээчийн санаатай худал мэдүүлэг, дүгнэлт, - орчуулагч, хэлмэрчийн санаатай худал орчуулга, - хуурамч нотлох баримт, тэмдэглэл, баримт бичгийг үндэслэж шийдвэр гарсан; 	Мөрдөн шалгах ажиллагаа болон бусад үйл баримтаар нотлогдсон
3.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх ашиг сонирхлыг хамгаалж оролцсон оролцогчдоос шалтгаалсан нөхцөл байдал	<ul style="list-style-type: none"> - цагаатгагдсан хүн, хуулийн этгээд гэм буруутай болохыг нотлох нөхцөл байдал илэрсэн, - гэм буруугүй хүн, хуулийн этгээдэд ял оногдуулахад хүргэсэн нөхцөл байдал илэрсэн, - шүүх шийдвэр гаргах үед мэдэгдээгүй байсан ба оногдуулснаас хөнгөн, эсхүл хүнд ялтай зүйл, хэсэг, заалт хэрэглэх үндэслэл болох нөхцөл байдал илэрсэн; 	
4.	Шүүхээс хэрэг маргааныг хянан шийдвэрлэхтэй холбогдон гарсан аливаа шийдвэрээс шалтгаалсан нөхцөл байдал	- хуулийг илт буруу хэрэглэсэн шүүхийн шийдвэрийн улмаас хүний эрх ноцтой зөрчигдсэн;	
5.	Хууль зүйн объектив фактуудаас шалтгаалсан нөхцөл байдал	<ul style="list-style-type: none"> - хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн, - Өршөөл үзүүлэх тухай хууль гарсан, - уучлал үзүүлсэн, - яллагдагч нас барснаас шүүхийн тогтоол гаргах бололцоогүй болсон; 	

Эдгээр нөхцөл байдлууд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан ажиллагааны үр дүнд тогтоогдвол урьд гарсан хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож хэргийг сэргээн шалгах шаардлага гарцаагүй үүснэ.⁶

Шинээр илэрсэн нөхцөл байдлыг

⁶ Ж.Бямбаа, Ж.Эрхэсхулан, “Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал” УБ., 2018 он, 273 дахь тал

шалгахад мөрдөгч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмыг баримтлан шаардлагатай мөрдөн шалгах ажиллагааг явуулж нотлох баримт бүрдүүлнэ.⁷

Уг ажиллагаа нь 3 үе шатаас бүрдэнэ.⁸
Үүнд:

⁷ Мөн тэнд.
⁸ Ц.Бүжинлхам, “Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй” /Тусгай анги/ УБ., 2007 он, 181 дэх тал

1. Шинэ нөхцөл байдал буй болсныг прокурор илрүүлэх,
2. Шинээр нөхцөл байдлыг шалгаад тогтоогдвол, прокурор шүүхийн урьдах шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлаар хүчингүй болгуулахаар шүүхэд дүгнэлт бичиж хүргүүлэх,
3. Эрх бүхий шүүх дүгнэлтийг хянан хэлэлцэх гэсэн дараалалтай байна.

Энэхүү ярвигтай ажиллагааг үүсгэх эрх хэмжээг гагцхүү прокурорт хуулиар олгосон бөгөөд уг ажиллагааг үүсгэх шалтгаан нь иргэдийн гомдол, албан тушаалтны хүсэлт аль нь ч байж болно.

Манай Эрүүгийн процессын хуульд ОХУ-ын нөлөө илт мэдрэгддэг. Тухайлбал, ОХУ-ын одоо үйлчилж буй Эрүүгийн байцаан шийтгэх хууль⁹-ийн 49 дүгээр бүлгийн 413-419 дүгээр заалтуудтай адил журам манайд үйлчилж байснаа 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай өнөө үйлчилж буй хуулиар тогтолцооны үндэс суурь бүрдсэнийг судлаачид тусгайлан тэмдэглэжээ¹⁰.

ОХУ-ын ЭБШ хуулийн 49 дүгээр бүлэгт нэгэнт хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг сэргээх үндэслэлийг шинэ буюу шинээр илэрсэн нөхцөл байдал, бусад нөхцөл байдал гэж ангилсан байдаг.

Ингэхдээ "шинээр илэрсэн нөхцөл байдал" гэдэгт шүүхийн тогтоол,

магадлал, тогтоол гарах үед бодитойгоор байсан боловч шүүх бүрэлдэхүүн, шүүгчид мэдэгдээгүй нөхцөл байдлуудыг, "шинэ нөхцөл байдал" гэдэгт шүүхийн тогтоол, магадлал гарах үед шүүхэд мэдэгдээгүй байсан, гэмт явдал ба ял шийтгэгдэх байдлыг үгүйсгэсэн нөхцөл байдлуудыг хамааруулсан байна.

ОХУ-ын эрдэмтдийн үзэж байгаагаар "шинэ нөхцөл байдал" гэдгийг:

- Үндсэн хуулийн шүүхээс тухайн эрүүгийн хэрэгт анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүх Үндсэн хууль зөрчсөн хэм хэмжээг хэрэглэсэн гэж үзсэн,
- бусад шинэ нөхцөл байдал" гэж ангилж байгаа юм.

Харин "бусад шинэ нөхцөл байдал" гэдэгт:

1. Шүүх болон хэргийг мөрдөж байгаа бусад этгээдийн хувьд шинэ болон огт мэдэгдээгүйн улмаас гэмт хэргийн үнэн бодит нөхцөл байдлыг мэдэх боломжгүй байснаас хууль бус үндэслэлгүй шийдвэр гаргахад хүргэсэн нөхцөл байдлуудыг,
2. Хэргийн харьяаллын бус байдал нь түүний дотор давж заалдах болон хяналтын журмаар ямар ч маргаангүйгээр нотлогдсон шинэ ба шинээр илэрсэн нөхцөл байдлыг ойлгодог аж.

Үүнээс үзвэл, шинэ буюу шинээр илэрсэн нөхцөл байдал гэсэн хоёр ойлголт нь зэрэгцэн оршихийн зэрэгцээ өөр хоорондоо мөн ялгаатай.

⁹ Уголовно-процессуальный кодекс РФ. 2001., Глава 49. Статья 413-419


¹⁰ Ж.Бямбаа, Ж.Эрхэсхулан, "Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал" УБ., 2018 он, 274 дэх тал

¹¹ В.А.Пиголкин. Уголовно-процессуальное право РФ. М.,2006. стр 673,

Тодруулбал, “шинэ нөхцөл байдал” гэдэг нь нотолгооны төвшинд, “шинээр илэрсэн нөхцөл байдал” гэдэг нь хүчин төгөлдөр болсон шүүхийн тогтоол, магадлалын хувьд яригдах ойлголт юм.

Сүүлийн 3 жилд буюу 2018-2020 онд Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай прокурорын дүгнэлттэй нийт 37¹² хэрэг, Монгол Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхим нийт 78¹³ хэргийг хянан шийдвэрлэсэн байх бөгөөд энэ тоо жилээс жилд тогтворжих хандлагатай байна.

Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхим



Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх



Түүнчлэн шүүн таслах ажиллагаа, түүний шийдвэр дахин хянагдах, эсхүл сэргээгдэхэд нөлөөлж байгаа зарим

сөрөг хүчин зүйлүүдийг гадаад, дотоод шинжээр нь ангилбал:

- гадаад хүчин зүйлд: шүүх, шүүгч нараас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль дээдлэх зарчмыг хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс нөлөөлж байгаа нийгэм-эдийн засгийн болон бусад шалтгаан нөхцөл, хүчин зүйлүүдийг,
- дотоод хүчин зүйлд: шүүгч нарын мэдлэг боловсрол, сахилга ёс зүй, хууль хэрэглэх чадвар, шүүхийн мэргэжлийн удирдлага, зохион байгуулалт, менежменттэй холбоотой, өөрөө хэлбэл шүүх, шүүгч нараас шууд шалтгаалж байгаа тэр хүчин зүйлүүдийг хамааруулан авч үзэж болох боловч үүнийг зөвхөн шүүгч нарын алдаагаар хязгаарлах нь туйлын хангалтгүй билээ.

Дүгнэлт, санал

Нэгэнт хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу дахин хянах шаардлага гарч ирдэг. Энэ нь хууль зүйн болон эдийн засаг, ёс суртахууны асар их үр дагаврыг дагуулах нь ойлгомжтой.

ЭХХШТ хуулийн 41 дүгээр бүлэгт “Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянах” ажиллагааны үндэслэл, журмыг хуульчлан тогтоосон. Ингэхдээ мөн хуулийн 41.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн:

1.1-д гэрч, шинжээчийн санаатай гаргасан худал мэдүүлэг, дүгнэлт, орчуулагч, хэлмэрчийн санаатай худал орчуулга, хуурамч нотлох баримт, тэмдэглэл,

¹² Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүн таслах ажиллагааны 2018, 2019, 2020 оны нэгдсэн мэдээ.

¹³ Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүн таслах ажиллагааны 2018, 2019, 2020 оны нэгдсэн мэдээ.

баримт бичгийг үндэслэж шүүхийн шийдвэр гарсан нь тогтоогдсон;

1.2-т шүүгч, прокурор, мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан нь эрх хэмжээгээ урвуулан ашигласан нь хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрээр тогтоогдсон;

1.3-т цагаатгагдсан хүн, хуулийн этгээд гэм буруутай болохыг нотлох, эсхүл гэм буруугүй хүн, хуулийн этгээдэд ял оногдуулахад хүргэсэн, шүүх шийдвэр гаргах үед мэдэгдээгүй байсан ба оногдуулснаас хөнгөн, эсхүл хүнд ялтай зүйл, хэсэг, заалт хэрэглэх үндэслэл болох нөхцөл байдал илэрсэн;

1.4-т хуулийг илт буруу хэрэглэсэн шүүхийн шийдвэрийн улмаас хүний эрх ноцтой зөрчигдсөн; зэрэг 4 нөхцөл байдлыг шинээр илэрсэн нөхцөл байдал гэж үзэн, урьд гарсан хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг хүчингүй болгон хэргийг сэргээн шалгаж болохоор зааж өгсөн байна.

Шинээр илэрсэн нөхцөл байдлыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 41.2 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу прокурорын даалгавраар мөрдөгч мөрдөн шалгах ажиллагаа явуулж тогтоодог.

ЭХХШТ хуулийн 41.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, 1.2-т заасан үндэслэлээр явуулж буй процесс ажиллагааны хэлбэр, журам нь харьцангуй ялгаатай.

Тухайлбал, ЭХХШТ хуулийн 41.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-д заасан үндэслэлээр мөрдөн шалгах ажиллагаа явуулж гэрч, шинжээчийн санаатай гаргасан худал мэдүүлэг, дүгнэлт,

орчуулагч, хэлмэрчийн санаатай худал орчуулга, хуурамч нотлох баримт, тэмдэглэл, баримт бичгийг үндэслэж шийдвэр гарсан нь тогтоогдсон гэж үзвэл прокурор шууд давж заалдах болон хяналтын шатны шүүхэд шинэ нөхцөл байдал илэрсэн хэмээн ханддаг бол мөн хэсгийн 1.2-т заасан буюу эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эрхлэн явуулагчид болох шүүгч, прокурор, мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан нь эрх хэмжээгээ урвуулан ашигласан нь хуулийн хүчин, төгөлдөр болсон шүүхийн шийдвэрээр тогтоогдсон тохиолдолд зөвхөн тэрхүү шийдвэрийг үндэслэн шинэ нөхцөл байдал илэрсэн гэж үзэж байна.

Гэвч өнөөдөр ЭХХШТХ хуулийн 41.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-д заасан үндэслэлээр шүүхийн шийдвэрийг хянуулахаар ирүүлж буй байдлаас ажиглахад, нэн ялангуяа улс төрийн болоод өндөр албан тушаалтанд холбогдсон хэрэгт зайлшгүй хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг үндэслэн зохих шатны шүүхэд хандах ёстой хэмээн үзэх ялгамжтай хандлага ажиглагддаг.

Ром-Германы гэгдэх зарим орнууд, тухайлбал, ОХУ, ХБНГУ-ын эрүүгийн процессын хуульд дээрх 2 тохиолдлын аль алинд шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарч холбогдох этгээдийн гэм бурууг эцэслэн шийдвэрлэсэн үед шинэ нөхцөл байдал илэрсэн гэж үздэг.

Иймд ЭХХШТ хуулийн 41.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-д заасан үндэслэлээр явуулсан мөрдөн шалгах ажиллагааны үр дүнг шүүх хуралдаанаар

хэлэлцэн холбогдох этгээдийн гэм бурууг тогтоож, шаардлагатай бол тухайн шийдвэр давж заалдах журмаар хянагдсан байх нь зүйтэй.

Учир нь, ЭХХШТ хуулийн 41.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, 1.2-т зааснаас үүсэх эрх зүйн үр дагавар, процесс ажиллагааны журам ялгаатай зохицуулагдсан нь ойлгомжгүй байх бөгөөд боловсронгуй нэг мөр болгох шаардлага байгаа нь харагддаг.

Түүнчлэн, шинээр илэрсэн нөхцөл байдал ба шинэ нөхцөл байдлын ялгааг цаашид хууль тогтоох практикт ялгамжтайгаар авч үзэх шаардлагатайгаас гадна, шүүхээс материаллаг болон процессын

хууль хэрэглэх явцад гаргасан алдаа, зөрчлийг шинжлэх ухааны үндэстэй судалж, үүнд нөлөөлж буй хүчин зүйл, шалтгаан нөхцөлийг бүрэн тогтоож авах, хуулийн байгууллагууд хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эрхлэн явуулагчдын эрх зүйн соёлын төвшинг дээшлүүлэх талаар системтэй ажил зохиох нь чухал байна.

ХҮН ТАНИХЫН УХААН

Ж.БЯМБАА

Шихихутуг их сургуулийн анхны профессорын нэг Галдангийн Совдын гэгээн дурсгалд зориулав.

Совд багш маань бичиг бичиг номын билиг танхай авъяастан төдийгүй зөн совинтон гэмээр цэцэн мэргэн, хүн танихын увидастай нэгэн байж билээ.

Увс аймгийн прокурор Гэнэн гуай Цөлхөр овгийн Галдангийн Совдын энэ шинж чанарыг гярхай ажиглаж цэргийн албанаас дөнгөж ирсэн цэл залуухан, малын санитар түүнийг Увс аймгийн Завхан сумаас дуудан ирүүлж прокурорын мөрдөн байцаагчаар шууд томилсон юм гэнэлээ.

Тэр үед аймгийн шүүхийн орлогч даргаар ажиллаж байсан миний аав, ахмад дайчин М.Жавхлан надад нэгэн сонирхолтой зүйл ярьж өгснийг хожим нь Совд гуайгаас лавлаж сонирхоход “Тийм юм болох нь болсон. Нэг их хуучлаад баймаар айхтар зүйл биш л дээ” хэмээн эс тоомсорлосон мэт даруухнаар өгүүлж билээ.

...Хил дамжсан малын хулгайн том “төлөөлөгч”, наадамд гурван даваатай, найранд гурван дуутай нэгэн сайн эр аймгийн төвд дуудагдан ирж гадуур шалгагдаж байгаад гэнэтхэн сураг нь тасарч, жил гаруй хугацаа өнгөрчээ. Эрэн сурвалжилсан боловч ажиг чимээ огт гаргаж чадсангүй.

Эзэн холбогдогч нь хаа байгаа нь тогтоогдоогүй, Монгол, Тувагийн хуулийнхны шүдний өвчин болсон

түүний хэргийг илрүүлэх үүргийг будаг нь ханхалсан мөрдөн байцаагч Совдод Гэнэн прокурор даалгасан аж.

Аавын өгүүлснээр Совд байцаагч тэр үед өндөрдүү нуруутай, өтгөн хар халмигтай, нүүрэндээ тун зохисон ширвээ сахалтай, ухаалаг, дуу хоолой сайтай /тэр үеийн хуулийн байгууллагын ажилтны нэгэн шалгуур байсан бололтой/ гялалзсан хархүү байжээ.

Мөрдөн байцаагч маань аймгийн Цагдаагийн хэлтсийн холбогдох албатай хамтарч эрэн сурвалжлах ажил чамбай, шаргуу явуулсны үр дүнд оргодол этгээдийн сургийг гаргасан гэнэ. Тэр ч атугай аймгийн хамгийн захын нэгэн суманд айлд хүргэн орж суурин амьдардаг болчихсон, элдэв хэл аманд орооцолдохдоо бүр больсон тухай ч баттай мэдээлэл авчээ.

Бас намрын сэрүү орж эхэлсэн тэр цагаар хил залгаа Завханы Сонгино суманд нэлээд өргөн дэлгэр наадам болохыг ч дуулжээ.

Совд байцаагч тун зоримог таамаглал дэвшүүлж ноцолдох, өрсөлдөх сонирхолтой тэр сайн эр аймаг, сумынхаа баяраар биш, чухам тэнд л очиж эр бяраа сорих нь зайлахгүй хэмээн тооцоолжээ.

Ингээд аймгийн прокуророо “сэнхрүүлж”

байгууллагынхаа ганц “ГАЗ-67 машиныг хөлөглөж цагдаагийн нэгэн ажилтантай Сонгиныг зорин хөдөлжээ. Хяргас нуурын хойт талын элс, хур бороонд үерлэсэн замын гол горхиудыг туулан зүтгүүлсээр Сонгины наадмын найман бөх үлдсэн байхад ам мөлтөс хүрчээ.

Сайн эр ч тэнд тун өнгөтэй барилдаж байна гэнэ. Совд байцаагч түүнтэй ганцаараа тусгайлан уулзаж баривчлахаар ирснээ “эвтэйхэн” дуулгажээ. Сүр дуулиан болголгүй өөрт нь учир байдлыг аядуу сонсгосон Совд байцаагчид мань эр их л талархалтай хандаж буй бололтой.

“Би таниас гуйх юм байна. Та бид хоёр нэг аймгийн харъяатууд. Бусдын наадмыг үймүүлж өөрсдийгөө гутаагаад юу хийхэв. Миний бие энэ барилдаанд түрүүлэхээр байна, гэхдээ төрт ёсны баярыг хүндэтгэлгүй яахав. Аймгаас эрэн сурвалжилж та энд ирсэн юм чинь би хулгайчаараа тооцогдож яваа юм байна. Иймд элдэв шуугиангүй үзүүр түрүүнд хүрье. Дараа нь та тааллаараа бол” гэх нь тэр.

Совд байцаагч сайн эрийг сүрхий ажиглаж байснаа “Наадам дуусангуут морь малаа хамт яваа хүмүүстээ өгөөд сумын худалдаа бэлтгэлийн ангийн үүдэнд хүрээд ир. Бидэнтэй хамт яваарай” гэжээ.

Дагаж явсан цагдаагийн ажилтан баргар царайлан их л дургүй байгаа бололтой энгийн хувцастайгаар ажиглалт хийхээр наадмын талбай руу зүглэжээ. Сайн эр аймаг сумынхаа нэр гаргаж тэр наадамд урамтай сайхан барилдаж үзүүр түрүү булаацалдсан төдийгүй амалсандаа хүрч

болзсон газраа мөрдөгчөөс түрүүлэн ирсэн байв.

Ингээд нутгийн зүг хамтдаа хөлгийн жолоо залав. Хичнээн шаргуу явсан боловч шөнө дөлийн бараанаар Увсын Өндөрхангай сумын төвд хүрчээ. Хонох буудаллах газраа ариа ядан олсон гэнэ. Гэтэл нөгөө саын эр “Энэ жижигхэн өрөө даан ч давчуу юм байна. Та гурав маань тухтай амарч хоно. Яг аймаг ордог зам дээр эндээс 10 гаруй км газар манайх байдаг юм. Би хүүхэдтэй болоод нэг их удаагүй. Хөгшин эхийн минь бие ч таруухан байгаа. Тэнд та нарыг тосон хүлээж байя” гэх нь тэр.

Цагдаагийн ажилтан жигтэйхэн дургүйцэж “Чи ер нь хэн юм бэ. Хулгайчид итгэж сул тавиад байна гэж бодоогүй биз. Одоо чамайг баривчилна” гэж зандарчээ. Байдал түгшүүртэй болж эхэллээ.

Гэтэл Совд байцаагч тун тайвнаар “Эр хүн эр хүндээ итгэсэн л бол итгэл төгс байх нь зөв. Хэлсэн газраас чинь маргааш өглөө чамайг авъя. Эндхийн газар орныг би мэднэ” гээд зөвшөөрч орхив.

Мэдээж тэр шөнө эрүүгийн төлөөлөгчөөс Совд гуай илүү түгшиж хоносон биз. Төлөөлөгч өглөө эрт босч яваад “арай ядаж нэг юм холбоо барилаа” гэсээр л баргар царайлан орж ирэв. Совд байцаагч түүнээс юу ч асуусангүй. Ямар ч бай буцах аянаа бүлх залгисан мэт хамтдаа үргэлжлүүлж эхэллээ.

Цаг хүрэхгүй шахам давхисны эцэст сайн эрийн заасан газар, гэрт нь иржээ.

...Тэрлэгээ нөмөрсөн хүдэр сайхан эр

бяцхан хүүгийнхээ толгойг үнэрлэн хоймортоо заларч, гуалиг үзэсгэлэнт гэргий нь тулганд аргалаа өрдөж цай хоол болсон үлгэрийн юм шиг жаргалтай гэр бүлийн дүр төрх... Совд байцаагчийн сэтгэлд хоногшин үлдсэн гэдэг.

...Замын бартаа донсолгоог хэлэх үү, бараг "ГАЗ-67"-тойгоо хамт бутарчих шахсан тэд зүтгүүлсээр харуй бүрий болсон хойно Улаангомд орж ирсэн байна. Ажил хэдийнээ тарсан тул авч ирсэн сайн эрийг баривчлан хорих зөвшөөрөл авахаар зусландаа гарсан аймгийн прокурорын гэрт нь Совд байцаагч очжээ.

Гэнэн гуайн амар мэндийг асуухад орон дээрээ буруу харан хэвтэж байсан тэрбээр тун ёозгүй "За, чи хулгайчаа суллаад тавьчихсан гэл үү. Яасан их өрөвчхөн хүн бэ" гэх нь тэр. "Үгүй ээ, прокурор оо би аваад ирсэн" гэнгүүт Гэнэн гуай хүүхэд шиг үсрэн босч ирсэнээ "Овоо доо! Би мөн их айлаа шүү. Чиний үгэнд итгэж ийм их хөл хөөрцөг болчихоод хулгайчийг тавиад туучихлаа гэж төлөөлөгчийн утас цохисноос хойш байх суух газраа олж ядлаа" гэж гэнэ.

Хорьж мөрдөх зөвшөөрөлд гарын үсгээ зурахаас өмнө Гэнэн гуай гэрийн гадаа машинд сууж үлдсэн сайн эрийг сүрхий ажигласнаа харуй бүрэнхийд Совд гуайн гарыг их л дотночлон чанга атгасан гэдэг.

Маргаашнаас нь байцаалт эхлээ юм биз. Мэдүүлэгтэйгээ танилцаж байсан сайн эр гэнэт тэмдэглэл хөтөлсөн хамаг хуудсыг нь хумхин базаж өрөө халааж байсан жижиг зуухны галд өргөчих нь

тэр. Совд байцаагч ухасхийсэн боловч амжилгүй бүхий л баримтаа үнсэн чандруу болгуулчихжээ.

Алмайрч сандарсан Совд гуайг сайн эр их л жоготойхон харж инээмсэглэснээ "Та битгий бухимд. Би таны хүн чанартайг чинь мэдэрсэн. Хийсэн хэргээ би бүгдийг нь бичиж өгье. Асуултаас чинь үзэхэд энэ талаар хомсхон мэдээлэлтэй байгаа юм шиг санагдлаа" гэх нь тэр.

...Удаж төдөлгүй Монгол, Туваг донсолгосон нэгэн ноцтой хулгайн хэрэг бүрэн илчлэгджээ...

...Совд гуай махир гаансаа дахин нэрж дээрх үйл явдлыг хуучилсныхаа дараа "Хүн таних тун хэцүү л дээ. Гэхдээ нүд рүү нь харж, амны хөдөлгөөн, нүүр царайг нь ажиглахад л ер нь ойлгогддог юм шүү. Сайн эр маань хулгайч нь хулгайч л даа. Гэхдээ тувагийн даварсан балмад этгээдүүдийн бод малын сүргээс сорчлон хөөж монгол руу оруулж ирдэг, хилийн орос цэргүүдэд огт баригддаггүй, ёстой нөгөө "Цахиур Төмөр" шиг золиг байсан юм. Шоронд байхдаа ажлын хоногоор шагнуулсаар, хэдхэн жилийн дараа эрх чөлөөтэй болсон. Гурван хүү нь аймаг, сумын наадмыг чимэглэн олон жил сайн барилдсан даа. Хүмүүжилтэй, хөдөлмөрч сайхан хүмүүс.

Харин "эцэг нь урт наслаагүй ч жаргалтай амьдарсан шүү" хэмээн шүүрс алдан өгүүлж билээ.

...Совд гуайн энэ мэт олон арван түүх, хуучийг олж цуглуулж амжаагүйдээ надад одоо харамсмаар санагддаг юм. Бичиглэж үлдээсэн бол мөн олон хуульчидад хэрэг болно доо.